



АРВАН ЗҮГИЙН АРВАН ХОРЫН ҮНДСИЙГ
ТАСАЛСАН АЧИТ БОГД ГЭСЭР МЭРГЭН ХААНЫ
ТУУЖ ОРШВОЙ

ГЭСЭР

www.kiebooks.com

**АРВАН ЗҮГИЙН АРВАН ХОРЫН ҮНДСИЙГ ТАСАЛСАН АЧИТ БОГД
ГЭСЭР МЭРГЭН ХААН АЛДАРШИН ДУУРССАН ТЭРГҮҮН БҮЛЭГ**

Бурханы зарлигийг мартав

Эрт нэгэн цагт Шигэмүн бурхныг нирвааны дүр үзүүлэхийн урьд Хурмаст тэнгэр Бурханд мөргөө гэж очив. Хүрч мөргөсний хойно Бурхан Хурмаст тэнгэрт зарлиг болгов: “Таван зуун жил болсны хойно ертөнцийн цаг самуун болох буй. Гэртээ харьж таван зуун жил болоод гурван хөвгүүнийхээ нэгийг илгээ. Тэр Ертөнцийн хаан тэр болтугай. Хүчтэн нь хүчгүйгээ барьж идэх буй. Гөрөөс өвөр хоорондоо нэг нэгээ барьж идэх буй. Чи гурван хөвгүүнийхээ нэгийг очуул. Тэр ертөнцийг эзлэх хаан тэр болох буй” гэв. “Таван зуун жил жаргалдаа ташуурч суув чи. Миний зарлигаар үтэр илгээгээрэй” гэв. Хурмаст тэнгэр: “зөв” гээд харьж ирэв. Ирсэн хойно бурханы зарлигийг мартаж Хурмаст тэнгэрт долоон зуун болтол суув. Сууж байтал Сударсун балгасны их хотын баруун өнцөг нь нэгэн түмэн бээрийн газар эвдрэв. Хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар хамаг зэр зэвсгээ авч: “энэ хотыг хэн эвдэв? Бидэнд өшөөт дайсан үгүй билээ. Асур нарын цэрэг эвдэв үү үүнийг?” гэж хотынхоо эвдэрсэн зүгт очив. Очиж үзэхэд хот нь өөрөө эвдэрсэн ажээ. Хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар бүгдээрээ ярилцав өвөр зуураа : “Энэ хот юунд эвдрэв?” гэж ярилцаж байтал Хурмаст тэнгэр санав: “Шигэмун бурханыг нирвааны дүр үзүүлэхийн урьд мөргөө гэж очиж билээ би. Мөргөсний хойно Бурхан над зарлиг болж: Таван зуун жил болоод гурван хөвгүүнийхээ нэгийг илгээ. Ертөнцийн цаг самуун болох буй” гэж билээ. “Хүчтэй нь хүчгүйгээ барьж идэх буй. Гөрөөс өвөр зуураа нэг нэгийгээ барьж идэх буй” гэж билээ. “Би мартаж жаргалдаа ташуурч таван зуун жилээ илүү долоон зуун жил илүү сууж байна би” гэв.

Тэнгэр нар зөвөлгөөн хийв

Хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр нар өвөр зуураа их хурим хийв. Хурмаст тэнгэр гурван хүүдээ элч илгээв. Илгээсэн элч нар нь Амин сахигч ахад нь хэлэв : “Авай чамайг Хурмаст тэнгэр эцэг чинь ертөнцөд хаан ор суухаар оч гэнэ” гэв. Амин сахигч нь хэлэв: “Би хурмаст тэнгэрийн хөвгүүн билээ. Очлоо ч ертөнцөд хаан оронд сууж үл чадах буй. Хэрвээ Хурмаст тэнгэрийн хөвгүүн очоод хаан оронд сууж эс чадваас хайрт хаан эцгийн нэр төрийг алдмуй. Би дургүйдээ үл очих биш. Сууж үл чадахаа айлтагнам би” гэв. Тэр үгийг аваад элч Үйл бүтээгч дүүд нь очив: “Авай чамайг Хурмаст тэнгэр эцэг чинь ертөнцөд хаан оронд суухаар оч гэнэ” гэв. Үйл бүтээгч хэлэв: “Би хурмаст тэнгэрийн хөвгүүн биш үү. Ертөнцөд явагч амьтан алтан дэлхийн хүн биш үү. Очивч би хааны оронд сууж үл чадна. Надаас ах гэвэл хаан суух ор Амин сахигчид буй заа. Дүү гэвэл Төгсцогтод буй заа. Надад юуны харьяа буй” гэв. Элч Төгсцогтод очив. Мөн урьд үгийг хэлэв. Төгсцогт хэлэв. “Их ах гэвэл Амин сахигч очно биз. Дунд ах гэвэл Үйл бүтээгч очно биз. Надад юуны хамаа буй. Очивч очъё гэж билээ. Эс чадвал хайрт хаан эцэг эхийн нэр төр хэрэггүй биш үү ” гэж гурван хүүхэд элчид мөн энэ үгийг өгүүлэв.

Элч энэ үгийг аваад хурмаст тэнгэр, гучин гурван тэнгэр нарт ирэв: “Гурван хүүхдийн чинь үг цөм тэр байна” хэмээв. Хурмаст тэнгэр гурван хөвгүүнээ ир гэв. Гурван хөвгүүн ирэв. Хурмаст тэнгэр зарлиг болруун: “Би та нарын ертөнцийн самуун болов. Туслахаар оч гэж би өөрөө мэдэж зарлиг болсонгүй билээ : Бурханы зарлигаар би та нарыг оч гэсэн билээ. Би та нарыг хөвгүүнээ болов уу гэж санаж билээ. Та нар миний эцэг байсан ажээ. Би та нарын хөвгүүн байсан ажээ. Та гурвуул миний хаан оронд суу. Миний аливаа явдлыг болбоос мөн зөвөөр зохиож явагтун. (Би бурханы зарлигаар алтан дэлхийд бууж амьтныг туслая” гэж) Хурмаст тэнгэр энэ үгийг зарлиг болов.

Хурмаст тэнгэрийг зарлиг болсны хойно гурван хөвгүүн нь малгайгаа авч сөгдөж мөргөв. “Эвүү! Хаан эцэг минь бидэнд энэ үгийг юу гэж зарлиг болном?” Амин сахигч энэ үгийг хэлээд айлтгав: “Хаан эцгийнхээ зарлигаар юунд үл очном? Очивч хааны орон сууж үл чадах буй. Хэрвээ Хурмаст тэнгэрийн хөвгүүн Амин сахигч хаан орон сууж эс чадав гэж ертөнцийн хүн элэглэвэл таны нэрд муу буй заа. Дэмий л тэнгэрийн хөвгүүн билээ хэмээгээд очих уу би? Дүүгээ ховлов гэхүү ? Энэ Үйл бүтээгч аливаа юмыг энэ чаднам ” гэв. “Эсруагийн аймагт арван долоон тэнгэр нар наадам хийж их хурим болсонд харвалга, барилдаан хийвч энэ Үйл бүтээгчийг нэг ч хүн чадахгүй, бултыг энэ чадна. Өвөр зуураа гучин гурван тэнгэр нар мөн бас харвалга, барилдаан наадам хийхэд бас үүнийг дийлэхгүй . Доор Лусын хаадын аймагт бас мөн л мэлзээ наадам хийвч үүнийг бас дийлнэ. Ер аливаа зүйл эрдмийг энэ үйл бүтээгч бүрэн сурсан билээ. Дэмий л тэнгэрийн хөвгүүн гэж очих уу бид ? Очивч мөн энэ чадна” хэмээв. Гучин гурван тэнгэр нар хэлэв: “Ер амин сахигчийн энэ үг цөм үнэн. Аливаа зүйл ч болов, бид сайн ч болов, ер мэлзээ хийж харвалга барилдаан хийвч булт манийг энэ дийлэх билээ. Амин сахигчийн тэр үг нь булт үнэн гэж Гучин гурван тэнгэр нар энэ үгийг хэлэв. ТөгсЦогт дүү нь ер эдний үгийг дагаж бүгд үнэн гэв.

Хурмаст дунд хүү ертөнцөд буух болов .

Бас хурмаст тэнгэр: “За Үйл бүтээгч ээ! Эд бүгдийг үг нь энэ байна. Одоо чи юу хэлнэм?” гэв. “Би юу хэлэх вэ? Хаан эцгийн зарлигаар очвол ч очъя. Хурмаст тэнгэр ахай минь, над Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуягаа өг. Цахилгаан өнгөт далавчаа өг. Нар сар хоёрыг хамтаар зэрэгцүүлэн ургуулан хийсэн манлай цагаан дуулгаа өг. Оюун эрдэнэ оньт гучин цагаан сумаа өг. Догшин хар нумаа өг. Билгийн гурван алд хар шор сэлмээ өг. Дуурсахуй нэрт алтан уургаа өг. Ерэн гурван жингээр хийсэн их болд сүхээ өг. Жаран гурван жингээр хийсэн бага болд сүхээ өг. Есөн салаат төмөр урхиа өг. Энэ бүгдийг найман ертөнцөд төрхөд буулгаж өгөөрэй” гэв. Хурмаст тэнгэр эцэг нь : “За өгье” гэв. “Гучин гурван тэнгэр нарын гурван тэнгэр та нар, над ертөнцөд нэгэн хэвлээс төрөх гурван хувилгаан эгчийг буулгаж өг. Нэг тэнгэрт нь миний биеийн дүртэй нэгэн хувилгаан ахыг буулгаж өг. Бусад тэнгэр нар энэ дагуулж явагч сайдаасаа гучин баатрыг буулгаж өг. Би ертөнцөд таныг илгэнэ гэж их дурлаж өг гэх биш, Хурмаст тэнгэрийн хөвгүүн ертөнцөд очоод хаан орныг сууж эс чадвал, хүнд дийлдвэл таны нэрд муу биш үү? Догшныг доройтуулж амьтныг жаргуулж явбал сайн нь энэ биш үү ? гэж гуйх минь энэ билээ “ гэв. Хурмаст тэнгэр, гучин гурван тэнгэр нар бүгдээрээ : “зөв биш юув, үйл бүтээгчийн энэ үг нь? Чамайг илгээх газарт юу гэж хайрланам бид? Бултыг өгье” хэмээв. Үйл бүтээгч “За” гэв. “Ах минь Амин сахигч, дүү минь ТөгсЦогт эс очив. Ертөнцөд хүрч амьтны тусыг бүтээсний хойно хаан эцгийн минь хаан оронд суух хишиг над буй за?” гэв. Бас “зөв” гэв. “Соронзон хүрлээр бүтээж хийсэн их илдээ өгөөрэй, ахай минь” гэв. “Өгье” гэв. “Ертөнцөд төрсөн хойно минь над амьтанд үл гартах нэгэн сайн морь буулгаж өгөөрэй” гэв. “Зөв, өгье” гэв.

Гэсэрийн төрөхийг угтаж мэдэв.

Түүний хойно ертөнцийн цаг самуун болсонд хар тэргүүт хүнээс эхлэн нисэх шувуу, гүйх гөрөөс бүгдээрээ хүслэн нэрт овоон дээр чуулган хийв. Гурван зуун өөр өөр хэлтэн амьтан, Арьяа Аланкари охин цагаан тэнгэр хэлмэрч хийв. Мо гүүш, Данбо нэрт Уулсын хаан Овоо Гүнжид энэ гурвуул төлөг орхив.

Арьяа Аланкари охин цагаан тэнгэр хэлэв: “Ай, гурван төлөгч нар энэ ертөнцийн цаг самуун болсныг даран чадах хаан төрөх үү? Үгүй юу? Төлгөө орхиж үз” гэв. Мо гүүш төлөг орхив. Төлөг орхисны хойно хэлэв. “Овоо Дүнжон гарво нэртэй, молор эрдэнэ биет, дун цагаан шүдэт, гарди шувуу тэргүүт, алтан шар хонгорцог үстэй, үсний үзүүрт нь уд модонд цэцэг дэлгэрсэн мэт тэр төрөх буй. Тэр төрвөл дээр тэнгэр нарыг эзлэгч тэр болох буй” гэв. “За, нэг дахиж төлөг орхи” гэв. Данбо нэрт төлөгч төлөг орхив. Орхиод хэлэв: “Арьяа Авалоки Одкари нэртэй, дэлгэрсэн цагаан гэрэлтэй, улаан хонгор царайтай, дээд бие нь хүний бие мэт доод бие нь лусын хаад могойн бие мэт, тэр төрөх буй. Тэр төрвөл доод лусын хаадын эзлэгч тэр болох буй” гэв. “За, уулсын хан Овоо Гүнжид төлөг орхи” гэв. Төлөг орхив. “Жамцо Дари Оддам нэрт маш цагаан өнгөтэй, өнгө гэрэл нь аран зүгт дэлгэрсэн тэр төрөх буй. тэр төрвөл арван зүгийн бурхан төгссөн, дунд биед нь дөрвөн их тэнгэр нар төгмөн, доод биенд нь найман их Лусын хаад төгссөн эр төрөх буй. Тэр төрвөл энэ Замбутивийг эзлэгч арван зүгийн эзэн ачит гэсэр мэргэн хаан тэр болох буй ” гэв.

Арьяа Аланкари охин цагаан тэнгэр бас хэлэв: “Тэд бүгд нэг эх, нэг эцгээс төрөх үү? өөр эцэг, өөр эхээс төрөх үү? Эцэг нь хэн буй, эх нь хэн буй? Бас төлөг орхиё” гэв. “Эцэг нь Уулсын хаан Овоо Гүнжид энэ болно .Эх нь Го баяны охин Амаржил болно” гэв. “Нэг нэгэндээ туслахын тулд нэгэн эцэг, нэгэн эхээс төрөх буй” “Эцэг нь энэ, эх нь энэ буй ажээ. Хаанаас ирэх вэ ? ” төлөгч нар хэлэв : “Ертөнцийн цаг самуун болсныг мэдэж дээр бурханаас зарлигтай, Хурмаст тэнгэрийн хөвгүүн юм уу? Ертөнцөд ингэж төрөх юм уу ? Бид эс мэдэв” гэв.

Арьяа Аланкари охин цагаан тэнгэр, тэнгэрт гарав. Мо гүүш Данбо нэрт, уулын хаан Одоо Гүнжид Хүслэн нэрт овоон дээрээс буув. Гурван зуун өөр өөр хэлтэн амьтан тархав. Тэр бүгд “Төлөгч нарын үг үнэн болов уу?” гэж ярилцаж “Үнэн” гэж тархав.

Цотон, Сэнлонг эхнэртэй нь хөөв .

Тэр цагт Дос, Донсар, Лин гурван отог улс байжээ. Досын ноён Сэнлон байв. Донсарын ноён Царгин байв. Лингийн ноён Цотон байв. (Тэдгээр амьтныг зовоож явагч тэр гурвуул ажээ) Цотон ноён агт сайтай ажээ. Нэг уруу орхисон чулууг гүйцэх буурал морь ажээ. Нэг нь голоор гүйх үнэгийг гүйцэх үнэгэн ухаа морь ажээ. Нэг нь хөндлөн гүйх зээр гүйцэх зээрэн ухаа морь ажээ .Тэр гурван отог улс Го баянд цэрэг мордож айсуй гэж цотон яарч нэгэн сайн мориор урьд хүрч хэл оруулав: “Танд Дос, Донсар, Лин гурван отог улс цэрэг мордож айсуй” гэв. Го баян дүрвэж нүүв. (Го баян өгүүллрүүн: “Сайн үг хэлсэн авай минь. Чи юу дуртайгаа ав” гэв. Цотон ноён өгүүллрүүн : “Тэр үзэсгэлэнт хүүхнээ өг” гэв. Амаржил өгүүллрүүн: “Эцэг минь. Эцэг минь би Цотон ноёны үг нь гурил мэт болоод зүрх нь гүр хар чулуу мэт гэнэ билээ: Би очихгүй. ” гээд дутааж гарав. Цотон ноён өгүүллрүүн: “Эцэг чинь нэгэнтээ үгээ хэлж барсны хойно чи дутааж хаашаа гарах” гээд хөөв.) Го баяны охин Амаржил мөсөн дээр халтирч унав.Охиныг барив. Охины сүүжний мах тасарч доголон болов. Цотон ноён “Би ийм доголон эм авбал миний нэр л муу болно үүнийг өөр хүнд өгье гэж ахдаа Сэнлон ноёнд өгье, хойно авахад сайн” гэж арга сэтгэж өгөв.

Сэлонд өгсний хойно охины хөлийн мах эдгэв. Урьдах мэт өнгө чимэг гуа сайхан болов. Цотон ноён үзэн ядаж “Ийм сайхан гуа үзэсгэлэнт эм бидэнд олох бэрх билээ. Үүнээс сайн хөвгүүн төрнө гэж төлөгч нар хэлсэн. Гэтэл сайхан хөвгүүн эс төрөв. Энэ цаг самуун болсон нь энэ эр эм хоёроос болов. Сэнлон, Амаржил хоёрыг хөөж орхиё. Урьдах эм, гэр, малыг хагацуулж авья” гэв. (Тэр цагт тэдгээр амьтан Цотон ноёны үгээс үл давах билээ) Сэнлон ноёнд цоохор тэмээ цоохор ботготой, цоохор хонь цоохор хургатай, цоохор ямаа цоохор ишигтэй, цоохор нохой цоохор зулзагатай, хэлтгий хар цачир өгч гурван голын бэлчирт цөлж илгээв.

Амаржил жирэмсэн болов.

Хөөж илгээсэн хойно Сэнлон өвгөн хоёр гурван малынхаа дэргэд огтоно урхидаж явав. Нэгэн өдөр арваадыг алж, нэгэн өдөр дотор наймыг алж явав. Амаржил түлээ түүж явав. Амаржил түлээнд очиж явтал өмнө нь нэгэн шувуун хэнхдэгтэй, хүн ууцтай тийм харцага сууж босож явна. Амаржил дуудаж асуув: “Хэнхдэг чинь яасан шувуутай адил буй? Ууц бөгс чинь яасан хүний төрөлтэй адил буй? Энэ юуны бэлэг буй?” гэж асуув. Харцага хэлэв: “Шувуун хэнхдэгтэй болсон минь үүдсэн биеэ эвдэн ирсний шинж билээ. Дээр тэнгэр нараас одоо ертөнцөд хувилж төрөх сайн эхнэр эрж явнам би. Төрөвч би ийм сайн эхнэрт төрнөм. Үгүй ч болов байнам зээ би” гэж хэлээд нисэж одов.

Амаржил шинийн наймны шөнө түлээ түүж харьж иртэл зуур нэгэн их хүн учралдаж үхэтхийж унав. Амаржил хэвтэж биеэ тэнхрэхлээр харьж ирэв. Хярмаг цас орсонд Амаржил мөн түлээ түүж мөрөөр мөшгиж үүрийн хярааны үед шөнийн унасан газарт очиж үзвэл тэнд нэгэн алд дэлэм мөртэй хүн олсоны мөрийг үзэв. “Энэ яасан их мөртэй хүн очив? гэж мөрөөр нь мөшгив. Тэр мөр нь их хадны хөндийд оров. Хадны хөндийгөөр Амаржил шагайж үзэв. Үзвэл алтан ширээн дээр бар цоохор тугтай, бар цоохор малгайтай, бар цоохор дээлтэй, бар цоохор гуталтай хүн алтан ширээний мөг түшлэгийг түшин сууж: “Энэ шөнө алжаахын муугаар алжаав би” гэж (сахлынхаа хярууг арчиж) суув. Амаржил үзээд айж дутаан харьж ирэв.

Гэсэр төрөв.

Гэртээ ирсэн хойно Амаржилын хэвэл нь ихдэж босож сууж үл чадах болов. Арван тавны өдөр өглөөгүүр өвгөн урхиа авч малаа тууж одохоор гарахад нь Амаржил хэлэв: “Чи юу гэж явнам? Миний хэвэлд хүн хэлэлцэх мэт гингэнэнэ. Би ганцаараа айж үхнэм. Ганц энэ өдөр миний дэргэд суу чи” гэхэд Сэнлон өвгөн хэлэв: “Чиний дэргэд би сууя гэхэд огтоно хэн алах вэ? Хоёр гурван малыг минь хэн үзнэм? Оготно эс албал бид хоёр амиа юугаар тэжээнэм?” гэж эс болж явав. Өвгөн явж огтоно урхидан, далан огтоно алж ирэв. Гэртээ үүрч ирэв. Өвгөн “Язгуураас энэ өдөр илүү алав би” гэж өвгөн гэртээ баярлаж “Эртний минь ерөөл буй за” гэж баярлаж суув. Оготноо гэртээ тавиад очив.

Бас үдийн хойно үдшийн урьд эхийн хэвлийн дотор хөвгүүн нь дуулан тавив: “Овоо Дүнжин гарво нэртэй, молор эрдэнэ биетэй, дун цагаан шүдтэй, гарди шувуун тэргүүтэй, алтан шор хонгорцог үстэй, үсний минь үзүүрт уд модны цэцэг дэлгэрсэн мэт, би төрөх буй. Би төрвөл дээд тэнгэр нарыг эзлэгч би болох буй” гэв. Бас нэг дуулав: “Арьяа Авалоки нэртэй, дэлгэрэнгүй цагаан гэрэлтэй, улаан хонгор царайтай, дээд бие минь хүний бие мэт, доод бие минь лусын хаад могойн бие мэт би төрөх буй. Би төрвөл доод лусын хаадыг эзлэгч би болох буй” гэв. Бс нэг дуулав: “Жамцо Дари Оддам нэртэй, маш цагаан өнгөтэй, өнгө гэрэл арван зүгт дэлгэрсэн би төрөх буй. Би төрвөл арван зүгийн дагинасыг эзлэгч би болох буй” гэв.

Бас нэг нь дуулав: “Гэсэр Сэрво Дондув нэртэй, дээд биенд минь арван зүгийн бурхан төгссөн, дунд биенд минь дөрвөн их тэнгэр буй. Би төрвөл энэ замбуулингийн эзэн арван зүгийн ачит Гэсэр мэргэн хаан болох би” гэж дуулав. Эх нь “Эвий эвий, эвий эвий, намайг ертөнцийн хүч эс хэрэглэж, гурван голын бэлчээрт хөөж орхисон. Над юуны бурхан төрж над баригднам аж. Над чөтгөрийн хувилгаан хөвгүүн төрж баригднам зээ. Муу эцэг тань Сэнлон өвгөн өлгий хийхээс түүний амийг тэжээх хүн үгүй. Таныг би өлгийдэж тэжээхээс үүрийн чинээ хар цачирт минь амь тэжээх хүн үгүй. Одоо би таныг өлгийдье” гэж гичгинэ ухах есөн алд төмөр гадсаар дөрвөн эрвэй (алд) гуу тус тусд нь ухаж тавив. Чингэтэл Овоо Дүнжин гарво “Эжий надад зай тавь” гээд оройгоос гарч унав. Өнгө чимэг нь адвиш сайхан гуа ажээ. Мөлхөж татаж эхдээ үл гүйцэгдэж явна. Эх нь хөөн гүйцэн ядаж явтал дээр тэнгэр нараас молор эрдэнэ заанд эмээл хазаар тохож, цан хэнгэрэг дэлдэж, сан хүж шатааж, молор эрдэнэ заанд цан хэнгэрэг дэлдэж байж унуулад аван одов тэнгэр. Эх нь : “Эвий минь, үнэн бурхан байсан байна” гэж уйлав.

Уйлтал: “Өхий (эгч) минь, над зай тавь” гэв. Эх нь баруун гараа өргөж оройгоо дарав. Дартал баруун суганаас нь унав. Бас мөлхөж татаж эс гүйцэгдэв. Доорхи их далайгаас Лусын хаан урьд ёсоор молор эрдэнэ заан арсланд мөн эмээл хазаар тохож, цан хэнгэрэг, хүж шатааж лусын хаанд аван одов. Их далайд авч одов.

Бас нэг нь : “Өхий минь, над зай тавь” гэв. Эх нь хоёр сугаа хавчиж хоёр гараараа оройгоо дарж байтал хүйснээс нь унав. Урьд хоёроос өнгө чимэг нь үлэмж сайхан гуа байв. Бас эхдээ үл гүйцэгдэж явнам. Эх нь хөөж явтал арван зүгийн дагинас хөх хирс заанд эмэл хазаар тохож, сан хүж тавьж цан хэнгэрэг дэлдэж ирж, арван зүгийн дагинас авч гарав. “Эвий эвий, эвий эвий гуу ухаж тавилаа? Одоо ядаж нэгийг нь ч таньж золгож тэвэрч озож хагацах нь эвий минь эвий яалаа” гэж уйлав.

Уйлтал нь бас нэг Гэсэр Сэрво Дондув: “Эжий минь би аль мөрөөр гарах вэ?” Эх нь: “Авай минь ёстой мөрөөр төр” гэж дуудав. Ёстой мөрөөр төрөв. Баруун нүдээ хялайж, зүүн нүдээ харж баруун гараа далайж, зүүн гараа атгаж, баруун хөлөө дээж өргөж, зүүн хөлөө жийж, дөчин таван дун цагаан шүдээ зуусаар төрөв, Эх нь “эвий эвий, яая би? Урьд үзэгдэвч гурвуул минь булт бурхадын хувилгаан төрж над эс баригдав. За нүгэлт хөвгүүн чөтгөрийн хувилгаан төрж над баригдав. Авай минь, чиний хүйг юугаар огтолном би?” гэж дэрэн дотроос хянгарыг авч хүйгий нь хөрөөдөв. Тэр хянгар хүйгий нь эс даав. “Эжий минь, энэ хянгар чинь миний хүйг үл даана. Гэрийн өмнө их далайн доторх ирмэгт хар чулууг авч огтол ” гэв. “Огтлохдоо ерөөл ерөө. Авай минь, чулуунаас бат амьтай болтугай гэж огтол. Хүйг минь цагаан өвсөөр боо. Авай минь, эзэлсэн улс чинь цагаан өвснөөс олон болтугай гэж боо” гэв.

Эх нь хормойдоо цуглан хүүхдээ аван гүйв. Их далай доторхи ирмэгт хар чулууг авч огтлов. Огтлохдоо мөн урьд үгээр огтлов. Хүйг нь цагаан өвсөөр боов. Боохдоо мөн урьд үгээр ерөөв. Гэсэрийг үзэгдэхэд баахан хүйтэн бороо орсон ажээ. Эх нь гэсэрийн хүйг огтлох гээд чигчий хуруугаа хөлдөөв. Энэ, нүгэлт, энэ чивэлт хүүхдийн хүйг огтлох гэж яваад чигчий хуруугаа хөлдөөв би гэж уйлав. “Эжий минь бүү хараа, бүү уйл Энэ хуруугаараа их далайд дүр, ямар болох нь вэ?” гэв. Эх нь хүүхдийн үгээр их далайд дүрэв. Хуруу нь урьдах мэт сайхан болов. Эх нь хүүхдээ авч очив. “Авай чамайг юунд өлгийднөм?” “Энэ гуунд өлгийдөө” гэж өргөв. Хүүхэд эхээс алдуулан унав. Бас эх нь өрөв. Хүүхэд эхээс унаад ноцолдон байж үг хэлэв: “Эжий минь, Баруун нүдээ хялаасан минь элээ шуламсыг тас хялайсан минь билээ. Зүүн нүдээ харсан минь энэ заяа, тэр заяа хоёрыг тэгш харсан минь билээ. Баруун гараа далайсан минь эсэргүүцэгч бүгдийг тас далайсан минь билээ. Зүүн гараа атгасан минь хамаг бүгдийг эзлэн барих минь билээ. Баруун хөлөө дээш өргөсөн минь шашныг мандуулах минь билээ. Зүүн хөлөө жийсэн минь тэр тэрс буруу номтныг доройтуулан гишгэсэн минь билээ. Дөчин таван дун цагаан шүдээ зуусаар төрсөн минь догшин шуламсын сүрийг тас залгисан минь буюу” гэж үг хэлэв. Эх нь: “эвий эвий, эвий эвий, хүүхэд төрвөл нэргүй хоёр хуруугаар хамраа бөглөж төрнөм билээ. Нүдээ аньсаар, шүдээ зуусаар төрөм билээ. Энэ яасан хортой хэлтэй хүүхэд төрж хэрэлдсээр, барилдсаар төрлөө” гэж хэрэлдэж байв.

Хэрэлдэж байтал Сэнлон ирэв. Нэгэн үе эм хүний дуу гарна, нэгэн үе барын дуу мэт гарна. Сэнлон өвгөн малаа тууж, арван огтоно үүрч, нэг гартаа есөн салаат төмөр үхрийг хөсрөөс олж чирж ирэв. “Энэ юув?” гэв. Амаржил хэлэв: “Ад муу хувхай хүлтгэр хишиггүй хүлтгэр! Чамайг би энэ өдөр миний дэргэд суу гэж эс хэллүү би? үүний урьд гурван хүүхэд хаагуур минь гарцгаав. Булт бурхадын хувилгаан төрж тэнгэр гарах нь тэнгэрт гарав, Лусын хаадад орох нь оров. Дагинаст гарах нь дагинаст гарав. Дээд тэнгэр гэж, доод лусын хаад гэж, арван зүгийн дагинас гэж хэн мэдлээ. Тэд бүгдийн тоогч мэдсэнгүй алдав. Ав одоо муу хүлтөгрийг. Чөтгөрийн хувилгаан хүүхэд төрж намайг барьж идье гэж ингэж байна” гэв. Өвгөн хэлэв. “Эвий, чи чөтгөрийн хувилгааныг яаж мэдэв? Дэмий тааж мэдэх бид бурхад буюу? Өөрийн үрсийг яаж алнам? Тэжээж үзье. Энэ өдөр би наян оготно алав. Энэ муу хоёр гурван мал минь булт боостов.” (Хээлтэй болов). Хэвэл нь газраас улам үргэлжилж явна. Язгуур гэрийн маань дэргэд оготно үгүй билээ. Годил харвах газарт оготно иржээ. Энэ өдөр хамаг газар цас орсон бөгөөд манай энэ муу гэрийн гадна годил харвах газар цас орсонгүй. Есөн салаат төмөр урхи үүнийг годил харвах газраас олов би. Энэ би? Төрснөөс ийм юм эс үзлээ би. Энэ тор буюу, урхи буюу? Энэ олж авчирсан юм минь энэ” гэв. Эх нь: “Чамайг яаж алах вэ? Тэжээж үзье” гэв.

Гэсэр, хэрээ, чөтгөр, оготно гурвыг алав.

Тэр цагт чөтгөрийн хар хэрээ нэг настай хүүхдийн нүдийг цохиж болгож алдаг байжээ. Гэсэрийг төрөв гэж сонсоод нүдийг нь цохъё гэж айсуй ажээ. Гэсэр түүнийг хувилгаанаар мэдэв. Нэг нүдээ хялааж, нэг нүдээ аньж, хялаасан нүдэн дээрээ есөн салаат төмөр урхийн шижимнээс татаад чөтгөрийн хар хэрээг бариад алж орхив.

Тэр цагт ямаан шидэт, нохой хоншоорт чөтгөр, Гүнгү эцэг Эргэслон (Гэлон) лам болон хувилж ирж, хоёр настай хүүхдийн толгой дээр авшиг тавигч болоод хэлийн үзүүрийг тас хазаж хэлгий болгох байсан ажээ. Түүнийг Гэсэр мэдэв. Тэр чөтгөр, Гэсэрт айсуйг Гэсэр мэдээд дөчин таван дун цагаан шүдээ зууж хэвтэв. Хүрч ирээд лам болж толгой дээр авшиг тавив. Хуруугаар шүдийг нь ухаж, соёогоороо бас шүдийг нь соёодож эс хүч хүрэв. “Энэ хүүхэд тань язгуур эх хэлтэй билүү, угаас ингэж зуурч төрж билүү” гэж асуув. “Уйлнам билээ бид эс мэдэв” гэв. Чөтгөр одоо хэлээ дүрж хөхүүлнэм. Хөхөгч болоод хэлийг багалзуураар нь тас хазаж алж орхив.

Гурван насандаа чивлийн оготно шар үхрийн чинээ болж газрын хөрсийг урвуулж, Монгол улст муу үйлдэж байсан ажээ. Гэсэр түүнийг мэдээд үхэр хариулагч өвгөн хүн болон сүх барин гүйв. Шар үхрийн чинээ оготно газрын хөрсийг урвуулж явтал өвгөн сүхээрээ үхрийн эвэр хоорондуур цохиод алж орхив. Дав дээр гурван догшныг алав.

Сэнлон баяжиж гэр бүлээ авчрав.

Түүний хойно хонь нь төрөв. Дун цагаан хурга гарав. Гүү нь төрөв. Билгийн хээр унага төрөв. Үхэр төрөв. Төмөр хөх хирс үхэр төрөв. Нохой төрөв. Төмөр хушуутай зэс өлөгчин төрөв.

Гэсэр тэд бүгддээ сан тавьж, огторгуй дахь Навса Хүрз эмэг эхдээ залбирав. “Эжий минь энэ бүгдийг минь сайхан тэжээж өсгө. Намайг хэзээ өг гэсэн цагт тэднийг өгөөрэй” гэв. Тэд бүгдийг нь Насва Хүрз эмэг эхдээ үзүүлж өгөв. Эх нь “Зөв” гээд авлаа. Сэнлон өвгөн, зовлонт эмээс төрсөн гэж нэрийг Жур гэж нэр өгөв. Жур хоёр гурван малаа хариулж явнам. Явахдаа гурван долоон хулс сугалаж авав. Гурван долоон харгана сугалж авав. Дэрсээр муу гүүгээ цохилгов. “Энэ гурван долоон дэрс минь цохих тусам дэрсэн цагаан адуу болцогоо” гэж цохилгов. Хулсаар муу үхрээ цохив. “Навч мэт сүүлтэй, хулсны үе мэт өнгөтэй ийм сайхан үхэр төрцгөө ” гэж цохив. Харганаар хамуут тэмээгээ цохив. Хувилгаанаар шившиж цохилсонд тэд бүгд булт төрнөм. Гагц гүүнээс дэрсэн цагаан адуу төрцгөөв. Мөн алиныг тоолном? Гэсэрийнхээ зарлигаар сар бүр дэд дэдээр төрөв. Гэсэрийн зарлигаар сар бүр төрөхөд тоолшгүй олон мал болов. Сэнлон өвгөн баяр нь танаггүй “Миний ерөөл буй за. Ганцын эх мянга гэгч энэ байнам” гэхэд нь Амаржин: “Үнэн биш юу вэ тэр чинь? Чиний ерөөлийг би хэдийн мэдсэн билээ. Адвиш ерөөлтэй биш үү, чи ” гэж хуурч зарлиг болгов.

Сэнлон, “Энэ малыг маань хэн хадгалнам?” гэж их улсдаа очив. Цотонд хүрч хэлэв: “Хүний үзэн ядаж хөөж орхисон үзэсгэлэнт сайхан эмээс чинь нэг муу хөвгүүн төрж байна. Муу гэж байлгана уу? Сайн гэж хаан орон суулгана уу? Муу ч болов суулгах жишээтэй л болов. Эм, хүүхэнд, гэр малыг минь над өг” гэв. Бүгд улс “Сэнлон өвгөнийх зөв биш үү” гээд эм, хүүхэд, тэд бүгдийг нь булт өгөв. Сэнлон өвгөн тэндээ авч харьж ирэв.

(Нөгөө эмээс Цас (Фаца Шалгар), Ронса нэрт хоёр хөвгүүн ажээ) Цас, Ронса, Жур гурвуул энэ малыг минь хариул” гэв. Гурван хүүхэд мал хариулж явна. Жур холын уулыг ойр болгож, ойрын уулыг хол болгож, малыг хувилгаанаар адуулж явна.

Жур эцэгтээ хэлэв: “Миний ерөөл буй за гэж, малаа өсгөв гэж баярлах чинь юу билээ? Одоо орд цагаан гэрийг үл барих чинь юув” гэж явав. Модонд хүрч бүгдээрээ мод огтолж явав. Өвгөн шудрага модыг огтолж нэг хэдийг унагав. Жур хувилгаанаар ханыг ханаар, унийг униар босгоцгоов. Сэнлон өвгөн сайхан шудрага мод үзэж огтолье гэж очивч Жур хувилгаанаар өргөст мод болгоно. Өвгөн огтолж ядаж гараа эсгэж ирэв. “Нүгэлт муу хөвгүүн очиж билээ. Шудрага сайхан мод гэж огтолье гэтэл өргөст мод болно. Гараа эсгэж санд мэнд харьж ирэв би” гэв. Жур орд цагаан гэрийнхээ модыг авч ирэв. “Ахай минь, огтолсон модоо юу гэж орхиж ирэв чи? Чиний орхисон модыг би авч гэр хийж ирэв би” гэв. “Үнэн. Би мод огтолж билээ. Огтолсон модоо газар эндэж гээгч билээ би. Энэ муу хулгай хийж авсан ажээ” гэв. “Ахайн минь үг үнэн. Чиний огтолсон модноос хулгай хийж авсан мод чинь тэнд хоёр гурван гэрийн мод байна.” гэв. “Чи юу огтолж явнам?” “Би хүч үл хүрэхдээ чиний огтолсон модоор гэр хийв би” гэв. Тэр гэрээ бүрхүүлэв.

Гурван хүүхэд малд очив. Сэнлон Ронсагийн эхийг дотночлон явнам. Цас Чихэр, Ронса хоёрт ширээн дээр тавьж өгөв. Журд нохойн идэх муу аяганд хийж өгнө. Жур гурван атга цагаан чулуу гурван атга хар чулуу авав. Цагаан чулуугаа хадны дээр дэлгэж тавина. Олон мал өөрсдөө бэлчиж очно. Харихдаа хар чулуугаар хавтгандаа хийгээд ирнэ. Олон мал хойноос нь өөрсдөө дагаж ирнэ. Маргааш өглөөгүүр гурвуул бас малд явав. Малынхаа дэргэд суугаад ярив. Жур хоёр ахдаа үг хэлэв: “Бид ийм олон мал хариулж явж өдөр бүр хоосон явмой. Нэгэн тугал алж идье” гэхэд Ронса хэлэв: “Эцэг эх маань биднийг донгодмой” гэв. Цас Чихэр дуугүй суув. “Донгодох юмыг би даая. Цас Чихэр минь нэг тугал барь” гэв. Цас нэг тугал барив. Жур алав. Арьсыг битүү туламлан өвчив. Махыг идээд ясыг тулам дотор хийгээд сүүлээс нь барьж гурван үе далалваас амьд тугал болон олон тугалын хойноос гүйв. Малаа авч харьж ирэв. Гурван хүүхэд гэртээ оров. Цас, Ронса хоёр босож байв. Жур зүүнтэй тавьсан идээнээс идэж суув. Эх нь хэлэв: “Жур юунд идээгээ идэв? Та хоёр юунд үл идэх буй?” гэв. Ронс хэлэв: “Жур дүү маань маньд нэг тугал алж өгч, түүний махыг идэж цадав. Идэхгүй” гэв. Сэнлон өвгөн: “Ээ! Жур тэр чинь үнэн үү?” гэж асуув. “Худал хэлнэм. үгүй” гэв. Өвгөн ташуур барьж босон харайв. Журыг ташуураар савна. Савахад нь Жур ташуур дээрээс нь ноцон хэрэлдэж байв. Байтал Амаржил гүйж ирэв. “Юу болов? Өвгөн!” гэв. “Энэ муу чөтгөр хүүхэд чинь нэг тугал барьж алж идэв гэнэ. Ийм нүгэлт ажээ” гэж уураа даран ядаж байв. Амаржил хэлэв: “Барсан муу, тэнэсэн муу хүлгөр! Чиний тугал тоогүй буюу? Тугалаа бүртгэв” гэв. “Чам мууд юуны ийм олон мал билээ? Үнэн идсэн ч гэсэн ганц тугалын төлөө үүнийг минь жанчих чинь юув? Биеийнхээ сайнаар өсгөсөн мал мэт санаж байна чи” гэж донгодов. Өвгөн гүйж тугалаа бүртгэв. Тугал нь бүрэн ажээ. Өвгөн гэртээ гүйж очив. Ронсыг “Яасан худалч билээ?” гэж донгодов. “Үүний хойно чи худал хэлэв зээ. Би чамайг үхтэл гөвшинө” гэв.

Маргааш өглөө гурван хүүхэд бас малаа авч очив. Жур нэг тугал алав. Ронс сүүлний ясыг нь хулгайлж өвөртлөв. Урьд ёсоор махыг авч идээд ясыг тулмын дотор хийв. Мөн гурван үе даллаваас оготор тугал болон олон тугалын хойноос мөрөөр нь гүйж очив. Малаа авч гэртээ ирэв гурвуул. Ронса хэлэв: “Жур дүүгийнхээ алж өгсөн тугалын сүүлийг идье” гэж өврөөсөө цустай сүүл гаргаж галд булж суув. Өвгөн “Ронса! Энэ чинь юув?” гэв. “Жур дүү минь маньд нэг тугал алж өгч, түүний дээрээс нь аван ноцолдов” “Энэ их зөнтөг (зөнөг) болох нь энэ үү? Энэ намайг давхийвэл жанчъя гэж над тэмүүлнэ” гэв. Журын эх нь гүйж ирэв. “Юун нүгэлт хүлтгэр, яав?” гэв. “Нэг тугал алж гэж Ронса сүүлний цустайг шарж сууна. Үнэн буюу? Худал буюу?” гэв. Журын эх нь хэлэв: “Чи энэ хөвгүүнийхээ үгээр юунд ингэж жанчнам? Тугалаа бүртгэж үзээсэй” гэв. Өвгөн тугалаа бүртгэв. Олон тугал бүрэн ажээ. Нэг тугалын сүүлнээс цус гарч явна. “Сүүлий нь огтолсон байна” гэж өвгөн гэртээ гүйж ирээд Ронсыг гөвшив. “Чи тэр бармыг юу гэж гүжирднэм?” Бутач ирээд хотчийг хорино гэгч энэ байна гэв.

Заяатай худал хэлэгдэхээр үнэнээр хэлэгдэе би. Заяатай маргааш чиний малаас олныг алж идье би (гэж Жур хэлэв. Гурвуул малд явав. Жур хойноос нь есөн эрэг алж их тогоо хувилгаанаар хурааж Ронсаг сүрээр дарж тэр махыг бүгдийг болгов. Махаа гаргаад сан тавьж, хамаг бүгдийг сахиусандаа зальбарнам: “Дээр Хурмаст тэнгэр ахай минь, дэд нь болбол Эсруа аймагт арван долоон тэнгэр нар, дэргэдэх гучин гурван тэнгэр нар, Навса Хүрээ эмэг эх гурван зуун жаран өөр хэлтэн амьтан сахиус минь, Мо гүүш, Данбо нэрт төлөгч минь, Уулсын хаан Овоо Гүнжид алтан дэлхийн хувилгаан эцэг минь, ялгуусан гурван өхий минь,

дээд арван зүгийн бурхан сахиус минь, доод дөрвөн их Лусын хаад минь, Та та бүгддээ муу биеэ үзүүлэх минь энэ. Ариун тахил тахиж наманчлах минь энэ буй ” гэв.

Хамаг сахиус нь : “Нусгай минь алтан дэлхийд төрж байна. Хамарт мань сайхан үнэр үнэртэж байна. Төрж маньд бэлгэ үзүүлэх нь энэ байна гэв.

Тэд бүгдээрээ залбираад Цас, Ронса хоёрын өмнө их ширээн дээр идээ тавьж өгөв.

Цас чадах чинээгээрээ идэж сууна. Ронса Гэсэрийн сүрд дарагдаж үл идэж сууна. Жур сахиусаа хурааж олон хүн болгоод бүгд идэж орхив. Ронса босоод гэрээ тэмцэв. Цас, Жур хоёул малдаа очив. Ронса эцэг эхдээ хэлэв. “Жур хөвгүүн чинь есөн эрэг хага татаж алав. Олон тогоо хурааж ирж бүгдийг чанав. Махаа болгож гаргасан хойноо дэмий дээр тэнгэр гэнэ, доор лусын хаад гэнэ, дэмий бурхад гэнэ, юу юу хэлэв, дэмий олон юм хэлнэ билээ. Би эс мэднэ. Цас бид хоёрт мах чанаж өгөв. Харан хониныхоо тулд гомдож эс идэв би. Хамаг мал хашаа очсоныг ч эс мэднэ. Махаа идэхдээ дэмий явдлын буюу олон хүн ирэв. Дэмий “Буу, буу” гэж угтан гүйж морийг нь авцгаана. Тэд бүгдээрээ хуримынхаа махыг бултыг идэж орхив” Ронса энэ үгийг өвгөнд хэлэв.

Өвгөн “Ийм нүгэл ажээ, ийм чивэл ажээ гэж ташуураа барин малдаа гарав. Дээр гарч өвгөн саравчилж харваас Жур дэргэдээ олон мал тууж явах ажээ. Өвгөний нүдийг хувилгаанаар халхалж бие малаа эс үзүүлэв. Өвгөн гэртээ гүйж харьж ирэв. “Үсэд бараагүй (огт харагдахгүй байна). Халаг хуухай. Жур гэгч чамайг дээ” гэж занаж сууна. Занаж суутал Жур олон малаа түрхэртэл тууж, дуулж элдэж ирэв. “За чи малаа бүрэн тууж ирэвүү ? Чамайг мэдлээ би” гээд ташуур барин угтан гарав. Журьыг ташуураар савна. Савтал ташуурыг нь булаан авч хаяж орхив. Өвгөн Журьыг ноцов. Жур унагч болоод “Ёо халхай” гээд өвгөнийг дээгүүрээ хаяж орхив. Өвгөн “Ёо ёо” гэж бархирна. Жур ч болов “Ёо халгай” гэв. Амаржил гүйж ирнэ. “Өвгөн, яав яав?” гэнэ .”Хөвгүүн төрж гэж санаж билээ. Чиний хэлсэн үг үнэн байсан аж. Есөн эрэг хага татаж алж идэв гэнэ. Энэ намайг жанчих гээд харин толгой дэгүүрээ хэт хаяж орхив. Бие минь эвдэр үү яав ? Адвиш өвднөм” гэв. “Эвдэрвэл эвдрэг. Ронса урьд тугал лав гэн гэн ирлээ. Тэр нь үнэн байл уу? Одоо есөн эрэг алав гэнэ. Биеийг чинь хаясан ч үнэн биз. Иргээ бүртгэж одоо үз” гэв. Өвгөн очиж иргээ бүртгэв. Ирэг нь бүрэн ажээ. Өвгөн ирэв: “Халаг хуухай, Ронса яалаа чи?” гэж өвгөн гаслав. Амаржил хэлэв: “Авай Жур яалаа чи? Гэр хийсэн хүн, хойно суув гэлээ. Гишүү огтолсон хүн, урьд явав гэлээ. Чамайг Ронса алья гэж байна. Одоо Ронсаг хов үг хэлж ирвэл Ронсын үгээр өвгөн жанчъя гэж очвол хуу (цөм) тоолж өг” гэж Амаржил хэлэв. “Чиний мууг аль бүр үзэх вэ би?” гэв.

Жур Ронсыг донгодов: “Чиний урьд, ганцаараа олон мал ч өсгөлөө би. Ганцаараа ч болов дуугүй хариулж явлаа би. Өдөр бүр алж идвэл би энэ малыг яаж өсгөх билээ ? Чи над өших чинь юу билээ ? Худал хэлэн хэлэн хэрэлдүүлэх чинь юу вэ ? ” гэж донгодов. Ронса дуун эс гарав. Цас Чихэр инээв. Өвгөн: “Эвий эвий, их үнэн биш юув? Чамайг үүний хойно хэлбэл гөвших буй” гэв.

Маргааш өглөөгүүр өвгөн дотроо санав. “Та гурав миний шийдээр явж чадахгүй байна. Малд одоо би очилцоно” гэж Цасыг аван малаа тууж явав. Тэр өдөр дуугүй хариулж үдэш өвгөн,

Цас хоёр малаа тууж ирэв. Түүний маргааш өвгөн Ронсыг авч явав. Хоёул мала хариулж явсаар гурван хонийг чононд бариулж идүүлэв. Үдэш ирэв. “Би мал хариулж билээ. Энэ муу Ронса хонийг хариулж явсаар гурван хонь чононд бариулж идүүлэв” гэж хэлэв. Жур хэлэв: “Намайг бол жанчих байсан. Мундаж (аз болж) намайг эс аваачсан зөв болж ” гээд суув.

Өвгөн маргааш өглөөгүүр Журьыг аван малаа тууж гарав. Жур холын уулыг ойр болгож ойрын уулыг хол болгож явав. Хонины захад очъё гэтэл чоно гүйж явна. “Ахай минь энэ чоно гүйж явахыг мэдэв үү?” гэв. Өвгөн хэлэв: “Юу мэдэх вэ? Хонь гэтэж явнам за” гэв. “За ахай чи энэ чоныг харваж оно. Оновол чи нэг эрэг авч алж махыг над бүү өгөлц. Чи бултыг ид. Чамайг алдвал би харвая. Би оновол би нэг эрэг алж махыг би идсүү. Чамд бүү өгөлцье би” гэв. Өвгөн “За” гэв. Өвгөн чоныг харвав. Эс хүргэв. “Ахай минь одоо хишиг над биш үү?” гэв. Өвгөн “үнэн буй” гэв. Жур харвав. Сум нь онов. “Ахай чи өвгөн хүн, дулаан бүслүүр (бэлхэмж) хий “ гэж (чонын арьсыг) өгөв.

Жур одоо өвгөнийг хувилгааны сүрээр дарав. Есөн хонь алав. Олон тугал хурааж хонийг барилж явахад өвгөн: “Халай Жур” гэж дуугарах гэв. Дуун гарч үл чаднам. “Ээ! яалаа” гэж босох гэв. Өндийгөөд босож үл чаднам. Өвгөн дуун үгүй харж суунам одоо. Хонины махыг Жур гаргав. Мөн бас олон сахиусаа хурааж өвгөнд олон хүн болж, ширээ өргөж аваачиж тавьж өгөв. Өвгөн Гэсэрийн сүрд дарагдаж идэж үл чадна. Хоёул одоо босов. Өвгөн босож гэрээ тэмцэж гүйв. Жур малд очив. Өвгөн гэртээ очиж эмдээ хэлж гашуудав. “Авай яая, ийе. Би үзлээ. Ронсыг хэлдэг үг эгээ үнэн байна. Есөн эрэг алав. Махыг Жур ганцаар тас идэж орхив. Амаржил! Чиний чөтгөр гэж хэлэгч чинь үнэн байна. Муус буюу, мангас буюу энэ? Энэ малыг барсан хойно мань биеийг барьж идэх байна энэ”. Өвгөн чингэж гашуудаж суунам. Жур олон малаа тууж элдэж ирэв. Өвгөн ташуураа барин гарч байв: “Авай Жур”. Ташуураар цохилтол нь ноцов. “Өвгөөн! Яав, юу вэ ? ” гэв., “Өнөө чи яасан олон хонь хага татав чи ?” гэв. “Явья. Чи бид хоёулаа энд учраа ололцохгүй . Цасад заалдъя” гэхэд “За ” гэж Жур бид хоёул хонинд очим гэхүл хонины захад чоно гүйж явна. Энэ муу хүү над хэлэв. “Ахай, энэ чинь чоно гүйж явахыг мэдэв үү чи? ” гэв. Чингэхэд “Хонь идье гэж явнам за” гэв би. “Ахай бид хоёул мэлзээ хийе” гэв. Чингэхэд “Гайгүй, юу билээ ?” гэв би. “Энэ чоныг харваж оно . Оновол хонь алж махыг над бүү ам хүргэ Чи ганцаар алж махыг ид ” гэв. Чингэхэд “За” гэв. ”Чамайг алдвал би харвая. Хэрвээ би оновол мөн урьд ёсоор идье би” гэв. “За” гэж хоёул харвав Өвгөн хүн би эс хүргэв Жур харваж алав .”Жур, өвгөн хоёул мөн урьд хонь идсэнийг тоолж хэлэв Цас хэлэв: “Өчигдөр Ронса та хоёул малд очоод гурван хонь чононд бариулж идүүлэв гэнэ билээ. Мэлзэж харваад урьд идсэнээ юу гэж заалднам. Ахай чинийх буруу. Өвгөн хүн дуугүй яв” гэв. “Энэ хүүхдийн минь зан ааш нь өөр байна” гээд явав.

Маргааш бас Журьыг аван малд очив. Адуу үхрийн захад шаазгай модны дээр сууж байв. Үнэг үхрийн дэргэдүүр гүйж явна. Жур хэлэв: “Ахай чи мэдэв үү? Үнэг шаазгай хоёр юуны төлөө ингэж малын дэргэд явна?” гэв. Өвгөн: “Эс мэдэв? ” гэв. “Шаазгай морины даарь цохъё гэж явна биш үү, түүнээс улам морины нугасанд орж үхэх биш үү. Энэ хоёулыг чи бид хоёр харваж алья. Бидний хэн албал нэг үхэр, нэг морь алж идье. Нэг нэгэндээ ам бүү хүргэе” гэхэд өвгөн “За” гэв. Шаазгайг харвав. Өвгөн эс хүргэв. “Ахай минь үнэг мөн энэ байна .Харва” гэв. Өвгөн ойрхон байна гэж баярлан нумаа дэлэв. Жур хувилгаанаар нумыг эс

даалгав. “Ээ! Яалаа би ?” гэж өвгөн нумаа ярвайж татна. Үл даанам, “ахай, үтэр” гэв. Өвгөн цочиж харвав. Эс хүрэв. Жур шаазгай үнэг хоёрыг харваад алав. Үнэгийг өвгөнд өгөв. Жур адуунаас нэг тарган гүү сонгож алав. Үхэрээс нэг тарган үхрийг сонгож алав. Өвгөн бас “Халаг ” гэж хэлье гэвч хэлж үл чаднам. Жур махаа болгов. Өвгөнд бас ширээн дээр аваачиж өгөв. Өвгөн идэж үл чаднам. Жур хувилгаанаар бултыг идэв. Жур одоо дуулж сууна: “Морины дарт цохёо гээд шаазгай, үхрийг хордуулья гээд үнэг, тэр хоёрыг харваж алья гээд өвгөн -Энэ гурвуулаанд өөр нэн ичгүүрт юм буй боловуу?” гэж дуулав. Өвгөн босож гэрээ тэмцэж гүйв. Эмдээ хэлэв: “Одоо би түүнтэй ханилахгүй. Малыг минь булт идээд хойно намайг идэх байна. Энэ аалиар чөтгөр ч биш мангас л буй за энэ” гэв.

Сэнлон гурван хүүхдээ шалгав .

"Энэ гурван хүүхдийн нэгтээ нь л би байя . (Энэ гурван хөвгүүдийн сайн мууг үзье) “ гэж ятуу урхидаж барив. Тулманд хийж амсры нь боов. Өвгөн хайнаг үхрээ унаж Цасыг сундалж аваачив. (Өвгөн сэмээр хавтаганы амсрыг нээв) Ятууг дүрхрэхэд үхэр туйлж орхив. Өвгөн үхэгч болж хэвтэнэ. Цас үйлна : “Ахай минь нэг гэвэл авыг тавиулах билээ. үгүй гэвэл аяныг таниулах билээ. Эвий яалаа! гэж уйлаад ирэв. Өвгөн үхрээ унаад харьж иржээ .

Маргааш босоод Ронсаг бас сундалж аваачив. Урьд ёсоор үхэр туйлж орхив. Өвгөн үхэгч болж хэвтнэм. Ронса уйлаад харьж ирэв. Өвгөн үхрээ унаад харьж ирэв.

Маргааш босоод Журьг бас сундалж аваачив. Явж байтал нэг хятад тариа тарьж явна. Тарианы захад бай мод босгож, модон дээр нь шаазгай сууж байв. Урьд ёсоор ятуу дүрхрэх, шаазгай нисэхэд үхэр туйлж орхив. Өвгөн үхэгч болж хэвтэнэ. Жур буун гүйж үхрээ барьж их дуу гарч уйлагч болов. Уйлаад хэлэв: “Намайг уйлав гэж энэ уул сургав уу? Уулын дэргэдэх мод сургав уу? Энэ хорт хятад тариа эс тарьж, тарианы захад байх мод эс босговол шаазгай юу гэж суугаад босох билээ ? Үхэр юу гэж туйлах билээ? Өвгөн минь юу гэж үхэх билээ ? Энэ хятадыг эрүүлсүү (шийтгэе) би” гэж очив. Жур урьд үгээ хятадад тоолж хэлэв. “Одоо чи үхсэн хүнээ амьд хүнээр төлүүлж авья гэнэ үү чи ?” гэж хятад үл анхаарав. Жур ирж хятадын тариаг тас эвдэж явна. Хятад тариандаа хорсож гүйж ирэв. “Чи ямар зарлиг болном, чиний зарлигаар чинь болном, чиний зарлигаар чинь больё би. Тариаг минь бүү эвд чи ” гэв. “Чамаа ял янх өг гэхийг байя. Энэ уулын модыг хадаж авчир. Эцгийнхээ ясыг дэгдээе би.” гэв. Хятад явав. Уулын модыг хадаж авчирч өгөв. Жур эцгийнхээ гадуур мод хураав. Их түймэр шатаав. Гал дүрэлзэн шатахад өвгөн хялааж харав. “Ахай минь үхсэн хүн харсаар үхвэл хойд амьд үрдээ муу ёр гэлээ” гэж эцгийнхээ нүдэнд шороо битүүлэн хаяв. Гал бас дүрэлзэн шатахад өвгөн хоёр хөлөө атирав. “Үхсэн хүн хоёр хөлөө атирсаар үхвэл үлдсэн эм хүүхний үе нь үл сунам гэлээ” гэж аврага мод үүрч ирж эцгийнхээ хоёр хөл дээр тавив. Эцгээ одоо галд өргөж аваачив. Аваачиж галд орхино гэхэд “Жур! Ахай чинь үхсэнгүй амьд байна” гэв. “Ахай минь, үхсэн хүн дуу гарвал хойд үрдээ муу ёр гэлээ” гэж галд орхино. “Авай (Жур) минь! Ахай чинь үхсэнгүй гэж байтал амьдаар нь алдаг буюу ?” гэв. “Ахай минь үхсэнгүй байна, сайн” гээд үхэрт нь дүүрч харьж ирэв. Өвгөн гэртээ ирээд эмгэндээ хэлэв: “Гурван хүүхэдтэйгээ малд явж билээ, гурван хүүхдийнхээ сайн муугийг нь тэнсье гэж явж билээ. Цас минь баатар сайн хүн болох байнам. Ронса минь зөөлөн (зөөвөрлөн) идэх хүн болох байна. Удаа нь хэлэхэд Журд минь үл хүрэх байна.

(Жур минь хэнээс ч илүү сайн эр болох байна!) гэв. Чингээд өвгөн гарч одов.

Эмгэн (Ронсагийн эх) муу санав: “Орхидос эмээс төрсөн хөвгүүн миний хоёр хүүхдээс илүү болох гээч юу вэ? үүнийг үтэр үгүй болгоё би” гэж ширээн дээр хоёр хүүхэддээ сайхан идээ хийж тавив. Журд ондоо хор хийж тавив. Гурван хүүхэд үдэш ирэв. Цас Ронса хоёр ширээн дээрээ гарч идээгээ идэж сууна. Жур зүүн тийш харж байна. Эх нь хэлэв: “Авай Жур! Юу гэж харж байна? Ширээн дээр гарч идээгээ ид” гэв. Жур гүйж гарав. Аягатай идээг аваад барьж сууж үг хэлэв: “Эжий ахай минь, манд урьд аяганы өмч хадгалж өгч бүлгээ. Эн өдрөөс малын өмч хагалж өгөх байна даа. Хоёр ах минь идэв. Эцэг эхдээ дээжээ эс барина. Эцэг нь эс мэдсэнээсээ авч идье гэтэл бас татаж авав. “Хэзээнээс эцэг эхийн гэр болохын эх тогоо энэ

билээ” гэж тогоонд хийв. Тогоо хагарав. Тулганд дусаав. Тулга хагарав. Тоононд дээш цацав. Тооно нь хэмхрэв. “Гэр болохын (урьд учирсан) шар нохой билээ” гэж нохойн толгой хоёр анги салав. Үлдсэнийг өөрөө зооглож, улаараа нэвчүүлж лусын хаад дахь эгчдээ тахил өгөв.

Цотон Журыг эхтэй нь хөөв.

Сэнлон өвгөн эх улсдаа нүүж очив. Олон улсынхаа захад буув. Цотон ноён авлаж явсаар үзэв. “Ээ! ийм сайхан цагаан гэр хэнийх вэ? Энгүй олон мал хэнийх вэ? Асууж ир” гэж хүн илгээв. “Сэнлон өвгөнийх” гэж ирэв. Цотон ноён бүгдээрээ гэрт нь ирэв. “Ээ! ийм олон мал, орд цагаан гэр хэн өгөв?” гэж асуув. Жур дэргэд нь ирээд хэлэв: “Төмрөө үл мэдэх хуурай билүү чи? Төрснөө үл мэдэх нохой билүү чи? Чамайг ахыгаа хөөж орхисонд дээр тэнгэр, доор лусын хаад бүгдээр өршөөж өгсөн гэр мал байна” гэв. Тэд “Энэ мууг үз” гэв.

(Нэгэн цагт Цотон ноён тэргүүлэн Дос, Донсар, Лин гурван отог улсыг хураагаад их чуулган хийж суув) Цотон ноён өгүүлрүүн: “Долоон албин долоон зуун хүн, долоон зуун морь, заяатай, заяагүйг (аль тохиолдсоноо) барьж иднэ гэнэ. (Бидэнд харьяат улсыг идэж барах байнам. Тэр долоон албинд сар бүр хошоод хүн өгье. Нэгэн өдөр зуун хүн морь идэхийг байг гэж хэлж илгээ) гэв. Тэр олон лус нь Цотон ноёны үгээс үл давахын тулд “Тийм бол зөв байна. Чи мэдэх биз” гэв. Тэндээс Цотон ноён өгүүлрүүн : “Ноён ч болов, харц хүн ч болов, ер бүгдээрээ жишиглэж тэр долоон албинд идэш өгье. Бид ноёд ахлаж очье”. Жур эх хоёулыг хишиглэж (ээлжид) өгье. Энэ өдөр та хоёр оч. Долоон албин барьж идтүгэй. Хойд өдөр биш хүн өгье ” гэв. Жур “За” гэж инээв. Эх нь “авай минь, яая, чи юу гэж инээнэм? Би чамайг байлгасан боломжтой сайн хөвгүүн төрөв үү гэж билээ. Барсан муу хөвгүүн төрсөн байна. Долоон албин гэгч өдрийн долоон зун хүн, долоон зуун морь барьж иднэм гэнэ бишүү. Чи би хоёрыг барьж идтүгэй гэж оч гэнэм биш үү” гэв. “Эжий минь дуу” гэв. “Эм хүн чи үл мэднэм. Энд суувал Цотон авгай ална. Тэнд очвол долоон албин идэх ёсон нь адил буюу” гэв. Дөрвөн насандаа данхар Донхор хоёр хайнаг үхэрт хэлтгий хар цачраа ачиж Болжморын хоолойг өөдөлж явав. Болжморын хоолойн эхэнд хүрч буув. Хэлтгий хар цачраа барив.

Жур долоон албиныг алав.

Жур эхдээ гал цахиж өгөөд гөрөөлөхөөр явав. Жур хоёр долоон оготно алж идэв. Нэг долоон оготныг шарав. Нэг долоог чанав. Үдэш суутал долоон албин өмнөө хүн бөгтөрч, хойноо зуун морь бөгтөрч ирэв. Жур угтаж гарав. “ээ! Арван зүгийн эзэн Гэсэр мэргэн хаан юунд гарав чи? Бид айж үхэх биш үү?” гэв. Жух өгүүлрүүн : “Таны хуурахыг би мэдэв. Та өдрийн долоон зуун хүн, долоон зуун морь, заяатай заяагүйг барьж иднэм гэж Цотон авгай намайг идтүгэй гэж илгээв. Хойд өдөр биш хүнийг өгье гэнэ” гэв. “Арван зүгийн эзэн ачит Гэсэр Мэргэн хаан, энэ зарлиг чинь юу вэ? Бид айж үхнэ” гэв. “За та намайг үл идэх болбол миний муу гэрт бууж цай шөл зооглож морд” гэв. Долоон албин мордов. Жур хэлэв: “Би танд нэгэн бэлгээ үзүүлье. Та нар долоон хөл морио над өг” гэв. “Ээ! долоон хөл морио өгвөл бид юу уная” гэж өвөр хоорондоо зөвшин хэлэлцэв. Жур хэлнэ: “Энэ миний долоон цагаан модыг унаж од. Уулыг огтол гэ. Галыг тасал гэ. Хадыг хамх дайр гэ. Бутыг булга дайр гэ. Далайг тасал гэж уралдаж яв” гэв. “Таны долоон хөл мориноос нэн сайн морь болмой за энэ минь” гэв. Долоон албин”За” гэж бууж гүйж, баярлаж ирж унан явав. Явахдаа уулыг огтол гэв. Мөн Гэсэрийн хэлсэн үгээр уралдаж явав. “Өчнөөн бид хурдан морьтой болсон байна. Далайд нэн сайн гэлээ. Далайд орвол сайн гэж билээ” гэж уралдаж оров. Долоон албин далайн ёроолд унаж үхэв. Долоон цагаан мод эзэндээ харьж ирэв. Долоон албиныг Гэсэр хувилгаанаар алав. Долоон хөл морийг авав.

Долоон зуун хүнийг шашинд оруулав

Тэр цагт сартагчин аягачин, булаагчин гурван зуун хар иргэн Журын гэрийн ойр эм, хүүхэдтэй авлаж ирэв. Жур түүнийг хувилгаанаар мэдээд нэгэн хувилгаанаа алтан хэнхдэгтэй, мөнгөн бөгстэй, дун цагаан хумстай хүрнэ болгон наадаж гайхуулж угтан хүрэв. Тэр гурван зуун иргэн авлахаа байж хүрнийг үзэж гайхалдаж харж байв. Наран шингэхэд Жур хүрнийгээ авахаар харьж ирэв. Гурван зуун иргэн тэнд хонов. Үдэш нэг хүн ирж хэлэв. “Манай нэг баахан авхай билээ. Хүрнээ өгөөч, наадуулаад өгье” гэв. “Хүрнийг минь алдвал гурван зуун агтаа өгөх буюу та?” гэв. “Өгье” гэв. “Чи сайдаасаа асууж хэлэх хүн буюу чи? Санаагаар хэлэх хүн буюу чи? Очиж асууж ир” гэв. Тэр хүн асууж ирэв. “Өгье гээд авч ир” гэв. Тэр хүн бас ирэв. “Хүрнийг чинь алдвал агт өгье гэнэ” гэв. “Хүрний минь алдуузай. Хичээ” гэв. “Тэр хүрнээр хүүхэд нь нар шингэх цаг болтол наадаад тогооны дор хөмөрч тавив. Хүрнэ нь газар ухаад эзэндээ шөнө харьж ирэв. Жур маргааш өглөөгүүр босон очив. “Хүрнийг минь өг” гэв. Тогоогоо татаж үзвээс хүрнэ үгүй. “Хүрнэ чинь газар хөндийлж гарч явсан байна” гэв. “Хүрнэ угаасаа дээр тэнгэрээс буудаггүй, газраар явдгийг мэдсээр байж намайг шоглож өгөхгүй байна. Мэлзээний ёсоор гурван зуун агтыг өг” гэв. “Манай гурван зуун агтыг авах эрийн эр чи мөн байна” гээд (дутааж хавцал замаар нүүв) Жур хойноос нь явган дагав. Хоёр их өндөр уулын хооронд орж явгал Жур наад өндөр уулын оргил дээр гүйж гарав. Нэг их хадыг огло татаж авав. Тэр хадаар цаад уулын оргилыг цохив. Цаад өндөр уулыг өргөж хөдөлгөхөд наад уул бас хөдлөв. Хоёр уулыг өргөж хөдөлгөж байхад тэр уулын чулуу доор гурван зуун хүний морь биеийг цохиж байв. Наашаа Журын зүг дутаавал бас мөн урьд ёсоор унагаж байв. “За, хайрхан богд, алахын муугаар алах нь, Чи ямар зарлиг болгоном? Чиний зарлигаар больё бид” гэв. “Над зарлиггүй биш үү. Хүрнийг минь өг” гэв. “Хүрнэ чинь үгүй болжээ. Чиний зарлигаар больё” гэв. Миний зарлигаар болох болбол сахал үсээ ав. Ном шашинд ор. Бацаг сахил ав гэв. Эр эмгүй булт ирж сахал үсээ бүгд авав. Тэднийг ном шашинд оруулаад гурван зуун агтыг аваад харьж ирэв, Гэсэр.

Цас Журьыг эргэж очив.

Жур хэлтгий хар цачрынхаа гадна долоон албины хөл морь, гурван зуун хал улсын хөл морь, тэр олон агтаа гаднаа зогсоож байв. Цас Чихэр ах нь уйлав: “Нусгай Журьыг минь Цотон ноён нүд муулж долоон албинд барьж идтүгэй гэж илгээлээ. Долоон албин барьж идэвүү ? Идсэн бол долоон албинтай тэмцэж үхье би. Амьд болбол дүүдээ золгоё би” гэж жигүүрт бор морио унав. Цавдат(ялтсан?) хуягаа өмсөв. Дуурсахуй нэрт дуулгаа эрдэнэт тэргүүндээ өмсөв. Гучин цагаан сумаа дүрэв. Догшин хар нумаа барив. Хүрмэй нэрт цод (цас?) болд илдээ зүүв. Болморын хоолойг өгсөж явав. Болморын хоолойн эхэнд олон адуу байхыг үзэв. Жигүүрт бор морио нууж уяв. Хүрмэй нэрт цул болд илдээ суга татав. Сэмхнээр цөм цөм гэж гүйж шагайж ирэв. Үзтэл нусгай Жур гэртээ хөлөрч дээлээ тайлж сууна. Цас Чихэр сэлмээ дүрэв. Гүйж оров. “Эвий! Цас минь” гэж босон гүйн тэврэлцэн уйлалдав. Гэсэр, Цас хоёулыг уйлж байхад алтан дэлхий бүгд догдлон хөдлөв. “Цас минь намайг үхсэн байвал долоон албинтай алалдая гэж ирсэн чинь энэ байна. Амьд болбол надад золгоё гэж ирсэн чинь энэ байна. Баатрын чинь бэлэг(шинж) энэ байна. Авай минь! дуу” гэж алтан дэлхийг сан тавьж номхотгов.

“Авай минь! Би чинь нусгай Жур биш буй. Арван зүгийн эзэн ачит Гэсэр мэргэн хаан би мөн. Үүнийг минь хүнд бүү хэл авай минь! Арван таван насандаа хүртэл хамаг догшдыг Жур биеэр явж номхотгох болно би. Тэр дээр Гэсэр биеэ үзүүлж таныгаа дагуулах буй би” гэв. Цас Чихэр инээв. (Жур хэлэв:”Чи урьд харь. Би хойноос чинь очъё. Энэ гурван зуун агтыг минь тэр муу эцэгт минь аваачиж өг. Энэ долоон морийг чи ав. Авай минь, би харив. Цотон ноён угтаж асуув. “Цас чи энэ олон агт хэнээс авав чи?” гэж асуув. “Журьыг долоон албин барьж идлээ. Би долоон албиныг алж, агтыг авч ирэв.” гэв. “Тэр муу үхвэл үхтүгэй. Чи минь л мэнд ирсэн сайн” гээд явав. Эцэгтээ гурван зуун агт өгөв. “За надаас өөргүй байна. Энэ хүүхэд минь” гэж өвгөн баярлав.

(Төдий Цотон ноён Цасын гэрт очоод “Морь өгье гэсэн билээ. Өг” гэв. Цас Чихэр өгүүллрүүн: “Энэ муу Цотон чи Журьыг минь долоон албинд илгээж алуулаад надаас морь авна гэх чинь юу вэ? Журьын төлөө чамайг алья ” гээд илдээ барьж босоход Цотон ноён ихэд айж гэрээс гаран мориндоо харайж мордоод дутааж харив)

Жур, Ир Тонгорог мангасыг алав.

Тэр цагт Ир Тонгорог нэрт мангас тэнгэрт дэвшүүлж (тулгаж) барьсан Хүрмэ нэрт суварганы оргил дээр гарч суух ажээ. Өглөөний нарыг өрнө зүгийн хүнд үл үзүүлж, үдийн нарыг дорно дахь хүнд үл үзүүлж, хүнийг хоногийн газраас харж үзээд үдийн газраас өрөвхийгээд залгихын Жур мэдэж чивэлт халтар тарвагыг ухаж тарвагачлах хүн болон хувилж хүрэв. Суварганы ёроолоор нүх ухаж хэвтэв. Мангас дуудаж асуув. "Чи юун хүн буй?" "Ай хайрхан чамд халдах ёсон үгүй. Би үгүйтэй яданги хүн, тарвагчилж тарвага алж явна. Энэ нүхэнд тарвага орж, тарвага ухаж хэвтгнэм, би" гэв. Мангас дуугүй суув. Сувраганы наад ёроолоос тэртээх ёроолыг хөндийлж ухаад суврагын түлхэж орхив. Суврага унаж дөрөв таван анги болов. Мангас сувраганы үзүүр дээрээс нь унаж бяцарч үхэв. Жур түүнийг алаад харьж ирэв.

Хэлтгий хар цачраа ачаалаад эхтэйгээ явав. Их улсдаа хүрэв. Цотон ноён үзээд "эвий" гэв. Жур "Юу вэ?" гэв. "Чамайг Цас долоон албин барьж идэв гэж хэлэв. Цас долоон албиныг алаад агтыг авч ирэв гэж хэлэв над" гэв. "Одоо Цас бид хоёрыг яая гэнэ чи одоо?" гэв. Цотон ноён: "Эх нь яа гэвэл тэгнэ" гэв. "Эцэг эхдээ Цас намайг юу гэж гүжир хэлэв?" гээд явав.

Цотон Журьг дахин хөөв.

Цотон ноён бас үзэн ядан хүрч хэлэв: “Энэ өдрөөс нутаг хуваая. Болжморын хоолойгоор бид нутаглая. Энхрэхийн зоонд Жур, эх хоёул очиж нутагла” гэв. Жур “За” гэж инээв. “Эвий! Авай минь, юу гэж инээнэ чи ? гэж уйлав эх нь. “Чамайг байгуулсан сайн хөвгүүн төрөв үү гэж баярлаж билээ. Барсан муу хөвгүүн төрсөн аж. Авай минь! Энхрэхийн зоо гэгч зун бороо үл орох, өвөл цас их орж, үргэлж шуурга болж байх бишүү. Аргал түлээгүй, гөрөөсгүй, тийм хувхай газар гэлээ тэр. Авай чи бид хоёрыг үртүгэй гэж илгээнэ бишүү. Цотон ноёны улсын дэргэд сууж өрмөг нөхөж амиа тэжээе бид” гэв. “Эжий минь, дуу! Эм хүн чи үл мэднэ . Ямаа ижлээ эрэм гэлээ. Мөргөлөөд хагацам гэлээ. Эм хүн хань эрэм гэлээ. Хэрэлдэж хагацам гэлээ. Эжий минь яв” гэж эхийгээ аван очиж нутаглав. Журьг хүрч нутагласан хойно Энхрэхийн зоо өлзийт сайн нутаг болов. Их далайгаас үүдээр ус урсаж ирэв. Гэр дээгүүр нь хамаг мод ургуулав. Тэр газарт Жур “Цахирмаг хоолт” нэр өгөв.

Энхрэхийн зонд Жур гөрөөлж явтал Таскийн (Тажигийн) Эрдэнэ хааны таван зуун худалдаачин Хятадын Дайвун хаанд очиж (сангийн эд) авч харьж одно. Тэдэнд хүний хоёр хар нүднээс биш үгүй юм үгүй ажээ. Тэр худалдаачинд үл чадах юм үгүй. Жур түүнд нэг бүлэг хувилгаанаар хорин хүн болгон хүрэв. Нэг бүлэг хувилгаанаа хатгаг зөгий хэдгэнэ болгож хүрэв. Тэр улсыг тэд ээрэв. Таван зуун худалдаачин явах аргаа эс олов. Үхэх нь ойртож байв. “Ай хайрхан богд, бид үл мэднэм бишүү. Энэ санг минь авья гэнэ үү чи? Дураа мэдэж ав. Манийг дагуулж нөхрөө болгоё гэнэ үү чи? Бид чамд больё” гэв. “Зөв, яв” гэж авч одов.

“Энд хоншим бодисадын сүм мэт гэр барьж өг. Алтан, мөнгөн, төмөр, чулуугаар хольж барьж өг” гэв. Таван зуун худалдаачин их далай дээр чулуугаар гүүр тавив. Аврага чулуугаар багана босгов. Унийг төмрөөр хийв. Тугалгаар цонх хийв. Тэр цонх бүрт гал эрдэнэ шигтгэв. Гэрт нь гэрэл оруулж хийв. Дээврийг мөнгөөр доторлон алтаар гадарлаж хийв. Нурууг гал эрдэнээр байгуулж хийв. Одоо тэр дотор нь хоншим бодисадын биеийг босгов. Гэр дотрох дөрвөн өнцөгт нь дөрвөн гэрэлт гал эрдэнэ уяв. Хоншим бодисадын өмнө нь нэгэн чандмани эрдэнэ уяв. Гүүрийн чулууг сугалав. Түүнээс рашааны ус урсав гэр дотор нь. Таван зуун худалдаачин үг айлтгав: “Салхинд үл гажих, бороонд үл эвдрэх зүл хүж үл эрэх, рашааны ус үл эрэх, элдэв зүйл төгссөн мэт санаж барив бид. Ай! Мэргэн хаан сэтгэлд чинь таалагдав уу?” гэв. “Барам (хөөрхий)! Таны зөв. Одоо би таныг хариулья. Та минь төвдийг дайрч харих буюу? Бишгээгүүрт явах буюу?” “Дайрч очно” гэв. “Цотонгийн гэрийг дайр. Танаас ирж тэр асуунам за: “Энхрэхийн зоо дайрч ирэв үү?” гэнэм за. “Дайрч ирэв ” гэв. “Манай тэнд нэгэн муу нусгай Жур Хоншим бодисадын сүм босгож чулуу, төмөр, мөнгө, алт, шил эрдэнэ, тугалга энэ бүгдээр хольж барьсан ажээ. Журьг бие нь үхэж, тэр гэр нь эзэнгүй байв. Цотонд ингэж хэлээрэй” гэв.

Жур Цотонг хазааргүй морь унуулан хөөв.

Тэр худалдаачдыг явуулаад Жур тэр гэрийнхээ гадуур өргөст модоор өндөр шөрөг босгов. Ганцхан үүд гаргав. Түүндээ гучин алд төмөр аргамж хийв. Хоёр гурван алд гадас хийв. Нэг гадсаа алтан дэлхийд шааж хаалгандаа төмөр аргамжаар урхи хийж морьтой хүн багтаж орох тийм чөлөөтэй шахав. Бялуунуудыг хурааж ирж дэргэд нь тавив.

Худалдаачин Цотонгийн гэрийг дайрав. Цотон ноён угтаж ирж асуув. Мөн худалдаачин өөрийн үг болгон Журын үгсийг тоолж хэлэв. Цотон ноён “сайн” гэж хар морио унаж, саадаг бүсэлж Энхрэхийн Зоонд хүрэв. Жур хувилгаанаар мэдэж аргамжааныхаа дэргэд үхсэн мэт хэвгэнэ. Цотон ноён хүч ирэв. Хар морь нь хаалганаас айж үргэнэ. Мориныхоо толгой түрүүг савж гуядна. Морь нь давхиж шурган ортол төмөр аргамжаанд торов. Жур босон гүйн ирж, нэг гурван алд гадсаа суга татаж авав. Аваад биеийг моринд давхарлаж ороож хүлэв. Хүлээд Цотонгийн морь биеийг гөвшив. Гөвшиж гөвшиж хоёр гадсаа аваад мөн морины хүлээсийг тавьж (хазаарыг авч) илгээв. Хар морь нь үсэд аван очив. “Энэ Цотон ноён галзуурав уу яав?” гэж хүн элдэж (хөөж) үл гүйцнэ. Сарвас хийж барья гэв. Баригдахгүй дутаана. Цотон ноён хүнд эс баригдсаар долоо хонов. Төвд улс Цотонгийн гадуур авлаж тэргээр гурван давхар хүрээлэв. Ав түрсээр ирж Цотонг ноцож барив. Төмөр аргамжийг тайлж авав. Мориноос нь буулгав. Цотон ноён гэлдэрхийлж байв. “Цотон авгай! Яав?” гэж бүгдээр “Олон худалдаачин миний гэрийг дайрч ирэхэд Журьыг үхэж үү, амьд байна уу? гэж асуув би. Үхэж гэж над худал хэлжээ. Тэр худалдаачны эхийг нь алав уу би, эцгийг нь алав уу би? гэж байна чи. Чиний эх эцгийг одоо Жур алав уу? Нэгэнт үхэх газарт байна чи. Зоонд түүнийг хөөж орхив чи. Чамайг жанчсаар алавч болох байсан” гэж донгодов. Донгодсон хойно бүгд улс тархав.

Жур Арлан гуатай уулзав.

Журыг гөрөөлж явгал Ма баяны охин Арлан гуа нэгэн хонь алж махаар нь үүрэгнэ жимстэй талх хийж тулманд хийж үүрч ирэв. Жур ирж уулзав. “Охин хэнийх билээ? Ямар хэргээр ирэв чи?” гэв.

“Ма баяны охин Арлан гуа билээ би. Ахай минь, чамаас нутаг гуй гэж илгээв ” гэнэ. “Чи одоо энд суузана” гээд идээг аваачиж эхдээ өгөв. Жур охины дэргэд ирэхэд охин унтаж байв. Жур эцгийнх нь адуунд очиж унага орхисон гүүний унагыг авч ирэв. Охины хормойд хучиж тавив. Жур охиныг “бос, бос ” гэв. Охин сэрж дээш сууна. “Яасан нүгэлт охин билээ? Яасан чивэлт охин ирэв чи, миний дэргэд? Эцэгтэйгээ сэтгэлтэй болбол морины толгойтой хүүхэд төрнө. Ахтайгаа сэтгэлтэйгээ болбол морины дэлтэй мэт хүүхэд төрнө. Дүүтэйгээ сэтгэлтэй болбол морины сүүлтэй мэт хүүхэд төрнө. Энгийн улс хятад боолтойгоо сэтгэлтэй болбол морьны дөрвөн хөлтэй мэт хүүхэд төрнө. Чи нүгэлт охин бос “ гэв. “Ээ! энэ надад юу хэлнэм?” гэж охин босон харайв. Охины хормойноос унага унав. “Эвүү, Эвүү! Яасан нүгэлт билээ? Яасан чивэлт билээ? Яая би? Авай, Жур үүнийг минь хүнд бүү хэл. Чи намайг ав” гэв. “Үнэн үү?” гэв. Охин: “үнэн” гэв. “Үнэн бол үүнийг минь долоо” гэж чигчий хуруугаа хатгаж цусыг нь долоолгов. Унаганы сүүлийг авч “Сүйлэх минь энэ” гэж охины хүзүүнд нь гөрөөд уяж өгөв. “Эцэг чинь ганц хотоор иртүгэй (ирж нутаглатугай)! Нутгийн бус хошууны хүнийг бүү халгаа” гэв. Охин харив.

Цотонгийн гэрт хурим болов.

Жур гөрөөлж явтал Мо баяны охин, Чойдон ламын охин дүү Мажиг Хумсан гуаг Цотон ноён их хөвгүүн Алтанд авч одов. Царгин түүнд авга нь болно. Чойдон лам охин дүүгээ хүргэж одов. Жур угтаж хүрэв “Чи хамгийн нигүүлсэнгүй их лам буюу. Үгээгүү яданги хүн буюу би. Лам над хишгээ өгөн соёрх ” гэж ламыг цулбуурдав. “Би хээрийн хүн чамд өнөө би юу өгөх вэ? Маргааш Цотон ноён их хурим хийх буй. Тэнд ир. Хишгээ өгсүү би ” гэв. “Өгье гэвэл унасан морь чинь өмссөн дээл чинь үгүй буюу?” гэж байна, Жур. “Энэ муугийн аашлахыг нь үз та” гэж Журын толгойг ташуураар цохив. Жур ламыг татаж орхив. Хэрэлдэж байв. Царгин авга нь ирэв. “Авай Жур, ахай Жур тавь” гэв. “Тэр хүнтэй бүү хэрэлд” гэв. “Худаа гэж Чойдон ламыг өмөөрье гэвэл дүү минь чи над уурлах. Дүүгээ чамайг өмөөрье гэвэл худ минь над уурлах. Маргааш их хурим хийх биш үү. Үгүй ч болов юу буй . Хүнээс сагал (сагил ямаа) гуйж авч ир” гэв. Жур: “Царгин авгайн үгээр тавья. Ай лам чамайг энэ ертөнцөд эрлэг хааны тэнд нэг ичгүүр болгоно би ” гээд тавив.

Маргааш Жур хүнээс нэг ямаа гуйж алж махыг болгоод тулманд хийж үүрээд эхийгээ аван очив. Цотон ноён эхлэн ширээн дээр суув. Чойдон лам эхлэн зүүнтэйгүүр эмсийн эхэнд адагт суув. Их хурим хийж байв. Журд ширээ эс хүртэж эрсийн адагт сууна. Журын эхэд нь ширээ эс хүртэж бас газар дээр сууна. Жур босон гүйж шороон дээрээс морины аргал хомоол авчирч тавив. Морины аргал дэр нэгэн дэрс авчирч хатгав. Дэрсний үзүүрийг гурван анги хагалж тэр дээр ширээ хийгээд суув. Их хурим түгээж идэв. Нэг ч хүн Журд мах эс өгөв. Цотон ноён хонины нэг хаа барьж сууна. “Авгай! Уулын чинээ мах байна. Далайн чинээ архи байна. Хишигт (азтай) нүдэнд үзэгдэвч шорт(азгүй) хоолойд эс орно. Барьсан хаагаа өг авгай над” гэв. “Дал өгье гэхэд баян суурь минь юм. Дунд чөмөг өгье гэхэд хүүхдийн минь сүлд билээ. Богтос чөмөг муугийн дээд муу буй. Хар газрыг чи ав. Ханиадыг чи ав. Уйлах хүний нус нулимсыг чи ав. Голын баруун газарт үхсэн малын мах, голын зүүн газарт үхсэн малын мах, голын хойно үхсэн нүгэлт малын мах эд бүгдийг чи ав. Буулгах охины эрээн мярааныг чи ав. Богтлох бэрийн өмнөх зэтгэрийг чи ав. Май” гээд өгөв.

Жур босон гүйв. “За! Олон бүгд сонс. Элий, элий! Цотон авгай над өглөг хишиг өгч байна. Хар газрыг над өглөө. Үүргэнэ, гичгэнэ ухах хүн, тариа тарих хүн надаас асууж яв. Асуулгүй явбал за үгүй их шившиг. Ханиад юмуу, уйлах хүний нус нулимс эднийг над өглөө, Надаас асууж ханиа. надаас асууж уйл. Асуулгүй уйлбал, асуулгүй ханиавал нь за үгүй их шившиг. Голын баруун газарт үхсэн морины мах, голын зүүн газарт үхсэн үхрийн мах, их голын хойно үхсэн хонины мах эд бүгдийг булт надад өг. Надаас асууж ид. Асуулгүй идвэл за үгүй шившиг. Богтлох охины эрээн мярааныг чи ав. Буулгах бэрийн өмнөх чөтгөрийг чи ав гэлээ” гэж Жур хэлээд босон гүйж Хумсан гуагийн өмссөн зүүснийг тасар татан авав.

Чингэхэд Чойдон лам хувилгаан байсан аж. Лам зүүн самсаанаас зөгий хорхой гаргаж, “Очиж Журын нэгэн нүдийг нь таслаад ир” гэв. Жур түүнийг хувилгаанаар мэдээд нэг нүдээ аньж, нэг нүдээ хялааж суув. Хорхой дав дав хийж ирээд Жураас айж уруулыг нь хатгаад ламд очив. Лам: “Нүдийг нь хатгав уу чи?” гэж асуув. “Нэг нүд нь сохор, нэг нүд нь хялар юм. Уруулыг нь хатгаад ирэв би” гэв. “Зүүн самсаа өөд нь очиж ороод голыг таслаж ал” гэв. Хорхой айсуу. Жур нэгэн хамраа цус гарав гэж бөглөв. Зүүн хамрынхаа самсаанд урхи тосов. Хорхойг орох гэж ирэхэд урхиараа барив. Хорхойг бариад чанд атгав. Лам ширээн дээрээс үхэдхийн

хэвгэнэ. Чойдон ламын охин дүү Хумсан гуа ахынхаа сүнсийг барьсныг мэдэж нэг гартаа хачир шувууны толгойн төдий оюу эрдэнэ барьж, нэг гартаа нэг бутан архи барьж Журд айсуй. Жур өмнөөс нь : Эвүү, эвүү! Та энэ бэрийг үзээч, Манай төвдийн газар хааны хүний бэр болбол хүнд гурван он болтол үл золгоном билээ. Харц хүний бэр болбол гурван сар болтол хүнд үл золгоном билээ. Энэ яасан хадад эцэг эх үгүй нүгэлт бэр билээ? Энэ хорхой эх, эр чинь билүү? Эцэг эх чинь билүү? гэхэд буруу хандаж явж очив. Чойдон ламын бөгтөр хар заргач ирэв. “Авай Жур, ахай Жур! Үүнээс хойш үзэж байж эс өгвөл нүд нь тэсэртүгэй. Сонсож байж эс өгвөл чих нь дүлийртүгэй. Идэж байтал эс өгвөл шүд нь үйртүгэй. Барьж байж эс өгвөл гар нь хугартугай. Дун цагаан ууланд дун цагаан хурга өөрөө майлж байх буюу. Алтан уул буюу. Алтан ууланд алтан тээрэм өөрөө эргэж байх буюу. Төмөр уул буюу. Төмөр ууланд төмөр хирс үхэр өөрөө тоглож байх буюу. Алтан уул буюу. Алтан ууланд алтан саваа өөрөө савж байх буюу. Шоргоолжны хааны үйлэнд хураасан үйрмэг алтан буюу. Нар барих алтан цалам, сар барих мөнгөн цалам, шоргоолжны хамрын цус нэгэн халз (жижиг сав), бөөсний шөрмөс нэгэн атга, эр харавгар шувууны хамрын цус нэгэн халз, эм харавгар шувууны хөхний сүү нэгэн халз, зулзаган харавгар шувууны нүдний нулимс нэгэн халз, их далай доторх бул чулууны чинээ шүүст молор эрдэнэ бий. Авай Жур энэ эрдэнийг чи бултыг ав. Өнөө Хумсан гуаг чи ав. Энэхэн хорхойг тавь” гэж мөргөв. Жур хорхойг тавив. Лам Журд мөргөөд ширээн дээр салгалж суув. Хумсан гуаг авч амраг Цас ихэр ахдаа өгөв.

Жур Рогма гуаг гэргий болгож авав.

Тэр цагт Жало охин Рогма гуа () нөхөр сонгож (“Биедээ тэнцэх сайн хувилгаан эр эс олов би” гэж гурван харвах мэргэд, гурван барилдагч бөх, нэг их мэргэн лам, олон дагуулаа авч, тэд бүгдээ дагуулж, “Төвдийн газарт гучин хувилгаан баатрууд буй гэнэ” гэж “Сайн эр буй болов уу?” гэж ирэв. “Түмэн хүнийг хураа” гэв. Түмэн хүн хурна. (Төвдийн орноос Цотон ноён, Царгин ноён, Цас Чихэр, Бадмаарын хөвгүүн Бам Сорзо, Амбагадайн хөвгүүн Дормогодой, тэд бүгд очив. Шарай голын аймгаас Эрээн хаан, Мяраан хаан, Шигчин гурвуул очив. Мангасын улсаас Сахилдай очив. Ер бүгд хурсан хүн гурван түм болов.) Цотон ноён очиход Жур: ”Цотон авгай минь, намайг сундал” гэв. “Чи муу! Дагинасын хувилгаан Рогма гуаг авья гэж очих буй ? Би биш газар одьё” гээд явж одов. Царгин одов. “Царгин авгай намайг сундал” гэв. Журыг Царгин авгай “Нааш ир” гэж сундлав. Царгин хүрэв. Түмэн хүн хурж, Цотон ноён эхэнд сууна. Жур хэлэв: “Цотон авгайг би өөр газар одно гэж гомдож билээ . Одоо Рогма гуаг өнөө чинь авах байна. Сайн” гэв. Рогма гуа босож ирэв. “Энэ ахай (энд байгаа) хаадад эрдэмт сайн эр байна уу? Гурван харвах мэргэд, гурван барилдах бөх, эд бүгдийг минь гарах (ялах) хүнд очья гэж билээ би. Нэг ч гарах хүнгүй байна. Гурван харвагч мэргэдийн минь харваж гарсан хүнд, энэ бөхийг минь ялсан тэр хүнд очьё би. Хэдийчинээ сайн охин эр сонгоно гэж шүүмжлэх буй та. Намайг төрөхөд баруун дээвэр дээр сэру (хирс) гөрөөс тоглож байсан билээ. Зүүн дээвэр дээр минь Оролог нэрт гөрөөс тоглож байсан билээ. Наргүй өдөр гэрэл гарч байсан билээ. Үүлгүй өдөр бороо орж байсан билээ. Хатны тулган дээр минь тоть шувуу донгодож байсан билээ. Боолын тулган дээр минь Урангадайн гуа шувуу донгодож байсан билээ. Ийм есөн зүйл төгссөн дагинасын хувилгаан Рогма гуа охин би билээ. Харвагч мэргэн, барилдагч бөхөө гарга” гэв. Рогма гуагийн гурван харвагч мэргэний нэгийг өглөөгүүр харвуулбал нарны гурван цай чанахад бууж ирэх ажээ. Нэгний харвасан сум нь нэг цай чанахад бууж ирэх ажээ. Рогма гуа бас хэлэв: “Энэ манай хүн өглөөгүүр харвавал гэдрэг харж хэвтгээд сумуу бууж ирэхэд толгойгоо зайлуулдаг буй . Толгойн ормонд сум тусгадаг буй. Түүнээс биш удаан (хол) харвав ч тэр мэлзээгээ эс оновол муу гэдэг буй биз”. Одоо гучин хувилгаан баатар, Рогмагийн гурван харвагчтай бүгд харваж хэн хэнээ гаралцсангүй (гартааж чадсангүй). Барилдаж хэн хэнээ дийлсэнгүй. Тэндээс Рогма гурван их бөхөө авчраад барилдуулав. Эрээн хаан, Мяраан хаан хоёул хоёр бөхөд нь төлөөгүй ялагдаад нөгөө бөхөд нь харилцан орхилцов(хайнцав). Шигчин хаан нэг бөхөд нь төлөөгүй ялагдаад хоёр бөхөд нь харилцан орхилцов. Мангас улсын Сахилдай нэг бөхөд нь төлөөгүй ялагдаад хоёр бөхөд нь ялагдаж нэг бөхийг нь төлөөгүй ялав. Царгин ноён нэг бөхөд нь төлөөгүй ялагдаж хоёр бөхөд нь харилцан орхилцов. Цотон ноён гурван бөхөд нь төлөөгүй ялагдав. Цас Чихэр хоёр бөхийг төлөөгүй ялж нөгөө бөхөд нь харилцан орхилцов. Бадмаарын хөвгүүн Бам Сорза хоёр бөхийг нь хөтлөөгүй ялж нөгөө бөхийг бас орхитол Жур таван аргыг нь аваад ялж чадахгүй болгов.

Жур босон гүйв. Рогмагийн ламаас асуув: “Ай лам! Чадан ядан бахаднам би (Над бахдалтай сайхан байна). Би барилдаж үзье” гэв. “Авай чамаас илүү гучин хувилгаан эс чадав. Авай байг!” гэв. “Барилдъя л” гэв. “Барилд ” гэв. Жур биеэ засаж босов. Лам: -Манай бөхчүүд хаа байна? Энэ хүүхэд барилдъя гэнэ“ гэв. Их бөх нь босож ирэв. Жур биеэ үзүүлэв. Гэсэр биеэр хувилав. Хувилгаанаар хамгийн нүдийг халхлав. Нэг хөлөөрөө уулын оргилыг гишгэв. Нөгөө хөлөөрөө далайн захад гишгэв. Их бөхийг мянган бээрийн газар хаяж орхив. Дунд бөхийг хоёр мянган бээрийн газар хаяж орхив. Бага бөхийг гурван мянган бээрийн газар хаяж орхив. Бүгд улс Журыг ширтэж үл алдана. Гурван харвагч мэргэн харвав. Харвасан сум нь үдийн

цагт эргэж буув. Жур харвав. Журын харвасан сум үд болтол бууж эс ирэв. Үдэш болоход хав харанхуй болов. Хамаг улс “Нар шингэлээ. Шөнө болов” гэж тархая гэхэд Цас Чихэр хэлэв: “Үгүй, манай нусгай Журын сум хүрч айсуй” гэж. Жур толгойгоо зайлахад толгойн оронд нь тусав. Тэнгэр нарыг эзлэгч эгч нь Журын сумыг авмагц хамаг шувуу хэлхэж буулгав. Түүнд гарди оржээ. Гардийг нь унаж ирэхэд нарыг далдалсан ажээ. “Хамгаар эс чадсаныг нусгай Жур чадав” гэж хамаг улс тархая гэнэм.

Рогмо гуа “Байз” гэв. Нэг гартаа хонины хавьс (хавирга) барьж, нэг гартаа бутан архи, хачир, шувууны толгойн чинээ оюу эрдэнэ барьж: “Түмэн хүнд намайг буруу хандах зуур далан хонины хавьс, нэг бутан архийг түмэн хүнд түгээж өгч дуусаад хачир шувууны толгойн чинээ оюу эрдэнийг амандаа багтаан чадсан хүнд би очьё” гэж үүнд түүнд барив. Хамаг улс эс чадав. Гагц Бадмаарын хөдгүүн БамСорза чадах байжээ. Гэтэл Жур нуун сууж түүний дөрөв таван аргыг хулгайлж авав. Аргаа авгаад эс чадав. Рогма гуа Журд хүрч ирээд их нусыг нь үзээд буруу хандаж явж очив. Царгин авгай хэлэв: “Чи сайн боловч эм бишүү. Жур минь муу боловч эр биш үү. Гурван харвагч мэрэд чинь гартлаа. Гурвуул барилдагч бөхөө чи алдлаа. Иймийг үл мэдэх сайн чинь энэ буюу?” гэж донгодов. Журд авч очив. Жур угтаж гараас нь булааж авав. “Чи сайн ч, охин хүн. Хойд хормойндоо гал шатаж явахыг үл үзэх нүгэлт охин байна чи” гэв. Охин хойшоо харав. Жур хувилгаанаар түмэн хүнд далан хонины хавьс, нэгэн бутан архийг түгээн өгч дуусаад, оюу эрдэнийг амандаа багтаан үмхэж суув. Хамаг улс инээлдэв. Цотон ноён : “Муу ч болов миний садны үр Жур минь авав” гээд “Хойно (би Жураас нэг аргаар) авья” гэж арга сэтгэв. (Тэдгээр хурсан улс, Жало хааны охин Рогма гуаг Төвдийн Цас Чихэрийн дүү Жур авав гэж өгүүлээд) хамаг улс бүгд тархав.

Рогма гуа дагуулаа аваад дутааж харив. “Тэр муу айсуй буюу?” гэж хойшоогоо харав. “Бараагүй” гээд явав. Бас “Бараа үз” гэв. “Бараагүй” гэж явав. Жур хувилгаанаар хүрээд Рогмагийн хойно нь сундлав. “Бараа үзэгдэнэ үү? Хар” гэв. Дагуул нь харах гээд Журьыг үзэв. “Эвүү! Хараач. Хойно чинь сундалж явна бишүү” гэв. “Эвүү! Яая? Хэрхэх билээ? Би хагацашгүй зовлонд орж байна.” гэж уйлав. Өдийгөөс төдий хүртэл эр сонгосон ач минь урамгүй болов. Эжий, ахайдаа одоо юу хэлье? Аль нүүрээр золгоё гэж уйлж явна.

Жур хувилгаанаар түмэн хүний тоос гаргаж явна. Эцэг эх нь “Түмэн хүний тоос гарав. Мьяраан хаан авсан болов уу?” гэв. “Мянган хүний тоос гарав. Шигчин хаан болсон болов уу?” гэв. “Зуун хүний тоос гарав. Цотон ноён авсан болов уу?” гэв. “Жар далан хүний тоос гарав. Бадмаарын хөвгүүн БамСорза авсан болов уу?” гэв. “Хуй хий мэт тоос гарав. Цас Чихэр авсан болов уу?” гэв.

Чингэсэн хойно үзсэн чинь нусгай Жур сундалж хүрч ирэв. Эцэг нь охиндоо уурлан баруун үүдээр гаран хазаар ташуураа барин адуундаа очив. Ах нь охин дүүдээ уурлан нум сумаа аван зүүн үүдээр гаран хониндоо очив. Эх нь охиндоо уурлан бараагаа таталж харааж байна. Хятад (зарц) нь тогоогоо таталж сууна. Журд тохом буруу дэвсэж өгөв. Жур буруу хандаж суув. “Тохом дэвсэж өгөхөд буруу хандаж суух чинь юу вэ?” гэв. “Та моринд эмээл яаж тохож унадаг вэ?” гэв. Журьыг босгож тохмыг зөвөөр дэвсэв.

Жур Рогмагийн ширээн дээр гүйж гараад: “Эцэг чинь баруун үүдээр хазаар ташуураа барин очив. Адуунд нь дээрэм довтлов уу? Би баатар хан билээ. Над морь өг. Би нэхэж авчирч өгье. Ах чинь зүүн үүдээр гарч нум сумаа аван очив. Хонинд нь чоно довтлов уу? Би хавтгай

(мэргэн харваач) билээ. Над нум сум өг. Би алж өгье. Эх чинь бараагаа таталж харааж байна. Бараанд чинь албин оров уу? Би албины хараал сурсан билээ. Би харааж өгье. Хятад чинь тогоогоо таталж байна. Тогоо чинь боомтов уу? Би боомын тарни сурч билээ. Би тарнидаж өгье” гэв.

Эцэг эх нь бүгдээрээ үдэш хүрч ирэв. Охиноо донгодов. “Нүгэлт охин чивэлт охин. Хүний хүн авчрав чи. Адвиш “сайн эрийг” чинь нохой барьж идүүзэй! Нохойд идүүлээд зовлон манд болгов чи!” гэв. (Рогма, Журыг “Бүү хөдөл” гээд) тогооны дор хөмөрч орхив. Жур шөнө тогоог түлхэж орхив. Жур нэгэн хонь алав. Махыг өөрөө идээд үлдсэнийг нохойд тавьж өгөөд тугалын арьсан дээлдээ хонины цусыг түрхээд тайлж орхив. Жур (бусдыг дээлийг хулгайлж өмсөөд) хээр очоод хэвтэв. Өглөөгүүр босоод, эцэг эх нь үзэв. “Сайн эрийг чинь нохой барьж идэж байна. Зовлонг тусдаа чи даа. Гай болбол ганц чи хариуцна” (Рогма гуа яарч босоод тогоогоо нээж үзвэл Жур байхгүй. Гадаа гарч үзвэл дээл нь хагарч хэвтэв. Хоёр нохойн аманд цустай байв)

Охин дотроо гэмшиж харааж сууна. Сууж байгаад бодов: Чадсан үйл нь биенээс нь илүү билээ. үхэв үү, үгүй юу? “ гэж Рогма гуа “Эрж үзье” гэж явав. Эрж явтал Жур өмнө нь хувилгаанаар олон адуу хариулсан хүн болж уулзав. “Ай адууч хүн! чи нусгай Журыг үзэв үү?” гэж асуув. Тэр хүн: “нусгай Жур гэгчийг би танихгүй ” гэв. “Дос, Донсар, Лин гурван отог улс Журыг Жало хааны охин Рогма гуа аваачиж алахын муугаар алаад, эцэг эхийг ньталахын муугаар талья гэж айсуй гэв. “Энэ хүний үг нь үнэн” гэж Рогма гуа уйлж явав. Жур өмнө бас олон хонь хариулсан хүн болж хувирав. Хоньчин хүнээс асуув. Хоньчин хүн мөн урьдах үгийг тоочин хэлэв. “Энэ хоёр хүний үг нь нийлэв. Над одоо үхэхээс өөр хэрэггүй байна. Эцэг эхийн гадна очиж муугаа үзүүлж үхэхээр, тусгаар үхье би. Энэ голд унаж үхье” гэж их хадан уруу довтлов. Довтолтол Жур хувилгаанаар морины сүүлнээс татав. Хойшоо харж үзвэл Жур байв. “Эвүү! Жур морд ” гэв. Жур мордов. Алтан шар усаа цувуулж явав. Нуснаас нь жигшиж Рогма гуа нуруугаа хотойлгож явав. “Жур яалаа чи! Буруу хандаж сундал” гэв. Жур буув. “Өндөр ууланд замтай биш үү. Нэг төрсөн биенд ганц толгой байх уу, хоёр толгой байх уу? Энэ моринд эндээс мордох уу” гэж толгойн халз өөд мордох гээд авирав. Жур: “Одоо эндээс мордье ” гэж морь өөд нь авирав. Авиртал морь туйлж орхив. Жур унаад үхэгч болж хэвтэнэ. “Авай Жур? Бос” гэв. Чингэтэл “Зөвөөр сундлах уу, буруу сундлах уу? Чиний санаагаар болье” гээд босов. Журыг зөвөөр сундалж аваачив.

Журыг хүрсэн хойно Рогма гуагийн нагац эцэг эх нь: “Зээ охин минь хувилгаан билээ. Сайн хүнд очив уу, муу хүнд очив уу? Үзье” гэж ирэв. Журыг хадам эцэг эх нь нууж, нэг аяганд будаа хуурч өгч барааны хөндийд дарав. “Авай минь, тэр хүнийг мордтол бүү гараарай” гэв. Нагац эцэг эх нь ирэв. “Хүргэн маань аль сайн хүн буюу? Муу хүн буюу?” гэж асуув. “Хай, яаж мэдэх вэ? Бага хүүхэд байна ” гэв. “Өнөө айлд очиж хурим хийж сууна ” гэв. Чингэж суутал нь Жур алтан шар нусаа цувруулж, Нусныхаа үзүүрт нэг буудай наалдуулж “над хэрэгтэй буюу?” гэж гарч ирэв. Рогмагийн нагац эцэг эх нь “эцгийн чинь түрүү толгой! Ингэж байна уу, та муусайн ?” гээд адууг хөөж харив.

Жур хэлэв: “Морь, хуяг, саадаг, нум над өг. Би баатар билээ. Нэхэж очъя” гэв. “Таатай (басамжлах аялга). Муу чамд яасан морь, ямар юм өгөх буй?” гэж эс өгөв. Хяр дээр хэвтэх хониноос нь ухна, хуц хоёрыг барьж хослож нэхэв. Нэхэж очоод морь, хүнийг цөм цохиж

орхив. Адууг авч ирж өгөв. Түүний хойно “Одоо би газартаа харья” гэв. Чам мууг яав гэж хариулах буй? Зүгээр суу” гэж зэмлэв.

Гэсэр хувилж Цотон ноён болж ирэв. Жур биеэр оготно урхидая гэж очив. Цотон ноён болон ирж Рогмагийн гадна буув. “Жур хаана байна?” гэв. “Сая оготно урхидахаар явлаа” гэв. “Төвдийг эзлэгч их ноён би байна” гэв. Хайран сайн бэр минь зовж байна. Муу Журьыг алж орхивол яана? Би алья. Эм өг гэвэл би өгье. Хөөж орхи гэвэл би хөөж орхиё. Би чамайг авья” гэв. Рогма хэлэв: “Би мэдэхгүй, Та мэднэ бизээ. Төрөл зураа байна. (Та нар садан хүмүүс шүү)” гэв. “Би чамайг авья гэж сэтгэл хурьцав” гээд мордож явж одтол нь Жур хүрч ирэв. “Тэр явагч хэн буй?” гэв. “Хай чиний төрөл чинь Цотон байна” гэв. “Юунд ирэв?” гэв. “Хай чамайг асуугаад мордож явав” гэв. “Би мэдэв мэдэв” гэв. “Юу мэдэв чи муу? Намайг л зовоох гэж байна чи” гэж донгодов. “Одоо над юу гэж үл золгоном?” гэв. “Би мэдэв. Төвдийн сайн эрсийг цуглуулж намайг алья гэх чинь зөв” гээд гарч явав.

Маргааш нь Гэсэр хувилж төвдийн гучин баатар болон ирж суув. “Энд ирсэн энэ сайн хүмүүс хэнийх вэ?” гэж асуулаа. “Бид төвд хүмүүс. Журьын эмийг өгөх бол өгөхөө хэл. Өгөхгүй бол өгөхгүйгээ хэл гэж манийг илгээв” гэв. Жало хаан бүгдээрээ хэлэлцэв: “Өгье гэвэл хайран хүүхнээ эдэнд өгөөд юу санаж суух вэ? Өгөхгүй гэвэл гучин батар манийг алах байх. Нэг арга хэлж үзье” гэв. “Та харь. Бид хойно хүргүүлж илгээе, бүгдээрээ бэлтгэх ажил дуусгаагүй байна” гэв. “Журьыг муу гэж охиноо өөр хүнд өгөх болбол өг. Хэрвээ өгөхгүй бол Журьыг удтал байлгавал гучин хувилгаан баатар та нараас дээгүүр хүмүүсийг дийлсэн билээ. Та нар дэмий битгий сайрх” гэж хэлэв. “Одоо өөрсдөө мэд” гээд баатрууд явж одов. Жало хааыхан энэ үгнээс нь үхтлээ айж тэдний хойноос дагаж нүүв. Төвдөд хүрч хамт нутаглав.

Цотон заль гаргав.

(Цотон ноён “”Энэ Жураас Рогма гуаг нэг аргаар авбал сайн билээ) гэж санаж явав. Цотон ноён Дос, Донсар, Лин гурван отог улсыг хураагаад Журыг Цотон ноён үзэн ядаж хэлэв: “Гурван түмэн хүн хурж уралдая. Тавих бэлэг шавдат хуяг, дуурсахуй нэрт дуулга, томорцог нэрт илд, түмэн олон нэрт бамбай, чимгүүд эд бүгдийг тавьж уралдъя” гэв. Үүнд хэний морь гарвал (түрүүлбэл) тэр бэлгийг аваад, Рогма гуаг тэр хүн авья гэв. Гурван түмэн хүн уралдъя гэж цуглаж явна.

Жур сан тавьж огторгуй дахь Навса Хүрзэ эмэг эхдээ залбирав: “Эжий минь, энэ ертөнцөд хамаг амьтныг туслахын тулд арван зүгийн эзэн Гэсэр хаан болон төрлөө би. Хойд заяанд Эрлэг хааны тэнд хилэнцтэй бүгдийг сүнсийг тонилгохын улд Ханхой нэрт хөвгүүн болон төрлөө. Цотон ноён миний өвөр дэх эмийг авья гэж гурван түмэн хүн хурааж уралднам. Хээр унага минь сайн болбол түүнийг минь буулгаж өг. Муу болбол тэнгэрийн сүргээс нэгэн морь буулгаж өг” гэв. “Авай Нусгай минь байна” гэж хээр унагыг хувилган долоон настай хээр морь болгож буулгаж өгөв. Тэнгэрээс буусны тулд салхины хүрдээр эргэж Жало хаан золгов. “Ай муу хүргэн! Хамуутай хээр даагаар хэнийг гаргая гэж одно чи? Хайран хүүхнийг минь хүнд авья гэж одно уу чи минь? Буман тоот агтнаас унаж уралд ” гэв. “Чиний буман тоот агт чинь намайг үл даах болуузай. Сурснаараа хамуут даагаа унаж уралдъя” гээд явав. Гурван түмэн хүн болзооны газар хүрч, морь биеэ засаж байна. Их улс уралдав. Жур хамуутай хээр даагаа татаж хоцров. Татаж явж тавьж илгээв. Нэг түмэн хүний өмнө гарч ирэв. Бас татаж авч тавьж илгээв. Бас нэг түмэн хүний өмнө гарч ирэв. Журын өмнө Цотон ноён зээр гүйцсэн зээрэн ухаа мориороо будаа сацам газар явна. Цотонгоос өмнө Исмэй ноён сайн хөх морио унаж годил харвах газар бухуулж явна. Жур хамуут хээр даагандаа үг хэлэв: “Би зоригтын шинжээр дайръя. Чи баатрын шинжээр Цотонгийн морь бие хоёрыг дайрч орхи. Зээр гүйцэгч зааран ухааг богтос чөмгийг хуга гишгэж гарч оч” гэв. Хээр даага: “За ” гэв. Жур дайрав. Журын хэлсэн үгээр болов. Журыг гарч очсон хойно, Цотон ноён харж үзээд “Авай Жур яалаа?” гэв. “Авгай яалаа? Рогмаг минь хүн авуузай” гээд явж очив. “Гурван түмэн хүнийг гарсан хамуут хээр даага минь, Исмэй ноёны хөх морийг гарам за” гээд татаж явж тавьж илгээв. Исмэй ноёны сайн хөх морь ганцааран зуузайг шудран явж очив. Тэгээд годил харвам газар замыг хааж үл гүйцэгдэн явна. Жур хамуут хээр даагандаа үг хэлэн үйлав. “Эвий! Хамуут хээр даага минь яалаа чи? Шавдат хуяг, дуурсахуй нэрт дуулга, томорцог нэрт илд, түмэн олон нэрт бамбай, чимгууд, зузаан насан дээр учралдсан Рогма гуа минь. Эд бүгдийг минь хүнд алдуулахыг хүсэв үү чи?” гэв. “Авай нусгай минь. Би тэнгэрийн унага буюу. Энэ ертөнцийн морь боловч дөрвөн үе надас илүү ах, үс нь миний үснээс илүү олон. Би гүйцэж болохгүй байна. Огторгуй дахь Навса Хүрзэ эмэг эхдээ залибар” гэв. “Эжий минь долоон настай хээр морийг минь, доргош буулгаж өгөв. Газар дээр Исмэй ноёны хөх морь түрүүлж гарав. Хайран олон эрдэнэ чимэг минь, хувилгаанар авсан Рогма гуаг минь Исмэй ноён авах гэж байна. Эжий минь, яалаа? ” гэв. Эх нь сонсов. “Эвий Нусгай Жур минь хүнд гартаж уйлж явна . Овоо Дүнжон нааш ир . Хамуут хээр даагыг чи үлээж үз. Исмэй ноёны морийг би нэг аргаар үзье” гэв. Хоёул огторгуйгаар зэрэгцэн буув. Хээр даагыг овоо дүнжин үлээв. Долоон настай хээр морь биендээ тохов. Хазаар зуузайгаа хэмлэн шудрав. Навса хүрзэ эмгэн эх нь Исмэй ноёны хөх морины хоёр сугаар гал сумаар харвав. Хөх морь дөрөв тав годройтож унав. Болзооны газарт даага уралдам газар ойртсон байв. Исмэй ноён: “Эвий яалаа?” гээд босон уйлж байна. Одоо шудран гарах миний ээлж боллоо” гээд явж очив. Жур хуяг, дуулга, илд,

эрдэнэт чимгуудийг авч Цас Чихэр ахдаа өгөв. Жур гэртээ харив.

Маргааш бас Цотон ноён Журьыг үзэн ядаж (Дос Донсар, Лин гурван отог улсыг хураагаад) хэлэв: “Бух гөрөөсийг хэн хүн алж арван гурван үе сүүлийг огтолж авсан хүн Рогма гуаг автугай” гэв. Хамаг улс очин, Жур хүрээд бухыг алангир нум, шихнэг сумаар бухын хоёр нүдний дундуур шувт харвав. Арван гурван үе сүүлийг огтолж авав. Цотон ноён хүрч ирэв. “Авай Жур минь, үүний хойно чамайг бүү зэмлэе. Чамайг бүү жанчъя Өөрийн үрээс нэн дотно саная би. Арван гурван үе сүүлээ над өг” гэв. “Авай сүүлийг яах вэ, өгье. Би сая саадаглаж (ан хийж) явна. Над исманда нэрт сумаа өг” гэв. “Сум яах вэ, май” гээд өгөв. Жур хувилгаанаар сүүлээс гурван үе огтолж аваад өгөв. Цотон ноён олонд авчин очив. Авчин цуглаж ирэв. Цотон ноён их дуу гарган дуудав: “Бухыг би алсан. Арван гурван үе сүүлийг би огтолж авлаа. Рогма гуаг би авах буй” гэв. Жур хүрч очив. “Эвий эвий! Цотон авгай яасан нүгэлт худалч билээ чи! яасан чивэлт худалч билээ чи! Бухыг би алж, арван гурван үе сүүлийг огтолж байтал минь чи хүрч ирээд “Авай Жур минь Үүний хойно бүү хараая, бүү жанчая. Өөрийн үрээс нэн хайрлая. Энэ сүүлээ над өг ” гэж эс хэлэв үү чи? “Авгай сүүл ч яах вэ өгье. Би сая саадаглаж явна. Над исманда нэрт сумаа өг” гэж эс хэлэв үү би? “Сум ч яах вэ? ” гээд над эс өгөв үү чи?” Сумыг сугалж үзүүлэв. “Эвий эвий! Энэ муугийн аашийг үз та. Эмээ авахад саадаг хадгалсан хүнээс минь хулгай хийж аваад дэмий донгодном бишүү энэ гэв. Жур: “Зөв бишүү. Одоо сүүл чинь бүрэн байна уу? Үз” гэв. Сүүлийг үзэв. Гурван үе дутуу байв. Жур: ”Гурван үе нь аль вэ ?” гэв. Цотон ноён дуу үл гарна. “Нүгэлт худалч чиний иймийг мэдээд би гурван үе сүүлийг аваад өгсөн минь энэ бишүү гэж өврөөсөө гурван үе сүүл аваад үзүүлэв. Цотон ноён ичиж буруу хандаж явж очив.

Жур мөн тэр шөнө Цотонгийн зуун найман хайнаг үхрийн үнэтэй хар морийг хулгай хийж алав. Цотон ноён маргааш нь нэгжихээр ирэв. Нэгжиж мориныхоо махыг гаргав. “Ээ! яалаа” гэж, төвд тангадын цэргийг хурааж ирэв. “Журыг алья” гэж ирэв. Цотон ноён түрүүлж зэр зэвсгээ хуягаа өмсч айсуу. Жур улаан хонгор царайтай их хүүхэд болж хувилав. Хэтэвчнээсээ дуурсахуй нэрт нумаа гаргаж татав. Татахад мянган луугийн дуу мэт хүрхэрч дуу гарна. Цотон ноёноос тэргүүлэн дутаав.

Маргааш Цотон ноён бас хэлэв: “Нэг өдрийн авд түмэн бух гөрөөсийг алаад түмэн бухын махыг нэг бухын сархинагт багтааж чадсан хүн, Одос мөрөнд хэн хүн олом гаргаж чадвал тэр хүн Рогма гуаг автугай” гэв. Чингээд олон вчин бүгд яьяв. Рогма гуа Жүрд нум сумаа үгүйн тулд тэмээчний нум сумыг авчирч “Жур минь хугалуузай” гэж өгөв. Жур хуга татаж орхив. Рогма гуа бас үхэрчний нум сумыг авчирч өгөв. Жур бас хуга татаж орхив. Би адуучны нум сумыг авчирч өгөхдөө : “Авай! Жур Үүнээс хойно нум сум бий болбол хавьс(хаврига) минь болтугай” гээд өгөв. Жур нмыг хуга татаж орхиод явж одов. Хүртэл авчин бух гөрөөсийг харваж агнаж байв. Жур явж хувилгаанаар нэг өдрийн авд түмэн бух алав. Түмэн бухын махыг нэг бухын сархинагт нь огтчоод хийж багтаав. Нэг бухын сүүлийг аваад шорогт өлгөөд явав. Олон авчин төөрч явтал Журьын тэр тэмдэгийг дагаж явав. Одоо мөрөнд хүрч түмэн хүн олом гаргаж эс чадав. Жур хүрч бух гөрөөсийг авчирч шахав. Бух эврийнхээ үзүүрийг цухуйлгаж мөрнийг гарч вав. Чихтэйг (хулан) авчирч шахав. Хажуугаараа ус хүргээд гарч явав. Зээрийг

авчирч шахав Жур хувилгаанаар Цотонгийн нүдэнд туруун чинээ (туурай хүрэх устай) болоод гарах мэт үзэгдэв. “За гурван их ноёд! олом гаргав. Олом сонго” гэв. Цотон ноён: “Би зээрний олмоор гаръя” гэв. Сэнлон”Би чихтэйн олмоор гаръя ” гэв. “Царгин авгай юу гэж дуугүй байна?” гэв. “Авай Жур минь чи мэд ” гэв. “царгин авай минь чихтэйн олмоор гар” гэв. Сэнлон, Царгин, хамаг авчин бүгдээр одлоо урсав. “Авай Жур тат” гэж дуудав. Жур ташуураа барин гүйж оров. Цотон ноёныг одоо ташуураар боомлож усны захад гаргаж ирэхэд “авай Жур, гаргахыг ч гаргалаа, боомыг цол авнам за. Би яая?” гэв. “За над өөр аргагүй ” гээд орхив. Цотон ноён бас бас урсаж амь нь тэмцэж явна. “Авай Жур тат” гэж бархиран явна. Жур гүйж оров. Жур Цотногийн үснээс нь үгтээж толгойг нь хожгор болгож айсуй. усны захад ирэхэд Цотон ноён бас хэлэв: “Авай Жур! Авч гарах нь ч авч гарлаа ёи. Хожгор цол авнам за. Би Яая?” гэв. “Зөв” гээд орхиод ирэв. Бас урсаж явнм. “Авай Жур! Одоо чи татаасай, үхнэм. ” гэв. Жур үл хөдөлнө. Улс нь : “Хайран хүн үхэх нь Жур татаж аваасай” гэв. Жур ташуураа хувилгаж хоёр иртэй илд сэлэм болгож өгөв. Цотон сэлэм дээрээс ноцов. Цотонг ч чирч вч ирсний дараа хоёр алга нь тасар яв, “Авай Жур авч гарах ч гарлаа чи, хоёр алга минь аль вэ?” гэв. “Хичнээн гэмийг над оногдуулж байна вэ ?” “хэдийг ч л хэлсэн” гэв. “Авгай гайгүй буй. дуу” гэв.

(Тэндээс хамаг бүгдээр Одос мөрөнд хэн олом гаргав, түүнд цол нэр өгье гэж хэлэлцэв. Энэ Журд цол өгье гээд Сал Дива гэж нэрийдэв.)

(Бүгд) авчин явж тэр шөнө хээр хонов. Их хүйтэн бороо оров. Түлээ аргал үгүй . Цотонгийн хүний хэл мэдэх нэг нохой байсан аж. Нохойг явж, Жур юу хэлэлцэж сууна сонс гэв. Жур хувилгаанаар нохойн ирснийг мэдээд хэлэв: “Маргааш нум сумтын голд бууна. Нум сум олж авнам за. Нум сумаа эвд. Гуталтын голд буувл гутал олох буй. Гутлаа хайнагийн эврээс өлгө . гурван хүний өвдөгөөр тулга тулж идээ чана. Идэж хоно. Хоосон бүү хоно.” Гэв. Нохой очиж Цотонд хэлэв. Журын үгийг бултыг тоочиж хэлэв. Цотон ноён их улсдаа зар хэлэв: “Маргааш нум сумтын голд орвол нум сум олно гэнэ. Гуталтын голд буувал гутал олох гэнэ. Гурван хүний өвдгөөр тулга тудж идээ чанаж ид. Энэ шөнө хоосон бүү хоно. Идээ идэж хоно.” Гэв. Цотон ноён босон нум сумаа эвдэж гурван хүний өвдөгөөр тулга тулав. Гутлаа хайнагийн эврээс өлгөв. Гал шатаж ирэхэд гурван хүн нь “Халхай” гээд тогоогоо түлхэж орхив. Идээ идсэнгүй хоосон хонов. Маргааш үүрийн хаяагаар Цотон ноён мордож Журд очив. “Авай Жур би юу?” гэж дуудав. “Авгай юу вэ?” гэж гарч ирэв. “Жур нум сумтын гол гэдэг чий хаана биилээ?” гэж асуув. “Авгай тийм юу вэ? Ямар үг вэ?” гэв. Нум сумтын голд буувал нум сум олох, гуьалтын голд буувал гутал олж авах гэсэн гэв. “Чамд хэн хэлээв? Авгай” гэв. “Над мий нохой хэлэв” гэв. “Нохойтой хэлэлцэх болбол чи сайн хүн байна” гэв. Цотон ичиж буруу харж явж одов.

Эргэж ирээд “авай энэ шөнө зүүд зүүдлэв гэгч чинь үнэн үү?” гэв. “За тэр минь үнэн билээ, авгай!” гэв. “хар бух харвавал гайтай, халзан бух харвавал айгүй гэж зүүдлэв би” гэв. Маргааш үүрийн хяраанаар их улс ав тавина. Цотон ноён одоо хар бух таарвал харвахгүй хар халзан бух хайж явна Үүрийн хяраанаар их бух магнай хоорондоо цантай (хяруутай) гүйж ирэв. Цотон ноён энэ хар халзан бух байна гэ хөөв. Хөөж явтал магнай хоорондох цан нь арилав. “энэ хар бух байна. Би буруу хөөж байна” гээд харьж ирэв. Авд орж явтал эвэр хоорондоо цас өлгөсөн

(наалдуулсан) бух гүйж ирэв. Энэ хар халзан бух гэж хөөв. Хөөж морьтой нохойгоо хөөж эргүүлж Журын дэргэд авч ирэв. “Авай Жур! Ахай Жур энэ бухыг харваж ал” гэв. “ээ авгай минь! Харвавал мууг эс мэдэв үү чил?” гэв. “Бух харвах гээд чиний морь нохойг чинь харваж алах буй. Харвахгүй” гэв. “авай Жур! Морь нохойд хамаагүй. Бухыг алж өг” гэв. “за авгай, тийм болбол миний морь муу, гүйцэхгүй. Намайг дайруулж эргүүлж авч ир” гэв. Отно ноён бухыг гүйцэж эргүүлж авч ирэв. Жур хорхойноос нь явж хувилгаанар Цотонгийн морь нохойтой нь нэвт харваад бухыг алж орхив. Цотон ноён бухын дэр буув. “авай Жур! Бухыг алах ч алла чи. Хайран морь нохойг аль” гэв. “За авгай гэгч нь нэг гэм хэлнэ биз гэж бодсон, үнэхээр хэлэв чи над. Би харвалгынхаа мууг чамд хэлсэн шүү” гэв. Жур хэлэв: “Бух чинь хар халзан бух биш, хар бух байна” гэв. Цотон ноён үзээд: “Авай яая би?” Халзан бух гэж хөөсөн минь хар бух байна. Авгай Жур яая? Гэв. “авгай! үүний гай нь морь нохой хоёрт болтугай! Авгай дуу!” гэв. “Авай минь, энэ чинь сайнс айн” гэв. Цотонгийн морь сайн, нохой нь хүний хэл мэдэхийн тулд Жур хувилгаанаар морь нохой хоёрыг алав.

(Тэндээс маргааш нь эрт авлахад Цотон хамаг улсад зарлав: “Түмэн бух гөрөөсийг алаад нэгэн сархинагт хэн хүн быагтааж чадвал тэр хүнд Рогма гуаг өгье” гэсэнд нэг ч хүн эс чадав. Бадмарын хөвгүүн Бам Сорза) чадах байсан ажээ. Жур таван аргыг хувилгаанаар аваад эс чадуулав. Тэр Бам Сорза түмэн бух гөрөөсийг алаад сархинагт нь хувилганаар багтаагаад нумын хичирт өлгөж явав) Хамаг улс авчин гэр гэртээ харв.

Рогма гуа угтаж ирэв. Царгинаас асуув: “Нэгэн өдрийн авд түмэн бухыг хэн алав? Одос мөрөнд хэн олон гаргаж чадав?” гэв. Царгин авгай: “Хэн чадах билээ? Миний Сал Дива чаах буй за” гэв. “Сал Дива гэгч хэн болов?” гэж Рогма мэдэн ядаж явав. Журд цол дуудасныг (олгосныг) эс мэдэж асуув. Цотонгоос авгай мөн тэр нэрийг асуув. Цотон: “Хэн хэн чадах билээ?” гэж дотроо гайхаж явав. Рогма гуа гэртээ харив. Жур үхэр унаж нэгэн шороог барьж үзүүрт нь бааст сархинаг өлгөж ирэв. Хадам эх нь угтаж гарч хүргэний алсан бухын мах буулгая гэж ирэв. Ирээд “Эвий эвий! Олон авчин намайг хуурч байна. Чи энэхэн сархинагт хийсэн баасыг юунд авч ирэв? Эмийгээ юугаар тэжээх вэ?” гээд гэртээ уурлаж оров. Хадам эх нь Журын сархинагтай махыг тогоон дээр орхив. Тогооны хэлхээ оосор татарч унан алаж байв. “ай ай! Хүргэн, энэ юу вэ?” гэв “Баастай сархинаг билээ” гэв. Гүйж гэртээ ороод махыг баганаар түлхэж орхив. Эх нь нэг зуух ухаж тогоо тавив. “эжий минь! энэ миний алсан бугын мах. Чиний ганц тогоонд багтахгүй” гэв. “Энэ айлын тогоог авчирч чана” гэв. Хадам эх нь айлын тогоо хураая гэж зүг зүгт илгээв. Олон зуух ухаж тогоонд ус хийв. Мах уйв. Булт дүүрч байна. Мах болж гаргавал олон хүн ирж иднэ. Хадам эх нь сархинагын нэг талыг идэв. Хадам эхийн хэвэлдээ мах шингээн ядаж үхмээр болж хэвтэнэ. “Эжийгэн минь гэдэс дүүрч үхэх нь байна” гэж Жур гурван алд цагаан модоор хэвлийг дээш гурав, доош гурав үе илэв. Эх нь дээш бөөлжиж, доош суулгаж эхлэв.

Цотон ноён үзэн ядаж зарлав: “гардийг хэн хүн алж, хоёр сайхан отгыг (өдийг) хэн хүн аваад (Рогма гуагийн малгайд хадаж чадвал) тэр хүнд Рогма гуаг өгье гэв. Хамаг улс хайдаг ав хийхээр нүүв. Жур хувилгаан биеэр огторгуйгаар очив. Муу (жинхэнэ) биеэр алтан дэлхийгээр очив. Жур хүртэл түмэн хүн хурж, гардийг хрваж үл хүргэж байна. Бадмаарын хөвгүүн Бм Сорза гардийг эгэм дундуур шувт харвав. Жур очоод гардийг магтв. “Хүрхрэх дуу

чинь ийм сайхан байна, хүзүү хоолой чинь хэдүй чинээ сайхан бол? ” гэв. Хүзүү толгойгоо үзүүлэв. Гарди : “Хүзүү толгой чинь ийм сайхан байна, хөвчин бие чинь хэдүй чинээ сайхан бол?” гэв. Хөвчин биеэ үзүүлэв. Бас “ХӨвчин бие чинь ийм сайхан байна, хүрс хүрс, ийш тийш дав дэв хийж нисвэл хэдүй чинээ сайхан бол?” гэв. Дав дав хийхэд нумаа татаж харвав. Харваад алав. Хоёр сайхан огтыг(урт өдийг) нь хувилгаанаар огторгуйгаар аваачиж Рогмагийн малгайд хатгав. Гардийн унасан биеийн өдийг олон улс бүгд дэд дэдээрээ булаалдав. Журыг энэ ч хүн түлхэж орхиж, тэр чхүн түлхэж орхиж явав. (жур нэг ч чандруу авч эс чадав.) Жур уйлагч болж байв. Рогма гуа уйлв. “Улсын сайн эрс гардийг алж отгыг нь эмс эмсдээ хатгаж өгөв. Эр минь Жур надад хатгаж өгсөнгүй. (Над отго байхгүй) гэж уйлв. Рогмаг олон улсын эмс үзэж уйлалдав. Бүгдээр “Нусгай муу Жур Рогма гуад гардийг алж хоёр сайхан оотгыг хатгаж өгөв. манай сайн эрс ийм хатай болоосой” гэж уйлав. Хамаг улс гэр гэртээ харив.

Жур эс харив. Рогма гуа харив. Гэртээ гүйж ортол хоёр сайхан отго нь хатавчинд нь тулж байв. “Энэ яасан жиг билээ?” гэж малгайгаа авч үзэв. Үзээд отгыг үзэв. “жур хувилгаан байсан байжээ” гэж баяртай явна.

Хойно нэг өдөр Рогма гуа, Журын мөрөөр мөшгөв. (рогма гутлыг өөрөө хийсэн тул гутлын улын мөрөөр андахгүй мэдэх ажээ) Гэсэр нэг хадны хөндийд хамаг сахиусныхаа дэргэд сууна аж. Их хурим хийж байна. Рогма гуа гаднаас шагайж үзэв. Гэсэрийг хараад “Миний эр ийм сайхан болоосой” гэж санав. Чингээд Рогма гуа гүйж оров. Чингэтэл Гэсэр биеэ хувилж Жур биеэр суув. Арьяа Аланкари охин цагаан тэнгэр Рогма гуад зэрлиг болов: “Ай бэр! Энэ өдөр чамайг олон сахиус бүгд цуглаж мөргүүлж байна. Энэ хуримаас ямарваа идээ өгвөл идээрэй чи. ” гэв. Рогма гуа “За” гэв. Их хурим дуусав. Дууссан хойно Арьяа Аланкари охин цагаан тэнгэр рогма гуад нэг болсон (Чанасан) хүүхдийн аяганд хийж авчирч өгөв. Рогма гуа (нялуун гээд) эс идэв. ТТүүний хойно үхсэн хүний хурууг авчирч өгөв. Рогма гуа огтолж зажлаад (хатуу гээд) нулимж орхив. Арьяа Аланкари охин цагаан тэнгэр (машид уурлаж) хэлэв: “Бид юу хэлэлцсэн билээ? (Нүгэлт бэр чи яагаад идсэнгүй вэ?) Их хуримчид тархав. Рогма гуа арга ядаад Арьяа Аланкари охин цагаан тэнгэрийг хормойдов. “ Ай бэр юу вэ?” гэв. “Чамаас үр гуйнам би ” гэв. “Чи түрүүчийн идээг идсэн бол Гэсэрээс илүү гурван хүүхэд төрөх билээ : Гэсэртээ тэнцүү гурван хүүхэд төрөх билээ Гэсэрээс доор гурван хүүхэд төрөх билээ. (Ирээдүйн цаг болтол Гэсэрийн үр тасрахгүй болоод хамаг амьтан тэгш жаргах билээ) Ай бэр чи идэж эс чадв. Одоо хэдийг өг гэнэм? Гэв. “Охин цагаан тэнгэр! Хэдийг өгөхөө чи мэд” гэв. ”Зуун наймыг ав” гэв. Охин цагаан тэнгэр, Жур хоёул Рогма гуаг гэрт нь хөтөлж ирээд гарч очив.

Жур эхнэртээ гавьяагаа тоочив.

Журыг гарсан хойно Рогма гуа уйлаад хадам эхдээ үг хэлэв: “Ай эжий минь! төдийгөөс өдий болтол аль бүр би ингэж зовох вэ? Чиний хөвгүүн чинь намайг зовоож байна. Зүгээр явахгүй зовж явахаар боож үхье би. Эрлэг хаанд заалдья би : Цаган нүд минь шарлав. Хар нүд минь цайв” гээд гарч одов. Рогмаг гарсан хойно Журын эх нь Журыг дуудав. Жур ирэв. “Эм чинь Рогма гуа үхье гэнэм. Төдийгөөс өдий болтол зовов би гэнэ. Эрлэг хаанд заалдья гэнэм. Хүний охин үхүүлж над муу нэр болохоос зүгээр яв. Авай минь!” гэв. (Жур өгүүлрүү : “Нэжээд хошоод зүйл дутуу билээ. Эхийн зарлигаас үл давахын тул одоо Гэсэрийн биеэр хувилъя” гээд гадаа гарч арван зүгийн бурхан, гурван эгчдээ есөнтэй мөргөж эхийн гэрт ороод эхдээ гурвантаа мөргөөд өөрийн гэрт ороод) Гэсэр мэргэн хааны биеэр болоод хэвтэв. Рогма гуа гаднаас шагайж байгаад гүйн орж Гэсэрийн дээрээс дарав. Гэсэр зарлиг болов: “Эр хүн эм хүний дээрээс дарах ёстой буй за. Эм хүн эр хүний дээрээс нь дарах ёс бий юу?” гэв.

Рогма гуаг дөрвөн зүгт хандуулж есөн ес гучин зургаан сургаал үг зрлиг болов. Зарлиг борсон хойно “намайг төрөхөд чөтгөрийн хар хэрээ нэг настэй хүүхдийн нүдийг цохиж нүдгүй болгоход нүдэн дээрээ есөн салаа төмөр урхиа тусгаж чөтгөрийн хар хэрээг барьж алаад нүдэн дээр нүд нэмсэн Нүдэн Гэсэр хаан би билээ .

Хоёр насанд минь ямаан шүдэт нохой хошууг төмөр араат чөтгөр Гүнгү эцэг Гэло лам болон хэлний үзүүрийг тас хазаж хэлгий болгоход дачин таван дцн цагаан шүдээр зууж, үл хөхөж хэвтэхэд “таны энэ хүүхэд язгуур (угаас) ийм билүү ? Өнөө ийм болов уу? ” гэхэд эцэг эх минь хэлэв: Язгуур төрөхөд амтай хамартай билээ. Өнөө үхэх гэж ийм болов уу? Эс мэдэв“ гэв. чингэхэд лам хэлэ хөхүүлэв. Хэлийг нь баахан хөхөгч болоод сайн хөнөм гэхэд улам хэлээ их хөхүүлнэм. Хөхөгч болоод хэлийг багалзуураар нь дөчин таван дун цагаан шүдээрээ тас хазаж алсан. Хоёр насандаа хэлэн дээр хэл нэмсэн Гэсэр хаан би билээ .

Гурван насандаа чивлий оготно газрын хөрс урвуулж Монгол улст муу үйлдэж явахад үхэр хариулагч өвгөн хүн болон хувилж бага болд сүхээ барьж очиход минь чивлийн оготно шар үхрийн чинээ хоёр эврийг хооронд цохиод алав. Гурван насандаа чивлийн оготны газрын хөрсийг урвуулж. монгол уус муу үйлдэж явахад чивлийн оготныг алсан арван зүгийн ачит Гэсэр богд мэрэн хаан би билээ .

Дөрвөн насандаа болморын хоолойд очиж долоон албин дөрийн долоон зуун хүн, долоон зуун морь заяатай заяагүйг идэж байхад Жур биеэр хувилж долоон албиныг их далайд унагааж алсан, (амьтны амин дэмээр амь нэмсэн арван зүгийн эзэн Гэсэр богд мэргэн хаан би билээ .

(Таван насан Энхрэхийн зоонд очиж нутаглаад, Энхрэхийн Зоош өлзийт сайн нутаг болгоод, Нолом талд (Тагзикийн) Эрдэнийн хааны таван зуун урчуудыг хурааж хувилгаанаар гурван өдрийг нэгэн өдөр болгож ган халуун болгож хэдгэнэ зөгийгөөр ээрүүлж усгүй болгож, таван зуун худалдаачнаар эцэг эхийн ач хариулахын тулд Хоншим бодисадын сүм бариулж Энхрэх

Зоог өлжийт сайн нутаг болгосон богд Гэсэр хаан би билээ .

Зургаан насандаа Рогма гуа чамайг гурван харвагч чи дагины хувилгаан Рогма гуа билээ гэж ирсэнд гурван бөхийг чинь аланд, гурван харвагч мэргэдийг чинь харваж гарсан (дийлсэн), гурван түмэн хүний тэргүүнийг төөрүүлж чамайг авсан, бас Цотон ноён үзүн яван хүрч гурван түмэн хурч морь уралдуульа гэхэд тавих бэлэг шавдаг хуяг, дуурсахуй нэр дуулга, томорцог нэрт илд, түмэн олон нэрт бамбай чимгүүдийг тавьж “Морь уралдъя. үүнд хэний морь гэрвэл тэр эрдэнийг аваад Рогма гуаг тэр хүн авъя ” гэв. Чингээд олон улс хурав. Би огторгуй дахь Навса Хүрээ эмэг эхдээ залбирч билгийн хээр морио сан тавьж барьж унаад гурван түмэн хүнийг гарч (ялж) олон эрдэнэт чимгийг авч Цас Чихэр ахдаа өгөөд, хамгийн тойндоо (эрхэндээ) оруулсан тойн Гэсэр хаан би билээ.

Долоон насандаа бас Цотон ноён үзэж ядан хүрч ирээд “Бух гөрөөсийг хэн хүн харваж алаад арван гурван үе сүүлийг хэн хүн урьд огтолж авбл тэр хүн Рогма гуаг автугай” гэв. Хамаг улс очив. Би хойноос нь хүрээд алангиир нум, шихнэг сумаар бухын хоёр нүдний хооронд шувт харваж алсан, хамаг улсбг тойндоо оруулсан, Цотонг ичээн хариулсан хавт Гэсэр хаан би билээ .

Найман насанд минь Цотон ноён бас “Нэг өдрийн авд түмэн бух хэн хүн алвал Одос мөрөнд хэн олом гаргавал тэр хүн Рогма гуаг автугай” гэв. Хамаг авяин хайдгаар (ачаагүй) нүүв. Жур биеэр алтан дэлхийгээр очиж, хувилгаан би?эр огторгуйгаар очив би. Бадмаарын хөвгүүн Бам Сорза эгэм дундуур шувт харвасан хойно би хүрч гардгийг толгойн тас харвад хувилгаан биеэр гардийн сайхан хоёр отгыг авч чамд хатгаж өгсөн, хамаг харвагчийг гарсан хвт Гэсэр хаан би билээ .

Арван насандаа эцэг эхийн ачийг хариулахын тулд Хоншим бодисдын сүм босгосон богд Гэсэр би билээ .

Арван нэгэн насандаа муу өвчний эзэн Ругмо Нагво нэрт чөтгөрийг барьж алсан баатар Гэсэр хаан би билээ .

Арван хоёр насандаа хавангийн эзэн төмөр сүйхт чөөтгөрийг барьж алсан, хаванг тасалсан хамгийн эзэн Гэсэр хаан би билээ .

Арван гурван насандаа боомын эзэн гүзээн толгойт чөтгөрийг алж, боомыг тасалсан богд Гэсэр хаан би билээ .

Арван дөрвөн наанда лусын хааны охин Ажу мэргэн, Гэсэр хоёул авд мордов. Ажу мэргэн, Гэсэр хаан хоёр хамт явахад Гэсэр хааныг долоон бух дайрав. Долоон бухыг шувт харваад, газар хадтал харвав би. Түүний хойно Ажу мэргэнийг есөн бух дайрч ирлээ. Ажу мэргэн есөн бухыг шувт харваад хадыг хадтал харвав. Одоо Гэсэр хаан “эр эмийг яаж мэдэх вэ?” гэж дотроо санав. Тэгж байтал нэгэн бух дайрав. Гэсэр хаан онон ядаж их улсаас хөөж гаргав. Ажу мэргэн хойноос минь хөөж очив. Гэсээр хойшоо харж үзээд “Би ч эм хүн билээ. Надаас энэ хойд хүн муу эм мэт байна” гэв. Ажу мэргэн хэлэв:”Өчигдөр болоход Амадайн хөвгүүн Төмөр хадайг алж, буурал морийг авла би. Өнөө болоход арван зүгийн эзэн Гэсэр хааныг алж, хээр морийг авах минь энэ” гээд хөтөлж явна. Гэсэр эс хөдөлж хэвтэнэ. Гэсэр нэг

хувилгаанаа өөр хүн болгож дуудав : "ажу мэргэн, арван зүгийн эзэн Гэсэр хааныг алав гэж Цас Чихэр ах нь гурван отог улсыг хурааж, Ажу мэргэнийг алья талъя гэнэ" гэж дуудав. Ажу мэргэн нуусан үсээ тайлж, баруун гөхлөө "Эцэг ахад минь бүү болтугай" гэж баруун гарынха уруу дэлгэж орхив. Зүүн гөхлөө "Дүү эхэд минь муу бүү болтугай" гэж зүүн гарынхаа уруу дэлгэж орхив. Гэзгээ "Хятад боолд минь муу бүү болтугай" гэж хойшоо дэлгэж орхив. Төдий Гэсэр мэдээд босон барилдав. Гэсэрийг нэг сөгтгөв. Гэсэр хэлэв: "Эр хүн гурван удаа барилдах биш үү. Дөрвөн үе тоосоо гөвөлцөх бишүү" гээд бас барилдав. Гэсэр: "Би дийлбэл чамайг алья" гэв. Ажу мэргэн "за гэв. Чигчийгээ хатгаж цусыг долоолгов. Одоо хоёул их далайд ус уухаар очив. Усанд хүрч очиход усн дотор сумын сүүдэр гялалзахыг үзэв. Гэсэр хэлэв: "миний хойноос хүн нум сум тэлж байна уу?" гэж хойшоо харж үзвэл Ажу мэргэн нум сумаа тэлж явав. Гэсэр хэлэв: "Чи юу гэж ингэнэм?" гэв. Ажу мэргэн хэлэв: "Би чамд тэлсэнгүй, далай дотрх загасанд тэлсэн билээ гэв. Үгээр нь загас үхэж, далай уланаар хөдлөж байв. Хоёул далайд хүрч ус уугаад, Гэсэр хувцсаа тайлж далайд умбаадтэр далайн тэртээ гарч суув Ажу мэргэн хүлээж сууж ядав. Дээл хувцасаа тайлж далайд ороход Гэсэр мэдээд исгэрч салхи хөдөлгөж хуй слахи болгохд Ажу мэргэний дээл увцас нь модны үзүүрт өлгөгдсөн байв. Гэсэр харин ирээд дээл өмсөж байхад нь Ажу мэргэн дайрч Гэсэрийн өвөрт оров. Гэсэр дөрвөн зүгт есөн есөн сургаал үг болов. Арван дөрвөн насандаа лусын хааны охиныг авсан арван зүгийн эзэн Гэсэр ачит богд мэргэн хаан би билээ .

Арван таван насандаа эдүгээ тэнгэр мэт тачёингаж, луу мэт хүрхэрч явах минь энэ буй за . Тэр үг өгүүлэхэд тэнгэр дуугарч, луу хүрхэрч рашааны хур орж байв. Гэсэрийг зарлиг болж байхад Рогма гуа нэгэн үе уйлж, нэгэн үе инээж суув. (Тэндээс хамаг бүгдээр Гэсэрийн биеэр болсныг сонсоод Цас Чихэр тэргүүлэн Дос, Донсар, Лин гурван отог улс цуглаж ирээд их хурим хийж хөг дуугаар цэнгэлдэн жаргав.)

**АРВАН ТАВАН НАСАНДАА АРВАН ЗҮГИЙН ЭЗЭН ГЭСЭР ХААН ГУЧИН
БААТРА ДАГУУЛЖ УМАР ЗҮГ ДЭХ УУЛЫН ЧИНЭЭ ХАР ЭРЭЭН
БАРС МАНГАСЫН ХУВИЛГААНЫГ АЛСАН НӨГӨӨ БҮЛЭГ**

Тэр цагт умар зүгт Мангасын хувилгаан уулын чинээ хар эрээн барс байжээ. Байх бие нь зуун бээрийн газрыг эзлэр ажээ. (Өндөр нь их гэсэн уулнаас үлэмж их гэнэ. Сүүл нь таван зуун алдын хар болд илд шиг хоёр иртэй, ийш тийш шарвахад тэнгэрийн цахилгаанаас нэн үлэмж гэнэ.) Баруун самсаанаас нь гал мандан шатаж, зүүн самсаанас нь утаа бургилж байна. Хүнийг хоногийн хоногийн газраас үзээд үдийн газраас үрэхийж залгина гэнэ. Арван зүгийн эзэн Гэсэр хааны ялгуусан гурван эгч нь Жамца Дари Оддам эгч нь гэсэрт очив. “Ай нусгай минь мэдэв үү чи? Умар зүгт мангасын хувилгаан уулын чинээ хар эрээн барс буй гэнэ.” Гэж хувилгаанаар ялгуусан гурван эгч нь зарлиг болгов. “энэ Замбутивийн улс чинь тэр барсын дэргэд явах ёсгүй гэнэ. Түүнийг хичээж дайл (байлд)! Авай минь ” гэв. “Эгчийн минь зарлиг зөв. Би эс мэдлээ. Түүнийг одоо очиж дайल्या” гэв.

Эрдэнэт Цас Чихэр ахдаа, гучин баатартаа элч илгээв. Тэд бүгдээ дэд дэдээр дуудаж “Ир” гэв. Тэд бүгд нь хүрч ирэв. Цас Чихэр айлтгав. “Манийг юунд ир гэв? Ай богд минь! гэв. Гэсэр хаан зарлиг болов: “Ай Цас минь! чи сонсов уу? Умар зүгт уулын чинээ хар эрээн барс буй гэнэ. Хүнийг хоногийн газрас үзээд, үдийн газраас өрөвхийж залгина гэнэ. Түүнийдэргэд улаан хөлт хүн үл байх гэнэ. Арван таван насандаа хүртэл алива зүйлээр хувилж явж тандаа нэг ч удаа баатрын бэлэг (шинж) эс үзүүлэв би. Баатрын ыэлэг үзүүлэе, яв” гэв. Арван зүгийн эзэн Гэсэр хан хээр морио унав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуягаа өмсөв. Цахилгаан өнгөт далавчаа дүрэв. Наран саран хоёрыг хамтаар зэрэгцүүлэн хийсэн манлай цагаан дуулгаа эрдэнэт тэргүүндээ асаав. (өмсөв). Оюун эрдэнэ оньт гучин цагаан сумаа дүүрэв. Догшин хар нумаа дүрэв. Билдгийн гурван алд хар шор сэлмээ зүүв. “Миний хойноос хүний харцага болсон Цас Чихэр минь жигүүр бор морио уна! Шавдат хуягаа өмс! Дуурсахуй нэрт дуулга эрдэнэт тргүүндээ өмс! Гучин цагаан сумаа дүр! Догшин хар нумаа барь. Хүрмэ нэрт цул болд илдээ зүү! Намайг Цас Чихэр минь дараалж яв.” гэв. “Шумуурын хойноос нь Бадмаарын хөвгүүн Бам Сорза сайн хөх мориой уна! Хөх гадарт хуягаа өмс! Хөвчин зэр зэвээ ав! Шумуурын гэзгийг чи удаал (дараа нь яв.) гэв. “Бам Сорза хойноос нь хүнй нагац болсон Буйдан минь гүйлэн бор морио уна! Хамаг зэр зэвээ ав! Гучин баатар минь чамайг дагаж дэд дэдээр явна. Гэзгээ (цуваагаа) бүү тасал. Бам Сорзыг чи удаал!” гэв. Энэ үг зарлиг болоод арван зүгийн эзэн гэсэр хаан гучин баатраа авч явав.

Явбал уулын чинээ хар эрээн барсыг хоногийн газраас харж үзэв. Үзээд : “Уулын чинээ хар эрээн барс тэр буюу” гэж Гэсэр хааныш зарлиг болоход эрдэнэт Цас Чихэр “Та дуугүй яв. Та нар харахгүй ” гэв. “Гэсэрийн жолоо хаагуур болбол, түүгээр явья ” гэв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан лугшин хатирав. Уулын чинээ хар эрээн барс үдийн газраас дутаав. Арван зүгийн эзэн Гэсэр хаан билгийн хээр морио тас гуядан давхив. Гэсэрийн хойноос нь гучин баатрууд дэд дэдээрээ дараажлж явав. Уулын чинээ хар эрээн барс үдийн газраас Гэсэр хээны өрөвхийж залгиж алдав. Алдуулаад барсыг гүйцэж эрэгцүүлж явав. Гучин баатраа хүчр ирэхэд “Тэд чухам баатар уу? Баатар биш үү? Сорье” гэж барсын аманд хувилгаанаар оров. Ороод барсын доод, уруул, хоёр соёог хоёр хөлөөрөө гишгэв. Тагнайг толгойгоороо тулав. Хоёр завжыг нь тохойгоор тулаад явган суув. (Төдий билгийн хээр морь нь алд цулбуураа яирж гурван ертөнцөд хүнгэртсэн янцгааж явав. Билгийн хээр аорь нь Цас Чихэр эхлэн гучин баатарт өгүүлрүүн: “Гэсэр богдыг барс залгивай” гэсэнд Буйдан түүнийг сонсоод барсыг үзэж маш ихэд айгаад “одоо биднийг залгих болно гээд ” гучин баатрыг дагуулан дутаав. Цас Чихэр Буйданг үзээд “Ээ! байз. Буйдан яалаа чи ? ” гэж Буйданг дуудав.

Буйдан хойшоо харалгүй дутаагаад их уулст хүрэхийн рууд захын бэлчирт(нутагт) хүрэв.

Гэсэрийн дэргэд эрдэнэт Цас, хүний бүргэд болсон Шуумар, Бадмаарын хөвгүүн БамСорза энэ гурав ыаатар үлдэв. Цас Чихэр нөгө хоёр баатартаа үг хэлэн уйлав: “Арван зүгийннарван хорын үндсийг таслагч ачит Гэсэр бгд мэргэн хааны минь уулын чинээ хар эрээн барс загив. Муу Буйдан гучин баатрыг аван дуьаав. Богдын минь хайраннэр. Одоо бид гурвуулыг дутаавал хэдэн догшид юу гэнэм? Атаат ах дуу Шарайголын гуван хаан юу гэнэм? Та хоёр минь юу санам ? ” гэв. “Бид хоёл юу мэдэх вэ? Цас Чихэр минь мэд” гэв. “Намайг мэд гэж хурим хуримлахыг мэд гэнэм үү? Орвол ор, харьвал харь. Та хоёрын зориг ” гээд Цас Чихэр уйдлж байж жигүүрт морио тас гуядав. ()Билгийн хээр морь өгүүлрүүн : “Цас Чихэр авгай минь! арван зүгийн эзэн богдыг залгивч өалтан дагина (Рогма), та хоёрыг түшэж авбал богдын нэгэн биеийн тадий бизээ? Алалдахыг байг! ” гэв. Цас Чихэр өгүүлрүүн : “Эцгээ! Чи нүүрэндээ үстэй морь гэгч ийм үг хэлж байна. Нүцгэн нүүртэй Цас Чихэр би богдыг барст залигуулаад амьд харьсанаас үхсэн минь дээр гээд) Хүрмэ нэрт цул болд илдээ суга татаж барст очих зуур санав. “Арван зүгийн эзэн гэсэр хаан маань хувилгаан билээ. Үхэв үү? Эсвүү? Хэрвээ амьд болбол эрдэнэт махбод би?д нь хүрнэ” гээд Хүрмэ нэрт цул болд илдээ дүрэв. Барсын хоргож самуурахад барсын магнайн арьсан дээрээс зүүн гараар ноцож барсыг эс хөдөлгөв. Цасыг ноцолдож байхад нөгөө хоёр баатар нь сэлмээ суга татаж буун гүйлдэж айсуй .

Гэсэр хаан барсын маань дотор байж зарлиг болов: “Эрдэнэт Цас Чихэр минь, мэдэв би чамайг .Энэ барсын эрьсыг бзз эвд Аргаао алья” гэв. “Толгойн арьс нь зуун дуулганы гэр болох буй. их биений арьс зуун тавин хуягийн гэр болох буй. Цас минь таьт” гэв. “ай Богд минь! Юу зарлиг болов ? ” гэж инээгээд тавив. Гэсэр хаан зүүн гарараа барсын багалзуурыг баазаж гэлдрүүлж байж баруун гараар сумч шил ишг оновчоо сугалж аваад барсын багалзуурыг тас дараад гарав. Өарсыг алаад : “Цас минь уран биш үү, чи? Толгойн арьсыг толгойн арьсыг гучин баатартаа гучин дуулгатэны гэр зөвлөн эсгэ. Их биений арьсыг гучин хуягийн гэр зөвлөн эсгэ Үлдсэн гурван зуун хошуучийн сайн сайнд өгье” гээд тавив Гэсэр хаан барсыг алаад гурван баатраа аван явав. Явтал Цас Чихэр зарлиг болгон айлтгав: “Ай! Богд минь! Буйдан гучин баатрыг чинь аван дутав. Хайран нэр чинь” гэв. Арван зүгийн эзэн Гэсэр хаан зарлиг болгов: “Цас Чихэр минь дуугүй яв. Хар багаас догшдыг доройтуулж явахдаа Буйдангаар газарчуулж явлаа би. Адилтгавал Буйдан баатар харанхуй шөнө хатгасан зүү үл андах ийм газарёч буй. Дуугүй яв. Бүү ичээ түүнийг” гэв. “Цол нь Мэргэн тэвнэ буй” гэв.

ХЯТАДЫН ГОНМА ХААНЫ ТӨРИЙГ ЗАССАН ГУТГААР БҮЛЭГ

Хятадын Гонма хааны хатан бурхан болов. Хатнаа бурхан болсонд хаан зарлиг болов: “үүнд минь боссон хүн босоогоор уйл! Суусан хүн суусаар уйл! Идсэн хүн идсээр уйл! Идээ эс идсэн хүн байсаар уйл! (Энэ засгийг хэн хүн эвдээд буруу явбал тэр хүний тэргүүнийг мянган хэсэг болгоох буй) “ гэж хаан ийм зарлиг болгов. Хамаг улс гашуут болж хааны сайд яамны гадна цуглаж үг хэлэлцэв : “Хатан бурхан болсон билээ. Ясыг барих (оршуулах) билээ. Лам нарыг хурааж дөчин есөн хоног ном уншуулсан билээ. Хаан хатан гэргий хэлэлцэж авбал болно. хамаг улсаа жаргуулбал зохино. Энэ хатан гагцаар үхсэн биш. Хамаг улс цөм үхэх байнам ” гэв. “”Ийм зарлиг юу вэ энэ? Одоо энэ хааны сэргээн чадагч хэн болов? гэж эрэлцэв.

Эрэлцэж олон ядаж суутал тэр хааны долоон хожгор дархан ажээ. долуулаа бүр ах дуу болно. их хах нь Саваагүй сахруу хожгор ажээ. Түүнийг ятган явагч эм нь буюу. Тэр хожгор дархан үйл барьж (ажлаа хийж) суутал эмдээ үг хэлэв. “Энэ хааны түшмэд хааныг хэн сэргээж чадах боловгэнэм. Арван зүгийн эзэн ачит Гэсэр мэргэн хаан сэргээж эс чадвал түүнээс өөр хэн сэргээж чадах буй ? Энэ муусайн мэдэхгүй байна” гэв. Эм нь хэлэв: “Эвий! Яасан саваагүй тэнэг муу нүгэлт хожгор билээ чи. Хааны зайсангуудыг эс санасныг чи сануулах буюу ? Өмнөх ажлаа дуугүй хий ” гэв. Саваагүй хожгор эр юугаа үл илгээхийг мэдээд : “Ус авчир, өлсөж үхэх гэж байна. Идээ чанаж идвэ” гэв. Эмээ явахад авч явах савны ёроолыг шивж шивж орхив. (Эм нь эрийнхээ үгийг үнэн гэж санаад суулганы ёроолыг цоолсныг эс мэдээд оосроос нь нь барьж аваг ёроол цоорсны тул ус эс тогтож байв. тэр эмийг удахын зуур дархан хожгор) эмээ усанд явуулаад хурсан сайдын дэргэд хүрч очоод :”Ай түшмэд! Хааныг сэргээн чадагч хэн болов ? Олов уу? гэв, “Бид эс олов ” гэв “Энэ хааныг хэн сэргээж чадах билээ ? Арван зүгийн эзэн ачит мэргэн гэсэр хаан сэргээж чадах буй за” . Түшмэд: “Энэ хэцүү буй за ? ” гэв. “Чи л залж эс чадвал хэн залж чадах буй?” гэв. Явбал би явъя. надад морь хөтөч, (Хүнс) өг гэв. Тэдгээр ноёд, сайд ихэд баярлаж! морь, хөтөч, (хүнс) цуглуулж өгөв.

Хожгор дархан явав. Гэсэр хаанд хүрч був. Гаднаа буухад н Гэсэр хаан хувилгаанаар саваагүй мэдээд орохын урьд сүрээр дарав. Тэр дархан орсон хойноо суухаа үл мэднэм. Мөргөхөө үл мэднэм. Дэмий алмайрч харж сууна. Гэсэр хаан хэлэв : “Муу хожгор чи хэнийх вэ ? Яасан муутэнэг хожгор суухгүй яав ? Гарах ч үгүй яав? Дэмий л байдаг чинв юу вэ ? ” гэв. (Гэсэр богд наян нэгэн өөр хэлээо асуувал) тэр дархан (төөрсөн хурга мэт элмэрэн) дуу эс гарав. Гэсэр хаан сүрээрээ дарахаа байв. Хожгор дархан сэхээ орж мэргэн үг айлтгав: “Хятадын Гонма хааны хатан бурхан болж билээ. Хаан зарлиг болж “Боссон хүн босоогоороо уйл! Явсан хүн яваагаар уйл! Эс явсан хүн суугаагаар уйл! Идсэн хүн идсэнээрээ уйл! Эс идсэн хүн байсаар уйл!” гэж ийм зарлиг болж билээ. (Хаан ёсгүй зарлиг засаг тархааж гүр их улс бид маш их зовов) Чингэхэд хааны заларч сэргээх ажаамуу гэж илгээв”” гэв. Тэр хожгор дуу эс гарав.

Гэсэр хэлэв: “За очвол ч очъё би. (Танай хааны санд аливаа зүйл эрдэнэ бүрэн гэгч үнэн үү? ” гэв. Хожгор өгүүлрүүн : “Би яаж мэдэх вэ ? манай ноён сайд, хааны санд дутуу юмгүй гэж хэлэлцдэг” гэв. Гэсэр зарлиг болруун: “Тийм болбол) Дун цагаан уул бий. дун цагаан уулын өвөрт дун цагаан хурга өөрөө майлж бах бий . Түүнийг авчир. Алтан ууланд алтан тээрэм өөрө эргэж байх бий. Түүнийг авчир. төмөр уул бий. төмөх ууланд хөх хирс төмөр үхэр өөрөө тоглож байх бий. Түүний авчир. Зэс уул бий. Зэс ууланд зэс ноход өөрөө хуцаж байх бий.

Түүнийг авчир, Алтан уул бий. Алтан ууланд соно өөрөө түрхэрч байх бий. түүнийг авчир. Наран барих алтан цалам бий Түүнийг авчир. Шоргоолжны хааны үлийд хураан бий. түүнийг авчир. Саран барих мөнгөн цалам бий Түүнийг авчир. Бөөсний шөрмөс нэг атга бий. Түүнийг авчир. Эр харавтар шувууны хамрын цус нэгэн халз бий Түүнийг авчир. Эм харавтар шувууны нүдний нулимс нэг халз бий. Түүнийг авчир. Зулзган харавтар шувууны нүдний нулимс нэг халз бий Түүнийг авчир. За эд бүгдийг авчрахгүй бол долоон дархны толгойг авчир. Энэ олон эрдэнийг авчрахгүй бол би очихгүй” гэж зарлиг болов. “За ” гээд хожгор явав.

Гэсэр хааны зарлигийг тоолон ноёд сайд нартаа айлтгав. “Ээ! ийм олон эрдэнийг хаанаас олох вэ ? Нэгийг ч олоход бэрх байна. Харин долон хожгор дархны тэргүүнийг өгье гэв. Долуулыг цохилж өлөв. долоон толгойг хоёр хүнээр илээгв. Гэсэр хаанд аваачиж өгөв. “Зөв хэрэгтэй хүний толгой над авчирч байна, сайн” гээд нэгэн тогоонд хүний толгойг бидэнд өгөх гэж чанаж байна уу? ” гэж санав. Хонины махыг гаргаж хоёр элчид өгөв. Долоон хүний толгойг шалзалж хоосон ясыг нь авав. Долоон гавал аяга зож хийв. Тэгж суутал хоёр элчийг “харь” гэв. “Би хойноос чинь очъё ” гэв. Хоёр элч харив.

Долоон гавлаар аяга хийгээд архиар эрз нэрэв. Арзаар хорз нэрэв. Хорзоор шарз нэрэв. Шарзаар борз нэрэв. Борзоор дагва, дигва, марва, мирва ийм нэрт долоон халз хийж аарцанд шүүж авав. Долоон тахил барив. Бариад Навса Хүрза эмэг эхдээ салхины хүрдээр илгээв. Навса хүрээ эмэг эх нь авч зооглоод хөлчүүхэн суув. “Нусгай минь ирэв үү? ” гэж өнгиж үзэв. “Эжий чамдаа золгоё”

(Алтан дэлхийд бууж ирсэн хойно эжийдээ золгосонгүй билээ) Над шат буулгаж өг” гэв. “Авай минь! золгоогүй нь үнэн билээ ” гэж дээсэн шат буулгаж өгөв. “Эжий минь! ганц ач намайгаа унаж үхтүгэй гэж дээсэн шат буулгаж өгөв үү чи? Над төмөр шөт буулгаж өг” гэв. Төмөр шат буулгаж өгөв. төмөр шатаар гэсэр хаан гарч очиж эмэг эхдээ золгов. “Эжий минь ёиний муу бжэр чинь, миний муу эм Рогма гуа хэлнэм билээ: “Дун цагаан уул бий . Түүний өвөрт дун цагаан хурга өөрөө майлж байх юм гэнэ. Алтан тээрэм, төмөр хирс үхэр, алтан саваа, зэс хошуут нохой, алтан соно, бөөсний шөрмөс нэг атга, шоргоолжны хамрын цус нэг халз, наран барих алтан цалам, эр харавтар шувууны хамрын цус, эм ахравтар шувууны хөхний сүү нэг халз зулзаган харавтар шувууны нүдний нулимс нэг халз, далайн дотрх шүүст молор эрдэнэ эд бүгд миний Жало хаан эцэгт минь цөм бий гэнэ. Тэр нь үнэн буюу ? ” гэж асуув. “Авай минь тийм олон эрдэнэ тэр мууд юун олдох буй? Булт над буй за тэр бүгд ” гэв. “Эжий! хаана буй тэр бүгд чинь ? Өг үзвэ” гэв. “Авай минь би чамд юу гэж хайрлах вэ ? Тэр оньст хайрцагт буй, ав” гэв. Эхээсээ түлхүүрийг аваад оньстйг түлхээд түлхээд эмгэнийг буруу хандах зуур олон эрдэнийг аваад цөмийг өвөртөлөв. “Эжий минь! чамд золгов би. одоо харъя” гэж иөмөр шатаар буув. Буутал эмгэн дуудах. “авай Жур минь! Юу гэж яарч харина чи ? нэгэнтээ ирснийг цай шөл зоогловол яана вэ чи ?” гэв. “Эжий чамд золголоо. Эжий минь цай шөлөөр яахна вэ ?” гээд төмөр шатаар бууж харив. Тэр цагт хүнийг үдэхдээ хойноос нь үнс хаях ёстой байсан аж. “авай минь мэнд яв!” гээд хойноос нь үнс хаяв. Тэр хаясан үнс нь огторгуйд бутарч цагаан үүл болжээ .

Гэсэр хаан доор дэлхий дээр бууж хормойгоо дэлгэж олон эрдэнэсийг дэлгэж үзэв. Бус эрдэнэ бус буй. Дөрвөн эрдэнэ үгүй байз. Эр харавтар шувууны хамрын цус, эм харавтар

шувууны хөхний сүү зулзаган харавгар шувууны нүдний нулимс, далайн дотрхи шүүст молор эрдэнэ энэ дөрвөн эрдэнийг авч эс чадсан байна би. Одоо хаанаас авья би” гэж арван зүгийн эзэн Гэсэр хаан огторгуйд явагч эр харавгар шувуунд зүүд өгөв. Эр харавгар гшувуу үүрийн хяраанаар сэрээд эмдээ үг хэлэв. : “Энэ биз төрмөн ийм зүүд эс зүүдлэв.би. Энэ шөнийн зүүд минь : Найранзана мөрний эхэнд найман он байдарсан (хусарсан) алагч үнээ үхсэн хэвтэнэ. Би очиж түүнмй махыг идэв. Гэж зүүдлэв. Би. Юун ч сайн билээ зүүд минь! ” гэв. Эм нь хэлэв. “Огторгуйгаар явагч амьтан алтаг дэлхий дээрх улайд буух ёгүй гэлээ. Алтан дэлхийдявах амьтан хөх огторгуйд гарах ёсгүй гэлээ. Одоо цагт арван зүгийн эзэн Гэсэр хаан төрөхдөө хүний мах арьсаар хуычиж төрөв гэлээ. Арван зүгт хувилдаг гэлээ. Түүний идэх мах ч буй за. үЗооглох рашааны далай ч буй за. Хувилгаан хүн арга хийх мэдээгүй биш үү? Байг!” гэв. “Бүү од” гэв. “Би огторгуйгаар эргэж үзээд хүнгүй болбол бууж идье. Хүн буй болбол эргээд ирэн, би . зүүд минь үнэн буюу, худал буюу ? Очиж үзье ” гээд явлаа. Эм нь хорьж ядан хоцров.

Арван зүгийн эзэн Гэсрэн хаан Найранзана мөрний эхэнд найман он байдарсаан алагч үнээг алж махыг дэлгэж тавив. Есөн салаат төмөр урхиа цээжинд нь тосуулж тавив. Дэргэд нь нүх ухаж урхиныхаа жишмээс нь барьж нууж хэвтэв. Эр харавгар шувуу огторгуйгаар ирж эргэж үзэж явна. Хүнгүй байна гээд бууж махыг идэв. Бөгсний махыг идээд, хэнхдэгт нь орж идэх гэтэл есөн салааь төмөр урхиныхаа жишмээс нь татаад шувууу б арив. Бариад дэвхцүүлж, харайлгаж байж хамрыг нь цохиж цус нэгэн халз авч байв. Чингэж байтал эм нь огторгуйгаар уйлж явж эрдээ үг хэлэв: “Чамд би эс хэлэв үү! Одоо энэ бишүү. Одоо үхэх чинь энэ буй за ” гэж эм нь уйлж явахад Гэсэр хаан хувилгаанаар мэдээд зарлиг болгов. “Ай эм харавгар шувуу эрийг чинь алахаа больё. Эм харавгар шувуу чи над хөхнийхөө сүүг нэг халз өг. Зулзгана харавгар шувууны нүдний нулимсыг нэг халз өг. Их далай дотор бул чулууны чинээ шүүст молор эрдэнэ буй. Түүнийг өг. Энэ гурвыг авчир. Үгүй бол эрийг чинь ална би” гэж харайлгаж дэвхцүүлж байна. Эм харавгар шувуу өгүүлрүүн “Өрвөн зүүгийнэзэн айх мэд Гэсэр хаан! Эрж үзье. Бүү ал. ” гээд явав. Зулзагандаа хөхүүлэхгүй байж нэг халз сүү авав. Их далайгаас бул чулууны чинээ шүүст молор эрдэнийг олж авав. Энэ гурвуулыш авчирч арван зүгийн эзэн Гэсэр хаанд өгөөд эр юугээ авч одов.

Төдий Гэсэр мэргэн хаан олно эрдэнэсээ аваад хятадын Гонма хаанд очив. Төдий хүрээд Гонма хааны гэрт ортол Гома хаан, үхсэн хатнаа өвөрлөж сууна ажээ. Гэсэр хаан зарлиг болруун: “ Ай хаан! энэ чинь буруу бишүү. Үхсэн хүн, амьд хүн хоёр хамт суух ёсгүй буй за. Хаантан өөр гэргий авч, хамаг улсаа жаргуулбал энэ ертөнцөд алдарших сайн нэр чинь тэр” гэв. Гонма хаан : “Энэ тэнэг хүн хэн бэ ? Үүнийг би ганц жил орхих байтугай арван жил болтол үл орхих болно би” гэв. “тийм болбол хааныг яана?” гээд. Гэсэр хаан гараад хааныг нойрссоны хойноөвөр дэх хайныг хулгай хийж авав. Аваад өвөрт нь үхсэн нохой хйж тавив. Хаан өглөө босоод : “Эвүү эвүү! Өчигдрийн хүний хэлсэн үг үнэн байна. Энэ минь хэвтсээр нохойы болов. үүнийг цааш авч орхи ” гэв. Аваачиж оршуулав. Нэгэн хаалагч хүн хэлэв: “гэсэр гэгч орж ирээд хатныг аваачиж орхилоо. Би айж түүнд дуу эс гарлаа” гэв.

“Эвүү эвүү Энэ Гэсэр хатныг минь авч орхив. Зүгээр орхих биш, минимй өвөрт амьдын нүгэл чивэл нохойг юу гэж орхином? үүнийг алья” гэж могойт гууд Гэсэрийг аваачиж орхиулав. Гэсэр эм харавгар шувууны хөхний сүүнээс могой бүгдэд баахан баахан сацав. Могой бүгд хордож үхэв. Их могойгоор дэр хийж, бага могойгоор дэвсгэр хийж хонов. Арван зүгийн эзэн

Гэсэр хаан эрт босоод дуулав: “Энэ гонма хаан намайг могойт тамд орхиж могойгоор алуулах хаан байна гэж саналаа би. Могойгоо надаар алуулж уаргах хаан байсан аж “ гэж дуулав. Могойн нүхийг сахигч хүн очиж хаандаа хэлэв.

Гэсэр хааныг аваачиж зөгийн тамд орхив. Алтан соноо тавиад зөгийг тас бариулав. Зөгийг алаад Гэсэр дуулав : “Энэ Гонма хаан намайг зөгийг тамд орхиж алуулах хаан байна гэж саналаа би. Зөйгөө надаар алуулаж жаргах хаан байсан аж ” гэв. Зөгийн нүхийг сахигч хүн очиж хаандаа Гэсэр хааны зарлигийг цөмийг тоолж хэлэв. Бас араатны тамд аваачиж орхив. Гэсэр хаан зэс хошуут нохойгоо тавиад араатныг там бариулав Гэсэр хаан дуулав. “Энэ хаан гэсэрийг араатан тамд орхиж алах хаан гэж саналаа би. Гэтэл надаар араатан тамйын амьтныг алуулж жаргах хаан болов” гэж дуулав. Араатан там сахигч хүн очиж хаандаа хэлэв: “тэр хүн үхсэнгүй. Араатан тамынхныг тас алаад дуулж хэвтэнэ” гэв.

Бас харанхуй гуунд аваачиж орхи гэв. Гэсэр хаан наран барих алтан цалмаараа, саран барих мөнгөн цалмаараа нар сар хоёрыг уурагдаж барад байв. харанхуй гуу нь гийгэж хонов. Гэсэр босоод дуулэв. “Энэ хаан Гэсэрийг харнхуй гуундаа орхиж алах хаан байна гэж саналаа би. гэсэрээр харанхуй гуугаа гийгүүлж жаргах хаан байсан аж” гэж дуулав. Гуу нүх сахигч хүн очиж хаандаа .Гэсэрийн зарлигийг булт тоолж эхлэв.

Бас, “их далайд аваачиж орхи” гэв. Аваачиж орхив. Бул ч улуун яинээ шүүст молор эрдэнээ тэвэрч ороь. Оруулахад далай хоёр анги болон хатав. Гэсэр хаан молор эрдэнийн дэргэд тоглож явж дуулав. “Энэ хаан Гэсэрийг их длайдаа орхиж алах хан байна гэж саналаа би. Гэсэрээр далайгаа хатаалгаад, хамаг улсаа усгүй жаргужулах хаан байсан ажээ ” гэж дуулав. Далай сахигч хүн очиж хаандаа хэлэв: “Тэр хүн үхсэнгүй, далай хатав. Тийм дуу дуулж явна” гэв.

Бас “Зэс илжгэнд унуулж дөрвөн зүгээс их хөөргөчнөөр хөөрөгдүүлж алья” гэв. Гэсэр хаан морины чинээ цавгүй хар нүүрсээр биедээ нухаж түрхв. Хөөрөгчин ирж дөрвөн зүгээс их гал хүрч ирэхэд биеэсээ хувилгаанаар ус урсгаад галыг унтрааж орхив. Галыг нь унтраагаад Гэсэр урьд ёсоор дуулав. Хөөрөгчин очиж хаандаа хэлэв. “Тэр хүн үхсэнгүй, энэ үгээр дуулна” гэв.

Бас “Ирт мэсээр цавчиж ав” гэв. Гэсэр хааныг харвах, цавчих гэхэд хувилгаанаар лтан саваагаар зэвийг нь хугар хугар цохилж байв. Алан ядаж очиж хаандаа хэлэв: “Яасан нүгэлт хүн билээ? Алах арга одоо манд үгүй болв. Бид алж үл чадмой. Хаан гэгээндээ айлд” гэв.

“Олон жад хурааж жадны үзүүрт өлгөж ав” гэв. Гэсэр хааныг авачив. Аваачиж орход Гэсэр хаан алтан тээрмээ аваачиж хуурч зарлиг болов: “Одоо үүнд арга үгүй билээ. Одоо үхэх минь энэ байна” гэж байв.

Гонма хааны охин Гүнэ гуа хувилганаар мэдэв. “Энэ муу л аль бүр ингэж зовж явна?” гэв. (Гүнэ гуа мянган алд утас, хөхөө(тоть) шувууг өгөөд өгүүлрүүн : “Чи газар усандаа нөхөргүй юу?” гээд уяж, утаснаасаа барьж тоть шувуугаар Гэсэр хаан гэртээ элч илгээх болов. Хотын асар дээр гаран тоть шувуунадаа их дуугаар зарлиг болв:”Тоть шувуу минь яв яв ” гэв. “хятадын Гонма хаан арван зүгийн эзэн Гэсэр хааныг алав” гэв. Надаас дээр гурван баатар минь ирэг. Надтай тэн (адил) гурван баатар минь ирэг. Надаас доор гурван баатар минь ирэг. Гучин баатууд минь хойно болтугай. Осөн баатар минь ирж, энэ хааны хот балгасыг эвдээд,

энэ хааныг алахын муугаар ал гэв. Үзэж байтал үнс болго . Харж байтал хар нүүрс болго Хамаг улсыг аваач гэ. Ай тот шувуу минь яв гэв. Тоть шувуу явав. Гэсэр хаан утасныхаа шижмээс барьж байв.

Гонма хаан бүгдээр сонсож : “Эвүү! Яалаа! Ганц Гэсэрийг алж эс чадав бид. Одоо есөн баатар нь ирвэл биднээс юм үл үлдэх байна. Ай Гэсэр хаан шувуугаа дууд Юу өг гэснийг чинь өгье бид гэв. “Шувуу минь хол явав ” гэж байв. “Ямар зарлиг болном чи? Чиний зарлигаар больё бид ” гэж бүгдээр мөргөв. Гэсэр хаан зарлиг болв: “За охиноо Гүнэ гуагас сэмхэн асуув: “Авай, чамайг гГэсэрт өгье. Чи очихгүй болбол биднийг алаад чамайг аваачна” гэв. “Авай ахай минь! Арван зүгийн эзэн Гэсэр хааныг хэрэглэвэл бас ахай юугаа ална гэж байтал би юу гэж үл очих буй?” Хаан “Зөв” гэв. Гүнэ гуаг зарлиг болов: “Эцгийн чинь энх жаруулав би. Эн биений чинь дэргэд гурван жил болтол суув би. Одоо харьж гэр малаа эргэж ирье” гэв. Гүнэ гуа: “Эвүү! Арван зүгийн эзэн Гэсэр хаан минь зарлиг юу болном? Энд суу гэвэл суух буй за. Үгүй болбол би чамтай явах буй за Үгүй болбол би чамтай явах буй за. Энд юу гэж ганцаар сууна би ?” гэв. “Зөв “хоёл бэлэглэе(бэлэг шинжье) ” гэв. Төдгүй хотын гадна гарч хоноё” гэв. Гэсэр билгийн хээр морио унав. Гүнэ гуа хөх халзан луусаа унав. Хоёул хотын гадна гарч хонохдоо бэлэглэн хэлэлцэв: “Чиний үг зөв болж хоёул энд сжуух болбол миний илгийн хэр морь, чиний луус хоёр хотынхоо зүг хандаж хонотугай. Чиний үг буруу болбол миний үг зөв болбол миний билгийн хээр морь гэр зүг хандтугай” гэв. “За” гэд хоёул хонов. Арван зүгийн эзэн Гэсэр хаан үүрийн хяраанаар гарч харан гэтэл луус морь хоёр хотын зүг хандаж байв. “ай! Билгийн хээр морь минь энэ чинь юу вэ ? Миний гэр зүг ханд” гэж дуудав. Билгийн хээр морь нь гэр зүгээ хандаю. үнэ гуаг ссэрүүлэв. “Үүр цайж байна. Бос” гэв. “За, чи бид хоёр бэлэглэж хонов. Хэнийн бидний үг зөв. Хэнийн бидний үг буруу болов? Морь луус хоёрыг харж үзб гэв. Гүнэ гуа харж үзэж “Чиний үг зөв. Миний үг буу байна Эргэхээ чи мэдэх байна. Эзэн Гэсэр хаан минь харивал харь ” гэв.

Хоёул мордов. Гүнэ гуа гагцаар гэж хот хүртэл үдээд арван зүгийн эзэн Гэсэр хаан заларч явав. Зуур нэг их өндөр ууланд и хүрээв: “Төдгүйгээс өдий хүртэл үйлдсэн үйл маань их билээ. Одоо диянд сууя ” гэж суув. Ялгуусан гурван өхий нь, Овоо Дүнжин Гарво нэртэй эгч нь бууж ирэв. “ Авай нусгай минь дээд бие чинь арван зүгийн бурхан төгссөн, дунд бие чинь дөрвөн их тэнгэр нар төгссөн, доод бие чинь дөрвөн их лусын хаад төгссөн, жачсаны чинь хилэнц арилна билээ . Алсны чинь сүнс тонилно билээ. Энэ Замбутивийн эзэн Гэсэр хаан чи биш үү. Одоо үүнээс нэн (илүү) ямар бурхны төрөл олъё гэж суунам чи?” гэв. “Эгчийн минь, зарлиг зөв. Морь биеэ алжааснаас сууж билээ. Харьё” гээд морпов.

Гэсэр хаан явав . Үүрийн хяраанаар гэртээ хүртэл Рогма гуа булган хөнжилд шургаж нойрсож байсан ажээ. Рогма гуа минь өлөнд хэвтэх улаан бяруу мэт шурга хэвтэхээр өндөр уулын орил ээр явах өлөн буга мэт үүрийн хяраанар босч ийн тийн харан яваасай чи “ гэв. Нанжун хятад босов. “Ай Сэцэн Нанжун минь босон гүшйж оч! Хурдлан ир! Алтан хөвөөт аргалаар дотроло! Мөнгөн хөвөөт аргалар гадарла. Усн эх мэт буй. Ихээхэн хий. Давс зээ мэт буй. Багаахан хий. Цай эцэг мэт буй. Багаахан хий. Сүү нагац мэт буй. Ихээхэн хий. Тос ноён мэт буй. Багаахан хий. Буцлахад сүүн далай долгилох мэт сана. Самрахад олон бурсан хувраг ном унших мэт сана. Уухад алтан цэгций (шувуу) нүхэнд орход адил сана. Арван зүгийн эзэн арван хорын үндэсийг таслагч авай богд минь заларч ирж байна. Цай яарч чана” гэв. Сэцэн Нанжин Рогма гуад үг айлтгав. “Тэр зарлиг чинв юу вэ? Чиний бие алтан авдранд адил

боловч дотор нь шар үөрмөс хийсэнтэй адил буй за. Миний бие иорины түнхэрцэгтэй адил боловч дотор минь Ханхуй нэрт мангас хийсэнтэй адил буй за. Арван зүгийн эзэн Гэсрэ хааныг ганц тогоо ццайгаар баясгах буу чи? Арсланы голын эхэнд буусан Арслан авагад нь хэл. Зааны голын эхэнд буусан заан авгад нь хэл. Амраг Цас Чихэр ахад нь хэл. Тэр бүгд нь их хурим авч ирж золготугай” гэв. “Энэ үг миний буруу болов уу?” гэ мөргөв. “нанжин минь, энэ үг чинь зөв буй. Тэд бүгдэд нь улаагаар явж зарла . Гэсэр хаандаа золготугай. .Сэцэн Нанжун угаалгаар явж зарлав. Тэд бүгд нь баярлаж их хурим авч ирж Гэсэр хаандаа золгодов. Их улс тархав.

**АРВАН ЗҮГИЙН ЭЗЭН ГЭСЭР ХААН АРВАН ХОЁР ТОЛГОЙТОЙ
МАНГАСЫГ АЛИВАА ТӨРӨЛТЭЙ НЬ ТАСАЛЖ АРЛАН ГУА ХАТНАА
АВЧ, АЛТАН СУВАРГАНЫ ДЭРГЭД АМАРЛИН СУУСАН
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

Цотон ноён Арлан гуа хатныг хөөв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан Арлан гуа (монголоор Түмэнжаргалан, төвдөөр Бумжид гэж бас өөр хоёр нэртэй) хтныхаа нутгийг олон улсаас нууж заримдаа нэжгээд сарын газар, заримдаа хоёр гурван сарын газраар суулгаж байсан ажээ. Олон хүн эс мэдсэн билээ. Цотон ноён мэдэж орхив. Гүйн барих Шар цоохор морио унаж шоргоолжин саадгаа бүсэлж очив. арлан гуад золгоод “Ай хайран сайхан бэр минь! рван зүгийн эзэн Гэсэр хаан чамд сүүдрээ үзүүлж явна тэр. Хятадын Гонма хааны төрийг засаж Гүнэ гуаг авч гурван жил сууж ирэв. Одоо Рогма гуагийг дэргэд сууна. Чамд ирэхгүй байна. Цааш харвал түмэн хүн инээх мэт, нааш харваол түмэн хүн инээх мэт ийм өнө дүртэй хайран авай минь чи зовож байна уу. Чамайг би авъя” гэв. “Эвүү!!Эвүү Цотон авгай минь, энэ чинь ямар үг вэ! Түмэн Цотон ноён хурж ирэвч ганц шөнийн Гэсэрийн минь зүүд сүүдэр хоёртэй тэнцэж чадахгүй. Энэ үгийг чинь дээр хөх мөнх тэнгэр сонстугай . Доор Хөрст алтан дэлхий Эдүгээн эх сонстугай. Хөдлөх амьтан бүгд сонсвол чинь дүлийртүгэй, нүд нь тэсэртүгнй. Амла үл болхо үг энэ чинь. Дуугүй сууж цай шөл зооглож харь” гээд их хурим өглөг өгч хариулав.

Цотон ноён харьж долоо найм хоноод бас ирэв. Арлан гуад үг айлтгав: “Эвүү!! Авай хайран сайн бэр минь чи зоюохын муугаар зовж явна. Чамайг би авъя гэв “Эвүү! Авай! Урьд үг минь хүнийх болов уу, хойд үг минь өөрийнхө болов уу ? Эрхт мөнх тэнгэрийн хөвгүүн эзэн Гэсэр хаан минь намайг гээв үү? Энэ өдөр Цотон ноён чамд өгөв үү ? Ариун Түшид тэнгэрийн хөвгүүн арвн зүгийн зэн Гэсэр хаан минь намайг гээв үү? Авгадаа Цотон ноён чамд өгөв үү? Би чамайг муу гэж эс очив у? Бэрийнхээ алиа найдангуйг минь мэдэв үү чи? Чамайг нэрээ эс хайрлавал над ямар нэр байх билээ?” гэж хорооны хөвгүүдийг “Бялуу шийдмээ авч ир” гэж дуудав. Цотон ноёныг морь биегүй гөвшиж, морийг вч явган тавьж илгээв. Цотон ноён нэг сарын газар гэртээ хоёр сар болж хүрэв. Цотон ноён биеэ арчилж сэнсэнд сууж унд шанз хийж идээд биеэ тэнхрүүлэв.

Цотно ноён биеэ тэнхрүүлж одоо гэртээ долоо найм хоноод : “Чамайг даа! Арлан гуаг Гэсэрээс хагацуулах арга эс хийдэг бол!” гэж зангаад хүнс авч хараалын нүхэнд очив. Тэр нүх хүнийг жаргуулах буюу зовоох аргыг зүүдэнд нь хэлж өгдөг ажээ. Тэр харааллын нүхэ хүрч гурван сар бартал хэвтэв. Цотонгийн санаанд юм эс оров. “эвүү! Харалын нүх зөнгөө төөрөв үү? Цотон би хатах минь энэ буюу? Яасан заяа билээ?” гэж нэгэн ес хоногт огт хүнсгүй хэвтэв. (“Тэр муу нүхийг аливаа юмыг эндүүрэлгүй мэддэг гэж хүн худал хэодэг бол түүнийг эвдэе” гэв) Түүний хойд шөнө хараалын нүх хүн болон Цотонгийн зүүдэнд орж үг хэлэв: “Арлан гуагийн малчинтай зохицон нэгэн намганд (Хүхүүрт) цус дүүртэл хий. Нэгэн намганд хорз дүүртэл хий. Нэгэн намганд тараг ддүүртэл хий. Энэ гурван намагны амсрыг бүү бөглө. арлан гуагийн шамтавын (банзлын) оосроос нь уяж тавь. Зул унтраад нойрссны хойно : “Хатан! “үнээ хөхөв” гэж дууд. “Хэд хөхөв?” гэж асууна. “Зуу хөхөв” гэ (гэхийн захирах хэлбэр). (Тугал таргалтугай) Гайгүй” гээд нойрсоно. Нойрсуулаад бас дууд : “Хатан Үнээ хөхөв ” гэ. “Хэд хөхөв?” гэнэ. “мянга хөхөв” гэ. Мөн бас (Тугал таргалтугай) “Гайгүй” гээд нойрсоно. Бас дууд “Хатан Үнээ хөхөв ” гэ. “Хэд хөхөв?” гэнэ. “ булт хөхөв” гэ. “Эцэг эхийн саальсүү тасрах нь” гээд босон харайна. Тэр гурван намган дотрох асгарвал АРлаг гуа Гэсэрээс хагцуулхын арга тэр болно гэв.

Цотон явж Арлан гуагийн адуучид хүрэв. Адучин адуугаа нэгэн төхөмд хурааж байна. төхөм

дүүрэхтэй пунд байвал дутуу байна гэж хайж олох ажээ. Цотон ноён хүрээд : “адуу тань ямар байна? Олон уу? Цөөхөн үү? Тарган уу ? Туранхай юу? ” гэж асуув. Адуучин хэлнэ: “Олон болбол заримыг нь чамайг ав гэв үү? Цөөхөн болбол маньг заслага (шийтгэ) гэв үү? Туранхай болбол маньг жанч гэж илгээх үү? Тарган болбол маньш шагна гэв үү? ” гэв. Цотон ноён үг : “Хол бай! Энэ муусайн аашийг нь үз та. миний өмнөөс ийм үг хэлэх нь юу вэ? ” гэж морины толгой түрүүг цохиж явж одов. Адуучин бүгдээр: “Цотон авгай адуу хулгай хийе гэж ирж байна. Яв! яв!” гэж хэлэлцэж олон адуучин бүгдээо ирж Цотно уургаар гөвшив. Цотон ноён дутаан одов.

Тэмээчид нь очиж золгов. Мөн урьд үгээр асуув. Мөн тэмээчин уурлалцан Цотног гөвшив. Цотно дутааж очив. Үхэрчинд золгов. Мөн урьд үгээр боллоцов. Цотон үхэрчнээс дутааж хоньчинд очив. Бас хоньчноос “Хонь чинь ямар вэ?” гэж асуув. Мөн адуучны үгэр хэлж бас хэрүүл загнав. Одоо Цотон ноён биеэ өвдөхөд нэгэн бүдүүн хонь хийж аваад ууланд гарч биеэ тэнхэрье гэж очив.

Биеэ тэнхрээд Цотон ноён Арлан гуагийн тугал хадгаласан хүнд үдэш барйа бүрийд явж очив. Ирж золгоод: “Энэ дөрвөн хошуу малчинд хэн нь жаргалтай, хэн нь жаргалгүй вэ?” гэж асуув. Тугалёин хэлэв: “маньд юуны жаргал байх билээ. Зуны бороог бороо гэхгүй, олон тугалын хойноос явж зовно биш үү бид. (Бусад сүргийг хадгалсан хүмүүс жаргалтай байна) Адуучин гэвэл агтыг дураар мэдэж унана. Архийг (айргийг) дураар мэдэж ууна. Хүслээ ханаж явна бишүү! (Тэмээчин тэмээгээ ачаад сүүт сааж ууж жаргал явна Үхэрчин үхрээ ачаад сүүт сааж уугаад жаргаж явна. Хоньчин хонио алж идээд унгасыг нь авч эсгий хийж сүүт сааж уугаад жаргаж явна) Тэд тэр дөрвөн хошуу малчинд юуны ялгал! Зовох болбол бид буй за. (Биднээс илүү зовлонт хүн энэ газар дээр үгүй) гэв. Цотон “Таныг тэр дөрвөн хошуу малчинаас илүү жаргалтай болгосуу. Та над юу өгөх вэ? гэв. Эвүү! бид Цотон ноён авгайдаа юу гэж храамлах вэ ? Олох чадалтай бобол олсноо өгнө. Олж чадахгүй болбол юугаа өгнө бид ? ” гэв. “Хөөрхий минь таныгаа үлэмж жаргуулах буй за, би” гэв. Тугалчин “за сайн” гэж баярлав. Нэгэн тугал алж Цотонд хурим өгөв. Цотон тугалчинд хэлэв: “ нэгэн намганд цус хий. Нэгэн намганд тараг хий. нэгэн намганд хорз хий ” гэж тугалчинд тоолж хэлэв. Тугалёин гурван намганд тэр бүгдийг хийэ Арлан гуагийн банзлаас уяж тавиад шөнө. (дүл болоход) зул унтраагаад : “Хатан! Үнээ хөхөв “ гэж дуудав. “хэд хөхөв?” гэв. “зуу хөхөв” гэв. “Тайгүй”. (Тугал таргалтугай) гээд нойрсов. Урьдын өмнө үгийг дахин дахин хэлж дуудав. Арлан уга уурлаж “сааль сүү тасрах нь байна (Та тугалаа эхтэй нь нийлүүлсэн байна Гэсэр ирэх цаг босон билээ. Хэрэв маргааш эрт ирвэл архигүй яана!)” гээд босон харайв. Шамтвасаас уясан гурван намган дахь булт асгарав. (Арлан гуа тэр тугалчаа ихэд жанчивай. Тугалчин ийн стэгэрүүн! “цотон ноён биднийг жаргуулсан биш, зовоохын аргыг байсан ажээ” гээд машид харааж явав. Тэр Арлан гуагийн асгасан нь дорно зүгийг чиглэж асгарсан байна) Түүний уур нь (зүүн зүгийн) арван хоёр толгойт мангас хүрэв.

Мангас өвдөв. “Төлөгний минь улаан утсыг өг” гэв. “Би юунд өвдөв?” гэж үзэв. ҮЗтэл арван зүгийн эзэн Гэсэр хааны өөр өмчтэй, өөр нутагтай, өнгө үзэсгэлэнт сайхан гуа нэгэн хатан байна. Тэр хатан хараалын нүхнээс гурван намганд муу юм хийж над цацсан байна. (Би түүнийг хялбар хариулж чадна) Надаас өөр хэн чадах вэ?” гээд гурван намганд мөн тэр гурвуулыг хийв. Тэгээд гэсэр хаанд муу бэлэг тавиад (Гэсэрийн зүгт)асгав.

(Шумнас(мангас) өөрөө эдгэв) Гэсэр хаан чилээрхэв. Хамаг улст өвчин тахал олон болов. (Гэсэр хаан есөн өдөр, есөн шөнө юм зооголсонгүй, гал түлсээр суув. Цотон ноён, Царгин ноён, ЦасЧихэр хийгээд гучин гурван баатар, гурван отог улс ер бүгдээр цугларав. ЦасЧихэр хэр есөн өдөр есөн шөнө болтол Гэсэр богдын дэргэдээс нэг агшин зуур гарсангүй нэг агшин зуур унтсангүй, гараас нь барьсаар суув. Цас Чихэр өгүүллрүү: “Цотон авай, Рогма гуа_ Нанчун гурвуул очиж Гэсэрийн минь заягаар төрсөн Мо гүүш Данбо төлөгчид “Юунаас болсон шалтгааныг үзүүл” гэсэнд Нанчун өгүүллрүү : “Цотон авай, бэргэн хоёул очиж үзүүл. Би Гэсэр авайн дэргэд сууна” гээд Гэсэр богдын нөгөө гараас б арьж суув”)

Рогма гуа, Цотон ноён хоёул Гэсэрийн Мо Гүүш Данбро нэрт төлөгчид очиж үзүүлэв. : “Гэсэр хаан юунаас чилэрхэв? Хамг улст өвчин тахал юунаас болов? Үз” гэж хэлэв. Төлөгч нар үзэв. : “Ийм ажээ. (Гэсэр богдын өвчин нь гэмгүй эдгэх байна. Энэ өвчний шалтгаан нь) Гэсэр ханд минь өөр нутагтай, өнгө зүс сайхан нэгэн хатан байна. Гэсэрийн нгэн хар сэтгэлт төрөл (авгай ах) байна. тэр хараал нүхнээс муу үг олж сонсоод Арлан гуад чивэл хийж мангаст асгаж цацасанб айна. Мангас өвдөж биеэ бвдсний шалтгааныг төлөгний улан утсанд үзэж мэдэв. Тэр мэдээд тэр идээнд муу билэг тавиад нааш асагаж, үүнээс Гэсэрийн чилээ болсон байна. хамаг улсын өвчин тахал түүнээс улам болж байна” гэв. “Одоо үүнийг явал сайн болох вэ?” гэв. “Рогма гуа! Төлгийн хэл бол тэр хатныг хөөвөл сайн болох . ийм нүгэлт юм гарч байна.” гэж төлөгч нар хэлэв. (төдий хоёул харьж ирэхэд Цотон ноён өгүүллрүүн: “ай Рогма гуа минь! Мо гүүш Дамбн өгүүлсэн үгсийг өгүүлэхэд амраг авга гэхэд намайг гэж санах байна. Би Гэсэртээ муу сэтгэл үүсгэж явбал дэд тэнгэр намайг таалахгүйй. энэ үгийг Цас Чихэр, Нанчун хоёрт бүү хэл.Гэсэрийн өвчнөөс айснаа над гаргах (оногдуулах) болуузай. Өөр өвчит амраг хатан гэгч нь Арлан гуа мөн биз. Гэсэр Хятадаас ирээд чамтай удаан суусны тул Гэсэрт минь тэр муу санасан байна. Түүнийг Гэсэрт бүү хэлье. Гадуур хөж орхиё. Чи дуугүй суу . Намайг хэл гэгтүн. Би хэлье” гэв. Төдий хоёул гарч хүрэв. Цас Чихэр өгүүллрүүн : “Мо гүүш Данбо юу зарлиг болгов? гэв.. Рогм гуа өгүүллрүүн : “их ноён та өгүүлтүгэй. Би мартав” гэв. Цотон ноён өгүүллрүүн : “Гэсэрийн өөр өмчит амраг хатан нь муугаар үзэж өвгсөн байна. Түүнийг хөөж орхивол Гэсэр эдгэнэ. Эс хөөвөл эдгэхгүй” гэв. Цас Чихэр өгүүллрүүн”Тэр хатан нь одоо хэн бэ?” гэв. Цотон ноён өгүүллрүү: “Тэр амраг хатан гэгч нь Арлан гуа биз” гэв. Төдий цас Чихэр ама бариад өгүүллрүүн: “Тэр бэр минь, сайн язкгуурт сайн бэр билээ _ Гэсэр минь эдгэсэн хойно ихэд гомдох байна. Гэсв Гэсэрийн аминаас илүү биш дээ. Цотон авгай, Рогма гуа та хоёр мэв. Гэсэрт бүү өгүүлье” гээд Гэсэрийн дэргэд орж суув.)

Рогма гуа, Цотон хоёул гадуур Арлангуад элч илгээв. “Гэсэр хаан чилээрхэж байна. Хамаг улст өвчин тахал чамаас болж гэнэ. Чамайг зайлуулж явуулья гэнэ. Чи явбалГэсэрийн чилээ сайн болох гэнэ. Үгүй болбол муу” гэж хэлнэ. Элчид Арлан гуа: “Үгийг чинв мэдэв би. Гэсэр намайг хөөж байна уу? Рогма гуа, Цотон хоёр хөөж байна уу ?” гэв. Рогма Цотон хоёр чиний эзэн буюу ? Гэсэр хөөж байна” гэв. “Энэ нүгэлт үйл Цотонгийнх буй за. Гэсэр минь намайг үл хөөх бизээ. Рогма Цотон хоёр намайг хөөж байна. Би явья . Эрхт мөнх тэнгэрийн хөвгүүн эзэн Гэсэр хааны минь чилээ сайн болтугай. Энэ өдөр миний зовсноор юу дутах! Эртний ерөөлийн хүчи болбол эргэж авахаа тэр минь мэднэ биз ” гээд “Элч чи харь! Би явья” гэв.

Арлан гуа хамаг улс хорооныхоо үгээгүү ядууг цөм цуглуулаад “” Намайг бий мэт гэр малыг минь сайхан авч яв! Та бүгдээрээ “ гэж хэлээд “Гэсэрийн минь чилээ их гэнэ. Гэнэт зовлон над хүрч иржжээ. Таныг цуглуулц байгаа минь энэ билээ. ” гэв. (Ирсэн элчээс “Аль зүг одох

вэ? ” гэсэнд “Дорно зүг од гэв. ” Сангаа түгээж өгөөд Арлан гуа уйлж явав. Хорооны үгээгзз ядуу хамаг улс тэргүүлэн булт гашуу болон уйлалдан нэхэж явна: “ай хайран эрдэнэт авай минь. Хамаг их улсаа юу гэж тэвчнэм чи? Чамайг жаргах газар бүгдээр жаргая . Чамайг зовох газар бүгдэр зовьё бид. өөрийн энэ бие минь үхэвч үхье” гэж дагаж уйлж явна. Арлан гуа “Ингэж бүгдээр явбал эзэн Гэсэр хаанд муу гэнэ. ”Хамаг бүгдээр явбал хайрт эзэн Гэсэр хаанд минь муу гэнэ. Та бүгд. Минь харь” гээд “”4худалдаж идье гэж авсан эрдэнийн сангаа түгээж өгөд явав. Хамаг улс харвж ирэв.

Арлан гуа дэмий ганцаар явж байтал цагаан өнгөт газарт хүрэв. Алиаа амьтан нв булт цагаан байв. Чандаган элч угтаж ирээд аваачив. Цагаан өнгөт улс их хурим хийжс “манай хаанд заяат буюу?” гэж цагаан дэл өмсгөж, цагаан морь унуулж үдээд ирэв. Түүний цаана явж алаг газар хүрэв. Шаазгай элч угтаж аваачив. Тэр урс урьд ёсоор хурим хийгээд мөн эр ёсоор үдээд харьж ирэв. Цааш шар өнгөт газарт хүрэв. Үнэг элч угтаж ирээд аваачив. Аливаа амьтан урьд ёсоор хурим хийж үдээд харьж ирэв. Цааш яваад хөх өнгөт газар ирэв. Цоно элч угтаж ирээд аваачив. Мөн урьд ёсоор хурим хиж үдээд ирэв. Цааш хар өнгөт газар хүрэв. (Бүх юм нь хар байв. Түүнээс хар хэрэ элч ирээд хар хувцас өмсгөөд “Энэ эм бидэнд хамаагүй” гээд цааш илгээв)

Их далайд орж дмий явна. Агт уралдам газраас халуун салхи амьсаалж ирэв. “Эвүү!Энэ юу билээ? гэж айж явна. Арлан гуа бас үрээ уралдам газраас өдий хүйтэн салхиар амьсгалж ирэв. Арлан гуа тэр салхинд хийсэж тогтож дан, “Гэсэр хаан минь яалаа! Гэж уйлж явна. Даага уралдам газраас (нэгэн их хөнхөр хар хүн) дээд уруулаа тэнгэрт, доод уруулаа газарт хүргэж ирэв. Арван хоёр толгойтой мангасас Арлан гуа айж угтан сөгдөж мөргөөд үг хэлэв: “дээд Хурмаст тэнгэрт хан гэлээ. Энэ шөнө ирэхдээ хээр хонолоо би. Зүүдэлсэн болов уу? Үнэн болов уу? Их гарди болж намайг огторгуйд авч гарах мэт билээ. Хурмасттэнгэр хаан болов уу энэ ? Яаж танъя үүнийг ? Энэ өглөө явган явж ядаж их далйн захад унтлаа би. Далай дундас аврага загас мэт өрөвхийж авлаа намайг. Загас биш лусын хаан болов уу? Чамайг яаж танъя ?” гэж мөргөв. “Арван зүгийн эзэн Гэсэр хааныг түдэж(саатаж?) явна гэж арван хоёр толгойтой мангаст босож (оргож) ирлээ би. Мангасын хаан мөн болов уу? Биш болов уу? нэгэн цагт би ийм хааны үнээ саах хятад эм болоосой би, үнс гаргах шивэгчин болоосой би.” гэж мөргөв. Мангас ”ха ха, сайн сайн, яв” гэж дүүрэв. “Авай битгий ай! Чамайг ыби идэхгүй . Миний ерөөлийн хүчин биз. Чамайг би сонслоо. Гэсэр хааны нэгэн сайхан хатан буй гэж авья гэмээж нь арван зүгийн эзэн Гэсэр хааныг хэцүү гэхэд нь байлаа би. Үнээ саах хятд болох мэдээгүй ” гээд авч явав. Хотдоо Ароан гуа хүргээд хоёр гурван сайхан хатнаа залгиж орхи. Арлан гуаг мангас авав.

Гэсэр хаан арван хоёр толгойт мангастай байдлахаар бэлдэв.

Арван зүгийн ээн Гэсэр хааны чилээ сайн болов. Аливаа улс өвчин тахлаас тонилов. Арван зүгийн эзэн Гэсэр хаан зарлиг болов: “Хятадын гома хааныд очиж төрийг засаж Хятадад гурван жил сууж ирэв би. Рогм гуа минь чинийхээ дэргэд ирээд чилээрхэж удав би. Одоо Арлан гуадаа очье ” гэж “Билгийн хээр морийг минь барь гэв. Билгийн хээр морийг барив. Рогма гуа үг айлтгав: “Арван хорын үндсийг таслагч айх мэт богд миь! Арлан гуа хатан чинь муу болов гэлээ. Одоо хаана очих вэ чи?” гэв. “Эвүү! энэ юу гэнэ? Тэр минь өнөө яаж муу болох билээ ? Байз би очно” гэв. Рогма Цотонд хүн илгээв. Цотон ирэв. Рогма Цотон хоёр үгсэж Цотон Гэсэрт үг айлдав. “Ай богд минь! Үнэнийг айлтгая би чамд. Арлан гуа чинь чамайг түдэж явна гэж арван хоёр толгойтой манаст оргож очив. Авай минь морь биеэ түргэн зуур амар гэв. Богдын зарлиг : “эмийн минь буруу болбол эмэ ална би. Би явья ” гэж Гэсэр хаан “мордьё” гэж байна. Цотон ноён : “Айх мэт богд минь хар багаас мангастай оролдож явж мангасын мангасны барилыг би авлаа. Авай минь би нэхье” гэв. “ Авай минь байг! Тэр муу мангас хэцүү буй за. Би нэхьеб гэв. “Авай минь тэр мууд юуны хэцүү билээ? Би нэхье” гэв. “”4 Авай минь тийм ы болбол яарч яв. 6 гээд хурим хийв. Өглөг өгч их улсынхаа хагас дундуурт өгөв. Цотон аргалж гэртээ харьж зэр зэвээ авч нэхье гэж явав. Хоёр гурав хоноод Цотон ноён “Би чилээрхэв” гэж их улсдаа зар өгөв. Түүний хойно Цотон ноён “Би муу болон өвдөв” гэж бас их зар өгөв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан (нэгэн сар болсон хойнол) билгийн хээр морио унав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт дуулга, эрдэнэсээр давхарлан хийсэн хөө ха хуягаа өмсөв. Хамаг зэр зэвсгээ авч Арлан гуагаа нэхье гэж мордов. Цотон ноёныг “Үхэв” гэж сонсоод : “алдсан эмээ нэхэхээс илүү энэ өдөр янаг төрөл авгай болох хэрэгтэй. Тэр минь үхэж гэнэ” гэж “Ясыг нь барьж, сүнсийг нь огторгуйд гаргая би” гэж очив. Гэсэр хааныг хүрч очмиход Цотон ноён үхэгч болж ширээн дээр нэг нүдээ хялааж, нэг нүдээ аньж, зүүн гара сарвайж, баруун гараа атгаж, зүүн хөлөө жийж, баруун хөлөө атирч хэвтэв. “Эвүү! Авга минь үнэхээр үхэв үү чи? Авгай минь үхсэн бололтой мана их гэрийн их хүү Алтаныг үхүүлэх муу ёр болж байна. Үхсэн хүн нэг нүдээ аньж нэг нүдээ хялааж үхвэл муу ёр гэлээ” гэж хяласан нүдэнд нь цацъя гэж шороо атгаж очиход Цотон ноён хялаасан нүдээ анив. “Нэг гара атгаж, нэг гараа сарвайж үхвэл хойд үрээсээ юм өг гэсэн мэт муугийн бэлэг гэлээ” гэж гарт нь очиход гара атгав. “Нэг хөлөө атирч нэг хөлөө жийсээр үхвэл хойд амьд үрдээ муу ёр гэлээ” гэж хөлд нь очиход хөлөө жийв. “Авгайгаа өндөр модонд өлгөж их түймэр тавив. Цотон ноён босон гүйв. “Эвүү! Аьгай минь. Үхсэн хүн галд шөрмөсөө шатахад босдог гэлээ, тийм буюу ? гэж галт модоор өмнөөс нь чилэв. “Халхай!хуухай! Үхсэнгүй авгай чинь гэж бархирав. “Авгай минь үхсэнгүй байна. Нааш ир” гэж түймэр дотуур чирч авч ирэв. Цотонгийн үс, зүс, гар хөл нь цөм халсан байв. (Цотно чи надад юунд худал хэлэв? “ гэсэнд) Цотон ноён өгүүлрүүн : “Арван хоёр толгойт Мангас гэгч үлгэргүй хэцүү гэлээ гэж хүч нь адбиш ихийн тул чамайгаа очиж үхнэ гэж арга хийсэн минь энэ билээ” гэв. Гэсэр зарлиг болруун: “авгай минь! Энэ чинь юутай сайхан арга билээ! Зөв ” гээд Гэсэр хан гэртээ очив.

Гэсэр хаан “Одоо явья ” гэж бэлдэв. Лам нар, багш нар ирж Мангасны оронд явахыг хорьж айлтгав. “Чи үүний урьд Хятадын Гонма хаанд гурван жил саатасны тул Арлан гуа чамд уурлаад догшин Кинарсын уулан дээр гараад буртаг сан тавьсан тул дөрвөн зүгийн хамаг догшид, амьтныг цөм өвтгөж бурхны ном шашин цөлийдөв. Арлан гуаг манас аваачив. Одоо

тийм тул лам чинь би хориноб гэвэл Гэсэр хаан зарлиг болруун: “За би мэдэв. Сайн лам ирвэл сүнсийг тонилгоно гэлээ. Дундад лам ирвэл ном уншина гэлээ. муу лам ирвэл гаднах малыг авна. Гэр дотрох эд барааг авна гэлээ. Ийш тийш харж над аль сайныг өгөх вэ гэж горьдоно. Тийм лам юун адил вэ? гэвэл хоёр ёохор хүн зам олно ядаж явах адил гэлээ. Холбоотой бяруу модонд ороолдсон мэт гэлэ. Бацаг сахилаа хичээ! Харь” гэв. Ноён хүн, зарагч хүн ирж хорин айлтгав. Хариу хэлэв: “Их төр, засаг цаазаа хичжээж хадгал. Заргаа бүү хоёчил. Харь!” гэв. Түүний хойно Цас Чихэр гучин баатар, гурван зун хошувч нар ирж хорин айлтгав. Хариу хэлэв. “Миний явсны хойно аливаа зүгээс дайсан ирэх мэдэгүй . Хуяг дуулга, зэр зэвсгээ хичээж зас. Харь!” гэв.

Эд бүгдийг харьсны дараа Рогма гуа хорин айлтгав. “Намайг төрөхөд баруун дээвэр минь Сэрү нэрт гөрөөс тоглож байсан Зүүн дээвэр дээр минь Бруг луу нэрт гөрөөс тоглож б айсан: Наргүй өдөр гэрэл гарч байсан: Үүлгүй өдөр бороо орж байсан Ноён тулган дээр минь тоть шувуу донгодож байсан. Хатан тулган дээр минь хөхөө шувуу донгодож байсан. Богдсын тулган дээр иминь уран гуа шувуу байсан билээ .

Цаст цагаан уул гадаад тив гэлээ. Цагаан аслан дотоод эрдэнэ гэлээ. Зэс хөх зогдор нь орчлонгийн чимэг гэлээ. Тэр гурван эрт өдрөөс үүдэж гэлээ. Гэсэр бил хоёрт тийм өлзий хутаг орших болтугай. Хар уул гадаад тив гэлээ. Тэр гурван эрдэнэ эрт өдрөөс үүдэж гэлээ. Одоо ч болов өлзий хутаг Гэсэр бид хоёрт орших болтугай. Ийм ийм есөн эрдэм төгс Рогма гуа чинь хорьж байна би” гэв. Гэсэр хаан зарлиг болруун : “Есөн зүйл дагины хувилгаан Рогма гуа хатан минв үнэн болбол хуурай газраас ус гаргаж өг. Хоосон газраас жимс гаргаж өг. ” гэв. Хоосон газраас жимс, хуурай газраас ус гаргаж өгөв. Арван зүгийн эзэн Гэсэр хаан гурван жил суув.

Гэсэр мангасынд очив.

Гурван жил болсон хойно гэсэр хаан билгийн хэр морио унав. Эрдэнэт олон чимгүүдээ өмсөж явах болв. Рогма хатан зарлиг болруун : “Хээр морь Гэсэрийн явдлыг эс дуусгавал дэд сүүлийг чинь хяргаж үнс болгоно” гэв. Гэсэрийн идэх рашаанд идээг хавтганд хийж өгөв. Хээр мориой идэх үзэм чихрийг хүзүүнд нв уяж өгөв. Гэсэр хаан явав. Гэсэр хойшоо харж явав. Хээр морь хэлнэм: “Эм хүн тэр үгийг хэлсэн байхад чи юу гэж хойшоо харна?” гэв. Гэсэр явав (Цас Чихэр хойноос нь хөөж ирээд “Биш баатрууд байтугай. Би ганцаар явалцай” гэв. Гэсэр зарлиг болруун : “Чи надтай очих ёсгүй. Энэ сумыг минь би? мэт санаж яваарай” гээд саманд нэрт сумаа сугалж өгөв. тэр сумыг аваад их гомдож ужйлсаар харив.) Гэсэр хаан билгийн хээр морио унаж өндөр уулын оргил дээр гарав. Морио дэвхцүүлж дүүлүүлж байж, ялгуусан гуван эгчдээ залбирав. Ийн өгүүлрүүн : “Овоо Дүнжин Гарво минь, Арья Аволки Одкари минь, Жамца Дари Оддам минь ”! та ялгуусан гурван эгч минь Аль зүгт одьё би нусгай чинь ?” гэж залбирав. Гурван эгчийн сахиус нэгэн хөх шувуу бууж ирэв. “Авай нусгай минь яв” гэж донр зүгт аван одов. Хөх шувуу хэлэв. “Гэсэр нусгай минь, үүний цаана арван хоёр толгойтой мангасын хувилгаан, нэг бух гөрөөс бий. Баруун эврээ дээд огторгуйд тулгаж, зүүн эврээ доод дэлхийд тулгаж, нэг идэхдээ талын өвсийг тал долооно. Нэг ус уухдаа нэг уулын урсгал горхины усыг эх адаггүй тас залгилж орхино. Ийм хэцүү дасан буй. Авай минь хичээж дайл” гэв. Гэсэр хээн “Эгчийн минь зарлиг зөв гэж явж довглов. Бух гөрөөс аравны газар харайв. Билгийн хээр морь долооны газар харайв. Гурван газрын зайтай хоцорч явахдаа Гэсэр хаан ову эрдэнэ очит гучин цагаан сумаар намнав. Сумыг нь ялгуусан гурван эгч нь цуглуулж авав. Гэсэр хаан бух гөрөөсийг эс онож, мөрөө буцаж сумаа эрж эс олов. Гэсэр хаан бух гөрөөсийг эс алаад : “Эгч минь яалаа! Бух гэрээс аравны газар харайв. Билгийн хээр морь минь долооны газар харайв. Гурван газрын зайтай хоцорч явахдаа оньт гучин цагаан сумаар намнав. Оюу эрдэнэ оньт гучин цагаан сумаа эс олов би ”” Бие минь ядрав. Морьминь зүдрэв. Эгч минь яалаа! гэж уйлж явна. Ялгуусан гурван эгчийн сахиус нэг хөх шувуу ирж хэлэв. “Авай нусгай минь! Юу гэж уйлнам ? Эм хүн үү чи ? Эр хүн “За” гэсэн газартаа юу гэдэг билээ. Оюу эрдэнэ оньт гучин цагаан сумыг чинь авч тавьсан би. Биед чинь зооглор ламын адис шнгэсэн идээ, бимлгийн хээр морийг чинь б ордох арвай буудай эднийг бэлэн хийж тавьсан би. Эднээ аваад яв. Авай Гэсэр минь! “ гэв. Очтол тэр бүгд нь бэлэн байв. Аваад : “Эгчийн минь зарлиг үнэн байна” гэж оюу эрдэнэ оньт гучин цагаан сумаа дүрж адист тдээгээ зооглож, билгийн хээр морио бордоо явав. Бух гөрөөсийн мөрөөр явж ойртож хээр хонов. Билгийн хээр морио сойв. Өөрөө нойрсохдоо зүүн хойш хандаад урд хормойгоор иолгойгоо бүтгээд (Гуа Довыг дэрлэн) нойрсов. Бух гөрөөс шөнө (Дүл болох цагт ирээд билгийн хээр морийг “Би чамайг авч одьё : Чи үл болох болбол чамайгш залгина” гэв. Билгийн хээр морь өгүүлрүүн : “ Нүгэл хэлэнцэт этгээдэд очихгүй би. Чи намайг залгих гэвэл гэвэл би Гэсэрийг сэрээж босгоё . Чи намайг залгиж болохгүй. Бусад морь шиг санаж байна. Намайг залгивагч дөрвөнг таваг минь гишгээсээр байхын тул чи бид хоёул зэргээр үхэх биз” гэв. Төдий бух гөрөөс айгаад) нэгэн өрөвхийвж долоохдоо билгийн хээр морины дэл сүүлийг бас долоов. Бас нэг долоохдоо оу эрдэнэ оньт гучин цагаан сумны өдийг тас долоов. Билгийн хээр морь хэлнэ: “Бух гөрөөс нааш сонс . Болбол намайг маргааш битгий гүйцээрэй чи” гээд Гэсэрийн нүүр дээр нь уулын чинээ баасаар багаад явав. Арван зүгийн эзэн Гэсэр хаан үүрийн хяраанаар сэрэн цочиж уулын чинээ б аасыг хаяж орхив. Тэр баас нь нэгэн тал дүүрч хэвтэв. Босон харайвал өйлгийн оньт гучин цагаан сум нь өөдгүй хавчаахайн сум болж байв. “Хүний сахиус ингэж байхад, миний огторгуйн дахь олон сахиус минь,

орчлон дахь аль бүгд хамаг сахиус минь та бүгдээр яалаа.! Ялгуусан гурван эгч минь! Бух гөрөөс ирж билгийн хээр морины дэл сүүлийг тас долоож хамуут хээр даага болгож, оюун эрдэнэ оньт гучин цагаан сумыг минь өдийг тас долоож гучин цагаан сумыг синь өөдгүй хавчаахай болнож орхиж ” гэв. Ялгуусан гурван эгчийн сахиус нэг хө гшувуу ирж хэлэв: “Авай минь, уйлах болбол харь. Эр хүн атаандаа биш үү Эхнэр хүн чөтөөндөө биш үү. Эрэг эс нурвал хас хад болно билээ. Эр хүн эс эндвэл хүрэл эрлдэнэ чулуун зүрхт болно гэлээ. Билгийн хээр морийг бодож дэл сүүлийг ургуулах арвай буудайг тавилаа би. Биед чинь зооглох ламын адис шингэсэн идээг тавьлаа би. Оюун эрдэнэ оньт гучин цагаан сумыг чинь өдөлж тавьлаа би язгуурын хийснээс муухай боловуу ? Сайхан боловуу? Үз” гэв. Үзтэл язгуурын хийснээс злэмж сайхан мэт байв. гучин цагаан сумаа дүрж биедээ зооглоод билгийн хээр морио өглөөгүүр үд болтол гурван үе бодоод дэл сүүлийг ургуулаад, Гэсэр хаан явав. Бух гөрөөсний мөрөөр явж билгийн хээр мориндоо үг хэлэв. : “Ай! Билгийн хээр морь минь бух гөрөөсний өмнө гүйж гарах уу? Эс гарвал дөрвөн тавгийг чинь огтлоод эмээр хазаараар үүрө харина би ” гэв. Билгийн хээр морь нь : “ АРюан зүгийн эзэн Гэсэр хааны минь зарлиг зөв. Бух гөрөөсний өмнө гүйж гарвал гарна би. Бух гөрөөсний магнайн цагаанаар харваад баруун хажуугийн хардлахын түүгээр сумаа гарга. Чамайг түүнийг алвал өшиглөж орхойд огторгуй дахь гурван эгид чинь очьё би.” гэв. “За, зөв. “ гээд Гэсэр хаан билгийн ташуураар баруун гуяыг гурав гуядаад давхив. Хээр морь Гэсэрт уурлаж Гэсэрийг огторгуйгаар аван явав. Амыг нь татан ядаж хээр морь нь Гэсэр хаанд зарлиг болов: “Ай! Билгийн хээр морь минь огторгуйд явагч үл тогрууг хөөх начин харцага билүү ыи. Алтан дэлхий дээр зүгээр яваасай, Авай минь” гэв. Алдтан дэлхий дээр бууж хөвчин газрыг цөмөр цөмөр гишгэж харайж явна. Тоос нь Гэсэрийн толгой дээгүүр бур бур хийж явна. “Ай билгийн хээр морь минь, хөвчин газрыг хөндийлөн гүйх номин солонго уу чи ? Алтан дэлхий дээр зүгээр гүйж аль. Хэрэгтний өмнүүр гараасай авай минь!” гэв. Алтан дэлхий дээгүүр гүйгээд бух гөрөөсний дээгүүр гарав. Билгийн хээр мориор Гэсэр хаан дайран харвав. Бух гөрөөсний магнай нь цагаанаар харвасан сум нь баруун хажууны харлахын түүгээр гартал харвав. Бух гөрөөсийг сумаар харваад билгийн хээр морио орхиж гүйн очиж охор сүүлнээс нь гурван үе огтлож үмхэв. Ялгуусан гурван эгчийн сахис огторгуйгаас заларч ирээд бодит биеэр зарлиг болов: Авай нусгай минь! Дайрах чинь баатар эрийг шинжтэй байна. харвах чинь хавгай мэргэн шинжтэй байна. Билгийн хээр морио хол орхиод буж ирэх чинь тэнэг шинжтэй байна. Урьд огтлоод үмхэх чинь залгидаш шинжтэй байна. Энэ бух гөрөөсний махыг огторгуйд олон сахиус бүгддээ, ялгуусан гурван эгчдээ, бүгд олон сахиусандаа дэд дэдээр ариун тахил тахиад зооглоосой чи минь “ гэв. “Эгчийн минь зарлиг зөв. Өлсөв үү? Яав би? Өшив үү? Яав би? ” гээд бух гөрөөсний махыг дэд дэдээр тэд бүгдээрээ ариун тахил тахиад зооглов.

Гэсэрийг мордоход нь ялгуусан гурван эгч нь хэлэв. : “Авгай нусгай минь үүнээс цааш шулмасын газарт бузар буртаг муу буй. Бид осихгүй. Чи минь ганцаара яв. Очих замд шулмасын хувилгаан нэгэн албит гол бий. Түүнд морь хүн, хад дэмий хангижнаж урсааж байдаг. Түүнд “Гүрү суухаа!” гээд билгийн ташуураар гурав дохиод гарч в. Түүний цаана шулмасын хувилгаан хоёр хад бий. Хав хав хийж нийлж салж байдаг . Түүнд чи аргаа мэдэж гарч яв Авай минь! Түүнээс цааж алтгаа явдлаа чи мэд ” гээд харив.

Арван зүгийн Гэсэр хаан явав. Өнөөх албинд гол хүрэв. “Гурван эгчийн минь хэлэгч үг үнэн байна” гэв. “Гүрү суухаа” гээд билгийн ташуураар гурав дохиод гарч явав. Түүний цаана

мангасын хувилгаан хоёр хаданд хүрэв. “Эгчийн минь хэлэгч хоёр хад энэ байна” гэв. Билгийн хээр морио хувилгаж хамуут хээр даага болгов. Биеэ хувилгаж хатсан муу хүн болов. хаданд хүрээд хадыг хуурч үг хэлэв: “Эвүү! Эвүү Энэ хоёр хадны үтэр түргэн хав хав хийх нь юутай сайхан билээ! Зөв, зөв. Төвдийн газраас ирсэн хамуут хээр даагатай хатсан муу хүн наймаг үзээд үтэр түргэн хав хав хийнэ болов уу? Энэ ер язгуурын сурсан зан нь энэ болов уу? манай төвдийн газрын хад бол хүнийг зуур хоногийн газраас, эсвэл үдийн газраас хав хав хийж алдаг билээ. ай, би айж үхэх гэж байна. Би харъя “ гэв. Хоёр хад : “Энэ хүний үг зөв” гээд “Хөөрхий, айна гэнэ Үнэхээр ч зуур хоногийн газраас ирээд хав хийж алья” гээд хоёр хад хол хол болов. гэсэр хаан хоёр хадыг хол өолгоод билгийн хээр морио дав хийж гуядаад гарав. Хоёр хад гэсэрийг хавчиж ална гээд өвөр зуураа хамхарч бутарч хэвтэнэ.

Гэсэр хаан цаана хүрээд мангасын аливаа өнгөт улсыг үзээд мөн тэр өнгөөр хувирч гарч явав түүний цаана мангаёын тэмээ хариулагч хүн тэмээний чинээ чулуу эрчийдээд (нитгэрээд) сум болгож явна. Гэсэр түүний үзээд үхрийн чинээ чулууг аваад сум болгож эрчийдэв. “Ай нөхөр! Чи хэнийх вэ ? ” гэж дуудав. “Тэмээчин “Би тэмээчин” гэв. “За хоёужла цохиолоцож наадъя ” гэв. “За зөв” гэв. “Дээгүүр цохих уу? доогуур цохих уу?” гэв. Тэмээн хэлнэ : “Би дээгүүр цохиё Чи доогуур цов” гэв. Тэмээчин Гэсэрийг тэмээний чинээ хадаар далайж байж цуохих гэв. Гэсэр Жур биеэр хувилаад бага хүн болоод байв. дээгүүр цохиод алдав. Ай нөхөр! Хишиг над болов уу?“ гэв. Гэсэр хаан доогуур нь цохигч болоод зүрхний нь эхээр цлхив. Тэмээчин мужирч унав Дарж хэвтгээд үг асуув гэсэр : “манасын хот нь хаана байна ? Наад зам нь хялбар юм уу ? мангас хаагуур гөрөөлж явдаг юм” гэв. “Мангасын хот мөн энэ ойр бий. наана нь тэнгэрийн цагаан даваанд тэнгэрийн хүүхдээр харуул тавьсан. Түүний цаана манай мангасын хүүхэд хар даваанд харуул харж буй. Аливаа учрыг тэнгэрийн хөвгүүн мэднэ “ гэв. Гэсэр хаан түүнийг алаад нөгөө гурван хошуу малчныг мөн тэр ёсоор алаад явав.

Тэнгэрийн цагаан даваанд хүрэв. Тэнгэрийн хүүхэд Гэсэрийг үзэж уйлаад дуудав: “Эвүү! Энэ газар улаан хөлт амьтан үл шгэх билээ . Хэрвээ хүн ирвэл мангас адах билээ. Аль богд болов? Яаж танъя” гэж уйлав хүүхэд. “Авай хүүхэд бү ай! Нааш ир. Би арван зүгийн эзэн Гэсэр хаан. Та тэнгэрийн хүүхэд үү? Яасан билээ та ? ” гэв. Эцэг эхэд эрхлээд алтан дэлхий дээр бууж наадаж явгал биднийг арван хоёр толгойтой мангас гэнэт ирээд өрөвхийж аван ирэв. “Гэсэр ирэх болов уу ? гжэ маанр харуул тавьсан нь энэ билээ гэв. “За тийм болбол арван хоёр толгойтой мангасыг би алж өгье. Та над юу өгөх вэ хүүхэд?” гэв. “Ай богд! чамд юугаа боловч үл хайрлана” гээд мөргөв. “ай! Арван зүгийн эзэн Гэсэр хаан минь! Үүний цаана ертөнцийн шар даваа бий. Тэр хүүхдэд мөн үгээ хэлээд гарч оч. түүний цаана нүгэлт арван хоёр толгойтой мангасын даваанд мангасын хүүхдээр харул тавьсан . тэр даваанд явшгүй гуу, мод, хад, бий. Өдөр ч үгүй, шөнө чүгүй, хав харанхуй будан мэт байх бий. Түүнд энэ хэрэгтэй болов уу” гэж өврөөсөө гал эрдэнэт шил авч өгөв. “Ай богд! Тэр давааг гарах болбол үүнийг барьж гарвал гэрэл орох буй” гэв. “ай хөөрхий хүүхэд! Энэ чинь зөв. ” гэв. “таныг ачилъя. Ай богд! Тэр давааг гарч очвол цаана нь гурван өндөр уулын дунд жалганд нэгш тохонй чинэ хүн бий. төлөгний улаан утсаар шарж идэх мах үл андах ийм бэлэг буй. Түүгээр бэлэг үзүүл. Сайн гэвэл оч. Муу гэвэл байг” гэв. “Зөв” гээд. гэсэр хаан явав. Ертөнцийн шар даваанд

тэнгэрийн хүүхдийн үгээр хэлж гарав. Түүний цаана мангасны хар даваанд хүрэв. Хүрэл үнэхээ өвс үгүй өнөр уул байв Өдөр шөнө үл мэдэгдэж мана тунаж хав харлаж байна. Бэлд нь бууж балин өргөж олон сахиусандаа залбилрна. “огторгуй дахь олон сахиус минь, ялгуусан гурван эгч минь.! тэнгэр хүрхрэх мэт, луу нажигнах мэт болж нудрагын чинээ мөндөртэй бороо оруул . Өшөөт дайсны хацүү давааг өрсөн давна би ” гэв. Тэнгэр хрхрэх мэт, луу нужигнах мэт их бороо болж нударгын чинээ сөндөрт хур орж байв. Эрднийн шилийг баруун гартаа атгаж билгийн хээр мориой тэр давааг харайлгаж гарч очив. мангасын хүүхэд мөндрөөс айж толгойгоо бүтээж хэвтэнэ. Гэсэр нударгын чинээ чулуу өвөрлөж мангасын хүүхдийн толгойг цоо цоо цохиж алав.

Тэднийг алад цааш гурван голын дунд гол өөд явав. Үнэхээр тохойн чинээ хүн байна. Гэсэр билгийн хээр мориой хувилгаж хамуут хээр даага болгов. Биеэ хувилж муу хүн болоод хүрч бууь. Бууж очихдоо : “Хол бай. Энэ тохойн чинээ хүн төлөгний улаан утсаар шарж идэх мах үл андах гэж худал үг байх” гэж бодов. Гэсэр тэгээд хүрч суув: “Тохойн чинээ хүн чи үз. Цагаан мөрөн өөд цагаан атан тэмээнд буй. Түүнийг дээрэмдэхэд очно би. төлөг үз. Шар мөрөн өөд шарга азрагатай адууг дээрэмдэхээр очно би. Төлөг үз. Хар мөрөн шар азргатай адууг дэрэмдэхээр очно би. Төлөг үз. Хар мөрөн аад хөр халзан азаргатай адууг дээрэмдэхээр очно би. Төлөг үз. Тохойн чинээ хүн улаан утсаа ганц суглаж үзэв. Ы”Цагаанг маран аад бүү оч. Бурхны зам буй. Шар мөрөн өөд бүү оч. Сав ертөнцийн замбуй. Хар мөрөн өөд оч. Мангаст зоригтой байна чи. Явдал чинь бүтэх байна” гэв. Мордтол нь : “Өө байз! Нэг утсаа үзээгүй билээ” гэж дуудав Гэсэрийг үзэв. Үзээд хэлэв: “Дээд биенд чинь өрвөн зүгийн бурхан төгссөн байна. Дунлд биенд чинь дөрвөн их тэнгэр нар төгссөн байна. Доод биенд чинь дөрвөн их лусын хаад төгссөн байна. Адилтгавал энэ Замбутивийн эзлэгч арван зүгийн эзэн Гэсэр хаан чи биш үү? Энэ муу тохойн чинээ хүн төлөгний улаан утсаар шарж идэх мах үл андах гэж ухдал үг гэж худал үг гэж бодож ирсэн байна” гэв. “Ай мэргэн оточ! Түүнд минь уурлав уу? ” гэж асув. “Юу гэж уурлах вэ ? Энэ өндөр уулын дунд замар гарч очтол мангасын хувилгаан нэгэн эрвэн сэрвэн мод бий :. Иэр модны дэргэдүүр хүн гарахд ирт мэсээр цавчилж алдаг буй. Түүнийг хичээж дайл” гэв. “За ” гээд Гэсэр хаан явав.

Тэр модны барааг үзээд битлгийн хээр морио огторгуйд гаргав. Биеэ хувилгаж гуйланч хүн болов. Билгийн гурван алд хар шор сэлмээ хувилгаж хоёр ачмагт хийсэн баахан гурил болгов. Хамаг зэр зэвсгээ хуилгаж хоёр ачмагт хийсэн баахан гурил болгов. Шил ишт оновч хутгаа баруун ханцуйндаа хийв. Модны дээрээс нь хүн болон мэсээр далайна. Дээш харахад их дуугаар “Эвүү!” гэв. “гуйлагч хүн намайг ирж суухад мод билээ. Энэ мод юу гэж хүн боон ирт мэсээр далайх яасан хувилгаан мод билээ энэ ? Би энэ ахуйг тойрсон (хэрмэл) гуйланч билээ. Дээр хурмаст тэнгэрийн хувилгаан модон буй гэлээ. Өштөн дайсныг үзвэл өрсөн ална. Тэр аод үгээгүү ядуу хүнийг үзвэл өршөөн хайрлана гэлээ. Түүний хувилган мод болов уу энэ? Энэ замбутивийн эзэн Төвдийнг гэсэр хааны хувилаагн мод болов уу энэ ? Харьтан дайсныг үзвэл хар сэтгээд алдаг гэлэ. Хамаг үгээгүү ядууг үзвэл зам зааж өгдөг гэлээ. Хамгийн эзэн Гэсэр хааны хувилгаан мод болов уу чи ? Яаж танъя? Арван хоёр толгойтой Рагшасын хааны хувилгаан мод буй гэлээ. тэр болбол яахыг нь эс мэдлээ би. Ахуйг тойрсон муу үгээгүү яданги

гуйланч билээ би. Өнөө энэ модны ёроолд баахан тамс ургаж, түүнийг ухаж ид” гэв. Төмс ухагч болж модны ёроолыг хөндийлөн ухаж сумч шил ишт оновчоор тас тас огтчив. Модыг түлхэж орхиод Гэсэр билгийн гурван алд хар шор сэлмээр тас дэлдээд түймэрдэж орхив.

Гэсэр хаан, Мангасын ордонд Арлан гуатай уулзав.

Мангас хувилгаан модоо алдсаны тулд гөрөөлж явтал гэнэт “Толгой өвдөнө” гэж “Их далайдаа орж биен сэрүүцье” гэж хэвтэнэ. Хэвтсээр унтав. Арван зүгийн эзэн Гэсэр хаан харцага болж хувиран хүрэв. Мангасын зүүн нүдэн дээрээс хатгаад дутаав. Мангас өрөвхийж алдаад босож (бүргэд болоод) хөөв. Гэсэр цаад өндөр уулын оргил дээр гараад тохойн чинээ хүн болж наадаж явна. Мангасыг хүрч ирэхэд бас бор харцага болон нисэж их далайд ирээд тохойн чинээ хүн болж наадаж явна. Их далайд мангасыг хүрч ирэхэд мөн харцага болон нисээд явав. Манас гүйцэн ядаж гэртээ харив. Арлан гуад үг хэлэв: “Эвүү, яалаа би. Энэ биеэ төрсөөр ийм зовлонг эс үзлээ би. Энэ өдөр гөрөөлж явтал миний толгой гэнэт өвдөөд их далайд орж биен угааж хэвтсээр унтав би. Гэнэт бор харцага ирээд зүүн нүдний минь дээрээс хатгаад дутаав. Босож хөөтөл минь өндөр уулын оргил дээр гараад тохойн чинээ хүн болоод наадаж явна. Өндөр уулын өөд хөөе гэтэл харин их далайд нисэж очоод бас тохойн чинээ хүн болж наадаж явна. Далайд очиход минь бас нисэж одов. Хамаг аргаа барав би. Бор зүрх минь булиглав. Богино хаврига минь шархирав. Үстэй толгой минь өрвийв Үе гишүүн минь чичрэв. Эвүү, яасан нүгэл билээ ? ” гэв. “Арван зүгийн эзэн Гэсэр хаан ирэв үү ? Хурмаст тэнгэр хувилж ирэв үү? Лусын хаад ирэв үү? Асур нар ирэв үү ? Ямар догшид ирсэн болов ? Тэр дөрвүүлээс өөр над нэг хүн халдах ёсгүй билээ. Булт ширээг би авсан (бусад бүх орныг би эзэлсэн)” гэв. Арлан гуа хэлэв: “Эвүү! сайн эр минь!” Арван зүгийн эзэн Гэсэр хаан гэгч арван зүг хувилдаг балай олон (их олон) хувилгаангүй биш үү? Бурхан төрөлтэй гэж шувуунд үл хувилдаг. Асур нар биз. Хэн гэнэм чи үүнийг ? гэв. “Энэ үг эгээ мөн” гэв.

Мангас маргааш өглөөгүүр (Хотын хөөлгөнд бяруун чинээ хоёр аалзаа тавиад “Энэ эмийг хотын гадна гарвал залгиж орхи” гээд) гөрөөлөхөөр явав. Арван зүгийг эзэн Гэсэр хаан билгийн хээр морио унаж мангасын хотод очив. Мангас хотоо үлгэргүй өндөр арьсан ажээ. Гэсэр хаалгыг нь олон ядаж нэгэн үе билгийн хээр мориндоо үг хэлэв: “ ай! билгийн хээр морь минь! Чи намайг хотын дэгүүр авч гар. Хот дотор алтан шагай унагаасан мэт тов хийтэл тусаж бай. Намайг авч гарч эс чадвал дөрвөн тавгийг чинь огтлоод эмээл хазаараа үүрч харъя би. Чамайг авч гартал би унаж хоцорвол энэ шулмасын хотод нь унаж үхээд махаа нохойд идүүлье би” гэв. “Эвүү! Айх мэт богд баатар минь энэ зарлиг чинь юу вэ ? ийм тийм гэж юу гэж зарлиг болно вэ ? Би чамайгаа за гэсэн газар үл гэдэг билүү? Чи гучны газар очиж хашгиран довтолж ир. Годил харвам газраас “За за, яв яв” гэж баруун гуяг гуядаж амыг минь татаж ир. Би чамайгаа авч гарахаа би мэдье ” гэв. “За одоо зөв” гэж арван зүгийн эзэн Гэсэр хаан гучны газарт очив. зкүүн гараар жолоотой дэлээ дээрээс нь ноцов. Хоёр хөлөөр тас хавчив. Баруун гараар гуяг нь гурван үе гуядаад хашгиран давхив. Билгийн хээр морт огторгуйгаар яван очив. Орохдоо алтан шагай болон хот дотор тов хийж тусав. Билгийн хээр морио огторгуйд гаргав. Биеэ хувимлж гуйланч хүн болов. хамаг зэр зэвсгээ хувилгаж хоёр ачмагт бахан гурил болгов. Билгийн гурван алд хар шор сэлмээ хувилгаж гаруван алд хар таяг болгов. нэг нүдээ сохойлгов. Хотын хайсан дээгүүр гарч : “Энэ юутай сайхан хот билээ! энэ ахуйг тойрсон үгүй яданги гуйланч хүн билээ би. Дээр хурмаст тэнгэрийг ч үзлээ би. Доор лусын хаадыг ч үзлээ би. Тэр хоёулын ийм с айхан том биш л дээ. Төвдийн арван зүгийн эзэн Гэсэр хааны нэг сайхан хот бий гэлээ. Түүнийг сэ үзлээ би. Арван хоёр толгойтой манасын нэг сайхан хот бий гэлээ. Түүнийг эс үзвэл би. Дэмий сажилж явсаар энэ хоёр хааны нэгийг

хотод учрав уу би? Энэ хотын хатан хаан хоёрыг үзээсэй би” гэж урт мод тулж их дуугаа гаргаж гэр зүгт очив. Очтол улаан өрхт үлгэргүй их цагаан гэр байна. Түүний үүдэнд хүрээ. Баруун хаваьчинд, зүүн хатавчинд хоёр бяруун чинээ аалз хэвтэнэ. Арлан гуа Гэсэрийн дууг сонсоод : “Эвүү! эвүү! Гэж бсож гүйн гарав. Хоёр бярууны чинээ аалз бол манасын хувилгаан байсан аж. Арлан гуаг гадгаш гарвал залгиж орхи гэж тавьсан элч байлаа. тэр хоёр аалз амаа ангайж арлан гуаг умхэж рхиё гэж айсуй. Одоо үгүй яданги хүн хар таягаараа хоёр аалзыг хувилгаанар цохиж алав. Гэсэр өөрийн хувилгаанаа мөн оронлд нь хоёр аалз болгож хуурч тавив. “Ай! Айх мэт богд минь хаанаасс ирэв? ” гэж Арлан гуа Гэсэр хааныг тэврэн хайлав. Арлан гуаг хайлж байхад : “Охор жолоот эхнэр гэгч энэ биш үү. Чамайг уйлж байвал мангас мэдэх биш үү. Бүү уйл. Тэр муугийн арга сүвийг зааж өг над“ гэв. Арлан гуагаас асуув: “Баруун хацартаа энгэсэг түрхэж баруун биеэ сайхан чимгээр чимсэн чинь юу вэ ? Зүн хацартаа хөө түрхэж, зүүн биеэ чимгээр чимсэн чинь юу вэ ? ” гэв. “Баруун биеэ чимгэлсэн минь баатар Гэсэр хаан минь ирж бачит мангасыг барин алж бас толгойг нь огтчихын бэлэг билээ. Зүүн биеэ муу чимсэн нь арван хоёр толгойтой мангасыг доройтуулах бэлэг бэлэглэсэн минь энэ билээ” гэв. Мангас өчигдрийн харцаганд зүүн нүдээ хатгуулсан тэр явдалаа над тоолж хэлсэнд чамагаа ирснийг мэдэд ийм бэлэг бэлэглэсэн минь энэ билээ “ гэв. “ай богд минь! Арван хоёр толгойтой мангас адбиш хэцүү байна. үхнэ болов уу чи минь ? Харь! ” гэв. “Эвүү! Арлан гуа минь тэр үг чинь юу вэ ? Харван хоёр толгойтой манасыг доройтуул гэж хэлэхгүй яав ? Арван зүгийн эзэн Гэсэр хаан болоод, арван хоёр толгойтой мангаст чамайгаа авьтаад Замбутивийн эзэн Гэсэр хаан гэж хотлоор дуурьсаж явах уу би? тэр дийлэх болбол чамайг авсаар авна биз. Би дийлэх болбол чамайгаа авч харина би” гэв. “Тэр нүгэлтийн ядлыг яаж мэдэх вэ би? Чамаас гэртээсээ гадгаш гарсангүй би. Хөх зэс луусаа унаж гөрөөлөхөөр явлаа Үдэш улаан нарнаар хангайы буга ачиж ирдэг. Дайсан хүний ирснийг мэдвэл тэр луус хамраа хууричр хазаарын зуузайг хэмлэж, дөрвөн хөлөө дүүлж дэвхцэж газар цавчилж ирдэг. Ороолон, Гараалан хоёр бор морь энд тэнд нь түлхэлцэж гүйж гарч явдаг. Өөрийн төлөгний улаан утсаараа шарж идэх махыг үл андах билээ ийм төлөгч буй . Аяа Богд минь чамайгаа ханаа хийе?” гэв. “Түүнд гайгүй, Над арга сүвийг нь аргадан асууж өг” гэв .

Гэсэр, Арлан гуа, гурван эгчийн тусламжаар мангасыг устгаж мөн тэнд саатаж суув.

Одоо Гэсэр Арлан гуа хоёул арга хийж (голомтын дор) долоон алд гуу ухаж Гэсэр түүнд оров. Хавтгай цагаан чулуугаар дарав. Түүний дээгүүр нэгэн бүсэнд маант зураад бүрхүүлж тавив. Түүний дээгүүр шороо үрвэ. Тэр шороон дээгүүр хагд өвс тавив. Улаан цагаан жирэмсэн (хосолсон) утас уяж тавив. Мангас үдэш улаан нарнаар хөх зэс луусандаа хандгай буга ачиж айсуй Тэр луус нь хармаа хуухирч, хазарын зуузай хэмлэж, газар малтсаар дүүлж дэвхцээр айсуй. Орооло, Гараалан, хоёр бор морь энд тэнд дүүлэн тлхэлцэж гүйж айсуй. “Энэ жигтэй эмийн минь жиг биз. Бачит эмийн минь бач биз. Дайсан ирсэн болов уу? хамарт минь цох хорхойн үнэр үнэртнэ. Төлөгний мнь улаан утсыг үтэр өг” гэв.

Арлан гуа : “Эвүү, эвүү. Жигтэй эм жиг хүрч гэгч чинь юу вэ ? Жигтэй Гэсэр минь ирж жилбэт мангасыг жиглэж байж огтчих болтугай! Бачит эмийн бач нь хүрч гэгч чинь юу вэ ? Баатар Гэсэр хаан минь ирж бачит мангасын багалзуурыг огтолж бас бурхаддаа тахил өгөх болтугай! (Чи надад юу гэж хилэгнэж байна? Намайг идье гэвэл үтэр идэгтүн). Гэсэрийг муу гэж, чамайг сайн гэж босож(оргож) ирлээ би. Жигт, бачит гэж би өнөө гэрт чинь суугаад яах вэ би?” гэв. “Жигт, бачит гэлэ гэж одоо чи намайг юу гэж харав ? Төлөгний улаан утсыг минь авч өг . Эм хүний салтаан доогуур бүү гарга. Нохойн салтаан доогуур бүү гарга. Зүүн хаяагаар бүү гарга. Төлгийн минь билэг төөрөх буй. Баруун хаяагаар гаргаж өг” гэв. Арлан гуа ороод мөн тэр муу гэсний бэлгээр хийгээд өгөв. Луусан дээрээ байж төлөг үзэв. “Эвүү! Арван зүгийн эзэн Гэсэр хаан ирж луугаар дарж, хар шороогоор үрэлхийж хэвтэнэ үү, яана?” гэв. Арлан гуа : “Эвүү! чи юу хэлнэм ? Гэсэрийг хэн булах вэ ? Одоо би булав уу? Дэр хөх огторгуй эцэг минь болон дуудайсаа. Доор хөрст алтан дэлхий хүн болон дуудайсаа. Энэ бил хоёрын хэлэлцэхийг чагнаж байж сонсоорой” гэв. Гэсэрийн нгэн хувилгаан огторгуйгаас хүн болон дуудав: “Гэсэрийг муу гэж ирлээ чи. Одоо яв” гэв. Гэсэр дороос : “Мангас дэмий донгодоно” гэв. Мангас түүнийг сонсмогц “Эвүүяасан жиг билээ! гэж түүнийг дахиж үзэв. Үзээд: “Гэсэр үхэж байна. Хар газарт орж хавтга чулуугаар даруулж, цагаан цасаар бүрхүүлж, хар шороогоор булуулж, хагд өвсөөр хучуулж түүний дээр хөх өвч ургажээ. Хрэл эрэгтэй их далай байна. Түүний дээр хөвчин шувуу ё суухдаа чандраа унагааж явах байна. Түүний дээр хэрээ, шаазгай сууж элэг болгож явах байна. Гэсэр үхсээр нэг жил барж байна. гээд буув. “Их чиглүүр өг” гэв. (Арлан гуа нэгэн их төмөр баганыг чирж авчирч өгөв. Мангас түүнийг) авч шүдээ чигчлээд (Шүдний завсраас өвч хуяг дуулгатай) хоёр гурван хүнийг унагав. “Ай! Миний идэх идээг өг” гэв. Арлан гуа тэр үхсэн хүнийг махыг хуурч өгөв. Мангас идэв. Арлан гуа өвөрт нь оров. “Ай сайн эр минь . Одоо чи өнөө гөрөөлж ирээд дэмий донгосож байна. Гэсэрийг муу гэж, чамайг сайн гэж ирлээ би. Энэ хот чинь хаалгагүй. Чи гараад явна. Би гэрт чинь хоцроно. Нүгэлт Гэсэр ирвэл нь намайг алаад явах байна. Түүний ирэхийг би мэдвэл чамайгаа гэж хэл оруулах буй” гэв. “Эвүү! Би чамд хэлэхгүй. Гурван зүйл итгэлгүй юм байдаг. Бороохой модыг модонд үл тооцох. Болжмор шувууш шувуунд үл тооцох. Болзоогүй эмийг нөхөрт үл тооцох гэв. “Намайг авч ирээд гэртэх сайхан хатнаа залгиж орхилоо чи. Одоо нэг хатан олбол чи намайг бас идье гэж байгаа биз. Нүгэлт Гэсэр албал ч алах биз. Яая би ? Ерөөл минь мэдтүгэй!” гээд хэвтэв. “Арлан гуа! Энэ үг чинь зөв.” гээд. “Хээ! Хээ!” гэж инээгээд “Нааш хэвт” гэж тэюэрч авлаа .

“Май!” гэж хоёр алтан бэлзэг өгөв. “нэгийг нь гарахдаа хамрынхаа үзүүрт тавьж гар. Хот минь хаалгаа нээж өгнө. нэгийг нь бас орж шигчий хуруундаа зүүж ир. Хотын минь хаалга

нээж өгнө. Би ургаш явна гээд хойш явдаг буй” Дөрвөн зүгт явахаа тоолж эхлэв. Арлан гуа хэлэв: “За сайн эр минь _ тэр ч тэр болтугай. Гэсэрийн хувилгааныг би булт тоолж мэднэ. Гэсэр ирвэл нв яаж дийлэх вэ чи? Чиний хуилгааныг би мэдээгүй билээ. над хэлж өг. Зоог (ханамжтай) сонсьё би” гэв. “Тэр мууг ирвэл шичгий хуруугаар алахгүй юу би? миний гэрээс өмнө гурван өнгө их далай бий. Түүний наана таван давхар хулс бий. наад далайн захад хулсны цаана цагаан бух, хар бух хоёр мөргөлдөж байдаг. Цагаан бух Гэсэрийг сахиус өглөөгүүр дийлдэг . Үдэд миний сахиус хар дийлдэг. Түүний минь албал тэр намайг алах биз. Түүнээс өөр намайг яаж алах билээ. Хойно нэг их хот буй. тэр хот дотор гурван охин дүү минь бий. тэд есөн улаан модны үзүүр дээр сууж байна. Түүнийг минь албал тэр намайг чадна. Түүнээс өөр яаж чадах билээ! Тэр зүүнтээ гурван далай бий. Түүнд гурван марал наадаж явдаг. үдийн халуунд далайгаас гарч ирж гана тэрийж хэвтдэг. Тэр гурвуулыг нэг сумаар харваж оноод, дунд марлын гэдсийг хага татаж алтан хайрцагийг аваад хага днвсэж, түүний дотроос зэс тэвнэ авч хуга татвал намайг ална. Түүнээс өөр яаж ч адна тэр намайг. Баруунтаа нэг хот бий. Түүнд нэг хувилгаан эгч минь бий. Төрсөөр над үзүүлээгүй нэг бутан хорхой сүнс минь бий. тэр хорхойг минь албал намайг алж чадна. Тэр түүнээс өөрөөр яаж алах вэ! Хувилгаанаа дуусав” гээд хэтэв. Арлан гуа : “Огоо, Тэнэг байна чи. Урьд би чамд юу хэллээ. ? Хэний нь хувилгаан илүү болов? гэж чамаас асуусан шүү би. Бас бий юу ? Хэл” гэв. “намайг унтсаны хойнол баруун самсаанаас минь их алтан загас гарч баруун морон дээр минь наадаж явах. Зүүн самсаанаас минь бага алтан загас гарч зүүн мөрөн дээр минь наадаж явах. Тэр хоёрыг алавч яах вэ. Нэг сайн бөхйн чинээ тэмцэж үхнэ биз би” гэв. “За намайг алавч ах минь тарнич лам, эх минь рагшас, гагцхүү Гарсун минь бий. Тэр гурвуулыг минь яаж ална. Миний би? болж оролдоход (тэмцэх) биз, тэр гурвуул минь. Хэрвээ тэднийг минь албал үргүй үхэх минь энэ” гэв. Арлан гуа : “Үнэн сайн эр минь! Одоо сэтгэл минь ханав. Гэсэрийн хуилгаан ийм олонгүй билээ. Чамд учирсан ерөөл минь биз” гэв. “Хээ! хээ! үнэн, үнэн” гэж мангас баярлаж хэвтэв. Мангас үүрийн хяраанаар босож ургаш явья гээд хойш явав. Арлан гуа Гэсэрийг босгов. Хоёр алтан бэлзэгэ өгөв. мангасын аливаа явдлыг булт тоолж хэлэв. Гэсэр “За одоо гайгүй” гэж билгийн хээр морио (урианы сангаар) огторгуйгаас буулгаж авав. Гарахдаа нэг алтан бэлзгийг хамрынхаа үзүүрт тавиад ирэхэд хаалга нээж өгөв. Гурюан өнгө дамжиж таван өнгө хулсыг түүлж очив. Наадах далайн захад цагаан бух, хар бух хоёр мөргөлдөж байв. Цагаан бух мэшдэж хоёр хөлөө бохирч, нүдээ улаанаар эргүүлж, цагаан хөөс гаргаж байв. Хар бух баруунтаа н онголзрож байв. Гэсэр хар бухыг нумаа татаж харвав. Зүрхний эхийг тас харваад, билгийн гурван алд хар шор сэлмээрээ тас цавчив. Таван өнгө хулсыг түймрээд хойшоо харалгүй дутаав. Хаалганд хүрч ирэхэд алтан бэлзгийг чигчий хуруундаа зүүж үзүүлэв. Хаалга нээв. Хойш харгал гурван өнгө далай нь Гэсэрийг гүйцэж ирэв. Гурван өнгө далайгаас Гэсэр дутааж билгийн хээр мориороо хаалга руу давхив. Далай, хээр морины хондлой дээгүүр өрөвхийж алдав. Хаалга хаагдав. Далай орондоо харив. Гэсэр Арлан гуадаа хэлэв: “тэр мууг алаад ирэв би” гэв. үдийн цагт хоёулаа сайхан найрлаж суув. Үдэш мангас айсуй за гэж гуундаа орж хэвтэв. Үдэш манас ирэв. “Ёо халхай! толгой минь өвдөнө. гэсэр ирэв үү?” гэв. Арлан гуа өгүүлрүүн : “Ээ сайн эр минь! Толгой чинь яав? Юм олж эс идэвүү чи?” гэв. “Бага цөөхөн олж идэв. Толгой минь гэнэт дүнгэнэж өвдөж явна” мангас өглөөгүүр босон хойш явна гээд урагш явав. Гэсэр гаран хойш явав. Их хотод н хүртэл гуван охи н дүү нь ?сөн улаан модны үзрр дээр сууж байв. Гэсэр хувилж өнгө ячимэгт сайхан хүн болж хот дотор нь хүрч ирэв. Есөн улаан модны ёроолд хүрэн аливаа зүйлийн наадмаар наадан дуулав: “Энэ улаан модны дэргэд суугч гурван охид хэнийх болов? Дээр хурмаст тэнгэрийн гурван сайхан охин бий гэлээ. Гэсэр хааны олхид бий гэлээ. Мангасын гурван

сайхан охид бий гэлээ. тэр дөрвүүлийн нэгнийх нь охин биз. Энэ ийм сайхан охид миний дэргэд бууж ирээд манай наадмыг үзүүсэй. Хэрээ буюу ? Шаазгай буюу Энэ модонд юу гэж суудаг болов ? ” гэв. “Үнэхээр энэ хүний үг зөв. Бид шувуу буюу ? Энэ модны үзүүр дээр дэмий суух минь юу вэ ? ” гээд бууж ирэв. Наадахыг үзэж охид наадалцан гайхалцав. “Ай! Хүн чи хэнийхи билээ ? ” гэв. “Би баруунтаа мөнх газраас ирлээ би. Хар малгайт Гарма-ын өгсөн зуун найман хив мяндас зангиа над бий . Түүнийг зүүхүү та? ” гэв. “Эвүү! Их ламын өгснийг юу гэж үл зууна ” Аль өг! гэв. “Хүзүүндээ зүүх үү ? хөлдөө зүүх үү ? та? ” гэв. “Юу гэж хөлдөө зүүх вэ бид ? Хүзүүндээ зүүе бид? ” гэв. “Нааш ир! Би зүүж өгье ” гээд өврөөсөө гурван нумын хөвч аваад гурвуулыг боомилж алав. Есөн улаан модыг огтёоод хотыг нь түймэрдээд орхив. Мангас үдэш “Толгой минь өвдөнө” гэж ирэв. “Бас биеэ өвдөж байхад гөрөөлөх хэрэг юу вэ? Чамд идлэх юм дутав уу? нэг өдөр өнжиж биеэ сайн болгоосой чи” гэв. “Чи надад юу хэлж байна ? Өвдөвч гайгүй. гөрөөлнө” гээд унтав.

Маргааш зүүн тийш явъя гээд баруун тийш явав. Гэсэр гаран зүүн тийш явав. Уд модонд гэтэж хүртэл нь гурван марал наад далайн захад очиж хэвтэнэ. Гурвуулыг нэг сумаар харваад дунд марлын гэдсийг хага татав. Тэр дотроос нь алтан хайрцаг унав. Хага дэвсээд зэс тэвнэ авч хуга татаж орхиод ирэв. Мангас үдэш “Толгой минь их өвдөж байна” гэж ирэв. “маргааш өнжиж биеэ сайн болгоосой чи” гэв. “Чи минь над юу хэлнэ ? Маргааш чамайг хөтлөж явж үзүүлье би” гэв.

Маргааш үүрийн хяраанаар мангас босов. Толгойгоо боож “Яв!” гэж Арлан гуаг хөтөлж аваачив. их алтан гэртээ оруулав. Түүнд (ундуй сундуй) үхсэн хүнийг хурааж орхижээ. Бас нэг аливаа чимэгт олон сайхан гэртээ оруулав. Түүнд малын мах, загасны мах, гөрөөсний мах эд бүгдийг дүүргэж тавьжээ. нэг хувхай модон гэр байна. Түүндээ аваачиж оруулав. Алт мөнгө эдийн сан тэд бүгдээ хурааж тавьжээ. “Эднийг идье гэж болбол ганц өдөр идэж орхино. Нөөж идье гэнэ биш үү би” гэв.

“Өвдөвч гайгүй. гөрөөлөхөөр явъя би” гэж зүүн тийш явав. Гэсэр гаран баруун дахь хотыг нь тэмцэв. Гэсэрийн амнаас нэг хөгшин хуа марал дүүлэн давхина довтлон ирэв. Гэсэр нумаа татаж магнайн цагаанаар харвасанд сум нь түүний охор сүүлний угаар гарав. Тэр марал сумыг цухуйлган дутаав. Гэсэр гэрт гь хөөж хүрэл их хотондоо ороод Есөн давхар чулуун хаалгаа хаав. Гэсэр тэр хаалгыг болд сүхээрээ цоо цохилоод ортол цал буурал эмгэн доод соёогоо тэнгэрт тулгаж, дээд соёогоо алтан дэлхийд тулгаж хоёр хөхө алтан дэлхий дээр унжуулж орой руу нь харвасан сумыг охор сүүлний угаар төмрийг нь гялаалган нохойчлон оцоон сууна. “Ёо халхай, яалаа” гэж сууна. Гэсэр гуа сайхан хүн болж ороод : “Ай эмгэн! Яасн бэ чи? ” гэв. “Алтан дэлхийд дураар явж амьтныг барьж иддэг билэ би . өнөө нэг хүнийг барьж идье гэж очиж билээ, би Гэнэт ингэж харвуулж зоюлонд орж хэвтэнэ. Өднөөс нь барьж суглаж цөхөв би. Үүсгэрээс нь барьж сугалж цөхөв би. Хар цусыг булгилтал харвав . Хайрт амийг миньтасартал харвав. Ай! Сайхан гуа хүн хэнийх вэ чи ? Энэ сумыг минь суглаж өг ” гэв. “Эвүү! эмгэн минь чиний сумын сугалж үл чадах би. Дээр хурмаст тэнгэрийн ч сум биз. Дундад Асур нарын ч сум биз. Би суглаж чадахгүй гэв. “Авай! хоёулаа нөхөр болья” “”Эгч минь чи яачихав? Намайг дүүгээ үл таних чинь юу вэ ? гэв. “Авай чи хэн минь билээ ? ” гэв. “Дүү чинь мангас бишүү би?” гэв. “Авай минь! чиний өнгө хэзээ ийм сайхан болов ? ”

гэв. “Гэсэр хааны хатныг авснаас хойш ийм сайхан болов би” гэв. “За намайг юу гэж харвав чи?” гэв. “Эгч чи намайг төрсөөр сүнсий минь нэг бутан хорхойг үзүүлээгүй гэж чингэж уурлаж харвалаа би” гэв. “Авай чинийхээ амийг хүнд үзүүлбэл чамд муу болно гэж чингэж үл өгдөг билээ . Үүний учраас чи намайг алах гэв үү ” гээд “Ав” гэж өнрүүлж орхив. “Эгч минь! Нааш ир, сумыг чинь сугалъя” гэв. Сугалагч болоод сумаар сэндлэн алав. Сүнсийг нь битүү байшинд оруулж түймэрдэж орхив.

Мангас үдэш ирэв “Ёо халхай!!толгой гэж өнхрөч хэвисаар унтав. Баруун самсаанаа нь их алтан загас гарч баруун мөрөн дээр нь наадаж явна. Зүүн самсаанас нь бага алтан загс гарч зүүн мөрөн дээр нь наадаж явна. Арлан гуа, хоёр уутанд нүүрсийг оо болгож нухаад суух орондоо хоёулыг тавив. Гэсэрийг босгов. Гэсэр босоод их болд сүхээ билүүдэв. “хар хийгч юу вэ?” гээд мангас өмнөх ууттай нүүрсийг залгиж орхив. Арлан гуа өгүүлдүүн : Зүүдлэж байна уу чи? Намайг идье гэж байна уу ? “хар хийгч юу вэ?” гэв. Утас ээрч суутал утас минь тасарч тогоонд орж хар хйв.“ гэв. “За би үзье” гэв. Нэг ээрээд харжигнуулав. “Адил байна” гээд хэвтэв. Гэсэр хаан босон сумаа эрчийдэв. Мангас босон харайж нөгө ууттай нүүрсийг залгиж орхив. “Зул үгүйд байж зулны гэрэлд байж залги намайг” гэв. “Бар хийгч юу вэ ? ” гэв. “Чагтага татахад минь түр хийв.” Гэв. “За тат тат” гэв. Татав. “Адил сонсдов” гээд унтав. Гэсэр хоёр болд сүхээ барьж ирэв. Арлан гуа хоёр атга нүүрс атгуулав. “намайг цавчихад чи энэ нүүрийг тэр шарханд нь хийж орхи” гэв. Гэсэр хоёр мөрөн дэх алтан загасыг хоёр мөртэй нь тас цавчив. Цавчсан хойноо Арлан гуа өнөөх нүүрсээ шарханд нь хийж орхив. Мангас унаж босоод(Гэсэрийг мэдээд “Хорт Гэсэрт хуртсан минь ” гээд) Гэсэртэй авалав.

Мангасыг Гэсэр унагаагаад арван хоёр толгойгий нь огтолж хэрчиж байв. Арван нэгэн толгойгий нь огтлон дүцсэж _ нэг толгойгий нь огтлох гэтэл мангас үг хэлэв: “Арван хорын үндсийг таслагч айх мэт богд алахын алахын муугаар алав чи намайг. Чи бид хоёрт их өшөө үгүй билээ. Дүүгээ чамайг муу гэж эмийг чинь авч ирсэнгүй билээ би. Хатан чинь өөрөө ирсэн биш үү. Хатнаасаа асуу. Хоёулаа ханьяла. Хаана өшөөт дайсан бий болбол түүнийг хоёул алья. Өвөл миний газарт дулаан биш үү, энд сууя. Зун чиний газарт сэрүүн биш үү. Тэнд сууя ” гэв. Гэсэр “Зөв” гэж харж байв. тэр үгэнд нь Жамцо Дари Оддам нэрт эгч нь огторгуйгаас дуудав: “Ай нусгай минь! үүний үгийг юу гэж итгэв чи. Биеийг ширэм болсны хойно алж чадахгүй. Үтэр” гэв. Толгойг огтлоё гэтэл хутга нь хага татаж орхив. Ширмигй урсгаад толгойгий нь огтолж орхив.

Түүний хойно мангасын унадаг хар халзан морийг унаж мангса болж хувилан ар таринч ламд хүрч буув. Буун хүрч очоод мөргөж авшиг тавиулагч болоод гэдсий нь хага татаж орхив. Лам “Ом” гэхэ мартаад “Пад” гэв. Хар хадзан морь гадна унав. Ламын нусыг моринд цутгаж өгөөд эдгээв. Хүүд нь Гарсунд очив. Долоон давхар хотын гаднаас “Гарсун минь!” гэж дуудав. “Юу гэв ? гэж гарч ирэв. “Ахай чинь таалъя, гараа өг” гэв. Хот нэвт гараа нь бариад : “Авай! Хаалгаа тайл! “ гэв. Хаалаг тайлав. Хүүгийн гарыг таалагч болоод огтолж орхив. “Ахай! яалаа!” гэж бархирч хэвтэнэ. Гүйж орон хүүг зайдлав. “Эвүү яалаа! Алахын муугаар алав чи. Ахайн минь өгсөн түмэн цагаан адуу бий. тэр дотор дун цагаан морь бий. Түүнийг ав. Намайг тавь!” гэв. “За мэдлээ ” гэв. Гэсэр. “Түмэн хар адуу бий. Тэр дотор бэх мэт хар морт бий . Түүнийг ав, намайг тавь! Түмэн хөх адуу бий . Тэр дотор хөх оюу эрдэнэ мэт морь бий.

Түүнийг ав, намайг тавь! Түмэн улаан адуу бий. тэр дотор миржа (гал) мэт улаан морь бий. Түүнийг ав. Намайг тавь! Яалаа чи “ гэв. Эцгийн чинь толгой . муу тэнэг хорт этгээд чи . Чамайг алавч, эс алавч тэр адуу хэнийх болох вэ ? гэв. “Би чамайг эцгээ ал гэлээ . Чи намайг үрийг ал гээсэй” гэв. “Одоо энэ үг чинь зөв. Эцэг эхдээ яаж золгодог билээ чи? Түүнийгээ хэлж өг!” гэв. Хүүгээр цамийг тоочиж хэлүүлээд толгойгий нь огтолж орхив. Мангасын эхийн гэрт хүү нь болон хүрэв. “Гэсэр ирж гэнэ. Эжий! Зэс тэвнэ алтан тэвнийг зааж өг” гэв. Эмгэн зааж өгөв. Эмгэн адислья гэж төмөр хэдрэгээ барьж “Гүрү рагша, Гүра Рагша ” гэж ургаш очив. Хүү алтан тэвнэ, зэс тэвнийг аван дугаав. Эмгэн мэдээд хөөв. Хүү алтан тэвна, зэс тэвнийг хуга татаж орхив. Эмгэн үхэв.

Арван хоёр толгойтой мангасыг алав. Аливаа үр үндсийг тасалсны хойно Арлан гуа хатан зарлиг болов: “Арван хоёр толгойт мангасын аливаа үр үндсийг таслав. Одоо хоёулаа алтан сувраганы дэргэд амирлан сууя” гэж Арлан гуа Гэсэрт алтан аяганд баг нэрт хар өнгөт идээг хийж бартв. Гэсэр түүнийг зооглоод аливаа бүгдээ мартан суув.

ШАРАЙГОЛЫН ГУРВАН ХААНЫ ТӨРИЙГ АВСАН ТАВДУГААР БҮЛЭГ

Хон хэрээ элчийн мэдээ

Шарайголын улсад ах дүү гурван их хаан байжээ. Цагаан гэрт хаан, Шар гэрт хаан, Хар гэрт хаан хэмээх тийм гурван хаан байжээ .

Тэр цагт Шарай голын хаан чуулган чуулав. Чуулгандаа Цагаан гэрт хааны Цагаан эрх хатнаас төрсөн Алтангэрэлт тайжид ийм сайхан авгай хаанаас авч өгье гэж чуулган чуулуулав. “Энэ ахуйн хаадын охидыг тоолж үзье” гэв. “Хүн, морь явж хүрэхгүй ” гэж цагаан харцгыг туулайн махаар бордож, “Дээр тэнгэр нарын охид сайхан уу ? Үзэ ир! ” гэж илгээв. Уран дуут тотийг хорхойгоор бордож “Хятадын хааны охин сайхан уу?” Үзэж ир! гэж илгээв. Үзэсгэлэнт тогосыг жимсээр бордож “Балбын хааны охин сайхан уу ? Үзэж ир! ” гэж илгээв. Үнэгийг шир шөрмөсөөр бордож “Энэтхэгийн хааны охин сайхан уу ? Үзэж ир! гэж илгээв. Хон хэрээг муусайн идээгээр бордож “Төвдийн хааны охин үнэн сайхан уу ? Үзэж ир! ” гэж илгээв. Чингээд тэд бүгд явав.

Цагаан харцага тэнгэрт гарад эс ирэв. Уран дууд тоть хрч ирээд хэлэв: “Хятадын хааны охин Гүнэ гуа гэж байжээ. Гэсэр, эцгийн нь төрийг засаад Гүнэ гуаг авч гурван жил суугаад харьсан байна. Гүнэ гуагийн өнгө чимэг нь хэвээр сайхан ажээ ” гэв. Тогос ирээд хэлэв : “Балбын хааны охины өнгө чимэг нь хэвэр сайхан ажээ. Ертөнцийн хэл үл мэдэх туд энд манд найргүй болов уу? гэж санана би ” гэю. Үнэг ирээд хэлэв: “Энэтхэгийн хааны охин өнгө чимэг нь ер сайхан ажээ. Газар элэгэж хэвтээд буурцгийн хар цагааныг тоолж хэвтэнэ. Гэм нь тэр байна” гэв.

Хон хэрээ гурван жил болтол эс ирэв. Хойд жил нь ирэв. Ирэхдээ Хар гэрт хааны гадаа дайрч хашгирав. Шар гэрт хааны дайрч исгэрэв. Цагаан гэрт хааны гадна ирж огторгуйгаар цэрвэж байж үгээ хэлэв: “ Хол газар очсон элч хэрээ би ирэв. Миний үгийг авалтай биш үү! “ гэв. Цагаан гэрт хаан : “Үнэн биш үү” гэж хоёр дүүдээ элч илгээн хамаг цэргээ хурааж ирэв. “ Ай хөөрхий . Энэ хэрээ жигүүрийнхээ үзүүрийг хугалсан булгалсан байна” гэж нэг хонь алж өгөв. “ай хөөрхий хэрээ! Энэ дээр сууж үгээ сайхан хэл ” гэв. “үгүй үгүй. Энэ өчүүхэн махан дээр чинь үл буух би ” гэв. “хөөрхи й энэ хэрэний үнэн зөв” гэж нэг гүү алж “Энэ дээр буу” гэв. “Энэ ачүүхэн маханд чинь бахдах биш би. Үл (суухгүй) .Таны тусад явсаар хөх огторгуйд дураар нисэгч хайран жигүүрийнхээ үзүүрийг хугалав би. Юм олж идэх хошуугаа булаглав би. Алтан дэлхий дээр дуруураа цөмчигч хөлийнхөө хумсыг барав би” гэв. “Энэ хөөрхий, зовлонгоо гашуудан хэлэгч үнэн зөв” гэж Шамба Мэруз найман настай хүүхдийг алж “Энэ дээр бууж хэл ” гэв. Хэрээ эсболж огторгуйд цэрвэж байж хэлэв. “Дээр хурмаст тэнгэрт хүрэв би. Хурмаст тэнгэрийн гурван сайхан охин байна. нэгийг нь гуйвал өгч болох, нэгийг нь булаавал авч болох, нэгийг нь хулгай хйвэл авч болох ажээ. Хурмаст тэнгэр догшин тул хаан авч үл ч адмой чи! ” Үүнд бууж үгээ хэл ” гэж алтан лог (шон) тавьж өгөв. Бас үл буун байж хэлэв: “Доор лусын хаадын гурван сайхан охин байна. Дунд Асурын гурван гуван сайхан охин байна. Лусын хаанд хүч ихтэй ,Асур нар догшин, иймийн тулд тэр хаадын охидыг хаан авч үл чадмой. Алиныг ч болов олж авбал мөн хурмастын охинтой адил болно. Алиныг тоолном би ?” гэв. Тэгж хэлсэнд мөнгөн дог, иөмөр дог хоёрыг тавьж өгөв. “Энэ дээр бууж үгээ хэл” гэв. Эс буув. Хэрээ бас хэлэв : “За төвдийн газарт арван зүгийн эзэн богд Гэсэр мэргэн хаанд хүрэв. Би. Хавны эцүг нь Жало хаан гэнэ. Гэсэр хааны хатан Рогма гуа гэж б айна. Рогма гуагийн босоо би? нь ургамал нарс модыг ханхуй нэрт магнаг торгоор бүрсэн мэт, Суугаа бие

нь таван зуун хүн суух орд цагаан гэр мэт. Баруун мөрөн дээр нь алтан шумуул эргэж байна. Зүүн мөрөн дээр нь мөнгөн шумуул эргэж байна . Баруунтаа наранд суувал хайлах мэт. Зүүнтээ сарны сүүдэрт суувал царцах мэт. Шөнийн гэрэлд нь зуун мянган агт манах мэт. Ийм цаглашгүй сайхан байна. Барьж суух гэр нь таван зуун хүн суух орд цагаан гэр байна. Бүрээс нь ханхуй нэрт магнаг торгоор хийсэн байна. Тулсан нь алтан багана байна. гэрт нь цаган суврага бий. Чандмань эрдэнэ бий. Унших ном нь алтаар бичсэн Ганжур, Данжур хоёр хөлгөн ном бий Цавгүй нүүрс бий. Гэсэр хаан эзгүй. Арван хоёр толгойт мангас Арлан гуа хатнаа авахаар нэхэж явсаар ирээгүй гэнэ. Дээр тэнгэр нар, дунд Асур нар, доор Лусын хаан, эд гурвуулын охид байх боловч Рогма гуатай тэнцэх нь үгүй байна ” гэв. Хаан эзэн эхлэн хамаг их цэрэг булт баярлав. “Ай! Хэрээ Энэ дээр буу! “ гэж модон дог тавьж өгөв. Эс буув. Цагаан гэрт хаан уурлаж :“За чи муу тэнгэрэс заяатай шувуу юу ? Чи муу манай тэжээж илгээсэн хэрээ биш үү чи ” гээд нум сумаа аваад дэлэв. Хэрээ айж үнсэн дээр унаж баригдав. “За! Рогма гуа гэж юу хэлнэ чи! Түүнээ дахиж хэл ” гэв. Мөн нэг тоолж хэлэв. “Эвүү! Энэ хэрэний үг болбол Рогма гуа юутай сайхан билээ! худал бол юутай сайхан уран үгтэй хэрэ билээ энэ! ” гэв. “Ай, хэрээ! очиж өегөө (цувдайгаа?) ид” гэв.

Шарай голын хаад Ганга шувууг илгээв.

Одоо үүнд хүн морь илгээвч удаан явах, хэзээ хүрч ирнэм тэд ? гурван хааны сахиус тэнгэр Ганга шувуунд хувилж очиж үзэх болов. Цагаан гэрт хааны сахиус Өргөн цагаан тэнгэр хувилж толгой өвчүүний цагаан болов. Шар гэрт хааны сахиус Шар өргөн тэнгэр бэлхүүсэнд хувилж шар болов. хар гэрт хааны сахиус хар өргөн тэнгэр сүүлэнд нь хувилж хар болов. Гурван хааны сахиус тэнгэрийн Ганга шувуунд хувилж явав. Гэсэр хааны таван зуун хүн барьж суух орд цагаан гэрийн тоонон дээр нь үүрийн хяраанаар ирж суув. (Элгээр тооныг даран, өвчүүгээр урд дээврийг бүтээв. Баруун зүүн жигүүрээр хоёр этгээдийн дээврийг бүтээв.) Үл хөдлөх цагаан гэр шир хийж хөдлөв. Тасрашгүй хив оосры нь хоёр нь үсрэв. үл гулзах алтан багана нь гулзайв. Рогма гуа цочин босож харайв. Хувцаслаад гэсэр хааны гучин баатраас хоорондоо янаглаж авчирч буулгасан Барс баатартаа хүрч Улан дуудав : “Эвүү! Барс баатар минь! (Лам хүн их унтвал аян аваасаа хоцроно гэлээ. Эм хүн их унтвал уйл нь хоцроно гэлээ Мод их хэвтвэл шоргоолж үүрлэнэ гэлээ Арван зүгийн эзэн авай богдыг минь арван хоёр толгойт мангас алав уу? Мангасын хувилгаан шувуу нь Рогма гуаг хатан намайг авья гэж ирэв үү? Цас Чихэр тэргүүнтэй гучин баатрыг алья гэж ирэв үү? Шувуу үувуунаас өөр шувуу ирж суув. Би айв ” Эд бүгдээ тоолж хэлэв. “Ай, Барс минь догшин хар нумаа хөвчилж, алтан цагаан сумаа онилж гарч ир!” Барс баатар догшин хар нумаа хөвчилж алтан цагаан сумаа онилж гарч ирэв Шувууг үзээд зүрх алаж догшин хар нумынхаа бариулыг алдаад, цагаан сумныхаа ониг мулталж гэлдэрхийлж харан байв. Рогма гуа уйлан хэлэв: “Эвүү! эвүү! чамайс барс баатар црол дуудсан хүний биеийг алаад, толгой дээрээ одоо ус цуглуулаасай. Эр хүн болод шувуунаас зүрх алддаг уу? Эхнэр гэмээж харвая би. Нум сумаа над өг, би харвая гэв. Барс баатар : “Эвүү! Эм хүнд нум сумаа өгч харвуулав гэвэл арван зүгийн эзэн Гэсэр хаан минв юу гэнэ ? Амраг Цас Чихэр ах нь, гучин баатар эд бүгд намайг “ эм Барс баатар” гэж дуудаж хууль болгох байна. ” гэж хар нумынхаа бариулыг чанд атгаж, сумаа онилж дэлж байна. Рогма гуа : “ Авай минь товчлуурыг алдаж нэг далных нь өдийг тас харвав. Шувуу босон Рогма гурван үе харан эргэв. Рогма гуа ч болов дээш гурюан үе харав. Шувуу явав. Барс баатрын харвасан өдийг Барс баатар, Рогма гуа хоёр цуглуулж авав. Өд нь гучин илжигний ачаа болов. Ганга шувуу газартаа хүрэв. Цагаан гэрт хаанд хэлэв : “Барма (хөөрхий) хэрээний хэлсэн нь булт үнэн байна. Алиныг тоочих вэ ? Гэсэрийн гучин баатар, Цас Чихэр ах нь гэгч байна. Гэсэр ирээгүй гь үнэн байна ” гэв.

Цагаан гэрт хаан хоёр дүүдээ эоч илгээв. үүнд : “Арван гурван настай хүүхдээс дээш лам банди ч болов бүү суулгая. Хэн хүн суувал алах ялтай ” гэж их зар тавив. Дунд дүү нь Шар гэрт хаан ирэв : “ай ах минь! Арван зүгийн эзэн Гэсэр хаан төрөхдөө хүний арьсаар хучиж төрөв гэлээ. Арван зүгт хувилдаг гэлээ. Гучин баатар нь боловч хэцүү догшин дайсан гэлээ. Түүнд мордохыг байлтай ” гэв. “Чи муу нүдээ тэсрэв гэж суу Нүгэлт өвчинд дайрагдав гэж хэвт Их цэргийг чинь би аваачина. ” гэж харааж илгээв. Отгон дүү Шамба Мэруз ирэв : “ай хайрт хаан ах минь! Гэсэр дээр Хурмаст тэнгэрийн хөвгүүн бишүү. Тэнгэрийн аймагт явахдаа дйилсэн амьтан нь олон Доор дэлхийд ирэвч ялгаагүй. Аливаа амьтны сүрийг атган төрсөн байна. Амраг Цас Чихэр ах нь, гучин баатар нь цөм хувилгаанд байна. Аван зүгийн эзэн Гэсэр хааны өвөр дэх эм Рогма гуаг авч чадах болтугай, гучин баатрын нэгнийг нь чэмийг авч чадах уу бид? ” гэв. “Энэ олон цэргээ явуулж энэ хавийн хаадын охидыг тоолж үзүүлье” гэв. “Нэг ч сайхан охин үгүй гэж үү?” гэв. “хэрвээ үгүй болбол сайд, тшмэд, тавнангуудын охидыг сонгоё бид. Нэг сайхан охин байвал авч Рогма гуагийн заслаар засаад

нэрийг нь рогма гуа гэж өагье. тҮүнийг хэн Рогма гуа биш гэх вэ! ” гэв. Ах нь харав : “Чихээ дүлийрэв гэж суу! чивэль өвчинд дайрагдав гэж хэвт! гэв. Энэ мэт олон зүйлээр хараав. “Намайг айж байна гэж санаж байна” гээд харив.

Маргааш нь Цагаан гэрт хаан цэргээ хурааж морьоё гэж байна. Шамба Мэруз алтан хундаганд хорз хийж ирж барив : “Анхан энэ цэргийн дотор аймтгай нь би биш шүү. Баатар нь харин би байна ” гэв. “Хаан тэнгэрийн хайрт хаадын хөвгүүн гэж тусгаар жаргана билээ бил. Хар биеэ муугаар хадрагч Гэсэр хаанд өгье гэж одох болод байна бид. Эрхт тэнгэрийн эрдэмт эздийн үр гэж суудаг билэ бид. Энэ биеэр муугаар энэ Замбутивийн эзэн Гэсэр хаанд эндье гэж одох болод байна бид. Явавч яъя . Энэ хүүхэд, лам нар, банди нар, өвгөд, хятадаа, аваачья гэдэг чинь юу вэ (дэмий) гэсэр хааны Цас Чихэр гучин баатар нь ”Шарайгол лам нар банди нараа, өвгөд хүүхэд, эм хяиадаа авч ирж” гэж дайрч ороод маньг Найранзана мөрний эхэнд суусан алаг нугасанд начин шувуу орсон мэт унагаах болно шүү. Олон үхэв гэх нэрээс цөөхөн үхэв гэх нэр дээр биз гэв. “Урьд үг чинь буруу билээ. Хойд үг чинь зөв байна” гэж хаан айлдаад олныг аваачихаа байгаад зөвхөн цэргээ шигшин тоочив. Тоочсон цэрэг нь гучин гурван буман цэрэг болов. Шарайголын гурван хаан цэргээ аван явав.

Цас Чихэр байлдахаар шийдвэрлэв.

Эрдэнэт Цас Чихэр нутаг нь хол байв. Чацарагны гол өөд Гурван Тулгатад байсан ажээ. Барс баатрын харвасан өдийг Рогма гуа тэр шөнө дүлээд (яваад) үүрийн хяраанаар хүрэв. Цас Чихэр эрт босож Чацарганы голд адуугаа усалж байв. “Эвүү эвүү! Үдийн цагт заларч ирдэггүй Рогма гуа минь үүрийн хяраанаар юунд ирэв ? Ронса жигүүрт бор морийг минь барь ” гэв. Жигүүрт бор морийг нь бариад хазарлаж эмээлийг тохож өгөв. Хүрмэ нэрт цул бод илдээ зүүж угтан хатирч очоод “Эвүү, Рогма гуа минь ” гэж хол газраас дуудаж асуув. “Гарт бартсан чинь мод уу, өд үү?” гэв. “Авай минь юуны мод байхав! Өд байна” гэв. “Би мэдэв” гэв. “Ирээгүй гурван үйлийг угтаж мэддэг би . Өнгөрсөн гурюан хаан, арван зүгийн эзэн Авай Богдбн минь үгүйг мэдэж Рогма гуа чамайг минь авч Цагаан гэрт хааны Цагаан эрхт хатнаас төрсөн Алтангэрэлт тайжид авч өгье гэж цэрэг айсуй байна. Гурван хааны сахиус тэнгэр Ганга шувуунд хувилж ирээд үзэж явсан байна чамайг минь ” гээд шувууны толгой нь цагаан, бэлхүүс эь шар, сүүлийн хар эд бүгдийг учрыг булт тоолж хэлэв. Цас Чихэр : “Тэр гурван хааны сахиус тэнгэр, ганга шувуунд хувилж ирсэн нь энэ. Тэр өдөр муу хэрээ явна билээ. Өөр юманд саатаж түүнийг алсангүй би. Энэ явдал тэр муу хэрээнийх байж болно” гэв. “За, арван зүгийн эзэн Гэсэр хаан минь эзгүй боловч амраг Цас нь, гучин баатар, гурван отог улс нь бид үгүй юу ? Ирэвч яавч, гайгүй иртүгэй! Рогма минь бүү ай! миний үг нийлднэ болов уу ? Үгүй болв уу? Цотонд аваачиж үзүүл, энэ өдийг! гэв.

Барс баатар, рогма гуа хоёул өдийг Цотонд аваачиж үзүүлэв. Цотон ноён үзээд “Эвүү, эвүү! Цасын минь үг үнэн байна . шарайголын гурван хаан бидэнд өшөөгүй билээ. Рогма гуаг булааж авья гэж ирж байна. Рогма гуа Хатны нолын Агуу аралд очиж нуугд. Улаан зүлгэнд нуугд. Урхтайн шар талд нуугд. Унгийн хар хавцгайд нуугд. Адуу байлгах газар тэмэ байлга. Тамаа байлгах газарт адуу байлга. Хонь байлгах газарт үхэр байлга . үхэр байлгах газарт хонь байлга. Рогма чиний унхах газар хятад эмийг чиний заслаар засаж унтуул. Чамайг эс олбол биднээс юу авна ? ” гэв. Рогма гуа, Барс баатар хоёул Цотонгийн үгийг Цасад очиж айлтгав.

Цас “Эвүү, эвүү! Тэр муугийн үгийг сонс та. Шарайголын гурван хаанаас айж Цас Чихэр ах, гучин баатар бүгдээр гэртээ суж, рогма хатныг тээрмийн чулууны дор булав гэвэл энэ муу нэрийг хаана багтаах вэ ? Амвд явснаас үхсэн маань дээр. Зуун анслах биеэ хайрлах мянган галавт үлдэх нэрээ гутаах болбол мал ажээ. Шарайголын гурван хаан бидэнд өшгүй гэж байна. Одоо юунд ирэв ? гэж эс хэлэв үү та? ” гэв. Барс баатар : “Ер санаанд эс роов. Шувуунаас зүрх алдсанаар санаа эс олж байна би” гэв. Цас хэлэв: “Дайсан үгүй цахгт Барс баатар би гэж биеэ сайрхах. Дайсан хүрч ирэхэд хэт дамий донгосох чинв юу вэ . Цэцэн үгүй цагт цэцүэн би гэх Цэцэн хүрч ирэхэд нууж суудаг уу чи ? Барс ирвэл барилдъя. өтөг (баавгай) ирвэл өрлөлцөе. Заан ирвэл заадалцъя. Арслан ирвэл алалцъя. Хүн ирвэл хүчдэлцье. Хатгагч хар могой болон ирвэл ханигарди болон дэгүүр нь доvloё. Хүрхрэх барс болон ирвэл хөх зэс зовгорт арслан больё. За За юу билээ ? Яв . Гучин баатар, гурван отог улс, төвд Тангадын цэргийг ир гэ. Морьтой морьгүй дэд дэдээр ир гэ. Их болзоо Чацарганы гол руу Гэсэр хааны минь гэр дээр Улаан зүлгэний тэнд ир! ” гэж элч илгээв.

Цас Чихэр зэр зэвээ аваад өөрийн биеийн цэргээ аван Рогма гуа Барс баатартай хамт явав. Гэсэрийн гэрт хүрээд нанчүг авч ирэв. Гучин баатар тэргүүлэн Төвд Тангадийн цэргийг морьтой, морьгүй дэд дэдээр авч ирэв. Их цэрэг цуглав.

Цас Чихэр, Шуумар, Нанчүн нар хайгуулд явав.

Цас чихэр асууруун : “Цэрэг цуглав уу” гэж дуудаж асуув. “Цугласан” гэж Шуумар хэлэв. Рогма гуа зарлиг болов: “Хэн түрүүлэн байлдах тухай шавга орхиё ” нэв. Цас чихэр хэлэв: “Шавгаа байзна Рогма минь. Шарайголын гурван хааны цэргийн олон цөөнийг тэнсэж ирье би. Надтай хүний бүргэд болсон Шуумар минь яв. Арван таван настай эрдэнэт Нанчун минь яв”гээд Цас жигүүрт бор морио унав. Цавдат хуягаа өмсөв. Гучин цагаан сум, догшин хар нумаа дүрэв. Харил үгүй ирт хатан илдээ зүүв:

ЦасЧихэр “Явья” гэж гурвуулаа явав. Элст уулын оргил дээр гараад харуул харж сууна. Гөрөөс энгүй олон гүйлдэж ирэв. Алтан дэлхий дээр явагч гөрөөс шархтай гүйж явна. Түүнийг үзэж Цас Чихэр зарлиг боловж: “Их тоос хөдлөв. Энгүй гөрөөс айсуй. Шарай голын гурван хааны цэрэг хүрч айсуй юу ? гэж харав. Хоногийн газраас харж үзэв. Үзээд: “Гурван хааны цэрэг Хатны голыг өөдөлж айсуй. Өмнөх гурван зуун хайгуулчин үдийн газр ява” гэв. Шуумар, Нанчүн хоёул угтаж очоод харж үзэв. Шуумар хэлэв: “Эвүү, эвүү! Цасын минь хэлэгч үнэн быайна. Юутай олон билээ. Алины нь алж баръя. Цас минь! Юутай өнгөтэй цэрэг билээ ? Огторгуйн олон одод бүгд алан дэлхий дээр буусан мэт. Алтан дэлхийн навч цэцэг огторгуйд ургасан мэт” гэв. Эрдэнэт Нанчүн шүүмжлэн хэлэв. “ай, Шуумар! Энэ үг чинь юу вэ ? Шарайголын цэргийн олныг яагаад мэдэв чи? Алтан дэлхийн навч цэцэг огторгуйд гарч ургасаныг хэзээ үзлэ чи ? Ийм оргүй худал хэлдэг үүү, Шуумар чи, Эр хүнд яан ав явахда зэр зэвсгээ засвал муу болдог уу? Эхнэр хүн хуриманд очихдоо засвал нь муу болдог уу? ” гэв. Шуумар хэлэв: “ Нанчүгийн үг зөв. Архайн дэмий үг хэлэв би. Цагаан гэрт хааны цэрэг сүү буцлах мэт айсуй. Цас минь шанагаар самарч дунд оруулагч бол. Шар гэрт хааны цэрэг түймэр шатсан мэт айсуй. Унтраагч Шуумар би болсуу. Хар гэрт хааны цэрэг нь үерийн ус урссан мэт айсуй. Нанчүн минь суваг татаж үгүй болгогч бол. Бяр юу билээ ? Гурвуул гурван хааныг довгольё” гэв.

Шуумарын үгэнд Цас зарлиг болов : “Та хоёулын минь үг зөв. Гурван зжжн хайгуулчдын урьдаар алья. Түүний цаана нэг хааны агтыг булааж авья. Хан олзолж үг авсан хойно, харих хоёрыг шийдвэрлэе бид. Шуумар нанчүн хоёул энтээгүүр очоод тэртээх сүвээг аваад бай. Би хойноос нь хашгиран ороод таныг дайруулъя. Эндээс дутаасныг та ал. Танаас дутаасныг ыби алья” гэв. Гурвуул мэн тэр үгээрээ болболцов. Нэг ч хүнийг амьд эс гарав. Гурван зуун агты нь хонхорт уяв. Дэргэдэх овоон дээр нь чулуугаар морьтой хүмүүсийг босгож хуяг дуулгыг өмсгөөжу амьд хүн мэт босгож орхив. Шарайголын цэргүүд нь гуран зуун хайгуулчин тэр уулын оргил дээр харж суна хэмээн хэлэлцэн суув.

Цас, Шуумар, Нанчүн гурвуул бас довтлоод Цагаан гэрт хааны түмээд мянгаад агтыг булааж аван гарч ирэв. Гурван хааны отгон дүү нь Шамба Мэруз, Цагаан гэрт хааны билгийн цагаан морийг унаж дөрвөн хөлд нь дөрвөн төмөр дөш уяж, дээрээс нь нэг тэмэр дөшөөж цохилж гүйцэж ирэв. Тийм хүндийг эс уявал уураа даран ядаж эзэн огторгуйд авч гарах морь байсан ажээ. ЦасЧихэр нөгөө хоёртоо нэгэн үгийг хэлэв: “Манай хойноос энэ нэг хүн гүйцэж айсуй байна. Хэлэлцэх болбол хэлэлцэе би. хэрэлдэх болбол хэрэлдэе би. Та хоёр минь адуугаа тууж яв” гээд нөгөө хүнийг угтав. Шамба Мэруз гүйцэж ирээд өгүүлрүүн : “Эвүү! Яасан олон агт хөөв та? Аль ах дүү билээ ? Хэнийх билээ? Нэрээ хэл” гэв. “Бид Төвдийн Гэсэр хааны үхэр хонь хариулагч билээ. Манай мянга таван зуун үхэр алдагдаж билээ. Тэр үхрийн

мөрийг мөшгөж явсаар гурван зуун хайгуулчинд хүрч очив. Хайгуулчин тань мөрийг гаргаж өгөв. Тэр мөрөөр мөшгөж явтал хоёр хааныд чинь хүрч очив. “Үхэр гаргаж өгб гэтэл “Гуйланч төвд! Яасан үхэр вэ ? ” гэж харин билдний морины толгойг цохив. Хэн эр төрж билээ ? Хэн эм төрж билээ ? гэмээж нь агтыг чинь авсан энэ билээ” гэв. Шамба Мэруз өгүүлрүүн: “Та юунд очоод үхрээ алдсан билээ?” гэв. Цасчихэр өгззлрүүн : “Арван зүгийн эзэн гэсэр хаа минь арван хоёр толгойт мангасыг алж хатнаа авч ирэв. Ирээд нуур длай мэт их хурим хийж үхэрчин хоньчингүй, аргалчин түлээчингүй бултад хишгээ өгсөн учир бид согтож унтаад үхрээ алдсан билээ”.

Шамба Мэруз харьж Цагаан гэрт хаанд Цасын тэр үгийг булт тоолж хэлэв. Цагаан гэрт хаан: “Эвүү, эвүү! Агтыг минь аваачвал аваачтугай. Нүгэлт Гэсэр ирсэн болбол харья би” гэж уйлав. Шамба Мэруз хэлнэ: “Нүд чинь тэсрэв гэж, нүгэлт өвчинд дайрагдав гэж харь. Их цэргийг чинь эргүүлж авч ирэв үү би? Ай татай! Муу амьтан дуу үгүй суузана. Унах найман шарга агтыг дуудан урьж мэдье би” гээд явав. Шамба Мэруз нумны хачирт малгайгаа өлгөж Гуа довны дээрээс нумаар хуруйлж хол газраас дуулан урив:

“Хаан мөнх тэнгэрээс заяагаар төрсөн

Хазаарлан унасан

Хар гэрт хаан чинь

Хайрт Шамба Мэруз чинь энэ бишүү!

Хар уулыг хөтлөөр давахад

Хандгай буга болон шургах чинь аль?

Найман шарга морь минь

Эрхэт тэнгэрээс заяатай төрсөн

Эмээллэн унасан эрдэнэт Шамба мэруз чинь би энэ бишүү!

Өндөр уулын өлөөр давахад

Өл буга болон дутаах чинь аль”

гэж дуудахад найман шарга агт Шамба Мэрузын дууг сонсоод янцгаав. Олон агт үүрсэв. Цас Чихэр зрлиг болов : “Шуумар, Нанчүн хоёр минь мэдэв үү та ? Энэ найман шарга агт хүний хэл мэдэх байна. Тэр хүний дуу гарахад эд тэрэгүүлэн олон агт бүгд үүрсэв. Үүгийг чинь ямар зүйлээр хувилбал тэр зүйлээр хувилая. Хичээж яв” гээд олон агтыг цуглуулан гилэв. Хуа уулын хөтлөөр явтал явтал найман шарга морь найман хуа зээр болон шургав. Цас Чихэр : “За, яв яв ” гээд харвалав. Гурвуул хоорондоо шургуулж явж гурван сумаар наймуулыг харваж орхив. Олон агт бүгд хөөрч дутаав. Хариулан ядаж хашгиран Хатны голын ганга эрэг руу унагааж алав. Хариулан гомдосон чоно мэт өнөдр дээрээс гарч ирж байв.

Шамба мэруз харьж Цагаан гэрт хаанд хэлэв: “ Нүгэлт үхэрчин биш байна. Цуут Гэсэрийн гучин баатар нь биз. Довтолсон мөрт нь чулуу хэмхэрч, мод хугарч, бидний агтыг булт алж орхив” гэв. Цагаан гэрт хаан : “үнэхээр тийм болбол авай мин харъя” гэж асуув.

Шамба мэруз : “Есөн сүв чинь бөглөрөв үү? Цэргийн чинь би авч ирэв үү? Харив гэх нэрээс халдаж үхэв гэх нэр дээр бишүү! ” гэв.

Цас Чихэр довтлох шийдвэр гаргав.

Цас Чихэр зарлиг болов: “Та хоёр минь юу снана ? Үүнээс хойш бусад баатрууд иртүгэй. Одоо бид харъяб гэв. Арван зүгийн эзэн Гэсэр мэргэн хаан авгайнхаа гуячин баатар цолыг хэзээ эвэх вэ бид? Эрдэнэт энэ бие харвж өвчнөөр үхээд, эм хүүхдээ цухируулж юу хийнэ? Энэ мэт цуст улаан цайнаас уулцаж хагацвал цурхируулж юу хийнэ? Энэ мэт цуст улаан цайнаас уулцаж хагацвал дээр” гэв. Шуумар өгүүллрүүн : “Нанчүнгийн минь үг зөв байна. Цас минь! Цагаан гэрт хааныг довтлов. Шар гэрт хааныг шуумар би довтолж. Хар гэрт хааныг Нанчүн минь доютол. Бяр юу билээ ? Гурвуулаа энэ гурван хаанд довтолоод харъя ” гэв.

Цас Чихэр өгүүллрүүн : “Та хоёрын минь үг зөв” гээд бас хэлэв: “Шуумар сан тавь. Нанчүн цавд (усан тахил өргө)” гэв. Цас Чихэр, Шуумар, нанчүн гурвуулаа мөргөж Гэсэр .хааныха сахиусанд залбирав. “Дээр хурмаст эцэг айлд. дэргэдэх Эсругайн аймагт хүчин төгссөн арван долоон тэнгэр нар айлдан соёрх. Дэд дэдээрээ гучин баатар буулгаж өгсөн гучин гурван тэнгэр нар төрөл төрснийг өршөөн сочрх . Дээд арван зүгийн бурхан, Арьяа Аланкари охин цагаан тэнгэр, навса, Хүрээ эмэг эх нь ялгуусан гурван эгч нь алтан дэлхийн хувилгаан Уулсын хаан Овоо Гүнжид цээг минь, дээд дөрвөн их тэнгэр нар минь, дугд сав ертөнц минь доод цагаан лусын хаанд мин, та бүгддээ дэд дэдээрээ ариун тахил тахина би. Цас Чихэр чинь ” гэв. “тахих миний шалтгаан юу вэ гэвэл” Энэ Замбутивийн эзэн Гэсэр хаан гээд, хүний өвөрдэх Эмийг авья гэхгүй . Харин Гэсэрийн минь хатан Рогма гуаг авья гэж Шарайголын гурван хааны цэрэг ирж байна. Ингээмж нь бид гуруул довтолж гэнэ. үүнийг минь зөвшөөн соёрхох болбол хамаг олон сахиус манай нөхөө бол. дэд дэдээр түмээд мянгаад цэргийн бараа болон нөхц, дөрвөн зүгээс дөрвөн их тэнгэр нар билдэнд бахан бороо оруулж будэн хдэн татжжлу байгаарай! гэж мөргөв.

Цас “Би Цагаан гэрт хааныг довтолсоор довтолж. Би түмэн хүнийг алж толгойг авья . Шуумар минь чи Шар гэрт хааныг довтолсоор довтол . Түсмэн хүнийг алж эрхий хуууг ав. Нанчүн минь Хар гэрт хааны довтолсоор довтол Түмэн хүнийг алж баруун чихийг нь ав. Бидний бэлэг энэ болтугайб гэв. Гурван бор морио залбирав. “хуруу гүйхдээ өнгөрсөн чулуу мэт гүй. Хажуугаар гүйхдээ хүдэр мэт гүй. голоор гүйхдээ үнэг мэт гүй” гэв. Гурван морь гурван үе шилогээж байв. Хошоод давхар худрага, хошоод давхар хөмөлдөрөг, хошоод давхар олом хийж морон явав. Шуумар өгүүллрүүн : “Уулзах болзо маань хана вэ ? гэв. Нанчүн өгүүллрүүн : “Шуумар минь дуугүй яв. Бидний зарим нь эм хүүхдээ авч ирэв үү? Зарим нь дан биеэр ирэв үү ? Мөн даруй дээр золголдох буйза гээд явав. Юуг тоочих вэ ? Яг хэлсэн үгээрээ болов. Гурвуулын олон сахиус нь дэд дэдээр түмээд мянгаад цэргийн төвөөр гаралцан явав. Даруй дээр золголцох эгж ирэв. Замдаа хайгуулчны гурван зуун агтыг аван ирэв.

Шарайголын гурван хаан адилтгавал тэнгэр ниргэсэн мэт, барс довтолсон мэт ийм болов. гурван хаан өгүүллрүүн босон нэг нэгэнтэйгээ уулзах гэсэн боловч үхсэн цэргээ үзэж энхрэн ядаж гурвуулаа цуглаж эс чадав. Үхсэн хүнээ цуглуулж үдийн цагт цуглав гурвуул. Цагаан гэрт хаан уйлан хэлэв: “Намайг довтологч их цэрэг гэвэл их цэрэг биш, дээрмийн хүн гэвэл дээрмийн хүн биш ганц хүн шиг байв. Довтлох дүр нь түмээд мянгаад цэргийн дүрээр байх нь юу вэ ? Яасан жиг билээ?” гэв. Шамба мэруз өгүүллрүүн : “За би чмд эс хэлэвүү? Үл мэдэх их тэнэг гэгч чи биш үү? Хувилгаад гэгч ямар вэ ? Юуны тулд хувилгаан гэгдсэн бэ? Үүнийг хэлнэ. Үүнээс хойно гучин баатар нь ирвэл манай олон цэргийн, бинийг, ой модыг ооль

сүхээр огтсих мэт болгохыг чи үзнэ” гэв. “өнөө нэхэвч үл гүйцэх, алж үл чадах бид, тэр гурвуулыг нэхэхээр үхсэн хүнийхээ ясыг баривал (оршуулбал) хэрэг нь тэр биз” гээд харив. Харьж очоод үхсэн хүний ясыг оршуулав.

Шуумар, Цас Нанчүн хоёртоо хэлэв: “Энэ олон толгой чих, хуруугаар юу хийх вэ бид. Орхиё. Хэн хэдэн хүн алсаныш мэдэлцэв. би” гэв. Цас Чихэр зарлиг болов : “Үүнийг хэдий чинээ хүнд ориё гэнэ чи Шуумар ? зовбол Шарайголын гурван хааны агт зовно .түүнээс өөр хэн зовох вэ ? Сууж үлдсэн гучин баатар биднийг үзэж мань жишээгээр явтугай. Өчүүхэн иргэд үзээд улам удам тзүрхээ хатуужтугай. үлдээж тогтоох Цотон ноёны өмнө авачиж цутгаж орхиё” гэв.

Гурвуул явж их улдаа хүрэв. Шуумар тэр толгой, чих, хурууг авчирч Цотонгийн өмнө цутгаж орхив. Цотон хэлэв: “Авай хүүхэд! юу билээ?” гэж хойшоо суув. Цас Чихэр хэлэв: “Ай цотоз авгай! Хүний толгой, чих, хурууг үл таих хүн нүдэн балай чихэн дүлий болоо юу ? Биендээ дайсан ирнэ гэвэл бидэнд өшөөгүй гэж Рогма гуаг нууя гэдэг билүү ? Гэсэр хаан эзгүй боловч энэ цэргийн ноён Цотон авгай байна шүү. Эрийн барьц энэ биш үү!” гэв. Цас Чихэрт Цотон хэлэв : “Авай, таныг үхүүжуй гэж тэгсэн билээ би. Энэ тань сайн” гэ. Гурвуул зуун агтыг Рогма гуа, Ажу мэргэн хоёр хатанд дээж гаргаж өгөв. Гучин баатарт нэжээд нэжээдийг хувааж өгөв. Үлдсэн морийг их цэргийн морьгүйд нь түгээж өгөв. Цотон эс өгөв.

Банжур, Зургаан эрхийтгэй тулав.

Рогма гуа асуув: “хайгуулчны жишээ ээлж хэнд вэ? Шавгаар үзэж явуулсугай” гэв. Цас хэлэв: “Рогма гуа минь, шавгаа байзна. Нэг хоёр баатрыг би амлая. Хойдохыг нь шавгаар явуулъя” гэв. Цас бас хэлэв: “Амбарын хөвгүүн Банжур минь морд ” гэв. Банжур бараан хар морио унав. Бадагт хар хуягаа өмсөв. Гучин цагаан сум, догшин хар нума дүрэв. Мишиил болд илдээ зүүв. Мордон явахда Цаст айлтгав. “ЦасЧихэр минь! Би ччадан ядан чинийхээ явдлаар хийх болно. Удах уу? түргэлэх үү? ” гэж асуув. ЦасЧихэр хэлэв: “Бид арай удаан явсан билээ. Найранзана мөрний эхэнд суусан алаг нугасанд начин шувуу орсон мэт нэг хэд шүрхийлээд ир” гэв.

Бажур явав. Элст уулын оргил дээр гарч Гэсэр хааныхаа сахиусанд залбирар. Цагаан гэрт хааныг довтлов. Есөн дахар хүрээлсэн цэргийг довтлов. Есөн тугий нь унагаж есөн хиурыг нь хугачив. Есөн идээ чанагчийг нь цавчив. Есөн сүрэг агтыг нь булаан авч гарав. Цагаан гэрт хаан үүрийн хяраанаар босож хоёр дүүдээ элч илгээв. Хоёр дүү нь хүрч ирэв. Цагаан гэрт хаан хэлэв. “Сая нүгэлт хүн ирж довтлов” гэж уйлан хэлэв. Шамба мэруз хэлэв: “Чи тоочоод яах вэ? Бид мэдэв. Уйлаад хэрэг бүтэхгүй. Уран аргаар нэхүүлье” гэв. “одоо нэг сайын эрээр нэхүүлье ” гэв. “мэргэний хөвгүүн Зургаан эрхийтийг эрүүл. тэр нэхтүгэйб гэв. Зургаан эрхийт ирэв. Цагаан гэрти хааны хөлөг бор моринд хоёр уут шороо ачиж өгөөд Бнжурт хэлэх үгийг зааж өгөв: ‘Ай, Төвдийн муу үгүй гуйланч дээрэмчин хүн биний адууг орхи. Унагат гүүг минь унаганаас нь хагацаалалгүй орхи. Даагат гүүг минь дааганаас хагацуулалгүй орхи. Тарганыг минь бүү хайлга. Туранхайг минь бүү эцээ. Сохор доглонг минь бүү төөрүүл. Цагаан гэр хааны минв яав гэж довтлов чи муу ? Есөн тугийг юу гэж унагаав. ? Есөн хиурыг минь юу гэж хугалав чи ? Есөн идээ чанагчийг минь юу гэж цавчив чи? Есөн сүрэг агтыг яав гэж авч ирэв ? Түмэн хүний дотроои тэргүүнийг нь юу гэж шантлав чи ? Мянган хүний дотроос маньг юу гэж идэш болгов. чи? Тугийн залааг юу гэж санжуулав ? тулгуур ишийг нь юу гэж хугалав чи? Адилтгавал Цагаан гэрт хаан минь наран саран хоёрыг шидэр ургуулах ийм хувилгаан бишүү. Би мэргэний хөвгүүн Зургаан эрхийт байна. Нэг харвахдаа нэг сайн нум зургаан сумаар онилж харвадаг билээ би. Бацаг сахиад хүнийг харвахгүй байна. хэрвээ харвал сүнс минь тамын ёроолд ойчино . Ай, чи, муу, адууг минь зүгээр орхи гэв. Амбарын хөвгүүн Банжур хэлэв : “Эвүү! Эцгийн чинь толгой! Муу тэнэг хорт хүн чи . Чамд өгье гэж авсан адуу юу ? Энэ баян Шарай голын гуйланч Төвдөөс юун адуу өг гэж байна чи ? Зүгээр хариасай. Чиний хааны хувилгаан гэгч үнэн бмз. Гэсэр хаанд хувилгаан байхгүй нв үнэн” гээд явав.

Банжурын дээгүүр гурван тас шувуу нисээж айсуу .: Эдүгээ Зургаан эрхийт өгүүлрүүн : “ Төвдийн гуйланч хүн чи үзэж бай! Чиний дээгүүри гурван тас ничэж явна. Урьдах нь эх нь байна. Хойдох нь эцэг нь байна. Дундах тас нь хөвгүүн нь байна. Дундах тасыг чиний дээр унатал харваж чадвал чиний толгой дээр хөнөөл хамаатай болно. Алдвал миний толгой дээр хөнөөд хамаатай болно” гээд харвав. “энэ дээр нэгэн шинж мэдэгдэнэ” гэж харваж тасыг Бажурыгн дэргэд унатал харвав. Банжур хэлнэ : “Эцгийн чинь түрүү! Эр хүн шувуунд эрийн сайнаа гайхуулдаг уу? Чи урьд бацаг санваар авсан гэж хэлсэн билээ?. Амьтны амтйг үл таслах гэгч чинь юу билээ ? Бацаг өгсөн лам чинь шувуу харваж албал гайгүй гэж хэлсэн үү? Чи муу айж байна. одоо чи үзэж бай Энэ хойд гурван уулын оргил дээр байгч бугыг үзэгьүн. Баруун уулын буганд эхийн хутаг байна. Зүүн уулын буганд эцгийн хутаг байна. Дунд уулын

бугыг харвая би. Буга харвах гээд зөвхөн бугыг харвах биш. Уурын бэлээс оройг хүртэд бут тас харвая. Зүүн баруун уулын буга хаагуур унахыг харж бай, чи муу!” гэж хэлэд Банжур нум сумаа дэлэхдээ нум сумандаа залбирав: “Нумны минь дээд гичир нь бугын эвэр билээ : Доод гичир нь цагаан зээрийн эвэр билээ. Хоёр элэг нь усны хар үүхрийн эвэр билээ. Бариул нь цагаан лавай билээ. Хөвч нь хөх солного билээ. Дээд гчирийг нь Гэсэр хааны минь арван зүгийн бурхан схь. Доод гичрийг нь дөрвөн их лусын хаад сахь. Хоёр элгийг нь дөрвөн их нар тэнгэр сахь. Хөвчийг нь хөхө солонго сахь. Бариулыг нь Банжур баатар би барина. Сумыг минь хий сайн салхин хөтөлж зал” гээд харваж илгээ. Уулын довыг тас бут харвав. Зүүн уулыг буга нааш унав. Баруун уулын буга цааш унавь. Сум нь хуй салхи болон тоос хөдлөв.

Зургаан эрхийт зүрх алдаж мориныхоо дэлийг тэвэрё гэлдэрхийлж харж байв. Банжур сумаа аван адууга тууж явав. Зургаан эрхийт нэхэж гүйцэж ирээд хэлэв: “Ай! Нэр чинь Банжур гэнэ үү? Эрдэнэт мэргэдтэй тэмцэхгүй . Эрхтэн хаад ноёдтой зөрчилдөхгүй Одоо би чамтай шид тэмцэллдэх минь үгүй Адуугаа гуйна би чамас ” гэв. “Ай сайн хүн, чамайг алж адугий чинь авах болно Чамд юу гэж өгөх вэ би?” гэв. Зургаан эрхийт хэлэв: “Авай, Банжур! Тогос шувуу үхэн үхтлээ сүүлээ хардаг гэлээ. тхобтой сайн хүн үхэн үхтлээ нэрээ бодно гэлээ. огоо ядавч дөлгөн цагаан морь, туруун (хэрээ) хар морь энэ хоёрыг минь өг. Энэ хоёрыг өгөл нэг шинж мэдэгдэнэ. ” гэв. Банжур уурлаж хэлэв: “Урьд та харвав. Нэгэн шинж грана гэсэн чинь чи. Одоо бас хоёр морь өг, нэг шинж мэдэгдэнэ гэнэ чи, Одоо шинж аль нь вэ ? Шинжээ үзүүл. Чи мууг албал Шарайголын гурван хаанд очиж намайг сайн эр гэж хэн мэдэгдэх вэ ? гэж алахгүй байна би. Чи бид хоёр анд болоё гэхэд унасан хүлэг бор морио өг. Цас Чихэрийн минь жигүүрт бор морьтой адил хос болно. Зүйрлүүлж уная. тэгвэл чиний өг сэнэс морийг чинь өгнө.Тэр дээр?сөн сайн морь нэмж өгье. Өгөх минь тэр болтугай!” гэв. Зургаан эрхийт : “ Эвүү, эвүү! Хүлэг бор морио өгчихөөд юу хэлж харих вэ би? ” гэв. Банжур хэлэв: “За чи намайг хуурд авья гэж байна уу? Одоо чамайг алаад авья. тэгвээл хүлэг бор морь хэнийх болох вэ ? Минийх болно шүү ” гэж хэлэв. Зургаан эрхийт өгүүлрүүн : “Эвүү, Банжур юу гэж уурлана чи? Өгье” гээд хүлэг бор морио бууж өгөв. Банжур хүлэг бор морийг аваад, өг гэсэн морийг есөн сайн адуутай өгөөд : “Миний явдлыг гурван хаанда сайхан хэлээрэй” гээд Банжур адууга тууж явав.

Зургаан эрхийт хариад гурвюан хандаа хүрч Банжурын аливаа явдлыг тоолж хэлэв. : “Энэ Шарайголд надаас илүү сайн эр байхгүй . Гэтэл түүнд би хорхой шиг байна. ” Ерийн гагц баатар нь уулыгш чингэж харваж явна. Гучин баатар нь ирвэл юу үлдээх вэ? гэв. Банжур гэртээ хүрэв. Хүлэг бор морио ЦасЧихэр т өгөв. Олон адууг урьд ёсоор сайхан хувааж авав. Цотонд юм эс өгөв.

Улааннүдэн Шимжүтэй тулалдав.

Цас Чихэр зарлиг болруун : “Одоо сүмбийн хөвгүүн Улааннүдэн минь морд” гэв. Улааннүдэн бөрт улаан морио унав. Бэгтэр цагаан хуягаа өмсөв. Бэлдсэн зэр зэвээ ваан ЦасЧихэрт ирэв. Мөн Банжурын үгээр асуув. (явах хугацааг асуув.) ЦасЧихэр хэлэв: “ хатны голын эхэнд суусаг хардаг нугасанд хачир үонхор орсон мэт болгоод ир” гэв.

Улааннүдэн явав. Шарайголын гурван хаанд хүрээд орж Банжурын явдлаар Шар гэрт хааныг довглов. Мөн Банжурын ёсоор болгож гарч ирэв. Шар гэрт хааны Хонгорын хөвгүүн Шимжү нэхэв. Элст уулбн хөтөл дээр гүйцэв. Мөн урьд зургаан эрхийтийн хэлсэн үгийг хэлж ирэв. Улааннүдэн хэлэв: “Татай! Муу яршиг” гээд адуугаа тууж явав. Шимжү хэлэв: “Ай, чи адуу минь үл өгөх болбол чи баатрын шинжээр байсугай. Би мэрэний шинжээр харвая. Үгүй болбол би баатрын шинжээр байсугай. Чи мэрэгний шинжээр харва” гэв. Улааннүдэн хэлэв : “Зөв. Чи намайг айв гэх болно . Би баатрын шинжээр байж өгье Чи мэргэний шинжээр харва гэв. Баатрын шинжээр байв. Шимжү мэргэний шинжээр нумаа татаж байж харвахад Улааннүдэн царын (пялын) чинээ амаа ангайгаад алгын чинээ нүдээ улаанаар эргүүлэн “За харва! ” гээд “ха ха гэж агдагнаж байв. Шимжү зүрх алаад дээгүүр харваж алдав. Улааннүдэн хэлэв : “За оодоо муу хушиг над болов уу?” гэв. “сумны минь бөхийг газар хол очиж бай. Толгойн чинь заадсыг салтал харвая. Унаж босоод очиж Шарайголын гурван хаандаа миний явдлыг тоолж хэлээд үхэх болно чи муу. Сумны минь хор тэнд гүйцнэ. (Хониныхоо ходоодыг идье гэвэл харигтун. манай эндэх хорхойд мөхөө идүүлье гэвэл нааш ир гэж гурван хаанд хэл!) гэ. Улааннүдэн харвав. Хэлсэн үгэр тусаж Шимжү унаж босож мориныхоо дэлийг тэвэрч гэлдэрч харив. Гэртэ хүрч гурван хаандаа Улааннүдэнгийн аливаа явдлыг тоолж хэлээд “Нүгэлтийн сумны хор гүйцэв үү?2” гээд Шимжү үхэв.

Улааннүдэн олон адууг урьд ёсоор хувааж авав. Цотонд бас юм эс өгөв.

Нанчүн, Арамжид, Түргэн Бирваа нартай байлдав.

“Одоо хайгуулыгн жишээ хэнд вэ? гэж шавга охин Наян настай Царгин өвгөнд тусав шавга. (Царгин өвгөн цагаан шаргал морио унаа Жанчирхай алтан хуягаа өмсөөд залах зэлмэн дуулгаа өмсөж ара мэт сумаа дүрж, залаа хөбчит нумаа дарж заан болд илдээ зүүж “За хүүхэд минь! Аль замаар явах вэ ? Аль хааны хүрээнд довтлох вэ ? ” гэсэнд Эрдэнэт эрх Нанчүн өгүүлрүүн : “Өвгөн эцгээ үхэв үү, амьд уу? гэж айж сууснаас залуу хүн би хатирч очоод адууг гиилж ирье)

Өвгөн эцгийгээ мордуулахаар хүүхэд би мордьё” гэж гүйлэгн бор мориой унав. Хөвчин зэр зэвээ өмсөв. Зуун нөхөөст хөө хар хуягаа өмсөж мордох гэв. Нанчүнгийн эм Мөн газрын хааны охин мөнгөлжин гуаг шинэ буулгаж ирсэн ажээ. Мөнгөлжин гуа хэлэв : “Авай минь! эм хүн шинэ ирээд сабаагүй гэж бүү сана. энэ шөнө би шившигт муу зүүдийг зүүдлэв би. (Эзэндээ ээлтэй, өөр хүний үзэхэд сайхан, эр халзан унагыг чоно идэв гэж зүүдлэв.) Энэ явдалд бүү яв. Авай минь ” гэв. Нанчүн “зөв” гэж байна. тэгж байтал Цотон ноён ирэв. “Авай Нүнчүн минь! Чиний явахаа болих зөв ч байж болно. Гэвч эмийнхээ үгэнд орж, үхэхээс айж боливол чинь аймтгай муу эр гэж чамайг олон улс элэглэх боно. Цотон ноён би арван таван насандаа юу эс үйлдлээ би” гэж хэлэв. “За” гэж Нанчүн тэр үгэнд нь “Мордьё” гэж мордов. Мөнгөлжин гуа эм нь уйлав. “Авай Нанчүн минь гагц дахин довтолж ороод гарч ирээрэй.! Хоёр дахин бүү довтол!” (гээд есөн алд хив алчуураа тайлж өгөөд уулж хоцров.)

нанчүн мордож явав. Элст уулын оргил дээр гарав. Улааннүдэнгийн явдалаар хар гэрт хааныг довлоод гарч ирэв. Нанчүнтэй уулзаж урьдын баатруудын хэлэлцэсэний адил үгситйг ярилцав. Арамжид Нанчүнг харвая гэж нумаа дэлэв. Нанчин гэсэрийн сахиусанд залбирарав. Харвах үед их хуй салхи салхилсан уяир сум нь дээгүүр гарч явав. “Одоо хишиг над болов ” гэв. “хүүхэд хүн надад юуны нэр төр байх билээ” гээд хуягт хүний дундуур шувт харваад хуяг морийг нь авав. “Гагц хүнийг алаад адууг нь авч очвол Гэсэр хааны минь гучин баатар намайг элэглэх болно Нанчүн хүнтэй учрахаас айж ганц хүнийг алаад ирэв гэж их улс элэглэх болно. ” гэж дахин довтолж оров. Уулын түргэн Бирвааг довтлов. Түмэн цэргийг нь тас цавчив. Гээгийг нь баглаж аваад гүйлэн бор мориныхоо сүүлнээс уяв. Есөн идээ чанагчийг нь тас цавчив. Есөн туг хиурыг нь хавад. Есөн сүрэг агтыг нь авч гарч ирэв. Уулын түргэн Бирва элст уулын хөтөл дээр гүйцэж ирэв. Ирээд хэлэв: “төвдийн дээрэмчин хөвгүүн чи дайлах болбол Шарайголын гурван хаантай дайтахгүй надтай юу гэж дайтав ? Алалдах болбол Шарайголын гурван хаантай аладдахгүй надтай юу гэж алалдав. Балбйын хааны хөвгүүн Түргэн Бирва намайг таниагүй юу чи ? Чи муу тугийг залаад яав гэж таслав чи? Тугийг ишийг минь яав гэж хугалав чи? Адууг минь зүгээр орхи. Авай, зовлон гэв. Нанчүн хэлэв: “үй, Эцгйн чинь түрүү! Чи муу уулын түргэн Бирва болбол би тэнгэрийн хөвгүүн Эрдэнэт Нанчүн байна. Гэсгээшгүй Гэсэр хааны хувилгаан баатрууд гэгч бид бишүү. Арван зүгийн эзэн гэсэр богдын минь аль муугий нь мэдээд шарайголын (гурван) хаанд ирэв чи. Урьд ЦасЧихэр, Шуумар бид гурвуул ирснээ чамд мэдүүлье . Чиний муугийн толгой хэдийн огтлох билээ ” гэв.

Тэгтэл Нанчүнгийн дээгүүр дгурван гулуу нисэж айсуу. Уулын Түргэн Бирва хэлэв : “Ай, Төвдийн хөвгүүн чиний дээгүүр нисэж ирэгч гурван галууны дунд дахь галууг харвая. Түүнээс сум минь цааш нэвтэрч өмнөхийг нь төмөр зэвээрээ сүлбэж, хойдохыг нь өдөөр

шүргэж орхино. Энэ гурван галуг тэгж харваж би чадвал адууг минь орхи. Эс чадвал адууг чи ав. ” гэв. Нанчүн “За” гэв. Түргэн Бирва галууг чиглүүлэн нумаа дэлж татаж байна. Нанчүнг дээш харах завсар Түргэн Бирва Нанчүнгийн хёр сугаар нэвт харвав. Нанчүн уаж босов. Есөн алд цэмбэн алчуураа тайлж хоёр сугаараа хар цус булиглуулж байж тас боож байна. Нанчүн хэлэв: “Эцгийн чинь толгой! Энэ муу чи айсан бишүү. Хоёр эм хэрэлдээд нэгийгээ хайчаар бүлсэнтэй адил бишүү. Би чиний ганц муу суманд үл үхэх Араг с сиймхий гэгч бөөатар эр нанчүн шинжээ үзүүлье би. Чи хол газар очиж малгайныхаа залаанд дэрс хатга. Дэрсний үзүүрт хонины хоргол хатга. Залаанаас дээгүүр хорголоос доогур, гагч дэрсийг тас харваж орхиё. Чи очиж гурван хаандаа хэл. “Би хоёр сугар нь нэг сумаар нэвт харвав” гэж хүрч хэл гэв. Түргэн Бирва “За” гэж Нанчүнгийн хэлсэн үгээр тэмдэг хатгаж хол очиж буруу харж зогсов. Нанчүн нумаа дэлж байхдаа хэлэв : “Эцгийн чинь түрүү Чи хуурав гэж, би хууртав гэж харихуу ? ” гээд хуягт хүнийг дундуур нь шувт харваж алав. Бор мориндоо алавхийж унаад Бирваагийн толгойг тас цавчаад гүйлэн бор мориндоо молцог хийв.

Түүний морийг аваад олон адуугаа тууж Элст уулын зоон дээгүүр тууж явна. Явтал цус урссар усгүй газар цангаж унах болов. Баруун тийш хэлбийж очиход нь зүүн дэлээрээ түшэж тогтоов. Зүүн тийш хэлбийж очиход нь зүүн дэлээрээ түшиж тогтоов. Дэл дээгүүр нь алдалж унахад толгой дээш өргөж түшсэн боловч эрхгүй унав. Төдий унаж хэвтгэл нь хоёр чоно махыг идье гэж хүрч ирэв. Хоёр хэрээ нүдийг нь цохъё гэж нисэж ирэв. Гүйлэн бор морь нь нанчүнгийн дээр нь дөрвөн хөлөөрөө хаацайлан байж Нанчүнгийн магтаж уйлав “хөх огторгуйд дураар явагч начин шонхор минь, Доош унавуу чи, эжий минь ? Гүн далайд дураар явагч аврага загс минь, өөшинд торов уу чи, эжий минь, Хөрст алтан дэолхий дээр дураар явагч Гэсэр хааны ач нанчүн минь, шулмаст атгагдав уу ? чи. Эжий минь ? Гучин баатрын минь хуурын хөг, хулсы үе мэт учирч билээ. Гучин бор морь бид шувууны жигүүр мэт учирч билээ. Эрхтэн тэнгэрийн хөвгүүн Нанчүн минь . Энэ Замбутивийн хүнд алагдав уу чи, эжий минь ? Хан тэнгэрээс заяагаар төрсөн хайрт нанчүн минь, Хар тэргүүт хүнд алагдав уу чи, эжий минь ? Эрдэнэт махбод биеийг н танд идүүлбэл намайг хэн гүйлэн бор морь гэх билээ ?” гэж хоёр ёоныг хойгуураа гарахад өшиглөж урдуураа гарахад зууж, цавчиж (батганыг сүүлээр ширвэж) уйлж байна. Нанчүн бяцхан сэхээтэн байсан ажээ. Морины салтаан доогуур хялааж үзээд хэрээнд үг хэлэв: “Ай, хоёр хэрээ : (сонстугай. огторгуйд явах жигүүртний хаан гарди, орчлогнийн урхит хүний урхинд торвол гарах чөлөөгөө үл оно гэлээ. Хар ууланд явах хүрэн эрээн барс, орчлонгийн гөрөөчин хүний аванд орвол орох гарах чөлөөгөө үл олно гэлээ. Би тэр мэт боллоо.) Миний хоёр нүднээс байтугай, махбод би? минь хэнийх болов. (та нарынх болно) идэхээсээ урьд очиж ЦасЧихэр эхлэн гуячин баатарт үг хэл. Танай эрдэнэт Нанчүн өшөөт дайсныг өм довтолж, охид хөвгүүдийг нь олзолж Элт уулын зоогоор (адууг нь) тууж айсуй . Замдаа усгүй цангаж үхэх гэж байна . Ус авчирч өг гэ. (Зургаан зүйл амьтны хэл мэдэх) Буйданд хэлээрэй!” гэв. “Энэ мэт хэлэх үг олон байвч “хай хэрээ! Буйдангаас бусад гуячин баатрууд шувууны хэл мэдэхгүй ” гэв.

Тэр хоёр хэрээ явав. Хүрч их цэргийн дээр эргэж явна. Нанчүнгийн аливаа явдлыг цөм тоолж өгүүлбэл Буйдан олон улсын дууг хураа! (дуугүй бай) гэв. Хэрээний үгийг чагнаж сонсоод Буйдан хэлэв: “эвүү эвүү, энэ хоёр хэрээний үгээр болбол Нанчүн минь мэгдэж байгаа бололтой ” гэж уйлж босон харайв. ЦасЧихэр, Буйданг “Яав? Нааш ир” гэж дуудав. “Би мэдэв

. Эр хүний дотор хуягт дуулгат хүн багтах бишүү. Эм хүний дотор яст үст хүүхэд багтах бишүү. нанчүнгийн минь тусыг тул хэрээний үгийг булт Цасд тоолж хэлэв. ЦасЧихэр, Рогма гуа, Буйдан гурвуул нуун далд уйлж байв. Их цэрэгт эс сонсгов. ИХ цэргээ хуурч ЦасЧихэр, Рогма гуа, Буйдан гурвуул “нанчүн маань тоолшгүй олон мал эдэлж айсуй . Бид ус аваачиж өгье. Нанчүнгаа угтъя” хэмээгээд мордож явав. “Тэр минь үхчихсэн болов уу? Амьд болов уу ? ганга эмчийг дуудав. Гунгаа эмч эр, эм хоёул хэлэв: “Энэ жил зүүн тийш явах тал муутай . Хэрвээ явбал үхэх болно” гэв. Буйдан ирж тэр үгийг Цас, рогма гуа хоёрт хэлэв. Рогма гуа уурлаж хэлэв: “ Энэ муугийн үгийг сонс! Гэсэр хааныг минь эзгүй гэж намайг эм хүн гэж, нанчшнгийн минь төлөө явахгүй гэж байна, энэ муу. Чамайг алавч надаас ял хэн нэхэх вэ? ” гээд гунгаа эмчийг аваад явав. Дөрвүүл Элст уулын зоогоор эрж олохгүй явтал гэнэт далдаас нэгэн их бараа гараад тэнгэрт хүртэл тоос хадуулаад явав. Дөрвүүл тэр мөрөөр мөшгиж явтал рогма гуа танив: “Гэсэрийн минь билгийн хээр морины мөр бишүү энэ” гэв. “үүнийг нэхэж яаж гүйцнэ?” гэв. Буцаад ирсэн мөрөө мөшгиж явав. Тэгж явтал олон адуу хүн хураасн мэт цуглаж байв. Дэргэд нь нанчүн байв. Гүйлэн бор морь нь угтан уйлж ирэв. ЦасЧихэр, Рогма гуа хоёул уйлав. Гэсэрийн билгний хээр морь нь Нанчүнгийн унасныг хувилгаанаар мэдэж ирж ,нанчүнгийн дэргэд олон агтыг хурааж байгаад явчсан нь тэр байжээ. Гунгаа эмч Нанчүнг үхсэнийг хоёр сугаар эь эм хийгээд эдгээв. Нанчүн Шарайголын гурван хааныш дайлснааа булт тоолж хэлэв. Түмэн хүний гэзгийг Уулын Түргэн Бирваагийн толгойг бүгдэд үзүүлэв. Түүнийг авч үзэж бүгдээр инээлдэж суув.

Цас Чихэр Зургаан эрхийтийг алав.

Суутал гэнэт эзгүй зурган сум ирж тусав. Нэг нь Нанчүнд, нэг нь Буйданд, нэг нь Гунгаа эмчид ирж тусав. Нөгөө гурван сум нь тэр гурвын гурван моринд ирж тусав. Рогма гуа “Эвүү, Цас минь! Энэ юу билээ ? ” гэж босон уйлав. Цас Чихэр зарлиг болруун :м “Ай, Рогма гуа минь, Дайсан хүний шинж энэ бишүү ? ” гэв. “Бүү уйл!” гээд гурвуулын гурван сумыг мугалж аваад Гунгаа эмчийн эмийг хийгээд мордов. Цас Чихэр уулын оргил дээр гарч үзтэл Шарайголын гурван хааны мэргэний хүү Зургаан эрхийт далд байж харвахдаа нэгэн сайн суманд зургаан сайн сум онилж шившиж харвасан ажээ. “нэг зарим сум минь хүнийг алдвал моринд тус. Морийг алдавч хүнд тус ” гэж шившиж харвасан ажээ. Цас Чихэр өгүүлрүн : “Чи муу мэргэний хүү Зургаан эрхийт бишүү. Чи мууг би мэдэв. Амбарын хөвгүүн Банжурт минь хүлэг бор мориой юу гэж өглөө чи муу ? ” гэв. Тэр Зургаан хуруут хэлэв : “Тэр үг чинь зөв. Танай нэгэн хөвгүн ирж аливаа бүгдийг минь агир болгож явахад харвасан минь тэр билээ ” гэв. Цас Чихэр хэлэв. “За тийм болбо над зэмгүй шүү” гээд Цас Чихэр сумаа харвав. Зургаан эрхийтийн сүнс нь зургаан хуруунд нь байсан ажээ. Тэр суманд ажирсангүй ., босон харайж нум сумаа дэлэв. Гэтэл Цас Чихэр хувилгаанаар мэдээд цул болд илдээ суга татаж довтлон очиж тавьтал нь зургаан эрхийг нь нум сумны хөвчтэй нь тас цавчиж орхив. Зургаан эрхийт амьгүй унав. Хуяг, морь, зургаан эрхийг нь аваад явж ирэв.

Иртэл нь Рогма гуа уйлж сууна ажээ. Цас Чихэр хэлэв : “Ай Рогма гуа минь . Чи уйлаад байвал энэ гурвыг энэ эмээр хэн эмнэх вэ? Тэр муу Зургаан эрхийтийг алаад ирэв би” гэв. Гэсэр хааны минь тэнгэрээс заяагаар авч ирсэн, үхсэн хүнийг эдгээгч Гунгаа эмчийн эмийг ихэд найруулав. Сан тавьж Гэсэр хааныхаа сахиусыг залбирав. Цас Чихэр “Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан авай богдын минь дээр Хурмаст тэнгэр эцэг нь, ялгуусан гурван эгч нь аль бүгд сахиус нь дэд дэдээр өршөөн соёрх Энэ гурвуулын минь эйлсэн (явчсан) сүнсийг эргүүлж авчирья. Хол очсон сүнсийг нь хурааж авчирья. Энэ хийсэн эм нь өднөөс хөнгөн, сумнаас хурван болго гээд мөргөж гурвуулыг сан дээгүүр утаад Гунгаа эмчийн эмийг хийв. Гурвуул даруй дээр эдгэв. Гунгаа эмч босоод “Бие минь тэнхэрээгүй байна. ” гэж эмээсээ дахиж уув. Нөгөө хёртоо бас уулгав. Уусны хойно гурвуулын бие нь язгуурт адил болов. Гунгаа эмч гурван мориныхоо сумыг сугалаад Зургаан эрхийтийн эрхийний нь махыг эмэндээ нийлүүлж гурван морины шархахнд түрхвэл гурван мрь эдгэв. Олон агтнаас есөн атран морийг сонгож алаад Гэсэр хааныхаа сахиусыг залбиран тахиж мөргөөд (гурван өдөр хурим хийгээд) гэрийн зүг явав. Рогма гуа, Буйдан хоёул адуугаа тууж хойноос нь явна. Цас, Нанчүн, Гунгаа эмч гурвуул Түргэн Бирваагиын толгойгоор замдаа наадаж явсаар гэртээ хүрэв. Олон адууг мөн урьд ёсоор сайхан хувааж авав. Хамгийн эзэн хаан байтал Цотонд эс өгөв.

Цотонгийн худал мэдээ .

Шарайголын гурван хаан Нанчүнгийн аливаа явдлыг хэлэлцэж цаашаагаа гурав ухарч буув. Хар гэрт хааны нэгэн баатар өгүүлрүүн : “Үүнээс бусад баатрууд цугаар ирвэл хэн тэсэх вэ! ГЭсэрийг эмийг авахбайтугай, нэг баатрын эмийг ч яаж авах вэ ? Рогмаг үнэхээр вья гэх дур байвал, гурван хаан тэнгэрийг залж ирэв. Тэгвэл авч чадах магадгүй байна ” гэсэнд тэр үгийг гурван хаанзөвшөөрч гурван схиус тэнгэрийг залбирвал даруй дээр Хилингийн гурван тэнгэр, Гэрч өчүүхэн зовох байна. Зововч төөрөг сайн байна” гэж бошиг соёрхов. ГУрван хаан ихэд баясалцав. Дөрвөн тэнгэр тэдэнтэй нөхцөлдөн суув.

Тэр цагт дээр Хурмаст тэнгэрийн чих нь хангинав. “Юуны шалтгаан болов ? ” Гэртээ бий болов уу? Юунд ирсэнгүй вэ гэж нэгэн элч илгээв. Тэр илч хүртэл гурван дагина, гурван тэнгэр гэртээ байв. Элч гурван дагина, гурван тангарт айлтгаруун : “Хаан хурмастын чих нь гурван хоног хангинсны тулд гучин гурван тэнгэрийг хураав. Тэгэхэд та зургууд очмонгүй. таныг юунд саатав ? Үтэр ир гэнэ. ” гэ. Тэр зургуул яаран Хурмаст тэнгэрийн дэргэд очив. Хурмаст тэнгэр зарлиг болруун : “Та зургуул юунд саатав. ” гэж асуувал. төдий гурван дагина, гурван тэнгэр ийн айлтгаруун: “Манай саатсан учир болбол Үйл бүтээгч гэртээ үгүй байв. АРван хоёр толгойт мангаст очсоор ирээгүй. Гэсэрийн атаат Шарайголын гурван хаан гэгч байдаг. Тэр хааны Алтангэрэлт тайж гэгч Цагаан гэрт хааны ганцхан хөвгүүн билээ. Рогма хатныг нь авья гэж Гучин гурван буман цэргээр мордож ирсэнд Гэсэрийн гучин баатар, Цас эхлэн хэсэг хэсгээр угтаж очоод Шарайголын цэрэгтэй хатгалдаж явахдаа бид гурван дагина, гурван тэнгэрийг злбирсаныг тулд бид зургуул огторгуйгаас нууцаар очоод сахиус болон нөхцөлдөв. Бидний саатсан учир шалтгаан нь эн билээ ” гэв. Хаан Хурмаст тэнгэр ихэд хилэгнэн зарлиг болруун : “Та зургуул дураараа ингэж явах чинь буруу билээ . Эрт Бурхны зарлиг : “Үйл бүтээгчид бошиго өгөхдөө хэрвээ үйл бүтээгчийг хүчин мөхсдвөл таны гурван дагина, урван тэнгэрийг хүчин нэм гэсэн нь үнэн билээ. Тэр Гучин баатарт нь хүч нэм гэснийг би мэдэхгүй. Гэсэр үгүй байтал дураараа очсон чинь буруу билээ! Үйл бүтээгчийн нэгэн их зовох цагт эхмжээ нь энэ биз. Эдүгээ төөрөг урьдаар тэр хаанд болох билээ. Тэр гурван ханыг зориг үйл ер бүгд цөм бүтэх болно ” Ингэж зарлиаг болоод : “Та зургуул үтэр одоод Гэсэрийн гучин баатарын гурван зуун жаран нэгэн судлыг сүнсэй нь үтэр яарч авч ир. Тэр гучин баатар цөм тэнгэрийн хөвгүүн биш. Эрт бурхан Гэсэртэй адил гучин баатарт бошиг өгсөнгүй бишүү. үүнээс хойш та зургуул тэр гучин баатрыг бүү өмгөөлө. Тэр гучин баатрын судал сүнсийг үтэр авч ир! Хойно амьдруулах болбол тэр үед буцааж өгнө ” гэв.

Төдий гурван дагина гурван тэнгэр Хурмастын зарлигаар огторгуйгаар нууж очтол Гэсэрийн гучин баатар басхүү “Мордьё” гэж “Жишжж хэнд болов? Халхай очъё, би очъё” гэж булаалдаж байв. Рогма швга орхиход нь дээрээс гурван дагина, гурван тэнгэр хувилгаанар мэдээд Рогмагийн тэр шавгийг эрхгүй Цотонд тусгав. ТӨдий (Хаянхярваа бурхны хуилгаан) Цотон ноён хар тогойт, цагаан сүүл цоохор морио унав. Шоргоолжин сааадгаа бүслэв. Ширэн ха\уягаа өмсөв. Хянгаран илдэ зүүв. Мордож яваад Шарайголын гурван хааныд очиж адуунаас нь хулгай хийж аё иртэл хойноос нь Цагаан гэрт хааны Бүргэл хар цус уугч түшмэл нэхэж Элст уулын хөтөл дээр гүйцэж ирэв. Цотон ноён ганцаар дэми й донгосож дуулж явна : “Би ЦасЧирэхийн чинээ сайн эр бишүү ” гэж бардамнаж “Энэ адуунаас Цасад нэг ч морь өгөхгүй

” гэж явгл Бүргэд хар түшмэл сонсоод : “Энэ муул хүн байна. Дэмий донгодож явах нь юу вэ ? ГЭртээ хүрний хойно бүү өгөлцөөрэй . Цасад гээд газрын далдаас нууж хашгиран дайрав. Цотон адуугаа орхин дутаав. Бүргэд Хар түшмэл эрхгүй гүйцэж ирэхэд саадаг нум сумаа аван Цотон ноён тарваганы хонхор нүхэнд шургаж оров. Бүргэд хар түшмэл өгүүллүүн : “Ай, муу гарч ир. Нүхэнд ороод хааша гаръя гэнэ чи ?” Цотон өгүүллүүн : “Адуу морь минь тэр байна. Түүнийг ав. Миний биеэр юу хийнэ чи ? ” гэв. Бүргэд хар түшмэл өгүүллүүн : “Мундаж сайн өглөгч ноён болов уу? чи ? Үнэхээр өглөгч хүн хүн байна чи. Тийм болбол саадаг нум сумаа өг ” гэв. Саадаг нум сумаа өгөв. Гучин цагаан сумны өдөнд шороо дүүрч ирэв. “Чи биеэрээ “Чи биеэрээ үтэр гарч ир Чи гарч ирэхгүй болбол аргалаар утна ” гэж ргал хормойлж ирэхэд Цотон хэлэв: “ Түшмэл авай! Чи намайг бүү ал. ГЭсэр үгүй байна. Рогма гуа авахуудахын аргыг би хэлж өгье. ” гэв. Түшмэл “За” гэв. Цотон нүхнээс гарч ирэв. Бүргэд хар түшмэл дуун үгүй Цотонг (Моринд унуулж дөрвөн мөчийг ганзгаар тас) хүлээд, адуугаа тууж гэртээ хүрээд гурван хаандаа Цотонг аваачив. Цагаан гэрт хаан өгүүллүүн : “Цотонгийн хүлээсийг тайлж тавь” гэв. Цотонгийн хүлээсийг тайлж тавив. Цотон ноён есөнтэй мөргөв. Цагаан гэр хаан : “Дээш суу” гэнэ Шамба Мэруз тэр хоёр дургүйцэж хэлэв. “Есөнтэй мөргөгч Цотон ноён, дээш суу гэгч Цагаан гэрт хаан энэ хоёул юутай сайхан амраг билээ ?” гэв. Гурван хаан : ” Цотон ночн авай минь, үг чинь юу вэ ? Хэл гэв. Цотон ноён хэлэв. “Гэсэр гэртээ үгүй Мангаст явсаар ирээгүй Гэсэрийн амраг ЦасЧихэр ах нь гучин баатрын хүч нь адбиш их байна. Тэд нар үнэхээр байвч яах вэ! Рогма гуаг авахын аргчг би зааж өгсүү” гэв. “За тэр үг чинь зөв. Хэл” гэв. “Бас үг бий юу хэл” гэв. Цотон ночн өгүүллүүн “Морь хуяг, зэр зэвийг минь өг. Над нэгэн бүлэг сайн муу адууг өг. Тэр адууг аваад харьж би худал хэлнэ. Би ингэж худал хэлнэ. “Шарайголын гурван хааны цэрэг буцсан байна. Би мөрөөр нь мөшгиж гүйцэн ядаж орхисон адууг авч ирэв” гэж хэлье. Тэгвэл манай хи цэрэг, гучин баатар бүгд үнэмшиж тархана. (Тэдний гэр нь хол хол байдаг. Гурван хоног, хоёр хоног нэг хоногийн газар байдаг. Цас Чихэрийн гэр нэг сарын газарт бий. Би шарай голын цэргийг буцсаны баяр гэ их хурим хийж арз архиар бүгдийг согтоогоод тараая. Та нар минийхойнооё нэхэж очоод (сул суух) Рогма гуаг ав” гэв. Шарайголын гурван хаан энэ үгийг зөв гэж баясаад бүгдийг булт өгөв. Цотонгийн морь, зэр зэвийг (сохор доголлон даарьтай) муусайн гурван зуун адууг өгөв. Цотон мордож яваад эргэж ирээд гурван хаанаас асуув: “Гэсэр бид хоёр нэгэн отог улсыг булаалдсаар билээ. рогма гуаг авсны хойно тэр отог улсыг өгөх ажаамуу?” гэв. Цагаан гэрт хаан “Өгье” гэв. Цотон мөргөөд явав . Гурван зуун адугаа гэрийн зүг тууж явгал нь хойноос нь Гэсэрийн анд Чадисмари нэрт түшмэл Цотонгийн энэ үгийг үнэн үү, худал уу тэнссүгэй гээд гүйцэж ирээд “За муу Цотон чи юуны тул Гэсэрээс урвав. ? Рогма, гучин баатар аливаа бүгдийг би аргалж авч өгье гэгч чинь юу вэ ? Гэсэрийн бие нь чиний ач бишүү. Алтан дагина бэр чинь бишүү. Гучин баатар төрөл чинь бишүү. ” гэв. Төдий “Энэ мууг алья” гээд илдээ суга татвал Цотон морин дээрээсээ бууж харайж сөгөн ийн айлтгаруун : “Богд Чадисмари ” түшмэл! Тэр зарлиг чинь эгээл үнэн билээ . Тийм болов чи эдүгээ гэгээндээ айлдан соёрх. Би эдүгээ дайсан хүний гарт баригдсан тулд өөрийн амиа аргалж гарсугай гэсэн билээ. Би ямаро тэнэг амьтан болж Гэсэр хаандаа хар санах вэ?

Тэгж айлтгасөөнл Чадисмари түшмэл: “барам хөөрхий Цотонгийн энэ үг нь эгээ үнэн” гээд гэртээ харив. Чадисмари түшмэл : “барам хөөрхий Цотон газрын дамаар нууж очоод түүнийг гэртээ орсны хойно гурван хаанд Цотон ирээд ийн айлтгаруун : “Таны гай нэгэн Чадисмари нэрт түшмэл намайг нэхэж очоод .: “ Гэсэр бид хоёул анд гэнэ. Чи юуны тулд гурван хаанд урвав Эдүгээ би чамайг алья ” гэв. Чи юуны тулд гурван хаанд урвав. Эдүгээ би чамайг алья”

гэсэнд би амиа гарья гэж худал хэлэв. Миний тэр үгийг “үнэн сайн” гээд харьж ирэв. Энэн үгийг гурван хаанд мэдүүлье гэж ирэв” гэв. Гурван хаан Чадисмари түшмэлийг авч ирээд Цотонгийн үгийг асуувал Чадисмари өгүүлрүүн : “Гурван хан минь! Эрт урьд Гэсэрийн аливаа рид хувилгаанышг та нарт тоолж өгүүлсэн минь үнэн билээ. Эдүгээ энэ Цотонгийн үг нь тун худал болуузай. “Би урьд эс хэллүү ? Энэ муу ракшем мэтийн түшмэлийн үгэнд бүү ор гэсэн минь эдүгээ үнэн боллоо. Энэ муу түүшмэлийг барь ” гэвэл Хар гэрт хаан зарлиг болруун : “Энэ Чадисмари түшмэлд эртээс дургүй минь үнэн билээ . Эдүгээ энэ цотон манд хар санадаг нь үнэн болбол цааш харилгүй юуны тул эргэж ирэв? Энэ хатан, түшмэлийг бариад гар хөлийг нь төмөр тушаагаар тушаад, хаан зарлиг болж, Цойрон урны хүү лам Номчийг урьж ирээд : “Энэ Чадисмари түшмэлийг аваачаад есөн давхар хар байшинд хадгал. Чамд жаран сайн хүнийг өгсүгэй . Хэрвээ алдвал лам номч чамайг эхлэн жаран сайн хүнийг алах болно” гэж захирав. Лам Номч тэр түшмэлийг гэртээ авч ирээд есөн давхар хар байшинд оруудаап суув.

Гурван хаан Цотонг “Чи эдүгээ харь” гэв. Цотон өгүүлрүүн : “гурван хаан миний хойноос арваад хоноод мөн болзоогоор ир!гээд Цотон ноён гурван зуун адуугаа тууж арав хонож гэртээ хүрч ирэв Цас Чихэр эхлэн гучин баатар, их цэрэг бүгдээр: “Цотон авайг у гэж удав?” гэж асуув. Цотон ноён хэлэв : “Шарайголын гцурван хааны цэрэг дүрвэж буцаж байна. мөрөөрнь явж эс гүйцээд орхисон муу адуугий нь авч ирэв. Та намайг байлдаж үл чадахыг мэдээд тэднийг буцсан хойно намайг хуурч илгээв. Би мэдэв. Миний үгийг итгэх болбол тарцгаая. Би адуу хулгайल्या гэж очиж их ядрав. Би муу боловч янаг төрөл чинь бишүү. Та нар намайг итгэхгүй болбол нэг хоёр хүнийг явуулж үз” гэв. ЦасЧиэхр хэлэв : “Та харийн хүн биш, өөрийн төрөл Цотон авгай байна. Юунд худаг гэх вэ ? Энэ үгэнд болбол Шарай голын цэрэг буцсан нь үнэн бөөына гэж их цэрэг бид бүгдээрээ тархья” гэв.

Цотон ноён өгүүлрүүн : “Эдүгээ таныг би бэлэг зохьтой гэж Номын манлайн нэг хурим хийе. Цас ,Рогма, Шуумар өгүүлрүүн : “Авайг энэ үг чинь маш зөв байна. Бид бгдээрээ номын манлай хурим идээд тахья” гэв. Цотон ноён уулын чинээ идээ, далайн чинээ арз архи хасаг тэргэнд тээж ирээд, Цас ,РРогма, Шуумар эхлэн гучин баатар бүгдээр хуримлаж жарган суутал огторгуйгаас гурван дагина, гурван тэнгэр нууж ирээд. Цас эхлээд гучин баатрын зөн билэг ухаан хийгээд гурван зуун ужаран нэгэн судал сүнсийг хуилгаанар аваад Хурмаст тэнгэрт хөөрөв. Цас эхлэн гучин баатар архины жаргалд ташуурч байсаар аливаа рид хувилгаан, гурван зуун жаран нэгэн судал сүнсээ автал эс мэдэн суув. Буйдан өгүүлрүүн : “Ер дарсны ихэд сайнгүй билээ. Эдүгээ гэр гэртээ тархаж хариад боть боть номыг номолвол хэрэгтэй нь тэрбилээ. ” гэв. Цас эхлэн бүгдээр “Буйдангийн энэ үг зөв” гээд тархахад Рогма гуа уйлж байж өгүүлрүүн : “Цас авгай минь Гэсэр минь чамдаа хэлдэг билээ. Цотонгийн инээх нв мяндас, үг нь гурил, зүрх нь гүр хар чулуу билээ. Дотоод нууж хэлэлц гэсэн билээ. Гадаах үйлийг Цотонд бүү хэлээрэй гэсэн билээ. Тэгээд Цотонгийн аймтгай худалч хоёр нь ертөнцөд арай б айхгүй биз” гэв. “Энэ үг үнэн” гээд Цас Чихэр, Нанчшн, Шуумар тэгүүлэн ахмаг их цэрэг тархав.

Рогма гуа Шарайголын цэрэгт баригдав.

Рогма гуа уйлж байж өөрийн хөтөч Аргын хөвгүүн Ариунд морь, зэр зэвээ засаж (Гэсэр богдын ховдноос таван зуун сумыг саадагт нь дүрж) өгөөд : “Шарайголын гурванхааны цэрэг буцсан нь үнэн үү, худал уу? Болгоож ир “ гэж илгээв. Ариун явж хоёр гурван газрын тэртээ очтол Шарайголын гурван хааны цэрэг (ялаа батгана мэт алтан дэлхийг дүүрэн) хүрч ирэв. Ариун дотроо сэтэгрүүн : “Энэ дайснаас гарч хэдүй чинээ хол насалмой би” гээд орж алалдав. Нэг мянган цэргийг алаад (Бүргэд хар түшмэдэд алагдав.)

Гурван хааны их цэрэг нь ГЭсэрийн сорнозон гүрээр бүтээж хийсэн их илд нь байсан ажээ .Тэр илдийг аваад ужуу дотор нууж гарч ирэв. Гэсэр хааны нэг хатан нь Лусын хааны охин Ажу мэргэн хатан нум сумаар харваж байв. Рогма, жидүгээр (хоёрдугаар) Ажу мэргэн хатныг ир гэж дуудав. Ажу мэргэн ирэв. Рогма гуа Ажу мэргэнд хэлэв : “Гурван хааны цуэрэг хүрч ирэв. Яах билээ ? Арга буюу билээ ? ” гээд уйлав. Ажу мэргэн хэлэв : “Арван зүгийн эзэн аюух мэт Богдыг минь гэртээ үгүй гэж, амраг Цас Чихэр, гучин баатрыг нь үгүй гэж, Нанчүн, Шуумарыг тархав гэж намайг эм хүн гэж дайрч ирээ биз. Цэргийн хайгуулчинтай аладъя” гэв. Гэсэрийн нэгэн их садагт нэгэн мянганы гадна дөчин сум чихэж авав. Аваад ажу мэргэн саадгаа бүсэлж угтан гарав. Цагаан гэрт хааны Алтангэрэт тайжид золгов. Рогма гуагийн нүүрт нь их цэргийн тоос хүрнэ. Гэж дөчин сайн хүн түрүүлж ирсэн ажээ. Ажу мэргэн угтан байж хэлэв: “Рогмаг авах гэгч эр тань аль вэ?” гэв. Алтангэрэлт тайж : “Би билээ” гэв. “Та дөчин сайн хүнтэй их цэргийн хошууч уу? ” гэв. “Бид хошуучин билээ ” гэв. Ажу мэргэн “”За та дөрвөн арав (дөрвөн хэсэг) болж бай “ гэв. Тэр дөчин хүн Ажу мэргэний хэлснээр дөрвөн арав болж байв. Ажу мэргэн дөрвөн хүнийг дөрвө арван хүнийг тас харвав. Сум нь цааш ташин очих их цэргийн хүнд тусчихав. өАжу мэргэн, Алтангэрэлт тайжийг алаад Алтан сандал нэрт Шаргал мориог авч унав. Мориой тас гуядаж их цэргийг хошуучид нь давхиж ороод хядаж явав. Шарайголын гурван хааны цэрэг дутаав. Шарайголын гурван хаан тэргүүлэн хамаг цэрэг хэлэв: “Цотон ноён биднийг хуурсан байна. Гэсэр бий ажээ. Цэрэгж нь билний хошуучийг хядаж явна “ гэв. Цэргийг засах таван сайн хүн гарав. Цагаан гэрт ханы отгон дүү Шамба Мэруз зэр зэв, хуяг дуулгаа өмсөж билгийн цагаан морио унаж гарав. Дараа нь бүргэд хар цус уугч түшмэл, гурав дахь нь Цагаан гэрт хааны охиныг авсан Солонгосын хааны хөвгүүн Манцог Зул, дөрөв дэх нь Шар гэрт хааны охиныг авсан Балбын хааны хөвгүүн Мял Гүнцог, тав дах нь Хар гэрт хааны охиныг авсан Мон газрын хааны хөвгүүн Монса Түсгэр энэ төвуул гарч дутаасан цэргээ идээр ширвэж. авч ирэв. Гурван хааны цэрэг энгүй олон ирэв. Ажу мэргэн нэгэн түмэн нэгэн мянган цэргийг алав. Саадга тэмтрэв. Сум дуусчээ. Тгийш тийш харав, сайн нөхөр үгүй. “Энэ цэргийг би дарах ёсгүй билээ. Гэсэр минь дарах ёстой дайсан ажээ. ” Гэсэр хувилгаанаар мэдээд “одоо яах вэ би?” гэж гэр малаа ууланд авч чгарав.

Шарайголын цэрэг, Рогма гуаг бүслэн авч барья гэж айсуй .

(Гэсэр богдын Сонронзон гүрээр бүтээсэн гцурван алд илд байжээ. Нэг дохихход мянган бээрийн газар өрөвхийх тийм илд байжээ. рогма гуа тэр илдийг аваад) баруунтайгаас түрж ирэх мянган хүнийг ширвэв. Зүүнтэйгээс ирэх түмэн хүнийг мөн тэр ёсоор тас ширвэв. Өмнөх хойдох хүн дуу гарав: “Илд далайхын урьд яв яв” гэж хэлэлцэв. Өмнөд хойдох цэрэг илд далайхаас өмнө амжиж түрж ирэхэд рогма гуа чөв чөлөөгүй болж аргаа бараад хувилгаанар огторгуйд боржин соно болон нисэж гарав. Цагаан гэрт хааны цагаан эээ сахиус нь Цагаан өргөн тэнгэр болон хөөв. Рогма огторгуйгаас доогуур болон нисэв. Шар гэрт хааны шар элээт сахиус нь Шар ӨРгөн тэнгэр болон доогуур хөөв. Рогма гуа алтан дэлхий дээр бууж хийн жигзүрээр нисэв. Хар гэрт хааны хэр элээ сахиус нь Хар өргөн тэнгэр болон Алтан дэлхий дээгүүр хөв. Рогма гуа арга барж алтан ддэлхий дээр зургаан зуун чавганц оолон хцувилж суув. Шарайголын гурван хаан танин ядаж, билгийн цагаан морь танина гэж тэр морийг авч ирэв. Цагаан морь хүрч ирээд Рогмагийг дэргэд ирж энгэрийг нь татлан газар цавчилж байв. Рогма гуа аргаабарж бищеэр болон баригдав.

Шарайголын гцурван хан Рогмаг бариад Гэсэр хааны цагаан саваргыг аваад чандмань эрдэнэ, алтаар бичсэн ганжур, данжур хоёр их хөлгөн номыг, арван гурван эрдэнэт сум,, цавгүй хар нүүрс, эд бүгдийг бултэвдэж аваачив. Рогма гуа уйлж явж Гэсэр хааны нэгэн муу хүнийг дуудаж ирэв. “Гэсэр минь манарч унаж магадгүй Мангасаа ирсний хойно намайг аваачсан, аливаа бүгдээ үзэж үхэтхийн унах биз. Хамрын нүхээр ут!” гэж сормууснаас нэг хялгас сугалж авч өгөв. “аманд нь цутгаж өгөөрэй!” гэж нүднийхээ нулимс нэг шанаг авч өгөв. Чингэж өгөөд Рогма гуа төдий явав.

Гучин баатар байлдсаар амь үрэгдэв.

Барс баатар нь Цас Чихэрийг үдэж архидсаар байсан ажээ. Согтуугаар ганцаар гэртээ хүрч ирж Рогма гуаг алдсаныг сонсоод зэр зэвээ авч хуяг өмсөж Шарайголын гурван хааны цэргийн цавчилж алаад цангаж унав. Шарайголын цэрэг Барс баатарыг алаад явав. Гэс.эр хааны үзэсгэлэнт Мэргэн хиа Гэсэр хаандаа нэгэн хүчээ өгөхийн тулд бас хойноос нь орж таван мянган цэргийг алаад гарав. Амбарын хөдгүүн Банжур сонсоод ганцаар гүйцэж ирж оров. Барс баатартай адил олон цэргийг алж явтал Бүргэд хар түшмэл бэх хр морийг нь сумаар харвав. Банжур явгаар алалдаж нэгэн мянган цэргийг алаад цангж уна. Сүмбийн хөвгүүн Улааннүдэн сонсоод царын чинээ амаа ангайж, аягын чинээ нүдээ улаанаар эргүүлж ирээд цэргийн дунд олров. Мөн Банжурын адилаар алж явтал түүний унасан бөрт улаан морийг хятадын Дайван хааны хөвгүүн Мял гүнцог сумаар харвав. Улааннүдэн явгаар хатгалдаж нэгэн мянган таван зуун цэргийг хүнийг алаад цангаж унав. Амбадайн хөвгүүн Төмөр Хади гүйцэж ирээд орж арван таван түмэн цэргийг алаад цангаж үхэв. Их Паюу, бага Даюу, Их Хүрхрэгч, Бага Хүрхрэгч, онжин Даюу, Ронца эд зургуул гүйцэн ирж зургуул мянган цэргийг алж явтал Түргэн Бирвэаагийн хөвгүүн Бөх Цагаан Манлай зургуулыг гээгэ даран ирж алав. Бадмарын хөвгүүн Бам сорза даруй дэр гүйцэж ирж таван түмэн цэргийг цавчиж явтал МИон газрын хааны хөвгүүн Монса Түмсгэр сайн хөх морийг сумаар харвав. Бам Сорза явгаар хоёр мянган цэргийг алаад цангаж унав. Түүнээс бусад баатрууд нь сонсоод согтуугаар дэд дэдээрээ орж гцурван зуу, хоёр зууг алаад урьд хожид унацгаав. Гэсэр ханы Бутаг нэрт хувилгаан баатар нь гал тэнгэрийн хөвгүүн байсан ажээ. Морьтой дайсанп болбол эрдэнэт шанагаа барьж ирээд морин дээрээс шороо утгаж аваад цацахад бүх юм шатаж үнсэн товрог болох ажээ. Олон цэргийг тэр галаар ухруулж явав. Шарайголын хааны арваад сайн эр Бутаг баатрын өмнөөс нь гэтэж ирж харвая гэвч галын илч утаа хоёрт ойртож чадахгүй байв. Шарайголын гурван хааны цэргийг олныг алж, цөөхнийг явтал Бутаг баатар өөрийн галын илч утаа хоёрт цангаж унаад алагдав.

Шуумар, Нанчүн, Цас Чихэр нар алагдав.

Алива бүгдийг цөм дууссаны хойнол Эрдэнэт Нанчүн нарын нутаг нь хол байжээ. Шуумар сонсоод үхэх амь, үгйүрэх малаа хайхрахгүй авхиж ирээд эхэлсэн довтлохдоо таван түмэн цэргийг алаад гарав. Рогма гуа дайсны гарт орж явахдаа "Цас, нанчүн хоёр минь хүрч эс ирэв үү?" гэж дурдаж уйлж ийн тийн харж явав. Холоос Рогма гуа Шуумарыг дуудруудн : "Ай, Шуумар минь, энэ цэргийн дотор Хиллингийн гурван тэнгэр Гэрч цагаан тэнгэр дөрвүүл байна. Хүзч нь үлэмж их болболтой. Цас, нанчүн, Шуумар та гурвуулыг хүлээсээр байна. Шуумар минь нөгөө хоёр нөхрөө хүлээгээсэй" гэсэнд Шуумр өгүүлрүүн : "Эвүү Рогма гуа минь! Надад юу хална чи? Тэр муу гурван тэнгэрийн хүч нь их гэж айхгүй. Цэргийг зузаан гэж дуаатхгүй, Цас, Нанчүн хоёрын минь нутаг хол бишүү . Тэр хоёр минь иртэл нь энэ цэрэг холддох болно. Цас ,Нанчүн хоёр намайг зэмлэх болно. тэр муу Хиллингийн дөрвөн тэнгэрээс айхгүй би. Аргадаж суухгүй" гээд Шуумар хилэгнэж давхин довтлохдоо басхүү хоёр түмэн цэргийг алад гурван хааны зүг шургалж ороод Рогмаг булааж авад гарвал Хиллингийн гурван тэнгэр, Гэрч цагаан тэнгэр дөрвүүл угтаж ирээд рогма гуаг булаж авав. Шуумар тэр тэнгэртэй хатгалдаж явтал Солногосын хааны хөгүүн манцог Зул мод ташаалж ирээд Шуумарын хайсан хар морийг харваж рхив. Шуумар явгаар дөрвөн тэнгэртэй гурван өдөр гурван шөнө хатгалдаж хангай хар сумаа онилж харвавал гурван тэнгэр амьтны хэл мэдэх сумыг хувидгаанаар мэдээд биеэ ийн тийн зайлбал эрхгүй тэр сум нь Хиллингийн хар тэнгэрийн сугар нь шувт нэвтрэв. Хөндлөнгөөс нь өргөн тэнгэр бас Шуумарын хоёр сугаар гшувт харвав. Шуумар хиллингийн хар тэнгэрийн сугаар нь шувт харвав. Шуумар Хиллингийн хар тэнгэр хоёр хамт унавал Гэрч цагаан тэнгэр хар тэнгэрийн шарханд нь эм хийгээд эдгээв. Харн Шуумар үхэв.

Даруй дээр нанчин хүрч ирээд эхэлж доьлохдоо зургаан түмэн цэргийг алаад гурван хааныг шаррхуулж орхиод Рогмаг булааж аваад гарвал Хиллингийн гурван тэнгэр угтан ирээд хатгалдав. Тэр үед Гэрч цагаан тэнгэр огторгуйгаас нууж ирээд Рогмаг хулгайлан авч одов. Нанчүэ гурван тэнгэрийг харваж цавчилж, жадалсаар их цэрэгт нь бүр хорогдуулаад бас хүү рогмаг дахин булааж аваад гарвал мөнхүү гурван тэнгэр угта ирж үймтэл золголцов. Гэрч Цагаан тэнгэр Рогмаг мөнхүү урьд ёсоор хулгайлж аван одов. Эдүгээ Ннчүн Хиллингийн гурван тэнгэртэй хатгалдаж явтал нь Бүргэд хар түшмэл тарваганы хонгилд мярааж байгаад гүйлэн бор морийг нь харважэ орхив. Нанчүн явгаар долоон өдөр, долоон шөнө хатгалдаж явтал нь Нанчүн судл сүнсээ цөм автасныг тодорхой мэдэв. Дотроо сана сэтгэв : "Эдүгээ энэ дөрвөн тэнгэрээс чадвал хоёр, ядвал нэгийг албал нэрд минь хэрэгтэй билээ " гэж сана дөрвөн тэнгэрийн давхар харвавал гурван тэнгэр бүр зайлсан учир тэр сум нь эрхгүй Шар тэнгэрийг хоёр сугаар нь шувт харвав. Тэр тэнгэр түдэлгүй хамт унав. Огторгуйгас цагаан Гэрч тэнгэр хилэгнэж ирж Нанчүнгийн хоёр сугаар шувют харвав. Нанчүн унав. Гэрч цагаан тэнгэр, унасан тэнгэрийн шарханд яаран эм хийгээд эдгээв. Нанчүнгийн толгойг огтолж авья гэтэл гэнэт нэгэн их хуй мэт бара үзэгдэв. "Сайхь нүгэлт Цас айсуй" гээд яарч явав . нанчүнгийн тэргүүнийг авах зав болсонгүй .

Эрдэнэт Цасын нутаг нь Чацраганы гол өөд гурван Тулгатад байсан ажээ. Даруй дээр Цас сонсоод жигүүрт бор мориой унав. Зүйлэн хйсэн олон эрдэнэт чимгүүдээ зүү. Зоиглон нэхэж гагцаар явтал наян наст Царин өвгөн сонсоод заан шарга мориой унаад Цас Чихэрийг гүйцэ ирээд Цас Царгин хоёул Шарайголын гурван ханы мөрийг мөшгиж явав. Цас Чихээ хэлэв : “Эвүү, Царгин авгай минь Гэсэр хааны минь Улаан зүрлэг их хотоос наау Хатны голд хүртэл олон хонин дотор огтор азарган чоно орсон мэт алж хядаж байна. Чи билд хоёрын морь гэж тэсэж явна” гэв. Биш хүний морь энэ үхсэн хүмүүсийн дундуур явж чадахгүй шүү дээ. Хайран гучин баатар минь

Гэв. Уураа даран ядаж : “Авайг минь чи үүгээр явзана. Би очиж шарайголын гурван хааны цэргийг манай баатрууд хэдийчинээ олныг алж, хэдий чинээг үлдээж вэ ? Тоогий нь мэдье” гэж хэлээд Цас Чихэр явав. Ийн тийн харж энэ ч уулын оргил дээр, тэр ч уулын оргил дэр гарч, Гэсэр хаанаа дуудаж уйлж явна. Ариун түшэд тэнгэрийн хөвгүүн алтан дэолхий дээр алдаршин дуурссан арван зүгийн эзэн Гэсэр хан минь! Эвүү, яалаа! Хурмаст тэнгэрийн хөвгүүн хувилгаан Гэсэр минь ялаа Өндөр уулын оргилд явагч шар эрээн барс минь. Өргөн далайн ёроолд явюаг аврага загас минь . Ариун Түшээ тэнгэр нараас амлан дагуулж и ирсэн гучин батар чинь, алтан дэлхий дээр чуулган хийж байж аьсан Рогма гуа хатан чинь, арван таван насандаа дуурсан явсан Нанчшн чинь амраглан явсан эрдэнэт Цас Чиэхр чинь би энэлэн шаналан уйлана. Авай Гэсэр минь яалаа! Арван хоёр толгойтой мангас алав уу чамайг минь! Арлан гуа хатан чинь чамайг арга хийж авч суулгав уу? Огоргуйн олон сахиус бүгд нь эвүү яалаа! Гэсэр минь!” гэж аливаа бүгдээ тоолж магтан уйлж явтал Рогма гуа хувлганаар мэдэж хол газраас дуудаж зкарлиг болруун . “Хүний харцага болон Цас Чихэр минь! Мод хурагвал үндэс нь үлддэг бишүү. Хүн үхвэл үр нь үлддэг бишүү. Мод үндэсгүй хугардаг билүү ? Үхсэн гучин баатарыг юугаар эдгээх вэ? Дайсны аюул хүнд бэрх байна. Гэсэртээ очиж хэлээд хоёул ирж өшөөгөө аваасай ” гэв. Цас Чихэр Рогма гуад хэлэв: “Эвүү, үг хэлэцэх зуур чи Шарайголын гурван хаанд урвав уу? Рогма гуа чи эрдэнэт энэ нүүртээ эсгий хадаж Гэсэртэй золгох уу? Гэсэр минь ирээд Эвүү! Цас минь яалаа?” гэж асуувал би юу гэж хэлэх вэ ? Үхэх бие биз. Ямар сайхан амиа хайрлах вэ би ? гэв. “Цотон бий юу?” гэж асуув. Рогма гуа хэлэв: “Эвүү, Цас Чихэр минь! Тэр смуу Цотон та нараас айж Шарайголын гуран хааны газарчыг дагуулан түрүүлээд явсан ” гэв. Цас Чихэр Рогма гуатай яриад дараа нь Царгин авгайдаа ирж сонссон үгээ тоолж хэлэв: “Ай, авгай минь! Шарайголын гурван хаан цэргээс үлдсэн нь дөрвөн буманцэрэг байна гэнэ. Ай, авгай минь эр хүн залуудаа ыбиз. Ишигний мах халуунда биз. Довгольё” гэв. “Авай Цас минь! Өмнөх минь ойр боллоо. Хойдох минь хол боллоо. Өндөр уулын оргил дээр гарч харж явья, авай минь! Намайг хаана унавал тэнд ясыг минь оршуул. ” гэв. Царгин өвгөн бас хэлэв : “Эвүү, Цас Чихэр минь! Зуланд унаж үхэх эрвээхэй билүү? Зуны зутраг хярунд дайрагдаж гандах тариа билүү? арван зүгийнэзэн Гэсрэ минь золгож Шарайголын гуран хааныг алж өшөөгөө авч хариасай, авай Цас минь гэж уйлж байж хэлэв.

Цас чиэхэро хатуужин байж хэлэв: “ Авгай минь! Айвй уу чи? Оолон үгээр яана ? Явья” гэж жигүүрт бор морио тас гуядаж хурми ирт нэрт цул бод илдээ суга татаад гүр хар чулуунд хоёр гурвантаа харвиулж нударч авав. Хиллингийн гурван хааны мөрийг мөрдөж Хатны голыг өөдөлж Шарайголын гурван хааны цэрэгт зүүн хойноос нь очиж оров. Түрэн фцавчихдаа сайн хадсан тарианы түрүү мэт болгож явна. ХАТНЫ ГОЛЫГ үхсэн хүнээр дзүүрэж явав. Хүний цуёанд гол улаанаао урсав. Гуран үе дайрч долоон түмэн цэргийг алж баруун тийш гарав.

Царгин, Цас Чихэр хоёул эргэж ирэхдээ нэг түмэн цэргийг алж ирэв. “Ай, Царгин авгай минь! намайг юунд ир гэв? “Авйа минь, энд тав зургаан өштөн сайн эр явна. Нэгийг нь чгэсэн ал” гэв. Цагаан гэрт хааны отгон дүү Шамба Мэрцз билгийн цагаан морио унаж, өвч хуяг дулгаа өмсч Цасыг угтав. Цас хоёул зөрчилдөв. Цасын жигүүрт бор морь, Шамба Мэрузын билгийн цагаан морь тэр хоёр морь бөл төрөл байжээ. Хоёр морь танилцаж хойшоо ухралдаж байв. Цас илднийхээ үзүүрээр дохиод хүрэхгүй байв. Цас тэгэхлээр зүүн гартаа илдээ аваад, нумны хөвчийг төс цавчаад гарав. Мөртөө тохиодлсон нэг түмэн цэргийг алж гарав. Шарайголын гурван хаанас Цас ганцаар нэг буман цэрэг алав. Олон цэрэг цавчсаны тулд ундаасаж Хатны голоос усыг уув. Цэст усанд сонтож унав. Шамба Мэруз мод ташаалан (Нууж) ирээд Цасын толгойг тас цавчиж алав. Гурван хаандаа толгойгий нь аваачиж өгөв. Рогма гуа Цассын толгойг үзээд өвчүүгэ дэлдэж, элгээ тэвэрч уйлаад Шарайголын гурван хаанаас Цасын толгойг гуйж аваад тэвэрч уйлав. “Арван зүгийн эзэн арван хорын үндэсийг таслагч Авай Богд минь ялаа! Дээд хурмаст тэнгэрийн хөвгүүн билээ л. Дагуулж ирсэн Цас Чихэр чинь үхэв бишүү., авай минь! Эвүү, Цас минь Дээд биенд чинь дөрвөн их тэнгэр нар төгсөж билээ л. Дунд биенд чинь сав ертөнц төгсөж ирсэн билэ л. Доод биенд чинь цаган Лусын хаан төгсөж билээ л. авай минь! Эрдэнэт Цас Чихэр минь ” гэж уйлж явав. Рогмаг уйлж явгал Цасын толгойг Шарайголын гурван хаан булааж авав. Рогма Цасыг хувилганаар эдгээе гэж үхсэн олон цэргийн хүнээс шархгүй хүнийг эрэв. Нэгч шархгүй хүн эс олдов. Булт шархтай байв. Цасын цавчсан цэрэг байна. Нэг харцыг олж Цасын сүнсийг тэр харцаганд юүлэв. Шарайголын гурва хааны цэргийн хүн бүрээс нэжгээд сумыг авч Цасын махбод биеийг дэгдээв. (шатаав).

Рогма гуа Гэсэрт захидал илгээв.

Рогма гуа Цасын нэгэн суманд бичиг бичив. Бичихдээ : “Арван зүгийн арван хорын тасалсан ачит Богд Гэсэр мэргэн хаан минь! Үхэв үү чи? Үхэх чинь тэр билүү ? Хэрвээ үхсэн бол яана би ? Амьд болбол зургаан насанд дээр учирсан Жало ханы охин Рогма гуа минь би, Цас Чихэр тэргүүлэн гучин баатар чинь арван гурван эрдэнэт сүм чинь цагаан суврага, чандмань эрдэнэ чинь, алтаар бичсэн Ганжур, данжур хоёр их хөлгөн ном чинь эд бүгдээсээ хагцав уу Гэсэр минь ? Тулалдаж үхэв гучин баатар чинь. Уулганд дайрагдаж баригдав би Рогма гуа чинь. Ай богд минь! ирж өшөөгөө ав” гээд сумаа хувилгаанаар илгээв. Илгээсэн сум нь Гэсэрийн суух мангасын хотонд Гэсэрийн ховдонд тусав. “Эвүү, ховд минь юунд хангир хийнэ ? Арлан гуа ховдыг минь өг ” гэв. Арлан гуа ховдыг өгөв. Гэсэр хаан ховдоо нээж үзээд. Үзээд Цасын сумыг авад танив. “Эвүү, эвүү! Энэ Цасын минь сум байна. ” гээд бэлэг бичгийг үзэв. “Үнэхээр Рогма гуа минь, эрдэнэт Цас Чихэр, гучин баатар минь, эд бүгд минь бий билээ. Би яагаад мартав ? Тэд бүгдэд минь дайсан ирээд байна. Над хэн хүн халдсан болбол түүний элгэнд нь тус гээд сумыг зүлгэж гэдрэг илгээв. Гэсэрийн илгээсэн сум нь Цагаан гэрт хааны Эрх хатны элгэнд тусав. Хатан нь үхэв. Гурван хааны цэрэг бүгдээр хэлэлцэв. “Дээд хөх огторгуй, дунд Асур нар, доод Лусын хаад, тэдний сум болов уу? Эс бол Арван зүгийн эзэн Гэсэр хааны сум болов уу? ” гэж айж дутаав. Рогма гуагийн дотор баясах сэтгэл төрж . Арван зүгийн эзэн Гэсэр хаан минь амьд байна. Илгээсэн сум минь нэгэн өшөө хүнд тусаж алав.

Рогма гуа, мөн тэр суманд бас бичиг бичив. Бичихдээ : “Чамайгаа Хтаны гол дээр ?сөн сар болтол хүлээсүү би. Есөн сар болтол эс ирвэл би Цагаан гэрт хааны гэргий болно ” гэв. “авай богд минь!” гээд сумаа илгээв. Лгээсэн сум нь Гэсэрийн ховдонд тусав. “Ховд минь юу гэж хангис хийв? Ховдыг минь өг” гэв. Арлан гуа вч өгөв. Гэсэр үзээд Цасын сумыг танив. “Эвүү тэр өдрийн ирсэн сум мөн . Эвүү өчнөөн болтол яагаад мартав би? Над хэн хүн халдсан болбол түүний элгээр нь тус гээд илгээв. Сумыг илгээсний хойно Арлан гуа : “Аюух мэт богд минь, өлсөв үү?” гээд мартуулах б агт нэрт идээг өгөв. Илгээсэн сум Цагаан гэрт ханыг үхрийн чинээ гүс хар чулуун дээр сууж байхад сүнгэнэж ирэхийг сонсоод : “Аюух мэт Гэсэр богдыг тахья би” гээд аяган дахь сумыг цайгаа сумны өмнөөс сацав. Гэсэр бурхан мөн тул сум үхрийн чинээ гүр хаданд тусав. Онъ нь арайхийн барьж сугалж цөхөв. Шарайголын гурван хаан бүгдээр ирэв. Ониноос нь барьж сугалж цөхөв. Өднөөс нь барьж сугалж цөхөв. “энэ сум хэнийх болов ? Арван зүгийн эзэн Гэсэр хааны сум болов уу? ” гэж урьд ёсоор айж нүүв. Рогма гуа ирж : “Аюух мэт богдын минь сум болбол хувилгаан сум бизээ. Уужинд минь сугарсан гарч ир. Биш болбол байг” гэд хэдыг нудран гарахад Гэсэрийн илгээсэн цаёынсум Рогмагийн уужны хормойд сугарч ирэв. Рогма гуа хэлэв : “Авай богддоо аль бүр илгээх вэ би?” гэж сумаа илгээхээ байв. Тэр хувилгаан сум нь хий хар салхиар өөрөө огторгуйд дэгдэв.

(Тэндээс Шарайголын хаад эргэж ирээд Төвд оронд гурван сар суув. Гэсэр богдын мянган таван зун хүн багтах ордон цагаан гэрийг Цотон нонд өгөв. Дос, Донсар, Лин гурван отог улсыг дөрвөн хошу мал, аливаа хамаг сайн бүгдтийг Цотон ночн авч Гэсэр богдын суух улаан зүлгэн дээр гурван өдөр гурван шөнө болтол их хурим хийж Төвдийн Цотон хаан гэж цол дуудав. “Бидэнд жил бүр алба хүргэж өөрийн биеэр ирж яв” гэж Шарайголын хад хэлэв.

Төдий Рогма гуа хатныг Цагаан гэрт хаан өөрийн биед авав. Рогма гуа, Хатны голд хүржжд худлаар аргалж “Маш их өвдөв” гэж идээ идэхгүй есөн сар болтол эс нүүлгэж суув. Гэсэр богд Ракшасынд оронд гэрээ мартсаар сууж эс ирэв. Рогма гуа есөн сар болтол Гэсэр богдыг хүлээж ядаад “Өвчин минь эдгэв” гэж Шарайголын Цагаан гэрт хаантай хамтаар явав.

Төдий Цагаан гэрт хаан, Хар гэрт хаан хоёул ийн өгүүлрүүн : “Гэсэр хэрэв амьд болбол ирэх магадгүй . Харуул тавья” гэлцээд гурван сарын газрыг үзэх нэг хүн үзсэнээ харваж үл алаж нэг хүн сүүдэрт харваж үл алдах нэг хүн, ийм гурван сайн хүнийг “Гэсэр ирвэл алалдаж үз. Үгүй бол бидэнд хэл оруулж үз” гэд Хатны голын эхэн дээр харуул тавиад нутагтаа харив.)

Гэсэр хаан хотын асар дээр гарч нойрсов. Үдэд сэрж суутал Гэсэрийн ялгуусан гурван эгч нь хоёр эмгэн, нэг үнээ болж хувилаад хотоын доогур явав. Нэг эмгэн нь үнээгээ хөтөлж, нөгөө эмгэн нь хойноос нь тууж явна. Тэр эмгэн нөгөөгөө дуудаж асуув. “Ай эмгэн минь! Энэ үнээ чинь хөгширөв үү? Эвэр нь яагаад хувирав. ?” гэж асуув. ЭМгэн хэлэв: “Энэ үнээ минь хөгширч мунажээ . Гэсэр хааныш ирэхэд тугал байсан, Гэсэр хаан ирсээр е?сөн жил болов. Одоо үүнийг хөгшрөх зөв” гэв. Гэсэр хан тэр үгийг сонсоод зарлиг болов : “Эвүү, яасан жиг билээ. Яагаад мартлаа би. Есөн жил болов гэгч юу вэ ?” гээд арван зүгийн эзэн Гэсэр хаан гэртээ очив. Арлан уг хэлэв : “Бас аюух мэт богд минь өлсөв үү?” гэж хэлээд урьд өгсөн баг идээгээ өгөөд мартуулав.

Гэсэр хаан хойд өдөр нь бас хотын асар дээр гарч суул Гэсэрийн Амин сахигч ах нь хэрээ болж хувираад очив. Үдийн цагт баруунтаагаас нэг хэрээ нисэж айсуй. Арван зүгийн эзэн Гэсэр хаан тэр хэрээг үзээд угтаж зарлиг болов: “Ай хөөрхий, энэ хэрээ нутгийн баас, шээс, тэмээний даарь, бээр олж идье гэж яарч явна” гэв. Хэрээ хэлэв : “Арванг зүгийн эзэн Гэсэр хааны энэ зарлиг зөв төрсөн газар минь, хотын зүүнтэйх суврага билээ. Баруунтаа идээшлэхээр очиж билээ. Би идэш олоод хоносон газраа хоноё гэж ирэх минь энэ. Энэ Замбутвийн эзэн Гэсэр хаантай адил амандаа шавар чихүүлсэнгүй. Төрсөн Төвдийн газар чинь, хувилгаанар авёан рогма гу чинь энд бий юу? Рогма гуа хатан чинь, Цас Чихэр тэгүүлэн гучин баатар чинь, эрдэнэт Нанчүн чинь, тэд бүгд чинь хаана байна ? Эд бүгдийгээ алуулахыг алуулаад вахуулхыг нь авахуулаад, ай намайг элэглэвч гайгүй ажээ.” Гээд нисэж явав. Гэсэр хаан зарлиг болов : “Эвүү, хэрээний үг үнэн байна. Арлан гуа хэлэв : “Аюух мэт богд минь өлсөв үү?” гээд баг идээгээ өгөөд мартуулав.

Түүний марааш нь Гэсэр хаан бас хотын асар дээр сууж байтал Гэсэрийн анд гурюн тэнгэр, гурван үнэг болон хувилаад гүйж ирэв. Гэсэр хаан угтан байж, зэрлиг болруун : “ Ай хөөрхий. Энэ үнэг нутгийн шир хярвас олж идье гэж эрж явна” гэв. Үнэг урьд хэрээний үг мэт тоолж хэлээд явж очив. Гэсэр хаан зарлиг болруун : “эвүү, юу гэж мартаж болов би?” гэж гэртээ гүйж оров. Ардан гуа : “Аюух мэт богд минь өлсөв үү” гэж мөн рьдах идээгээ өгөөд мартуулав.

Төдий Царгин, Сэнлон, Цас Чихэрийн хөвгүүн Лайзав, Үзэсгэлэнт мэргэн хиа энэ дөрвүүл өнөдр уулын оргил дээрх гарч, арван зүгийн эзэн Гэсэр хаанаа дурдаж уйлж суутал Гэсэр

хааны гурван эгчийн сахиус нь гурван тогоруу шувуу болон ирж огторгуйгаар эргэж үзэв. Царгин, Сэнлон, Лаызав, үзэсгэлэнт мэргэн хиа дөрвүүл уйлж дууссаны хойно Үзэсгэлэнт мэргэн хиа хэлэв: “Эвүү, эвүү! Энэ хувилгаан тогоруу шувуу байна. Маныг уйлахад уйлан эргэлдэв. Эдний дуу нь энэлгээтэй шаналгаатай нь юу вэ ? ” гэв. Цас Чихэрийн хүү Лайзав тогоруу шувууг магтан уйлав. “Эвүү, арван зүгийн эзэн арван хорын хорын үндсийг тасалсан авай Богд минь! дээд биед чинь арван зүгийнбурхан тэгссэн билээ, Дунд биенд чинь дөрвөн их тэнгэр нар төгссөн билээ. Доод биенд чинь дөрвөн их лусын хаад төгссөн билээ. Нэг хувилахдаа мянга таван зуун хувилгаанаар хувилдаг гэлээ. Аль хувилгааны тогоруу болов ? Эвүү ялаа. ? Нааш өршөөн ирээсэй чи ” гэж мөргөв. Жамцо Дари Оддам нэрт эгчийн нь хувилган тогоруу бууж ирж дэргэд нь суув. Үзэсгэлэнт мэргэн хиа тэр тогоруунаас асуув. Догоруу дуу эс гаргав. Дөрвүүл хэлэлцээж энэ тогоруунаас юу асуух вэ. аль аль бүгдээ булт тоолж бичив. Аливаа авсан алдсан бүгдээ булт тоолж бичив. “Эвүү, Гэсэр хаан минь үхэв үү, яав ? Хэрвээ үхээгүй бол энэ бичгийг минь түүнд өгөөрэй . Тэр минь мэднэ ” гэв. Тогрууны хүзүүнд уяж өгөв. Төдий тэр тогоруу нь явав. Тэр тогорууг явуулаад дөрвүүл хэлэлцэж : “Эвүү, энэ тогоруу богдын минь хувилгаан тогоруу байсан аж ” гэж дурьүүл хэлэлцэж байв.

Тогоруу төдий явж Гэср хааны суух хотод хүрэхэд Арлан гуа Гэсэр хаан хоёул хотын асар дээр сууж байв. Арлан гуа Гэсэр хааныг гарвал гарч, орвол орж Гэсэрийн нутагаа санахыг мэдэж гэтэж явах жээ. Тогруу огторгуйгаар эргэцэж явах зур санав. “Энэ чичгийг минь и Арлдан гуа үзэх байх Гэсэр хааныг минь Арлан гуа арга хийж үл явуулах байна. ” гэж мэдээд хувилгаанар мөндөрт бороо оруулав. Арлан гуа бороо орход гэртээ гүйн рхж. Гэсэр хаан өвөр дээрээ унасан рашааны нэгэн мөндрийг авч залгиад баг идээгээ бөөлжив. Тогоруу шувуу Гэсэр хааны дэргэд суув. Гэсэр хаан: “Эвүү, энэ тогоруу миний Төвдийн газрын тогоруу мэт юу билээ ? Яасан жигтэй тогоруу болов чи? ” гэж тогорууг дуудав. Тогоруу ирээд хүзүүн дэх бичгээ орхиж өгөөд явж одов. Гэсэр хаан бичгийг үзээд : “эрдэнэт Цас Чихэр, гучин баатар Рогма гуа гэж бий билээ л. Би яаж мартлаа ? ” гэж дуу гаран хайлав.

Гэсэр ханы билгийн хээр морь нь Гэсэр хаанд аливаа юм тоолж хэлэхийг нь Арлан гу мэдэж арвай буудайгаар аргадан тэжээж их мухар битүү байшинд оруулж төмөр өдрөөр чөдөрлөж төмөр ногтоор ногтолж, аврага модоор уяэ зарим өдөр өвс ус өгч зарим өдөр хоосон хорьж байв. Гэсэр хааныхан үйлах дууг сонсоод билгийн хээр морь уураа багтаан ядаж төмөр чөдрөө тас тийрч, төмөр ногтоо тас татаж, битүү байшингийн хаалтыг хага түлхэж гарч Гэсэр гүйж очиж уйлан үг хэлэв. “Рогма гуа хатан чинь, эрдэнэт Цас чихэр ах чинь, гучин баатар чинь, эрдэнэсээр бүтээсэн сүм хот яинв эд бүгдээр чинь му боллоо. Одоо хаана очье гэж уйлна чи ? ” гэж хэлэв. Гэсэр хаан зарлиг болов. “Авай билгийн хээр морины минь үг зөв. Билгийн хээр морь минь нааш ир. ” гэв. Билгийн хээр морь нь далд орон явав. Гэсэр хаан гэртээ гүйн орон Арлан гуад хэлэв: “Жигтэй бачигт эм! Шүүдрийн гилбэлгээн өнгөт дуулга, эрдэнэсээр давхарлан хийсэн хөө хар хуягийг минь өг. Хамаг эрдэнэт зэр зэв минь хана байна ? ” гэв. Арлн гуа нь : “Эвүү! Чи нмайг мангастай адил жигтэй эм, бачтэй эм гэх чинь юу вэ ? Төвдийн газраас хамуут хээр даагаты ирсэн хатсан муу хүн чамайг ирэв гэж учирсэн мангас эрээ аллаа. Чамайг сайн эр байна гэж авлаа би” гэж уйлж байв. Гэсэр хаан билгийн хазараа аваад “Билгийн хээр морь минь наау ир ” гэж дуудаж явав. Билгийн хээр морт нь эс ирэв. Гэсэр хаан ялгуусан гурван эгчээ залбиран хайлав : “Билгийн хээр морийг минь олж өг эгч минь 6 гэв. Жамцо Дари Оддам эгч нь дээр огторгуйгас зарлиг болов. ” “Авиа нусгай минь! Билгийн хээр морь чинь амд уурлаж ирэхгүй байна.и Шулмасын энэ Дармадай нэрт бор

морийг унаж оч. мөр дээр чинь олон хулан чихтий байж баригдах бий ” гэв. Гэсэр хаан Дарамдай мэт бор морийг хөтөлж ирэв. Сан тавьж огторгуйн олон сахиусаа залбирав. “Хамаг сахиус минь дэд дэдээр айлдан ёсоёрх . Би тандаа сан тавьж залбирав. Би хар стэгэлт мнгасыг алья гэж ирж билээ. Хар сэтгэлт мангасыг алсан би. Хайрт Цас Чихэр, гучин баатарт минь дайсан ирж гэнэ. Над халдсан дайсныг нэхье би. Та минь надад модтын нэг мод аргалтын нэг морины хэлтэрхий хомоол нэжгээд нэжгээд өг! олон сахиус минь! Өршөөт адисны хотыг түймэрдээд явья би ” гэв. Олон сахиус нь өршөөн соёрхож Гэсэрийн зарлигаар тэд бүгдийн өг гэсэн түлээг булт цөм дэд дэдээр буулгаж өгөв. Гэсэр хаан төдий шулмасын хотыг их түймэр тавин түймэрдэв. Түймэр хүрч ирэхэд Арлан гуа Гэсэр хааны нуусан зэр зэвийг булт гаргаж өгөв. Гэсэр хаан зэр зэвэ аваад зарлиг болов : “Ай! өчнөөн есөн жил болтол суусан минь үнэн байна” гээд “Хуяг зэр, зэв минь зэвэрч” гэж моринб хөх хомоолоор зүлгэ өнгө гаргав. Мангасын Дармадай бор морио унав. Шулмасын аливаа амьтны сүнсийг нь хувилганаар хоёр имди (цагаан хөлт) бор моинд ачив.

Арлан гуа хатнаа ван арван зүгийн эзэн, арван хорын үндсийг тасалсан ачит богд мэргэн хаан ахуй бүх нутгийн зүг залран явав. Явж байтал мөр дэр нв олон хулан чихтий дайралдав. Гэсэр үзээд хэлэв : “Мангасын есөн хотонд есөн жил болтол сууж дал мөр минь хөшсөн болов уу?” гэж “Энэ чихтийг намная” гэж Дармадай бор мориор зэрэгцэн довтлов. Чихтийтэй зэрэгцэн явтал чихтийн хойноос нэгэн их бараа дагаж хүрэв. Гэсэр хаан тэр барааг үзээд “Энэ яасан жигтэй бараа болов ? ” гэж санан очиж үзбэл билгийн хээр морь нь байсан ажээ. Гэсэр хаан билгийн хээр моринд зарлиг болов : “Ай, билгийн хээр морь минь! бид хоёул олон чихт хуланг намная . Чи унуулахгүй болбол дөрвөн тавгийг чинь тас харваад явах би” гэж зарлиг болв. Билгийн хээр морь гүйж ирж Дармадай бор морины дэл дээгүүр толгой тавин үг хэлэв: “Гэсэр богд минь, түр түүж айлан соёрх! Чамайг ракшасын оронд есөн жил болтол суух цагт хорь Шарайголын гурван хаан ирэв. Арван таван настай Эрдэнэ эрхтНанчүнг үхсэнд чоно хэрээг хөөж ясыг сахиж байгаад Рогма, Цас хоёрыг ирэхийг үзээд огторгуйд гарч очлоо би ” Рогма гуа миний эмээгийн өнгөтэй болтугай гэж ханхлй нэрт магнаг торгоор олбог (олонцог) хийнэ билээ. дулаан болтугаы гэж булгаар доторллож тохон хийнэ билээ. Зөөлөн болтугай гэж мяндасаар гөрж олом хийн билээ .Гэрэлтэй болтугай гэж алтаар горх хийж билээ. Өдлийн өдпөр хүйтэн гэж булгаар нэмнэж, арвай буудайгаар гурван үе бордоно билээ. Зуны өдөр сүүдрт уяж, үдийн халуунд рашааны усаар усалж үлэмж хүний идэх чихэр, чавгаар бордоно билээ. Адуусан төрөлтэй гэж үдэш нь сйн өвсөнд гаргаж идүүлнэ билээ. Би Рогма гуа, Цас Чихэр тэргүүлэн гучин баатр эд бүгдээс чинь хагацав. Арлан гуа чинь намайг мухар р хүрээнд оруудж хорьж зовоосонд уйлах минь энэ” гэв. Гэсэр хаан зарлиг болов : “Билгийн хээр морь минь чиний зөв” гэж арвай буудайгаар гурван үе бордож унав.

Унаад явтал мөр дээр нь орд цагаан гэр байв. Түүний гадна нэгэн үзэсгэлэнт эм байна. тэр эм угтан ирж хэлэв: “Арван зүгийн эзэн аюух мэт Бонд мэргэн хаан бууж шөл цай зооглож морд” гэв. Гэсэр хаан арлан гуад зарлиг болов : “Арлан гуа чи үгээр шууд яв. Би бууж энэ эмийг шөл цайг зооглож мордьё” гэж тэр эмийн гэрт буув. Тэр эм Гэсэрийг харж суутал эвэрт цох хар хорхой анжис хөллөж гзар хагалаж тариа тариад, арвай буудайг ургуулж, хадаж авад тогоонд хуурч нэгэн тамгатай боов хийвэ. Нэгэн тамгагүй боов хийгээд хоёр аяганд хийж тамгатай боовыг Гэсэр хааны өмнө тавив. Тамгагүй боовыг өөрийн өмнө тавиад гарч явав.

Гэсэр хааны ялгуусан гурван эгч нь нэгэн хөхөө шувуунд хувилж ирээд тоонон дэр нв суугаад зарлиг болруун: “Ай нусгай минь! чи мэдэв үү? Энэ муу эм чамд юу гэж идээ өгөх вэ? Хор хольж өгнө ” гэв. Тэр эвэрт хорхой нь эр нь бишүү. Тэр муу аван хоёр толгойт мангасын авга эгч нь мөн гэв. Гэсэр хаан тамгатай боодыг эмийн өмнөх аяганд хийгээд тавив. Эм орж ирээд Гэсэр хааны үл идэхийг үзээд эм гурван алд хар таяг модоо барьж иээд : “Сог сог” гэж Гэсэр хааныг “Юу гэж сууна вэ? Өмнөх идээгээ зоогло ” гэв. Гэсэр хаан тамгагүй боовыг аваад зооглов. Гэсэр хаан хэлэв: “Ай, эм! Идээгээ ид” гэв. Тэр эм боовын тамгыг үзсэнгүй идэв. Тэр эм “Сог сог” гээд Гэсэрийн толгойг гурван алд хар таяг модоор гурван үе дэлдэв. Гэсэр хаан бас эмийн таягийг булааж аваад “Гүр сог сог” гээд эмийн толгойг гурван үе дэлдэв. Эм илжиг болов. Гэсэр хаан илжиг, эвэрт хорхой хоёрыг хөтлөн аваачиж Арлан гуа хатны өмнө их түлээг хураагаад түймэрдэв. Түймэрдэхэд нэгэн үе хүн болоод бархирав. Нэгэн үе илжиг болон янцгаана. Тэднийг эрхгүй хуйхалж шатааж алж орхв. Гэсэр хааны сахиус нь туслаж манасын үр лүндсийг таслав.

Гэсэр замдаа Сахилдай баатартай уулзав.

Таслаад явтал орог нэрт улсын Сахилдай, ухаа морио унаж хошуут сумаа дүүрээд бардан дуулж явна. “Би эдүгээ болтол хүнээс айж үзээгүй. Энэ газар нмайг айлгах хүн байхгүй ” гэж явав. Гэсэр хаан бодов. “Эвүү! эвүү Энэ хэн болов ?” гээд модон дотуур нууж очоод билгийн хээр морио моднод нууж уяв. Их сумаа онилж ирээд зам дээр нь нуугдан суув. Сахилдай хүрч ирэв. Гэсэр хаан хашгиран босон харайн нум сумаа дэлэв. Сахилдай үзээд айж дутаав. Гэсэр хаан Сахилдайг таниад : “Эвүү Сахилдай нааш ир” гэж дуудав. Сахилдай хойшоо харж үзээд. “Эвүү хол бай! Нүгэлт Гэсэр хаан байсан ажээ .” гээд Гэсэр хаанд ирж мөргөн золгов. Гэсэр асуув: “За чи Өнөө энэ газар дээр намайш айлгах хүн үгүй гэгч чинь юу вэ ? Одоо чи надаас юу гэж дутаав чи ?” гэв. Сахилдай хэлэв: “Хэлсэн үг чинь үнэн билэ. Чамайг эс мэдэв би” гэв.

“За явъя ” гээд хоёул явав. Сахилдай хэлэв: “Гэсэр хаан чи өнөө намайг нэг айлгав. Одоо би чамайг нэг айлгая” гэв. “Айлгахдаа уруу хөөж худрагыг чинь таслая. Өөд хөөж хөмөлдрөгийг чинь тасалъя. Хөнлөн хөөж олмыг чинь таслъя. ” гэв. Гэсэр хаан зарлиг болруун: “Сахилдай! тэр үг чинь зөв ” гээд хоёул явав.

Сахилдай хэлэв : “Гэсэр чи бид хоёул замд ханилж явахдаа хоосон явах уу? Нэгэн улст халдаж адууг хөөж ирье” гэв. Гэсэр зарлиг болруун : “Сахилдай тэр чинь зөв” гэж хоёул Сав нэрт улсын адуун хөөж ирэв. Сав нэрт улсын Ронца нэрт хүн сайн хар морио унаж, хатгуурт сумаа дүүрч, чулуун хуягаа өмсөж нэхэн гүйцэж ирэв. Схилдай : “Би угтъя” гэв. Аюух мэт богд зарлиг болруун: “Чи байг би угтъя” гэв. Хоёулаа булаалдав. Арлан гуагаар шавга татуулья гэж шавгаа өгөв. Арлан гуагийн орхисон шавга Сахилдайд гарав. Сахилдай угтав. Сахилдай угтахад Гэсэр зарлиг болов. “Сахилдай чи мэдэхгүй : Энэ сав нэрт улст сайн эр үгүй. Миний мэдсэнээр бол ганцхан Ронца нэрт хүн бий. Тэр хучг болбол чи харваж цавчиж үл даалгах буй. Эмээлийн бүүргийг нь чиргүүлж харва. ДАвсгийг нь даана” гэв. Сахилдай Гэсэрийн тэр зарлигийг сонсоод “Зөв” гэж айлтгаад бууж дөрөөгөө гурван барим охор болгож св. Ронца гүйцэж ирэхдээ Сахилдайгаас дээгүүр нэг харав. Хойшоогоо нэг харав. Баруун тийшээ нэг харав. Зүүн тийшээ нэг храв. Морио тас гуядаж эрхгүй гүйцэж ирэв. Доошоо нэг харав. Ронца буув. Сахилдай хэлэв : “Хоёулаа наадахаа дөрөөгөө охор сааж наадъя” гэв. Ронца : “Энэ намайг хуурч байна” гэж дөрөөгөө гурван барим урт болгож мордов. “Чи хэнийх вэ ? ” гэв. Сахилдай хэлэв : “Би Орог улсын Сахилдай ” гэв. “Чи хэнийх вэ ? ” гэв. “Сав нэрт улсын Ронца би” гэв. Сахилдай асуув : “Дээгүүр минь харах чинь юу вэ ? Зүүн тийшээ харах чинь юу вэ ? Баруун тийшээ харах чинь юу вэ ? Зүүн тийшээ харах чинь юу вэ ?” гэв. Ронца хэлэв: “Дээгүүр чинь харж олон цөөхнийг чинь тэнссэн минь тэр. Хойшоогоо харж хойд нөхдөө тэнссэн минь тэр. Баруун зүүн тийш харж хатгуурт сумаа олон цөөхнийг, нцмныхаа хатуу зөөлөнг тэнссэн минь тэр. Доошоогоо харж хар мориныхоо хашин хурдыг тэнссэн минь тэр” гэв. “За адууг минь авч биеийг минь алх хүн, чи харва” гэв. “Адууг чинь авсан үнэн. Адуугаа авъя гэх бол чи харва Айх болбол харь” гэв. Ронца нумаа дэлэв. Сахилдайн эмээлийн бүүргийг чиглүүлэн харвав. Дөрөөгөө охор саасны тулд дээш өндйж орхив. Эмээлийн бүүргийг шувт нэвтэрч сум нь Сахилдаан салтаан доогуур хангинан гарч явав. Сахилдай хэлэв : “Одоо хишиг над болов уу? ” гэв. “Доогуур харваж морийг нь онож хилэнц болгох хэрэггүй. Бүсний гархийг чинь чиглүүлж харвавал элгийг чинь шувт гарна. Дээгүүр чиглэж харвавал өнгөлзүүрт чинь тусаж чамайг ална. Тэр хоёрын хоорондууо эмээлийн бүүргийн муу модыг

харвая. (Модыг харвахад хилэнцгүй)гээд бүүргийг чиглүүлж дэлэв. Ронца дөрөөгөөр урт болгосн тул өндийж эс чадав. ДАвсгаар нь шувт тусав. Ронца саадагнаасаа нэг сум суга татав. Махилдай хуурч хэлэв: “Сайн хүн болбол ганц суманд үхэхгүй, довтлон явж харвана.” гэв. Ронца довголж хрвах гээд шархаа даахгүй өнгөрч унав. Сахилдай Ронцыг алаад хар морийг нь унаад чулуун хуягийг нь өмсөөп саадгийг нь бүслээп өөрийн зэр зэвээ ухаа мориндоо ачаад Гэсэрийн хойноос явав.

Сахилдайг омогшуулья гэж Гэсэр бор мориой унаад, муу эмээд хазаараа тохож явна. Сахилдай гүйцэж ирээд ронца мэт болж хэлэв : “За Орог улсын Сахилдайг алж хамаг зэр зэвийг нь авя ухаа моринд нь ачла а би. Одоо Гэсэр хааныг алж өилгийн хэр морийг авья” гээд хуягаа хангинуулан хашгиран дайрав. Гэсэр дутаав. Өөд хөөв. Хөмөлдрөг нь тас үсрэв. Уруу хөөв Худрага нь тасрав. ХӨндлөн хөөв Олом нь тасрав. Гэсэр бууж гүйгээд улаан ухай царайтай хүү болоод их сумаа дэлж байха Сахилдай хэлэв “Өө! Би байна! Гэсэр гэж бархирав. Гэсэр хэлэв : “Чи намайг нэг айлгасан. Би чамайг нэг айлгав. Хэлснээрээ болв бишүү. бид ” гэв. Гэсэр хэлэв : “ Миний айсан үнэн. Улаан хонгор царайтай хүү болоод их сцма дэлж байхад минь “Би Сахилдай байна” гэж бархирсан чинь бас айсны шинж биш үү? ” гэхэд Сахилдай буруу харж инээж байв. Олон адууг хувааж аваад нутаг нутагтаа явав .

Гэсэр нутагтаа ирэв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан Нолом талд хүртэл мөр дээр нь нэгэн орд цагаан гэр байв. Гэсэр богд гэрийг үзээд зэр зэв бүгдээ авч хуяг дуулгаа өмсөөд үүдэнд нь очив. (Нэгэн эм хүн ,Гэсэр хааны Ажу мэргэн хатны гэр) гэв. Хүү өгүүлрүүн : “Арван зүгийн эзэн Гэсэр хааны Ажу мэргэн хатны гэр гэв. “Эх чинь гэртээ бий юу ? ” гэв. “эжий минь гэртээ байна. Эжий минь Хэдрэг хартай ноцолдож байна. Нэгэн үе Хэдрэг хар дийлнэ. Нэгэн үе эжий минь дийлнэ” гэв. Гэсэр хүүд зарлиг болруун “Авай, намайг баруун тийш очлоо гэж хэл. Энд байзнавал намайг саатуулах болно. Өшөөт дайснаа яаралтай нэхье би” гээд зүүн тийш дугаав. Ажу мэргэн нумаа хөвчиолж, сумаа онилон гарч хүүгээс асуув: “авай өнөөх хүн хашаа явав” гэв. Хүү хэлэв: “Баруун тийш явав” гэж. Ажу мэргэн баруун тийшээ харвал бараа үгүй. Зүүн тийш харав. Арван гурван гөрөөний тэртээ дуурсахуй нэрт дуулганы орой нь цухуйж харагдав. Ажу мэргэн дуулганы оройг нь тас харваж орхив. Гэсэр хаан хэлэв: “энэ нүгэлтийн уурлах нь зөв” гээд дуулганыхаа оройг морин дээрээс бөхийж аваад явав. Ажу мэргэн хүүдээ уурлаж : “Эцэг нь хортой болбол бага байж хүү нь нь ч хортой. (Худалчийн үр нь худалч)” гээд харваж орхив.

Төдий Гэсэр хаан нүүдэлдээ (хөсгөндөө) золгож, нүүдлийн урьд явав. Нагац нарас гэр орны сургийг асууя гэв. Өнөө асуусн үгийг хойтон жил нь хариулдаг юм байжээ. Гэсэр хаан хурдан хариу сонсохын тулд нагацынд очиж адуугий нь хөөв. Го баян шанагаа барьж цохилж гүйцэж ирэв. Го баян Гэсэрийг таниад хэлэв: “Барсан муу тэнэг! Чи муу миний адууг хөөж яана? Шарайголын гурван хаан ирж Цас Чихэр ахыг чинь тэрүүлэн гучин баатар гурван зуун хошуучийг чинь булт алав. Рогма гуа хатныг чинь авя явав. Аливаа бүгдийг чинь авав. Цотон ноён эзэлж, Сэнлон эцгийг чинь тайгам (шадар зарц) болгосон байна. Энэ бүгдээс эс мэдсэн муу нтэнэг, миний адууг юу гэж хөөх вэ ? ” гэв. Гэсэр хаан гэр нугийн сургийг сонсоод адууг өгөв.

Гэсэр хаан төдий нүүж нутагтаа хүртэл цотон ноён их хотын өмнө Гэсэр хааны таван зуун хүн багтах орд цагаан гэрийг нь барьж сууна ажээ. Гэсэр хаан одож Балагийн голын эхэн дээр буув. Шулмасын орноос авчирсан аливаа бүгдийг сүнсний хоёр имдийг хувилгаанар дэлгэн тавив. Хэмжээгүй ролон хүн мал болж уул хөдөөгүй бэлчин явав. Гуч дөчин цагаан ордыг тус тусад нь бриулав. Тэр дотор улаан өрхт их цагаан ордыг манлайлан бариулж суув. Гэсэр их хотоос эргэе гэж явав. Эргэж явсаар арван гурван эрдэнэт сум аливаа бүгдийг цөм аваачсаныг мэдэв. тэр бүгдийг үзэж Гэсэр хааны сэтгэл зовж үхэтхийн унав. Рогма гуагийн үг захисан хүн ирж Рогма гуагийн сормуусаар Гэсэрийн хамрыг утав. Нүдний нулимсийг нь нэгэн халбага авчирч аманд нь цутгаж өгөв. Төдий Гэсэр сэргэж босов. Гэсэр хаан төлдий босоод тэр хүнийг авчирч хүрээндээ буулгав.

Цотон ноён Гэсэр хааны эцэг Сэнлон олон адуундаа тайгам болгож яваалах ажээ. Цотон ноён хэлэв: “Ай! Сэнлон өвгөн чи явж энэ голын эхэнл яасан олон улс буув? Сайд ноёнд гэж над бүү гайхуул, бүү сайрх гэ! гээд “Хэд хоновло хоног тоолж мал авна ” гэж Сэндлн өвөгнийг

илгээв. Сэнлон өвгөн бор цоохор морио унаж, саадаг сумаа бүслэж, тонгоргон сэлмээ зүүж очив. Сэнлонөвгөн очих замдаа ганцаар ярьж адилтгаж явав. “Эвүү, эвүү Гэсэрийн минь явсаар энэ газар ийм сайхан өрөө хүн мал үгүй билээ л. Арван зүгийн арван хорын үндэсийг тасалан авай богдын минь эртний өргөө буудалтай адил байна. ийм сайхн буудаль гэр хэнийх болов ” гэж уйлж очив. Гэсэр хаан тотгороо шагайж үзэв. “Эвүү, эвүү Арлан гуа малгайгаа өмс манай өвгөн эцэг ахай айсуу байна. Буулгаж цай шөл өгч үгийг нь сонсож мордуулаарай! Намайг үзвэл дэмий ашилж мэднэ энэ. ” гээд ширээн дээр гарч хөшгөө товчилж суув. Өвгөн ирж : “Энэ гэр хэнийх вэ ? ” гэж асуув. Арлан гуа хэлэв: “Ай өвгөн юу гэв ?””

Гэж асуув. Сэнлон өвгөн хэлэв: “Цотон ноён намайг илгээв. Таныг хурдан нүү гэнэ. үгүй болбол хоног тоолж мал авна. Манй нутагт яагаад буув ? ” гэв. Арлан гуа хэлэв : “Ай өвгөн! Хааны чинь зарлиг зө. Эвүү айж үхмээр байна. Муу бид нүүе . ” гэв. “Ай өвгөн! бууж цай шөл зооглож морд ” гэв. Өвгөн бууж цоохор морио тушив. Саадаг нумаа тавьж орохдоо тонгоргон сэлмээ ургаш болгож оров. Арлан гуа эсий дэвсэж өгөв. Арлан гуа Гэсэр хааны их эвэр аяганд цай дүүртэл хийж өгөв. Өвгөн аягтай цайг аваад аягыг үзээд инээв. Цай ууж дуусаад аягыг өгөөд уйлж сууна. Хонины нэг хаа аяганд хийж өмнө нь тавьж өгөв. Өвгөн хутга үгүйн тулд тонгоргон сэлмээ гаргаж мах огтолж далган ядаж суув. Гэсэр хаан шагайж үзээд уярч хөшиг нэвг сумч шил ишт оновчоо хаяж өгөв. Өвгөн хутгыг нь аваад инээв. Өдгөн тэам түм огтолж идээд махыг буцааж өгөөд уйлав. Арлан гуа хэлэв : “Ай өвгөн! инээхийг асуу. Уйлахын соёрх гэдэг билээ. аяганд цай хийж өгөхдө чи аваад инээнэ. Ууусан хойно аягаа өгөхдөө уйлах чинв юу билээ. Мах идэхэд хутга үгүй сэлмээр даалган ядаж байхад нь хутга өгөхөд хутгыг үзээд инээж. мах идээд буцааж өгөхдөө уйдаа чинь юу билээ ? ” Өвгөн хэлэв : “Асуух чинь зөв. Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит мэргэн Гэсэр хаан гэгч миний хөвгүүн билээ. Арван хоёр толгойтой мангасын оронд Арлан гуа хатнаа нэхэж явсаар есөн жил болов. үхэв гэж санадаг би. Түүний минь цай зооглох эвэр аягыг үзээд түүнийг ирсэн болов уу гэж инээлээ. Авай минь, аяга нь энэ байна. Одоо бие нь аль вэ ? гэж уйылах минь энэ. Хутга аваад инээх минь түүний минь шил ишт оновч энэ байна гэж үзээд ирсэн болов уу? гэж инээнэ. Одоо бие нь аль вэ гэж уйлав” гэв. Арлан гуа бас уйлав. Гэсэр хан эс тэсэж босоож өвгөнийг тэвэрч хайлав. Гэсэр хааныг хайлахад алтан дэлхий бүгд догдлон хөдлөв.

Гэсэр хаан айхлахаа байж өвгөнд өгүүлрүүн : “Ай, өвгөн минь, дуу (Дуугүй бай) Эсм хүн үү чи! Би ирвэл төдий л биз. Тэр муу цотон мэдэх вий! Алтан дэлхийн аливаа амьтан булт доглон хөдлөх болно, дуу” гээд өвгөнийг явуулав: Гэсэр хаан алтан дэлхийг сан тавиад номхотгов. Гэсэр хаан өвгөнд хэлэв: “Өвгөн минь! ийм тийм дэмий үг бүү ярь. Дуугүй яв. ” гэв. “Үүнийг эмгэндээ аваачиж хоёуд шөл хийж уу ” гэж үхрийн нэгэн гуя өгөв. Өвгөнийг мордуулаад уулзасныг нь хувилгаанаар мартуулав. Өвгөн буцах замдаа бодов : “Эвүү эвүү Гэсэр минь ирсэн биүү ? үгшүй билүү? Зэрэглээ билүү? Зүүд билүү ? ” гэж ярив. “За ирээгүй гэхэд энэ газар над үхрийн гуя байтугай, ишигний шийр өгөх нэг ч хүн үгүй билээ” гээд өвгөн ганзгана дахь гуяа тавилж авч шагайь чөмөгнөөс нь барьж цоохор мориой гуядаж хүрч очив. очихдоо гуяа орхин, тонгорог сэлмээ гаргаж : “За муу Цотон нутгийн эзэн чи. Нутагтаа нутагтаа юу хийж сууна вэ чи муу? Цотон нутгийн эзэн, гэргий Алонжид хоёрын нэр сөнөнө. Сэнлон Амаржил хоёрын нэр ургана” гээд сэлмээ барин гүйн оров. Цотон ноён хэлнэ. “Цотон ноён!эвүү, эвүү! Авай минь намайг юу гэж занчиж байа чи? Би энэ голын эхний улсыг хөөж нүүлгэв. Голын эхэнд гурван сүрэг гөрөөс байна. Түүнийг голд шахан намнатугай гэж баярласан минь энэ билээ” гэв. Цотон хэлэв: “тийм болбол хөөрхий минь! Өвгөн чиний

зөв байна” гэж (цай өгч) аргад дэрлүүлэн хэвтүүлэв.

(Сэнлоэн өвгөн гэртээ харив.) Гэсэр хааны эх нь Амаржил эмгэн шөнө Сэнлон өвгөндөө уйлж хэлэв. “ай өвгөн минь Авай Гэсэрээс хагацасанас хойш чи бид хоёрт ямар жаргал байх билээ! Энэ өдрийн чинь баярлсан чинь чамд зовлон биз. Эдүгэ хэвт” гэв. Сэнлон өвгөн хэлэв: “Муу зөнөг хүлтгэр. Амаржил асуув: “Гутсан муу зөнөг дуугүй хэл . Авай Гэсэрээс минь нэг бэлэг мэджээ чи. Чам муутай адил гэнэ шүү? Хош гэнэ үү чи? Чи зүгээр хэлж өг. (тэр үхрийн махыг хэн өгөв?)” гэж эмгэн уйлж хэвтэв. Сэнлон өвгөн хэлэв: “Ай, эмгэн минь! дуугүй яв. энэ өдөр тэр улсыг нүүлгээд харьж иртэл зам зур нээн хөхөө хүн болон ирж хэлэв: “Гэсэр хаан үхсэнгүй, амьд гэнэ. Өвгөд эмгэдийг жаргаалья, өшөөт Цотонг алья гээд (үхрийн хөл өөгд) явж одов. Эмгэн уйлан баярлаж хэвтэв.

Маргааш нь ардан зүгийн эзэн Гэсэр хаан энэ ахуй тойрсон их настай өвгөн гуйланч лам болж хувилав. Нэгэн хувилгаанаа хоёр банди болгож дагуулж луус илжгэнд бахан хүнс ачаад гурвуул хөтлөлцөж ирээд Цотонгийн гална ирж буув. Цотон ночн гадна ширээн дээр гарч сууна. Цотон ноён ам нарыг үзээд : “Лам хэнийх вэ?” гэж асуув. ЛАМ зарлиг болов: “Би энэ ахуйг тойрсон гуйланч лам билээ. Энэ хауйн аливаа хаадад цөм хүрэв би?” гэв. “Аль халь хааадад хүрэв чи? ” гэж асуув. Лам зарлиг болов: “Авай надад эс хүрсэн газар үгүй. Булт хүрлээ би. Асуух хэрэгтэй үйл байвал асуу. Үгүй гэвэл байг гэж зарлиг болов. Тэр хоёр хүн харьж ирээд Цотон ноёнд хэлэв: “Би энэ ахйг тойрсон гуйланч лам билээ гэнэ. Энэ ахуйн аль аль хаадад цөм хүрэв. Авай, над эс хүрсэн газаргүй гэж хэлж сууна” гэв.

Цотон ноён : “Эвүү, эвүү, юутай сайхан үгтэй гуйланч лам билээ энэ? Нааш авчир” гэж авчруулаад асуув. “Ай лам! Арван хоёр толгойт манаст хүрэв үү чи. Цотон асуув : “Гэсэр хаан мангаст очлоо. Гэсэр дийлэв үү? Мангас дийлэвүү?” гэж асуув. ГЭСЭР хаан үхсээр есөн жил болж мангасын өрөөл дээр бие нь нарыг эзлэн сахиж өрөөл доод бие нь хөрст алтан дэлхийг эзлэн сахина ” гэв. Цотон хэлэв: “ За за сайн. Хүсэл минь ханв” гэж хэлээд : “Эрдэнэт эцэг лам минь нааш ир” гэж ширээн дээр суулгав.

Гэсэр хаан бэргэн ЦОТОНГИЙН эм Алонжид уйлав: “Эвүү, эвүү түмэн дэлхий! Юүтгэв чи? Тэнгэрийн хөвгүүн Гэсэр богд чамайгаа үл үхэхийн чинээ саналаа би.. Хайран төвдийн үр үндэс тасрав уу? Авай богд минь! ” гэв. Цотон хэлэв: “Гэсэр амраг хайртай болоо юу чи? ” гэж хэлээд Цотон эмээ гөвшив. Лам зарлиг болов : “Ай Цотон хаан! Гэсэр хаан гэгч чиний ач гэлээ л. Чиний халуун сэтгэлт төрөл чинь бишүү ? Түүний уйлах нь зөв биз ” гэв. Цотон хэлэв:“ Ламын зарилгаар больё ” гэж эмээ занчихаа байв. цотон хэлэв: “ Сайхан үгт гуйланч ламд өгье. Аливаа идээ юмыг цөм авчир ” гэж их хурим хийж олон юм авчирч өгөв. Цотон ноён суугаад : “Лам! энэ нохойд минь нэр өг” гэв. Лам зарлиг болов: “Энэ сайхан нохой байна. Урьд нэр өгөөгүй юу ? Би нэр өгье” гэж зарлиг болов. Цотон хэлэв: “ Адбиш сайн нохой билэ Эрдэмь лам нэр өгвөл сайн. ” гэж хэлэв. ЭРДЭМТ лам нэр өгье гэж хэлээд “Урьд эзнийхээ толгойг залгих гарз . Хойно өөрийн толгойг залгих гарз ” гэж нэр өгөв. Цотон хэлэв: “Урьд сайн үгт гуйланч билээ . Хонйо одоо муу үгт гуйланч болов : “За хаан чамайг хөөсөн ч би явна. Хөөгөөгүй ч би явна Арван зүгийн эзэн арван хорын үндэсийг тасалсан ачит богд мэргэн хаан үхсэнгүй . Атаат Цотонг алья гэж айсуу гэнэ” гэж зарлиг болоод явав. Цотон осож гүйж харайн: “Эвүү, эвүү Энэ юу гэв? ” гэж дэмий ийн тийн харж байв.

Лам ядаад хотын дотор явгал нэгэн хүүхэд таван зуун цоохор ямаа хариулж, нэгэн үе уйлж нэгэн лүе дуулж явна. Лам зарлиг болов : “Дуулах ч биш уйлах ч биш . Над өөр сонсдоно. Аль янаг төрлийн хүүхэд болов уу энэ? ” гэж очив. Золгоод лам асуув: “Авай хэний билээ чи? ” гэж асуув. Хүүхэд хэлэв: “Эвүү Цас ахайгаас, арван зүгийн эзэн Гэсэр мэргэн хаан авгай хоёроос хагацсаар Цотонгийн зарц болсоор нэг ч хүн намайг “Өө?! Авай чи хэнийх вэ? ” гэж асууангүй билээ” гэж хүүхэд хэлэв. “”4 Ай лам чи хэний вэ? гэж асуув. Лам зарлиг болов: “Ай хүүхэд! Би урьд асуув. Чи урьд үгээ хэл. ” гэв. Хүүхэд хэлэв: “Энэ Замбутивийн эзэн Гэсэр хааны эрдэнэт амраг ах Цас Чихэрийн хүүхэд билээ би (Миний нэр Лайцав) Гэсэр авгай минь арван хоёр тоолгойтой мангасыг дайлахаар явсны хойно Шарйголын гурван хан ирж рогма гцаг авья гэхэд Цас Чихэр, гучин баатар тэргүүлэн очиж эрийн сайныг хядан алж, агтын сайныг олз болгож ялгал атаат Цотон Шарайголын гуран хаанд урваж аливаа бүгдийг цөмйг дуусгав. Цас Чихэр ахай минь үхэв. Алиныг тоолох вэ ? Энэ мэт олон ” гэж хэлээд хүүхэд уйлав. Хүүхэд уйлан байж асуув: “Ай лам! Одоо зарлигаа над өөгсэй ” гэв. Лам зарлиг болов : “Авай би энэ ахуйг тойрсон гуйланч лам билээ” гэв. Хүүхэд хэлэв: “энэ ахуйг тоырсон болбол Гэсэр хан авгайг минь мангас дийлэв үү? Гэсэр хаан авгай минь мангасыг дийлэв үү? ” гэж асуув. Лам зарлиг болов: “ Зарим хүн мангас эндэж гэх юм. Зарим нь Гэсэр эндэж гэх юм. Хай би эс мэдэв” гэж зарлиг болов. Хүүхэдл хэлэн уйлав. “Цас Чихэр ахайгаас хагацавч Гэсэр мэргэн хаан авайгаас хагацахыг хэн санлаа. ? Хишиггүй муу бие минь! Эвүү яалаа ? Хүнд зарц болох минь энэ билүү? Өшөөт дайсаныг нэхэх гэвэл энэ бие минь багадана болов уу е явна. Хүний зарц болж хайран бие минь гутах болов уу? Ер тэр хоёроос мөнхөрсөнд би мөнхрөх үү? Нэхэх арга хийе” гэж эдүгээ уйлж явав хүүхэд. Хүүхэд уярах мэт үг хэлж уйлахад лам уйлав. Ламыг уйлахда алтан дэлхий бүгд догдлон хөдлөв. Лам зарлиг болов : “Авай хүүхэд дуу! (дуугүй бай) Хатуужих сэтгэл баривал чинь таарна. ”гээд явав. Хүүхэд хойноос нь даган явж “Ай лам байз” гэв. Лам : “Юу вэ?” гэж эргэж харав. Хүүхэд хэлэв: “ Ахуы биед амьд хэрэгтэй байна. Амиа хайрлагчид арга хэрэгтэй байна. Арван зүгийн эзэн Гэсэр хаан авгайгаа хүлээж, хүний таван уун ямаа хариулж үнэлж авсан эзгий минь ” гэж хавтагнаасаа эзгий авч : “Ай лам! Нэгээр Цас Чихэр эцгийн минь сүнсний тусад, нэгээр арван зүгийн эзэн Гэсэр хаан авайг сүнсний тусад, энэ хоёрын минь тусалд сайн ерөөл ерөөж өг” гэж эзгийгээ ламд барив. “над аливаа дайсанд үл эрсдэх увдис өг” гэв. Лам эзгийн аван уйлан зарлиг болов: “Авай минь! Дуугүй яв. үггүй хүнд арга хэрэгтэй бишүү. Өнчин хүнд хатуужил хэрэгтэй бишүү. Хурмаст тэнгэрийн хөвгүүн Гэсэр хаан хорт мангасыг алсан биз. Хоёр ааштай Цотонг хохимой модон адил болгоё гэж айсуу биз. Хоцорсон өнчин бүгддээ хотол тэнгэр нарын жаргалаар жаргуулмой зэ. Эрхт тэнгэрийн хөвгүүн эзэн Гэсэр хаан өшөөт мангасыг алсан бизээ. Ийн тийм хувилж өшөөт Цотонг чинь өлмийдөө гишиглэх биз. Эзэн Гэсэр хаантайгаа золголцох эрхт тэнгэрийн аргалаар жаргах болтугай! Авай минь! Одоо нэхнэ гэхэд нас бага байна. Хойно нэхнэ гэхэд хожимдох болов уу гэж хэлдэг тэр үг чинь баатрын шинж байна” гэв. “Май!” гэж лам Цотонгийн өгсөн юмыг бүгдийг өгөөд явав. Гэсэр хотын гадна гарч явгал нэгэн эмгэн дээлээ мөрөндөө өлгөж зүүн мөр нь дарьтаж аргал түүж нэгэн үе уйлж, нэгэн үе дуулж явах ажээ. Лам сонсоод гүйж очоод асуув: “Ай эмгэн! хэний вэ ? ” гэв. Эмгэн ламыг үзээд инээв. Түүний хойно уйлж байна. Лам асуув: “Ай эмгэн инэхийг асуу . Улахыг соёрх гэлээ. Миний урьд нэгэн үе дуулж, нэгэн үе уйлж явсан билээ чи. Эдүгэ намайг үзээд инээх чинь юу билээ ? Хойно нь уйлах чинь ву вэ ?” гэж асуув. Эмгэн уйлан хэлэв: “Авай лам минь, чиний асуух зөв. Арван зүгийн эзэн богд, арван хорын

үндэсмийг тасалсан ачит мэргэн Гэсэр хаан гэгч минь миний ганцхан хөвгүн билээ. Арван хоёр толойто мангаст очсоо р есөн жил болов. Тэр минь арван зүгт хувилдаг билээ. Хувилагч магнай дэхь мэнгэ, дөчин таван дун цагаан шүд нь хувилдаггүй билээ. Түүний минь хувилгаан мөн гэж инээв. Би. Хойно биш болов уу? гэж уйлав. би” гэв. Гэсэр хаан эхийнхээ тэр үгэнд эс тэсэв.

Билгийн хээр морио огторгуйгаас буулга унав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт долоон эрдэнэсээр давхарлан хийсэн хөө хар хуягаа өмсөж, хамаг зэр зэвэ булт аваад эхдээ зарлиг болов: “Ижий й минь намайг төрсөөр дайснаа дайлахыг минь үзсэн чи? Ижий минь! Энэ хотын асар дээо гарч намайг үз. Яаж аашилж ирэхийг минь хар. Ижий минь намайг үз” гээд бууж ирээд эхээ гурван үе тэврээд мордож явав. Эх нь нэгэн үе уйлж, нэгэн үе иээж босох суухаа үл мэднэ.

Гэсэр хаан Цотонгийн баруун хойноос түмэн мянган цэргийн тоос гаргаж довтлов. Цотон тэр тоосыг үзээд : “Эвүү! энэ их тоос юунаас гарав ?” гэж гүйж орон тотгоор шагайж үзэв. “Авай эм! сайхь нүгэлтийн тоос мөн байна. Эм! намайг бүү зааж өг. ” гээд тогоон дор орж хэвтэв. Гэсэр хаан хүрч ирэн билгийн хээр морио дэвхцүүлж харайлгаж байж тотгоор шагайж : “Ай, Цотон авгай б эргэн хоёр минь байна уу? Ир! Золгоё. Нусгай Жур чинь би ирэв. Өшөөт мангасыг алж ирэв би. Ахай минь үтэр ир!” гэж байв. Цотонгийн эм бэргэн хэлэв: “Авай Гэсэр минь, авга чинь тогоотын хөндийд очив. Амсарт нь дээрэм гарвал адагт нь бүгнэ гэж явлаа” гэв. Цотон : “Эм яалаа ?” гээд ширээний доор мөлхөж оров. Гэсэр хаан зарлиг болов. “Над уурлаан болов уу? Авгай, бэргэ хоёр минь над золгохгүй яав? Үтэр гарч ирээсэй” гэж байв. Бэргэн бас хэлэв: “Авай Гэсэр минь! Авгай чинь ширээтийн нуруунд очиж адарт нь дээрэм гарвал адаг хөл доор нь бүгэх гэж явлаа ” гэв. Цотон бас :”Эм яалаа чи?” гээд м эмээлийн доор оров. Гэсэр хаан зарлиг болов: “Авгай бэргэн хоёр минь! Таныгаа мөрөөдөнө бишүү би. Үтэр ирээсэй” гэв. Бэргэн нь хэлэв: “ Авай Гэсэр минь! авгай чинь эмээлтийн хөтөлд бууж эрвэгэр бүүргэнд нь дээрэм гарвал этгэр агтанд нь бүгэх гэж очлоо ” гэв. Цотно бас “Эм эвүү, яалаа?” гээд баруунтаа хурааж тавьсан гурва туламныхаа дундах тулманд гүйж ороод “өөе эм туламныхаа амсарыг боо! ” гэж хэлэв. Гэсэр хаан дотроо санаж : “Энэ муутай аль бүр ингэж байна би?” гэж бодоод шившив. “Өмнө зүгээс хонины чинээ цагаан үүл гар . Тэр хоёр үүл харшлалдан ирж хар салхи хөдлөөд мөндөрт хур орж, тэнэр донгодож их салхи болон хийсгэх болтугй. Цотон авгайн минь зөөсн, бэргэний минь нөөсөн тулам тулам дахь шар тос миний өмнө өөрөө өнхөрч ирж аманд минь орох болтугай! ” гэж Гэсэр хаан исгэрч байв. Өмнө зүгээс хонины чинээ цаган үүл гарав. Хлйд зүгээс үхрийн чинээ хар үүл гарав. Тэр хоёул харшлалдан нийлж хар салхи хөдлөөд мөндөрт хур орж тэнгэро донгодож их цагаан ордыг дайрав. Гэсэр хааны таван зуун хүн багтаж суух их цагаан орд салхины хүрдээр эргэж Арлан гуагийн гадн очиж эргэ байж тогтов. Арлан гуа угтан гараад хэлэв: “ Гэсэрийн эртний цагаан орд болбол энэ багананд минь тогт” гэж алтан баганаар зангаж тогтоов. Тулам дахь Цотон билгийн хээр морины дор өнхөрч ирж Гэсэр хааны өмнө нь хэвтэнэ. Гэср хаан зарлиг болов: “Бэргэний минь нөөсөн, авгайн минь зөөсөн гурван тулам идээ билээ. Есөн жилийн идээний дээжийг Журдаа хийж тавьсан байна. ” гээд туамны дээр сандайлан сууж Гэсэр зарлиг болв: “”4Энэ шар тосыг хутгаар хагалаж идье би Өлссөн хүн би согтох болов уу? Шөьгөөр хатгаж сорж идье би. 6 гэж хэлээд гуя руу нь

шөвгөөр хатгахад Цотон бяцхан ухасхийн хөдлөв. Их хатгахад их ухасхийж хөдөлж хэвтэв. “үүнд хий дүүрсэн болов уу?” гээд сумч шил ишт оновчоороо зураа руу нь далдартал дшрэв. Хар цус оргилж гарав. Цотон биеэ өвдөхөд тэсэж ядан “халхай хуухай! Авгай чинь Цотон би байна” гэд тулмаа тас тийрээд босон харайв. Гэсэр хан зарлиг болов. “Эвүү авгй минь, мөн байна, яалаа чи? Би чамайг тулманд тос хийж байна гэж санаж билээ.” гэж зарлиг болов. “За Цотон авгай цас Чихэр хэний төрөл билээ? Чиний төрөл бишүү. Гучин баатар чин хэний төрөл билээ? Чиний төрөл бишүү. Рогма гуа хэний бэр билээ. Чиний бэр бишүү. Чамайг яавал бах минь ханах бол? Уур миь яаж мохо бол е” гэв. Төдий “Халхай!” гээд есөн алд хар шор сэлмээ суга татаад давхийв. Цотон босон “”4Наана хулгайя! Барь барь гэж хөөж билгийн ташуураар цохин унагаж босгож хөөж явна. Цотон тарвагны хуучин нүхэнд гүйж оров. Гэсэр хаан хөөж ирээд “Энэ нүхэнд үнэг оров” гэж гал асааж байв.

Гэсэр хааны авга нь Царгин өвгөн : “Өмнө зүгээс хоины я чинээ цагаан үүл гарлаа. Хлйд зүгээс үхрийн чинэ хар үүл гарлаа. Энэ хоёр үүл харшлалдан ирж хэцүү тоос гаргав. Арван зүгийн арван хорын үнсийг тасалсан авай богдын минь нутгийн тэндээс энэ тоос гарч байна. Гэсэр минь өөрөө ирсэн болов уу?” гэж дээр гарч үзье гэж заан шарга морио унаж хүч мэдэж хүрч ирэв. Гэсэрийг үзээд : “Эвүү! Эжий минь, эвүү эжий минь!” гэж унан боёсон гүйтэл Гэсэр угтан өргөж авав. Тэврэлдэн уйлалдав. Гэсэр хаан Царгин хоёуланг нь уйлахад алтан дэлхий бүгд догдлон хөдлөв. Гэсэр хаан уйлахаа байж зарлиг болов: “авгай минь! минь дуу” гэж Царгинны уйлахыг байлгаад сан таавж алтан дэлхий номхотгов.

Царгин асув : “Авай минь энэ нүхэнд юу орж гэж утна вэ чи?” гэв. Гэсэр зарлиг болов : “Нүхэнд үнэг орж, утна би” гэв. Царгин хэлэв: “Авай минь! Үнэг биш Сйхь муу нүгэлт Цтоон биб гэв. “Энэ нүгэлтийг албал алалтай билээ. алтан яст янаг садан төрөл билээ.” гэв. “Дотор тэсэж үл болом, Гэвч авай минь бүү алзана, үүний хойно чи өөрөө мэд.! Авай минь. гэж Царгин хэлэв: Царгин өвгөн Цотонг дуудав. “Цотон! нааш ир!” гэв. Цотон гарч ирэв. Гэсэр билгийн хэр мориндоо зарлиг болов: “ай, билгийн хээр морь минь үүнийг есөн уда залгиж есөн удаа бааж орхи. Хойд залгихдаа удан бааж орхи.” гэв. Билгийн хээр морь есөн удаа зөлгиж, есөн удаа бааж орхив. Цотон хялагсн чинээамьтай хүн болон гэлдэрч босож ирэв.

Гэсэр эдүгээ Цотонгийн эм, бэргэнээ хайрлаж Цотонгийн улс, малын дундуурыг өгөөд Цотонгос салгаж гэрийнхээ дэргэд буулгав. Царгинд мангасаас авчирсан аливаа бүгдээ булт өгөв. Эцэг эхдээ Цотонгийн адиваа бүгдийг булт өгөв. Цас Чихэрийн хүү Лайцав, Нанчүнгийн хүү Райцав энэ хоёр хүүг гэртээ аваачиж Арлан гуад өгөв. Цотонгоос өшөөгөө аваад аливаа бүгд өнчнөө тэгш жаргуулсан нэгэн цадиг энэ бөлгөө .

Аяа, зургаан зүйыл амьтны тусын тулд, аливаа төрөл тутамд хагацал үгүй нөхцөл соёрх! Авай богд минь!

Гэсэр хаан Шарайголын хаадтай байлдахаар бэлтгэв.

Гэсэр : “Одоо Шарайголын гурван хааныш нэхэж өшөөгөө авъя гэж билгийн хээр морио унав Шүүдрийн гилбэлгээн өнгөт долоон эрдэнэсээр давхарласан хийсэн хөө хар хуягаа өмсөв. Цахилгаан өнгөт далавчаа зүүв. Наран саран хёйрг хамтаар зэрэгцүүлэн хийсэн малгайг цагаан дуулгаа эрдэнэт тэргүүндэ өмсөв. Оюу оньт гучин цагаан улссум, догшин ха нумаа дэлэв. Билгийн гурван алд хар шор сэлмээ зүүв.

Ай! надтай нэхэх хүн байна уу? ” гэв. Цасын хүү Лайцав, Нанчшнгийн хүү Райцав нар хэлэв: “Энэ дээр өшөөгөө эс авбал хэзээ авах вэ? Бид хоёр явъя” гэв. “Авай та бидний явдал өөр бишүү. та нарынхаа өшөөг би авъя . Та хоёр бага бишүү. Байг” гэв. Тэр хоёр хүү уйлж харив.

Цотон хэлэв: “авай минь! би нэхье” гэж ирэв. “Авгай, зөв Яв” гэв. Гэсэр дуурсахуй нэрт нумаа авч өндөр уулын оргил дээр гарав. Исмада нэрт сумаа авч шившив. “Ай сум минь! Шарайголын гурван хаанд очъя би. Өшөө дайсны хайгуулчин, харуулчин байна уу? Түүнийг өрсөн алаад хатны голын тэртээ тусаарай . тэнд чамайг олж авна би. Үгүй болбол хотод тусаарай! Хойно олж авна би” гэв. Сумыг татаж байж хувилгаанаар харваж орхив. Шарайголыгн гурван хааны тавьсан сайн гурван хүн явж байв. Нэг нь гурюан сарын газраас харах хүн байв. Нэг нь барьсанаа үл алдах бөх байв. Нэг нь сэрвэс хийснийг шүүр алах бушуу хүн байв. Гурван сарын газар харагч хүн өчив. “Мнд бүргэд буюу хэрээ буюу нэгэн төмөр атгасан юм айсуй” гэв. “Явдал (ёчиг) нь хаагуур вэ? гэж нөгөө хоёр хүн асуув. “Биднийг зорьж айсуй. Явдал нь адбиш түргэн байна. Бусдыг яаж мэдэх вэ ? ” гээд босон харайв. “Эвүү, хоёр нөхөр бос. Бүргэд хэрээ биш сум байна энэ. Шүүрэгч минь шүүр . энэ сум бидэнд ирнэ. ” гэв. Шүүрэгч хүн хэлэв: “(Тэр сум) намайг дайртугай . Би түүнийг юу гэж алдах билээ ? ” гэв. Харвагч хүн хэлнэ. “Хэцүү юм байна энэ. Бөх чи шүүрэгчийн бэлхүүсээр нь тэвэр. Бөхийн бэлхрүүсээ би тэврэе ” гэв. Гурвуул тэврэлдэж шүүрэгч гараа бэлэн зэхэж байна. сум хүрч ирэв. Шүүрэгч, сумны дундуур нь шүүрэв. Сум тэр гурвуулыг огторгуйгар аван одож Хатны голд хүрч ёроолгүй гүн цээлд аваачиж унагав. Гурвуул усанд унаж үхэв. Сумыг Гэсэрийн Одоо Дүнжин гарво эгч нь гадагш хаяж орхив. Сум хатны голын эхэнд шигдэж газарт хадаж байв.

Гэсэр Цотонг дагуулж явав. Долоо хоног идээ өгсөнгүй авч явав. Цотон олыбөрч мэгдэж явтал мөр дээр нь морины нэг хомоол байв. Гэсэр : “Хүнс барсан хүнд юутай сайн идээ билээ энэ” гэв. “Авай би хүнсээ барж билээ . Идье би. ” гэв. Гэсэр : “ Ид авгай. Идэхэд аргал гэж снагдах магадгүй .и тос шү энэ. ” гэв. Цотон ргалыг идээд явав. Бас зам дээр нь чөдөрийн тасархай алга хэвтэнэ. Гэсэр : “Эвүү! Энэ яасан сайхан идээ хэвтэнэ вэ!” гэв. “Авай би идье ” гэв. “Авай сур гэж санах биз. Хувилгаан идэ шүү. Ид ” гэв. Цотон авч идэв. Түүнээс цаш явтал тэрмийн чулуу хэвтэхэд Гэсэр : “Ай Цотон! Рогмаг минь Шар талд нуу гэж хэлсэн биз. Рогма нууж явсаар энэ гууг (сахиулсны сав) энд гээ орхисон байна. үүнийг зүү” гэв. Цотон : “Авай! Үүнийг яаж даая!” гэж дааж ядан байв. “Би зүүж өгсүү. Нүх нь энэ бишүү ” гэж цулбуураар оосор хийн ууцан дээр нь хүлж өгөв. (Арай чарай цааш явтал) : “Одоо Богд минь чамтай хамт явж үл чадна. Одооо хүнс үгүй үхнэ. Харья” гэв. “авгай дайсныг нэхье гэгч чинь яалаа? ” гэв. “Авгай чинь үхэх нь байна. Харья” гэв. “авгай харь” гээд Гэсэр хартал

Цотонгийн бие тээрмийн чулуунд үрэгдэж далны мөгөөрс цайж, Цээжнээс нь зүрх нь цухуйж, сугаар нь уушги нь цухуйж байв. Цотон харив. Цотон тээрмийн чулуугаа үүрч унаж босож харьж ирэв. Сэнлон өвгөн : “Эвүү, халхай!” гээд Цотонг татаж унагаад тээрмийн чулуугаар нь дарж байв. (Цотон бархиран цурхиран “Тусал. Сэнлон минь битгий ал” гэж бархирахад) Царгин дайралдаж хэлэв : “Сэнлон минь бүү ал! Тавь! Чи үүнийг алж юу хийнэ!” гэж тавиулав.

Гэсэр, Цас Чихэрийн сүнстэй дайралдав.

Гэсэр Шар талаар явж Хатны голын тэртээ гартал Исмада сум нь байв. “Ээ! өшөөт дайсны нэгэн (гурван хэцүү) хүнийг алсан байна” гээд сумаа хвч дүүрэв. Хатирч явтал Хатны голын дэргэд Хүслэн нэрт овооны бэлээр. Нохой шувуу ч үгүй билээ. Яасан хүн дуудав?

Гэж ийн тийн харж үзэв. Хүн байсангүй. Эвүү, Сая Гэсэр ирж дуудсан хүн хаша явчив? Яасан жиг билээ

Гээд явав. Бас : “Гэсэр минь байз” гэж дуудав. Гэсэр бас харж үзтэл шувуу хэнхдэгтэй, хүн бөгстэй харцгай ирж эмээлийн урд буурган дээр сууж уйлав. “Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан мэргэн хаан Гэсэр минь. Энэ замбутивийн амраг Цас Чихэр ах чинь би билээ” гээд урьдбн явдлаа тоолж хэлэв. Хэлэхэд Гэсэр хайлав. Гэсэр ханы хайлахд алтан дэлхий догдлон хөдлөв. Алива амьтан хамтаар уйлав. Гэсэр сан тавьж алтан дэлхийг номхотгов. “Ай Цас Чихэр минь! Амраг ах минь юунд гомдов чи? Эдгээ гэн үү чи% Тэгвэл бид хоёр гэртээ харьж чамд нэгэн хүнд эдгээе (Хүний биед сүнсий чинь оруулья) би. Эдүгээ Хурмаст тэнгэр ахайд минь очъё гэнэүү чи? Бүү уйл чи” гэв. “Авай богд минь! Сүүлд яахыг би өөрөө мэдье . Урьдаар явж Цаган гэрт хааны дүү Шамба Мэррузын зүрхийг над авчираарай . Би (шувууны хумс хошуугаар шувт) идэж хүслээ хангая. (Бас Шарайголд шулмасын ридэд хэцүү хүн) арав гаруй бий. Тэднийг аргаар алж сүнсийг (аюуш) тамыг ёроолвд орхи. Авай богд минь!” гэв. Гэсэр : “За би явъя” гэд уулын гөрөөсийг ууланд %, талын гөрөөсийг талд харваад “намайг иртэл үүнийг идэж суу” гээд явав.

Гэсэр Исмада сумаар Рогма гуатай харилцаа тогтоов.

Гэсэр шууд явж Шарайголд хүрэв. Өндөр уулын оргил дээр гарав. Үдэш билгийн хээр морио сойв. Нэгэн Исмада сум эзэндээ шөнө харьж ир! Үгүй болбол тэнд хэвт

Гээ харвав. Сумыг очиход Цагаан гэрт хан алтан ширээн дээр цай ууж суув. Сумны сурхирах (аймшигт чимээг) сонсоод : “Арван зүгийн эзэн аюух мэт богдын наманчлан тахья” гээд аягатай цайгаа сумны өмнөөсцацав. Сум тахилын цайны ачаар биеэс нь зайлж алтан ширээний хөлийг тас тусав. “Энэ сум дээр тэнгэрийн сум болов уу? Дунд Асур нарын сум болов уу? Доор лусын хаадын сум болов уу? Гэсэрийн сум болбол а манай гурван хүн яагаад үзсэнгүй. вэ ? Сумыг Рогма гуа танина” гэж Рогма гуад сум илгээв. Рогма гуа тэр сумыг үзээд өднөөс нь барьж хугалж цөхөв. Үүсгэрээс нь барьж хугалж цөхөв. “Дээр тэнгэрийн, доор Лусын хаадын дайсны (дарахын) тулд ирсэн сум болбол энэ хоно. Үгүй бол эзэнт сум эзэндээ харь” гээд тван өнгийн хив тоорго уяж хатавчаа түшүүлж тавив. Шөнө хуй салхи хөдлөд хувтилгааны сум салхины хүрдээр эргэж очоод Гэсэрийн саадагны дээд нүдэнд тусав. Гэсэр үүрийн хяраанаар өөд болж, нүүр гараа угаагаад саадгаа үзээд сум нь таван өнгийн торгоор манжлагдаж намилзаж хийсэж байв. сумаа авч үзээд : “Явдал зориг миньбүтэх байна. Муу Шарайголоос ганц сум минь таван зүйлийг олзлон авч ирсэн байна” гээд торгыг зургаан анги болгож Шарайголын хааны эхийн хутаг, эцгийн хутаг Жавсан Гонма нэрт уулыг тахив. Хутгийг урвуулав:

“Эрт цагт Шарайголын хааны хутаг билэ чи. Энэ цагт миний хутаг уул бол ” гэж сан тавьж ном уншиж байтал газар хөдөлж өвс, чулуу мод зулгаран унв. Гэсэр “ай энэ зөв” гээд мордов.

Гэсэр зууг наст лам болж хувилав.

Шарайголын гурван хааныд хүрэв. Шарайголын хааны уух ус нь хошоо хошоод булаг болжээ. Тэр дотор Цавчлан нэрт эрдэнэт булаг байв. Түүнээс шарайголын гурван хааныд охид ирж ус авч бие угааж явдг ажээ. Гэсэр тэр булагт очих зам дээр биеэ хувилгаж зуун настай гуйлнч лам болов. Билгийн хээр морио огторгуйд гаргав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуягаа хувилгаж ламын жанч болгов. Цахилгаан өнгөт хоёр цагаан далавча хуилгаж ламын хоёр ханцуй болгов. Манлай цагаан дуулгаа хувилж ламын малгай болгов. Билгийн гурван алд хар шор сэлмээ хувилгаж гурван алд хар таяг мод болгов. Оюу эрдэнэ оньт гучин цагаан сумаа, догшин хар нумаа хувилгаж ламын номт дэл болгов. Булагт очих зам дээр гуйранч өвгөн болж гэдрэг хэвтэв. Цаган гэрт хааны Цасан гуа охин нь Хятадын Дайван хааны хүү Мял гүнцогийн авсан охин таван зун дагуулаа дагуулж жимс идээ нааш цааш хаялцан наадаж айсуй. Тэр хаясан идээ гэдрэг харж хэвтсэн ламын аманд өөрөө орж байв. охид гүйж ирэн “Ай өвгөн! Чи хэнийх вэ?Бос!” гэж байна. “Бидний наадсан идээ үүний аманд оох учир юу вэ? Өвгөн чи үтэр бос!” гэв. “Эвүү хүүхэд! Энэ ахуйг тойрсон үгээгүй гуйранч лам билээ би. Та нар сайн сэтгэлт хүхэн болбол аман дах идээг минь бүү ав. Гурав мөргөж авшиг тавиулаадп харьж оч. Муу сэтгэлт хүүхэн болбол аман дэхь идээг ав. Дээгүүр минь алхалж гарч оч. Гайгүй юу билээ ? Боссон газраас сууж чадахгүй би. Суусн газраас босож чадахгүй би гэв. Охид : “Үүнд бид юу гэж мөргөх билээ ? ” гэж хэлээд аман дахь идээг нь ухчилж аваад “энэ муу өвгөнийг байтугай, эцэг эхийн дээгүүр ч бид алхдаг ” гээд дээгүүр нь алхаад харьж одов. Ус аваад ирэв охид. Түүний хойно Шар гэрт хааны охин Суман гуа мөн урьд ёсоор ус авья гэж олон дагуулаа дагуулж ирэв. Тэр мөн урдахын адил нэгэн үгээр ус аваад ламын дээгүүр алхалж харив.

Түүний хойно Хар гэрт хааны охин Чойрон дархны өргөсөн охин Цоймсон гуа, таван зуун охид, хутаг боол хятада дагуулж ирэв. Суулганы дээд бие нь дун, дунд бие нь шил бөгсөн бие нь алт байв. Тийм суулга барьсаар ус авахаар ирэв. Бас тэдний хаялцсаж наадсан үзэм, чихэр, жимс идээ нь ламын аманд өөрсдөө орж байв. Хутаг боол хятад ирж хэлэв: “Өө өвгөн! хүүхдийн мөрөөс зайл!” гэв. Өвгөн (мөн өжүүрхэж) хэлэв. “Боссон хойно сууж үл чадах би. Суусан хойно босож үл чадах би. ” гэв. Чоймсон гуа хүрч ирэв. “Юу гэж үл босон энэ өвгөн ? Хэний вэ ?” гэж асуув. Хутаг боол хятад Чоймсон гуад хэлэв: “энэ ахуйг тойрсон зуун настай гуйрамч лам гэнэ. Боссон газраас сууж үл чадна гэнэ. Суусан газраас босож үл ч адна гэнэ. Сайн сэтгэт хүүхэболбол амандах идээг минь бүү ав. Наманчйлан мөргөж орой дээрээ авшиг тавиулж яв. Муу сэтгэлтэй хүүхэд бол аман дахь идээг минь авч дээгүүр алхаж харьж оч гэнэ. ” гэв. Чоймсон гуа асуув: “Энэ ахуйн ль хаадад хүрч хаанас ирэв ? ” Одоо хаана очъё

Гэнэ. “Аль олон хадыг үзлээ би. Өнөө мөнх газарт очъё гэж Шарөйголын гурван хааныг дайраад явья гэж ирэв. Өмнө минь ойр болов уу ? Хойно минь хол болов. Насандаа дарагдаж идээ хоолоо олон ядаж хэвтэнэ би” гэв. Чоймсон гуа дагуулууддаа хэлэв. “Үүний аман дахь идэг авч юу хийнэ. Дээгүүр нь алхалж гарах өөр газар үгүй гэж үү ? гээд .наманчлан мөргөж орой дээрээ авшиг авахуулаад биштээгүүр зайлж гарав. Чоймсон гуа цагаан гэрт хааны нэгэн удган эмгэн дагаж ирсэн ажээ. тэр удган хэлэв: “ Чоймсон гуа байз ” гэж дуудав. Чоймсон гуа “Удган юу гэв?” гэв. “Би энэ шөнө зүүд зүүдлэж, арван зүгийн арван хорын үндсийг

тасалсан ачит мэргэн Гэсэр хан ирж Цагаан гэрт хааныг алтан ширээнээс нь шилжүүлж, түрүү толгой нь огтолж байна э гэж зүүдэлсэн. Энэ зуун наст лам биш Гэсэр хаан хувилж иржээ. Ламын хар жанч биш, Гэсэр хааны хөө хар хуяг биз. ЛАмын ханцуй биш . гэсэрийн цахилгаан өнгөт далавч биз. Энэ ламын барьсан гурван алд хар туяаг мод биш, билгийн гурван алд хар шор сэлэм биз. Үүнийг би Гэсэр гэж санан” гэв. Чоймсон гуа Удганыг хараав: “Эцгийн чинь түрүү, эхийн чинь толгой. Муу салдаг хүлтгэр (бөөдий онгон) дэмий юу гэж донгосоно чи? Энэ үгийг чи Цагаан гэрт авгайдаа хэлбэл чиний толгой түрүүг огтлохгүй юу. Өнөө яасн ийсэн гэсэр ирэх билээ ? Гэсэр гэгч хэн бэ? Энэ үгээ хүнд бүү хэл чи муу! ” гэж Чоймсон гуа донгодов.

Чоймсон гуа хувилгаан (дагина) байсан ажээ. “Арван зүгийн эзэн Гэсэр хаанд амьд гэнэ. Нэгэн цагт түүний гэргий болоосой би. Үгүй болбол түүний үнээг сах хятад эм болоосой би. үгүй болбол үнсийг асгах шивэгчин нь болоосой би” гэж идэх идээнийхээ дээжээр Гэсэр хааныг тахиж явсан ажээ. Чоймсон гуа Гэсэр хаан “над баахан дотно байна” гэж мэдээд зуун наст лам, хутаг боол хятадыг дуудав. Хятад боол "Ай лам! Юу вэ ?" гэж ирэв. Лам хэлэв: “Ъыулаг минь чи үерлэж үү, яаж ? Дундаас нь бүү ав. Замаг орох бий. Захаас нь бүү ав. Шороо орох бий . Дундаас нь наана захаас цаана хөлөө хөдөлгөлгүй байж ав. Рашааны ус орох болноб гэв. Хутаг боол хятад, ламын энэ үгийг очиж охиход хэлэв. Охид хэлэв: “Тэр яасан жигтэй өвгөн билээ ? ” гээд Он жилээр авсаар ирсэн усыг тэгж хэлэх юм ” гэв. Удган сонсоод : “Тэр намайг Гэсэр гэж хэлэв гэж дэмий донгосоно биш үү? Он жилээр үл үерлэх булаг эдүгээ юу гэж үерлэх билээ. ” гээд удган суанд гүйж оров. Удган үерлэсэн булагт орж үхэв. Өвгөн лам тэр удганыг бие мэдэв гэж булгийг үерлүүлж удганыг алж орхив. Хутаг боол хятад булгийн дундаас нь авав. Замаг оров. Өвгөний үгээр захас нь авав. Шороо оров. Өвгөний үгээр усаа аваь. Рашааны ус оров. Гэсэр хувилгаанаар суулгыг сэ даалгав. Таван зуун охид, хутаг боол хятадтай бүгдээрээ за за гэж өргөв. Дасангүй. “Эвүү энэ юуны жиг билээ ? Өнөө манай булаг үертэй болов. Удган унаж үхэв. Он жилээр гартаа барьж дааж явсан суулгаа эс даав бид ” гэв. Чоймсон гуа хэлэв: “Та энд байзна” гээд Чоймсон гуа ганц биеэр өвгөнд гүйж ирээд. “Дээд их лам! Бид суулгаа өргөу чадахгүй байна. Суулгыг өргөж өг. ” гэв. Өвгөн хэлэв: “Ай! нэгэн алиа охин, наадангуй ьохин байна чи. Урд үг минь өөрийнх ,_ хойд үг минь хүнийх билүү? Босож чадахгүй байна би. ” гэв. ОХин хэлэв: “Алиа охин биш билээ, би Арван зүгийн эзэн Гэсэр хааны аргад дарагдаж алиа болов уу би? Худалч охин бишээ би Хутагт Гэсэр хааны хувилгаанд дарагдаж худал үг хэлэв үү би. ? Чи зуун наст лам бишээ . Арван зүгийн эзэн Гэсэр хаан байна чи. Ай, Богд Гэсэр над нэгэ тэмдгээ үзүүл. Тэр тэмдэгийг чинь хүнд хэлбэл намайг чиний сахиус автугай. ” гэж ам алав. “Энэ охин вью гэнэ? ” гээд өвгөнийг хөдлөхөд доороос нь бярууны чинээ алтиан аалз босон Шарайголын гурван хаан хотыг тэмцэн гүйв. Хотыг нь гурван үе эргээд ирэхдэ хэлэв: “ Төөрөг эрт цагт Шарйголын гурван хаанд байлаа. Энэ зүгт арван зүгийн эзэн хаанд болов” гээд өвгөн ламын доор оров. Шарайголын гурван хааны хотын гадна байсан улс тэр аалзыг үзэж хэлэлцэв. “Энэ мал гэвэл мал биш, гөрөөс гэвэл гөрөөс биш Энэ эвэртэй юм юу билээ ? Хэлэх үг нь хүн мэт юу вэ ? Арван зүгийн эзэн Гэсэр хааны гучин баатрын сүнс нь биз энэ. ” гэж суув. Чоймсон гуа бярууны чинээ аалзыг үзээд: “За арван зүгийн эзэн Гэсэр хаан олон хувилгаан цэргүүдээ гаргаж үзүүлэв. Т Түүнийг хувилганаа үзүүлсэн хойо : “ай Богд! үдэш найман натсай өнчин хүүхэд болж хэвт. Опоо энэ суулгыг мин өргөж өг ” гэв. Өтгөн “Ёо ” гэж босов. “”4Олон хүхдийн эс даасан энэ суулгыг өвгөн хүн би даах уу ? Хэрэв даавал суулы чинь оосор тасраад хагарвал намайг бүү хараа” гэв. Чоймсон гуа хэлэв: “Эвүү! Чамайг юу гэж хараах вэ бид? ”

гэв. өвгөн лам суулгыг өргөж болоод хувилгаанаар оосрыг тасдаж орхив. Суулга унаж арван анги хагарав. Охин хэлэв. : “Яасан нүүглт өвгөн билээ ? Яасн чивэлт өвгөн билээ? Хар гэрт хаан бинийг алах болно. Одоо яая бид? ” гэж уылав. Чоймсон гуа охидыг донгодов. “Ай охид! Дээд их ламыг бүү хараа. Харавал эцэг минь намайг хараана биз. Та мууст хамаагүй” гэж хэлээд “Дээд их лам тарнийн хүчээр энэ суудлыг минь бүтэн олгож өг. ” гэв. Өвгөн лам : “Олон хүүхэд хойш бай Өвгөн хүн би тарина мартав уу, яав? Дээд буорхдыг залбирч тарнидпаж үзье” гэв. “Хүүхэд хойш! Хүүхэд хойш” гэв. Тэд зайлав. Лам хувилганаар суулгыг тарнидаж урьдахаас нэн өнгөтэй болгож үзүүлэв. Олон охид бүгд гайхаж, “Үнэн дээд их ламийг юу гэж хараалаа!” гэж гэмшинэ. Хутаг боол хятад, охид ус авч харьж ирэв.

Гэсэр, Олзвой хөвгүүн болж хувилав.

Шамба Мэруз (Хар гэрт хаан) охиндоо уурлаж донгодов. : “Яасан алиа найдангүй Явдлыг сурав чи ? Өглөөний гурван идээ идтэл хаана явав чи? ” гэв. Чоймсон гуа хэлэв: “Булагт надаж очиж билээ. Булаг минь (гэнэт) үерлэж удган унаж үхэв. Түүний ясыг эрж удав бид ” гэв. Чоймсон гуау хэлэв: и” Булагт наадаж очиж билээ Булаг минь (гэнэт) үерлэж удган унаж үхэв. Түүний ясыг эрж удав бид” гэв. “Ахай! Бидний булгийн зам дээр найман настай өнчин гуйланч хүүхэд хэвтэнэ. Сайн уран үг ярих юм Авч тэжээж чамд хөтөч болгоё” гэв. “Бид хүний гуйланч үрийг тэжээх байтугай, өөрсдийн гуйланчийг тэжээж чадахгүй байна. охин хүн зүгээр яв чи” гэв. Чоймсон гуа охин эцэгтээ уурлаж гэртээ харьж ирээд гурав хонотол эцгийн гэрт эс очив. Гурван хоносны хойно Чоймсон гуай эцэгтээ айлтгав. “Ахай минь!” Сайхь өнчин хүүхэд одоо болтол хэвтэнэ гэнэ. Түүнийг авч тэжээе гэв. Эцэг нь “Эвүү! Яах вэ! Авай тэжээ” гэв. Чоймсон гуай баярлаж хятад эмээ үтэр илгээж авчруулав. Гэсэр зааны ясаар арслан хийж тоглов. Алтаар эрвээхэй хийж нисгэж наадаж явав. Чоймсон гуа түүнийг авч эцэгтээ үзүүлэв. “Авай! хүүхэн Үүнийг хэн хйв. ” гэю. Чоймсон гуа : “Үүнийг тугаарын өнчин хүү хийв.” гэв эцэг нь : “Түүнийг авчир” гэв. Авчрав. Шамба Мэруз хүүгээс асуув. “Эцэг чинь уран билүү? Хэнээс сурав чи?” гэв Хүү хэлэв. Эцэг минь намайг бага байхад үхсэн. Би түүнийг мэдэхгүй . Нагац минь уран билээ . Өнөө Чойрон дарханыг урлаж суухад үзэж суув би гэв. Шамба Мэруз хэлэв: “Энэ хүү сайн хүн болох байна. Одоо өдөрт нь намайг дагаж миний хөтөч болж яв. Шөнөд нь үгээгүү ядуу олон хүүхэдтэй гэрт хонож яв” гэв. “Энэ хүүхдийн нэрийг хөсрөөс олж авсан (хөдгүүн тул) Олзвой гэж нэр өгвө” гэв.

Тэр цагт Шарайголын гурван хааны нэгэн хутаг, бул ц агаан чулуу байсан ажээ. Чойрон дарханд олзвой хүү хэлэв: “Энэ бул цагаан чулуу эвдэж хуяг хийвэл юутай сайн хуяг болох бол? ” гэв. Чойрон дархан хэлэв: “Авай! Энэ үгээ хүнд дэмий бүү хэл. Энэ гурван хааны хутаг чулуу бишүү. Энэ үгийг чинь сонсвол чамайг эд алах болно. ” гэв. Олзвой шөнө тэр чулууш үүрч аваачиж Чойрон урны хаалганы(хатавчны) дэргэд тавив. Олзвой өглөөгүүр очиж : “Чойрон дархан ахай минь бий юу ?” Гарч ир!” гэв. Уран гарч ирээд чулууг үзэв : “Эвүү яалаа! Бид эндэв үү? Энэ чулуны хутагб арагдав уу? Чулууг эвдэж хуыяг хийхээ болья Лам номч! Олзвой! энэ чулууг дөрвөн тал гаргаж цавч! АХуяг хийе” гэв. Лам номч өглөөгүүр цавчиж үд болж ирэхэд : “Олзвой хэлэв: “Авай лам номч хойшоо суу . Ооль сугарах магадгүй. орой руу чинь тусаж тархийг чинь хагалж алуузай” гэв. Олзвой хэлэв: “Чи муу дуугүй цавч! Өглөөгүүр над эс сугарсан оолв өнөө юу гэ сугарах билээ . Сугараад над тусвал би үхнэ биз. Чамд гайгүй” гэв. Олзвой “За над зэмгүй” гээд оолийг хувилгаанаар суга дэлэв. Оолв сугарч лам номчийн тархийг гартал тусав. Лам номч амьтай амьгүй хлалзаж хэвтэнэ. Олзвой : “Чойрон уран ир! ” гэж их дуу гаран уйлж зогсов. Өвгөн : “Яав?” гэж хормойгоо өргөн гүйж ирэв. Лам номчийг үзээд толгойгий нь тэвэрч :”Авай минь! яав?” гэж уйлаь. Лам номч хэлэв: “Би гурван талыг нь цавчаад биеэ алжаахад Олзвойд өгч билээ. Олзвой цавчихдаа хэлэв: “Авай, лам номч хойшоо суу! ооль сугарах магадгүй” гэв. “Над эс сугарсан ооль чамд сугарах болбол миний заяа болтугай” гэв би. Олзвой дэлждэв. Оолв сугараад орой руу минь иусав. Заяаны минь үхэл хүрч ирэв. ” гээд үхэв. Өвгөн уйламдаа : “Нүгэлт хутаг цагаан чулу хөдөлсний нүгэл энэ байна” гээд уйлав. Гэсэр хувилгаанаар Шарайголын гурван хааны хутаг цагаан чулууг эвдэв. Лам номчийн Гэсэрийн тухай баахан мэдэж явахад нь (сэргийлэн) алж орхисон алтгаан тэр байна. Чойрон дархан: “Олзвой!Хөөрөг дар! Энэ нүгэлт чулуугаар хоёр хуяг хийе” гэв. Урлаж суухад Олзвой төмрөөс нь (уван цуван) хулгай хийж аваад хөөргөнд нь

хийж орхив. Хойно хулгай хийж авсан төмрөөрөө жаран алд төмөр дэгээ хийж аваад нуууж Балбын хааны түргэн Бирваагийн хөвгүүн Бөх Цагаан Манлай, Чоймсон гуаг богтолъя гэж их хурим авч ирэв. Хар гэрт хаан : “Олзвой их хуримныхаа засуул засаж хэнгэрэгийн дотор элдэв зүйл дуутай төмөр зөгийгөөр өөр өөр дуу гаргаж наадаж явав. Бөх Цагаанманлай эртэгчин шар нумаа татаж (эрэлхэн тамшаалаган). Тэгээд хэлэв: “ Арван зүгийн эзэн Гэсэр хааны их Даюу, Ронца энэ зургаан баатарыг алсан Бөх Цагаан манлай би бишүү. надтай энэ их хурим дээр барилдах хүн байна. уу? Нумыг минь даах хүн байна уу?” гэж дуудав. Олзвой тэр үгийг сонсоод дотроо гэмшин уйлж дэргэд нь нь ирж “Ёо халхай” гэж биеэ суниаж байв.” гэв. Бөх Цагаан Манлай хэлэв: “ Эвүү! Энэ муу Олзвойү үзэвүү? Надтай барилдая гэж дурлаж нумыг минь татъя гэж дурлаж биеэ суниаж байна” гэв. Олзвой хэлэв: “ ЭвүүЧи дээдз тэнгэрийн хөвгүүн билүү? Доор лусын хаадын хөвгүүн билүү? Энэ ертөнцийн хүний хөвгүүн биз. Мөн миний адил хүний үр бишүү. Морь цуцвал биеэ хөрвөөж амардаг. Нохой гөрөөс хөөвөл ус ууж ундаа ханадаг. Би морь билүү? Би нохой билүү? Чамайг хурим авч ирж гэж баярлаж харин их төрийг (хуримыг) чинь засаж явгал над юу гэж ийм үг хэлнэ. чи? Хаан эцэг, хатан эхждээ м, хамаг бэргэдээ эмийг минь өршөөж өгөх болов уу? Үгүй болов уу? гэж ама цорвойж, алгаа хавсарч байхгүй, харин эмийг минь өгвөл авья. Өгөхгүй бол энэ гурван хааныг алж талаад харъя гэх шиг байна. Гэсэрийн арван таван наст Нанчүн чиний эцгийн алж толгойгоор нь мориндоо молцог хийж аваачив гэлээ. Чи муу, Нанчүн мэт тийм баатар уу? гэж донгодов. Бөх Цагаан Манлай хэлэв: “Хол бай! Энэмуугийн аашийг үз. За үтэр энэ шар нумыг минь татаж үз” гэж зандарч байв. Олзвой хэлэв: “Муу Олзвой би эс чадавч татаж үзье. Гурван хааны сахиус мэдтүгэй” гэж авав. Бөх Цагаан Мандай хэлэв: “ За чи тат. Элэгунээс нь халбага хийх эвэр үлдээгээрэй. Үйснээс энэ сумны онинд наах үйс үлдээгээрэй. Май тат!” гээд өгөв. Олзвой нумыг нумыг аваад шившиж хэлэв: “ Элэг нь халбага хийх хар нүүрс бол. үйс эь сумны онинд наах үйс бол” гээд татав. Олзвой хувилгаанаар татав. Нум нь үнс нүүрс болбон бутарч унав. Бөх Цагаан Манөлай босон гүйж ирээд Олзвойг ноцов. “Энэ бид хоёроор хэн дутах вэ? Хэн маань үхвэл ялгүй болтугай” гэв. “Гурван хааны минь сахиус мэднэ биз. Үхвэл яах вэ! Үүний гарт үхье би ” гээд хоёул авалцав. Бөх Цагаан манлай ачна, дэгээднэ, ташна. Олзвой, адилтгавал алтан дэлхий гадас шаасан мэт зогсоно. Олзвой сахиусандаа залбирав. “огторгуйн олон сахиус минь! Орчлонд алтан дэлхийн эзэн улсын хаан Овоо Гүнжид хувилгаан эфэг минь!Ронца, Онжин Даюу, их Даюу, бага Даюу, Их Хүрхрэгч, бага Хүрхрэгч та зургуулын сүнс зургаан чоно болж ирж түүнийг зургаан талаас нь тасар татаад яв гэж шившив. Олзвой: “Одоо хишиг над бишүү?” гээд бах Цагаан Мандай өргөж ирж дээш хаяж орхив. Бөх Цаган Манлайн хоёр хамраас нв цус гарч, дүүрээ нь дэлбэрч үхэв. Олзвойн залбирсан зургаан сүнс зургаан чоно болж ирээд зургаан талаас нь тасар татлаад явав. Гурван хаан: “Бөх Цагаан манлайн их ам эс зохив” гэж инээлцэв. Чоймсон гуа уйлж хэлэв: “ Өөр эрд очно гэхэд намайг мөр муутай нүгэлт охин, чивэлт охин гэж хэнч авахгүй жигшинэ. Түмэн лнй сүйн өр, мянган оны богтын өр ” болов. гэж уйлав. Уйлахад нь гурван хаан донгодов. “Чамайг хүн алиа охин гэж хэлэхгүй юу? Дуугүй суу” гэв. Их хурим тархах болов.

Хятадын хааны хүүн Мял Гүнцонг Цагаан гэрт хааны хүргэн ирэв. “Урьд БөахЦагаан манлай бид хоёр барилдахад харилцан ээлжтэй байдаг билээ. хоёр хүн барилдаад нэгжнээ ална гэгч юу вэ? Ялагдаад босон билээ. үхвэл яах вэ! Ялгүй болтутугай” гэж ирэв. Олзвойтой ноцолдов. Алиныг тоолох вэ? Мөн урьд ёсоор алж орхив. Шар гарт хааны хүргэн Солонгосын хааны хүүн Манцог Зул ирээд хэлэв: “Хоёр хн арилдаад нэг нэгнийгээ алах уу? Олзвой чи

урьд хоёр хүнтэй адил гэж бүү бод . Чи бид хоёр барилдая. Бид хоёроор хэн дутах вэ? хэн нэг нь үхвэл ялгүй болтугай гэж хэлээд Олзвойтой б арилдав. Мөн хувилгаанаар дүүргээгий нь дэлбэн орхиж алав. Хар гэрт хааны Чоймсон гуагийн эгчийг нь авсан Мон газрын хааны хүүн Монса Иүсгэр ирж хэлэв: “Урьд чи базыг минь алав. Одоо чи надтай барилдах уу? ” гэж ирэв. Олзюойтой барилдаад урьд ёсоор алагдав. Гурван хааны садыг Гэсэр хувилгаанаар тас алж явна.

Гэсэр ялж, Шарайголын байлдаан төгсөв.

Рогма гуа Цаган гэрт хан эрдээ хэлэв: “Энэ олзвой биш, Гэсэр хаан биз. Хамаг сайдыг чинь булт ална бишүү. Уулыг өргөгч бөхийг ирүүл. Түүнийг албал Гэсэр мөн гэж санана би. Эс албал биш гэж саная ” гэв. Хаан “За, зөв” гэж хэлээд Уул өргөгч бөх нэг мөрөндөө бухын долоон нойтон арьс нөмөрч, нөгөө мөрөнөө бас долоон арсийг эгэлдэрч ирэв. “Олзвой хүү гэрт бий юу? Үтэр гарч ир!” гэж зандарч байна. Олзвой “Яав?” гэж гарч ыирэв Бөх хэлэв: “”Олзвой чи сайн бөх гэнэ. Хоёулаа барилдъя” гэв. Олзвой хэлэв: “Чи гурван хаанд хүчээ өгсөн бишүү. Би гурван хаанд хүчээ өгөөгүй. Чи надтай атаархах хэрэг байна уу? Барилдахгүй” гэв. Бөх хэлэв: “ Энэ муу дуугүй, барилдъя. Хэн маань үхвэл ялгүй болтугай” гэв. Олзвой хэлэв: “ Наадвал наадъя. Яана? Намайг эс барилдвал чи алах биз” гээд Олзвойг биеэ засаж байхад нэгэн мөрнөөсөө бухын нэгэн нойтон арьс аваад тас мушгиж : “Май!Муу Олзвой!” гэж хаяж өгөв. Нөгөө мөрнөөсөө бас нэгэн арьсыг автал нь Озюой хэлэв: “ Бухын арьстай барилдъя гэж ирсэнүү? чи? ” гээд. Олзвой босоод ноцов. Бөх, Бөх Олзвойг дэгээдэв, ташив. Хүч ы эс хүрэв. Ачив. Хүч эс хүрэв. Олзвой адилтыгавал алтан дэлхийд гадас шаасан мэт (алзахгүй)зогсож байв. Олзвой сахиусандаа залбирав. “маханд дуртай саахиус миэь манхаан нь ав. Үсэнд дуртай сахиус минь үснээс нь ав. Цусандп дуртай сахиус минь цуснаас нь ав. дэд дэдээр ирж тасар татаж ав” гэв. Олзвой бөхийн биеийг огторгуйн зүг шидээр орхив. Гэсэрийн сахиус дэд дэдээрээ ирж тасар татан авч одов. Рогма гуа: “Гэсэрийн хутдгаан мөн байна” гэв. Рогма бас хэлэв: “Одоо Гэсэр мөн болбол над нэг тэмдэг үзүүлнэ биз. Биш болбол самнан сууж “Гэсэр минь” гэж магъяж хуурмаг уйлав. Гэсэр хаан олзвой биеэр шээзгий савар барьж аргал түүж явтал Рогмаг минь намайг мартаагүй байна” гээд Жи Очирдар бурхан, есөн Манжушири бурхнаа үзүүлэв. Рогма гуа: “ Гэсэр ирж” гээд босон дутаав. Олзвой хойноос нь хөөж гэрийн наана гүйцэж хавтгай чулуун дээр ташиж орхив. Түүнийг гурван үе өнхөрүүлээд. Гэсэр хаан хувилгаанаар ирснэээ мартуулав. Рогма гуах хариад Цагаан гэрт хаан эрдээ хэлэв: “ Гэсэр ирж билүү? Зүүд билүү? Зэрэглээ билүү? гэж уйлав. Олзвой цааш явахдаа Рогма гуаг занаж их сайн эртэй эм байна чи. Чамайг эрийн чинь махнаас нь эс идүүлээсэй. Цуснаас нь сэс уулгаасай . Би арван зүгийн эзэн Гэсэр хаан мөн бол тэгж чадна” гэж явав.

Рогма гуа Цагаан гэрт хаанд хэлэв: “Энэ Олзвой гэсэр хаан мөн шиг байна . Үүнийг могойт тамд хийэ орхи. Хэрэв Гэсэр мөн болбол могой барьж үл иднэ. Биш болбол могой бб арьж иднэ” гэв. Олзвойг могойт тамт хийж орхи. Олзвой, эр харавтар шувууны хамрын цус, эм харавтар шувууны нүдний нулимсийн могой бүрдэд баахан баахан цацав. Могой булт хордож үхэв. Олзвой их могойгоор дэвсгэр хийж, бага могойгоор дэр хийж хэвгэнэ. Олзвой дуулав: “ Гэсэрийн төр автахад Цас Чихэрг, гучин баатар нь Цотонгийн үгэнд орж, рогма гуагаа гурван хаанд атгуулав гэвээ. рогма Цагаан гэрт хааны гэргий болж гэлээ. Гэсэр хаан Мангасын оролд явсаар мартамтагай болж гэнэ. Одоо Рогма гуа Гэсэрээ санаад Цагаан гэрт хаанаас урваж байна. Гурван хаанд заяагаа учирсан сайн эр билээ би. рогма гуа Гэсэр хаанд урваад намайг элдэв аргаар алахыг оролдож бөайна. Аливаа зүйлийн арга хийвч олзвой би үхэхгүй. Гурван хааны минь сахиус мэднэ” гэж дуулав. Гурван хаан тэр дууг сонсоод хэлэлцэв. “Олзвойг Гэсэр мөн гэж танвсан нь буруу байна” гээд Рогма гуаг зэмлэж Олзвойг тамаас татаж авав. Тэр цагт Цагаан гэрт хааныд барс ирвэс хоёр нохой байжээ. Хүнийг барьж иддэг байсан ажээ. Рогма тэр хоёр нохойг барьж гинжилж байв. Рогма гуа хэлэв: “Олзвойг авч ир! Гэсэр мөн болбол нохой үл халдана. Биш болбол нохой барьж иднэ” гэж Олзвойг дуудав.

Олзвой шээзгий үүрч савар бариад аргал түүж Рогмагийн дэргэдүүр нь гүйж явав. Рогма гуа хоёр нохойг турхиран тавив. Хоёр нохойг хүрч ирэхэд Олзвой шээзгий хөмөрч тавиад өөрөө дотор нь орж хэвтэв. Рогма гуа хэлэв: “Гэсэр мөн болбол нохой үл халдах билээ . Нохойг халдаж очиход Олзвой аргын сайнаар гарав. Энэ Гэсэр биш байна” гэв. Олзвой гэртээ харив. Гэсэр биеэр хувилав. Мөн Олзвой биеэр гэртээ сууна. (ийм учраас Гэсэр Олзвой хоёр дүрөөр явах болов).

Гэсэр билгийн хээр мориой унаж хамаг зэр зэвсгээ хувилгаж олон цэргүүдэ дагуулж, Шарайголын гурван хааны хотын баруунтаа нь ирж буув. Туг хиур бүрээ татаж зүг зүгт зуух ухаж, олон тогоо нэрж их хурим хийв. Гэсэр богд барилдах бөхчүүд, харвах мэргэд эд бүгдээр наадаж элдэв зүйл олон хувилгааныг үзүүлж суув. Шарайгоын гурван хаан “Гэсэр ирэв ” гэж их цэргээ хурааж угтаж гарав. Шарайголын цэргийн хүрч ирэхэд нь Гэсэрийн цэрэг хувилгаанаа огторгуйд хөх суунаг татаад явж одов. Тэр Гэсэр хааны цэрэг буусан газар нь Шарайголын гурван хаан хүрч очвол зууханд нь гал ноцож идээ чанагдсаар байна. Олон галын захад бөөстэй хуурстай нэгэн бага хүүхэд хэвтэнэ. Тэр бага хүүхэд Олзвой сэлмээ суга татаж гүйж ирэв. Шармбөа Мэруз хэлнэ: “Авай Олзвой! Бүү ал. Байз. үгийг нь авья! Гэв. Олзвой задарч асуув: “за өнөөх олон цэрэг хэнийх билээ? гэв. Хүүхэд хэлэв: “танаас өшөөгөө авья гэж ирж билээ. таны цэргийг олон гэж, өөрийн цэргийг цөөхөн гэж дайлдаж үл болох байна. танайд энэ Замбутивийн дайсанп үл дийлдэх бөхөд үл ялагдах, мэргэдэд харваж үл гартах тийм нэгэн хэцүү хүү байна гэж айгаад харив” гэв. Олзвой асуув : “Чи юунд хоцров?” гэв. Хүүхэд хэлэв: “”Гучин баатрын өнчин үр билээ би. хүний хөтөч болон ирж билээ. Бөөс хуурсанд дарагдаж цэргийн явдлыг нь эс дааж унтаж хоцорсон байна би” гэв. Олзвой хэлэв: “Бугыг бугын эврээр ална гэлээ. үүнийг тэжээ Гэсэртэй дайлдуулбал яах вэ?” гэв. Цагаан гэрт хаан : “Олзвой үг зөв байна. Чи үүнийг аваачиж тэжээ хүн болго” гэв. Олзвой тэр хүүхдийг гэртээ авч ирэв. Тэр хүүхэд шөнө босоод явчив. олзвой өглөө гурван хаанд ирж хэлэв: “Сайхь нүгэлтийн чинь үр шөнө босоод явчжээ. гурван хаан хэлэв: “Одоо босож уу? Яаж вэ? Яамай Чи гэртээ харь ” гэв. Олзвой харив.

Рогма гуа Гэсэрийн мөн бишийг тэнсье гэж : “Чоймсон гуа олзвой хоёрыг өглөө эрт ир. Гэсэрийн газраас ирсэээр сан тавиагүй билээ. ир” гэв. Рогма гуа, Чоймсон гуа, Олзвой гурвуул хол очив. Рогма гуа: “Тэр өдрийн хурим дээр би зүүдэг гуугаа гэж билээ. олзвой чи үзэвүү?” гэж аврий нь татаж үзэх гэтэл Чоймсон гуа нүдээ эрмэж эс үзүүлэв. Рогма хэлэв: “Энэ өдрийн бурхнаас эрт өдрийн бярман дпээр гэлээ” гээд явж одов. Жавсан Гонма уул дээр хүрч сан тавихад Рогма хэлэв: Эр хүн байтал эм хүн яаж сан тавих вэ? Олзвой чи сан тавь “ гэв. Олзвой хүү сан тавихдаа : “Уулсын хаан Овоо Гүнжид, Арьяа Аланкари охин цагаан тэнгэр, Мо гүүш Дамба нэрт төлөгч, Овоо Дүнжин Гарво, Жамца Дари Оддон, Гэсэр сэрво Дондүв, Ом аа хум” гээд сан тавив. Рогма зөвшөөж хэлэв: “Олзвой чи юу ыюлыул үзсэн, вул болбол мэдсэн байна чи. Би чамаас юм асууя” гэв. Олзвой: “За” гэв. Рогма гуа асуув: “Тэр алтан мандал хамаг бурхдад тахил өргөсөн мэт тэр юу вэ? Дун тэвшинд хөх хирс ус дүүрэн мэт юу вэ? Нэгэн эмгэн дэргэдээ олон хүүхэд наадуулж байна. Тэр вюу вэ? Хоёр баатар хүн илд далайцаж байхтай адил үзэгдэгч тэр юу вэ? Сумын онь, нумны хөвч мэт байгч, тэр юу

бэ? ” гэж асуув. Олзвой хэлэв: “ За би тэр бүгдийг цөм хэлж өгсүү. И ойлж ав. ” гэв. Рогма гуа : “ Би ойлгож авъя” гэв. Олзвой хэлэв: “ Тэр алтан мандал мэт хамаг бурхад тахид өргөсөн мэт б айх . Тэр бол Нолом тал мөн. Дунгийн тэвшинд дунгийн ус дүүрэн байх мэт үзэгждэвч тэр бол Гэсэрийн арван насандаа эцэг эхийн ач харуульга гэж Хоншим Бодсадын сүм барьсан тэр бишүү. Хөх хирс тэвшинд хөх хирс ус дүүрэн байх мэт үзэгдэвч тэр бол алдарт Хөх нуур бишүү. нэгэн эмгэн дэргэдээ олон хүхэд наадуулж байх мэт үзэгдэвч тэр бол мөсөн уул Мачин Бомра мэт үзэгдэгч тэр бол догшдын хүчээр боссон .Хиурсан нэрт хар уул бишүү. Хоёр баатар хүн илд далайцаж байх мэт тэр бол Хатны голбн эхний хоёр хад бишүү. Сумны онь, нумныб хөвч болж байх тэр бол Хатны гол бишүү” гэв. Рогма гца уйлан байж дотроо: “Энэ олзвой биш, Гэсэр мөн байна” гэж “Лав мөн” гэж Чоймсон гуад хэлэв. Чоймсон гуа хэлэв: “Гэсэр хааныг үнэхээр таньсан болбол би энэ их улсад хэлье” гэв. Рогма хэлэв: “Би бэргэн чинь наадаж хэлсэн билээ. Чи бүү хэл” гэв. Олзвой хэлэв: “Рогма чи наанаа уйлавч цаана худал хэл” гэв. Гэсэр түүнийг мэдээд хувитдгаанаар ирснээ тэнэд мартуулж орхив. Чоймсон гуа, Олзвой хоёр гэртээ харьж ирэв.

Хойд шөнө Гэсэрийн хувилгаанг хүүхэд ирж Цагаан гэрт хааныш довтлов. Есөн туг хиурыг хугалж, есөн идээ чанагчийг цавчаад есөн сүрэг адуугиы нь авч явав. Цагаан гэрт хаан өглөөгүүр босон хоёр дүүгээ авч ирээд уйланг үг хэлэв: “Эвүү! цасан жиг билээ? Гэсэрийн хувилгаан болов уу? Энэ шөнө намайг довтлоод явав” гэв. Шамба мэруз хэлэв: “Бүргэд хар цус уугч түшмэл, Олзвой хоёроор нэхүүлье” гэж хэлээд тэр хоёроор нэхүүлэв. Хоёул нэхэж гүйцэж ирэхэд Гэсэрийн хувилгаан хүүхэд чулуу өвөрлөж тэр хоёрын өмнөөс нь ирж Бүргэд хар цусан уунч түшмэлд хэлэв: “ За Цотонг барьсан их сайн хүн чи биз?” гэж угтан ирээд чулуугаар шидэв. Бүргэд түшмэлийг тэсэхгүй болж хойш дутаахад олзвой угтаж өмнөөс нгь чулуугаар цохино. “Авай! яасан чи! Өөрийн хүчнээ юу гэж ална вэ? ” гэв. Олзвой хэлэв: “Эцгийн чинь ьолгой . Чи хэний билээ? Өшөөт дайсан бишүзү чи? ” гээд толгойгий нь чулуугаар цоо цохиж алав. Роёр хөлийг нь морины сүүлд уяж толгойгий нь газар чирж адуугий нь тууж харьж ирэв.

Гурван хаанд олзвой хэлэв: “Тэр нүгэлт хүүхэд Гэсэр байсан ажээ. Бүргэд хар түшмэл минь гүйцэж билээ. Гэсэр хаан, түшмэлийн минь толгойг чулуугаар цоо цохиж алав. Намайг гүйцэж очиход Гэсэр адууг орхиод огторгуйгааср хөх суунаг татаалд явчив. Би түүнийг яах вэ? Түшмэлийн ястай, адуугаа авч ирэв би” гэв. Гурван хаан хэлэв: “Түшмэл үхвэл үхтүгэй. Чи л амьд ирсэн нь яамай . Одоо гэртээ харьж биеэ амраа” гэв. Олзвой асуув:” Энэ түшмэлийн ясыг эрт өдрийн ханилсан ах дүү нь барих уу? Энэ өдрийн ханилсан нөхөр намайг барь гэхүү? “ гэв. Гурван хаан хэлэв: “Чи барь! Ах дүү нь хэзээ ирэх вэ! ” гэв. Олзвой түшмэлийн ясыг голын бэлчээрт аваачиж толгойг нь газар ухаж булав. Хоёр хөлийг тэнгэр харуулж мануухай босгов. Олзвой тэгээд сан тавьж залбирав. “Огторгуй дахь олон сахиус минь, орчлонгийн гучин баатрын синь сүнс! Би танд тэмдэг болу өшөөт дайсан олзын нэгэн хүнээр мануухай босгов. Шарайголын хамаг амьтныг та нар дэд дэдээр тас татаад түгээж ид. Хойшид ийм хууль болтугай” гэж ерөөл тавиад харив”.

Рогма гуа бас Гэсэрийн мөн бишийг тэнсье гэж алтан ширээ мөнгөн ширээ хоёрыг засаж

тавив. “олзвой мөн болбол мөнгөн ширээн дээр сууна ” гэж бодов. Олзюой тэгэж тэнсэхийг мэдэв. олзвой нэгэн биеэ хувилгаж Гэсэр болов. Билгийн хээр морио унав. Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуягаа өмсөв. Цахилгаан өнгөт далавчаа зүүв. Нар сар хоёрыг хамтаар зэрэгцүүлэхн уургалан хийсэн маналай цагаан дуулгаа эрдэнэт тэргүүндээ өмсөв. оюу эрдэнэт оньт гучин цагаан сум, догшин хар нумаа дүүрэв. Олзвой би?эр алтан ширээ дээр суув. Гэсэр мөн биеэр билгийн хээр морио унаад дэвхцүүлж, дүүлүүлж байж есөн алд хөр шор сэлмээ Шарайголын хотын хайсанд дүрж байж хэлэв: “ Шарайгол, Төдв хоёрт юуны өшөө байхав. Ишигний эвэр, дааганы сүүл төдий ч өр шир байгаагүй бишүү. Рогма гуа хатныг минь юуны тулд булааж авчирав. Арван гурван очирт сум, алтаар бичсэн Ганжур, Данжур хоёр их хөлгөн ном, чандмань эрдэнэ, цавгүй хар нүүрс, цагаан суврага, гучин баатар_ гурван отог улс, гурван зуун хошууч, эднийг минь юуны тулд сүйтгэв?” гэж байв. Хар гэрт хааны охин чоймсон гуа хэлэв: “ Охин хүн саваагүй гэж хэлэх болов уу? рогма гуа хатныг чинь өгье. Гучин баатрын чинь ор (шарилын шүтээн) босгож өгье .Цас Чихэр, Шуумар Нанчүн тэр гурвуул тоолшгүй олон цэргийг алж үхлээ. Тэр түүгээр харгатугай (тэнцэх болно). Цагаан суврага, цавгүй хар нүүрс, алтаар бичсэн Ганжур данжур хоёр хөлгөн ном, гурван зуун хошууч, гурван отог улс, арван гурван очирт сүм тэд бүгдийг чинь өгтүгэй ” гэв. Гэсэр хаан зарлиг болов : “Үл үл!(Үгүй, тэгж болохгүй). Гучин баатрыг минь эдгээж өг. Үгүй бол их шившиг ” гэж байв. Чоймсон гуа хэлэв: “Нэгэнтээ үхсэн хүнийг яаж эдгээх вэ?” гэв. Гэсэр хаан зарлиг болов: “ Эвүү эвүү! Гучин баатар минь ” гэж есөн алд хар шороор хотын хайсыг тогшиж байхад. Шарайголын гурван хаан үхэтхийж байв. олзвой алтан ширээнээс бууж гүйж гараад хотын хайсан дээр гарч Гэсэрийн есөөөн алд шор сээмээс шүүрэн алдаж байв. Чингэтэл Шарайголын гурван хаан : “Эвүү! энд олзвой Гэсэртэй аладаж болох байна” гэж (гориллов).Түүний хойд шөнө олзвой жаран алд төмөр дэгээгээ барьж хотын асрын өнцгөөс татж дээш гартал Цагаан гэрт хааны Өнгөн цагаан тэнгэр сахиуис нь олзвой оройн үснээс гэдрэг татаж орхив. Олзвой бие нь өвдөж хэвтэж хэвтэж босов Жаран алд төмөр дэгээ бас татаж давхарлагт гарав. Гараад Цаган гэрт хааны гэрт нь ортол рогма н гуа биеэ угаах гэж яваад эзгүй байсан ажээ. олзвой гэрт ороод Цагаан гэрт хааныг дарж алав. Гэдсийг нь хагалав. Зүрхийг нь огтлон авав. Рогмагийн уух нэгэн аяга хорз, идэх зүрхийг Гэсэр зооглов. Цагаан гэрт хааны зүрхийг, цусыг Рогмагийн тэр аяганд хийж тавив. Хооны толгойг дэрэн дээр нь тавиад хөнжлөөр бүрхэв. Чингээд олзвой барааны хөндийд орж хэвтэв. Рогма гуа далайд биеэ угаагад ирэв. Цагаан гэрт хааны цусыг (эндүүрэн) ууж, зүрхийг идэв. Рогма гуа : “Бие алжаасан болов уу? Цээжин дотор чинэрч байна. Яасан нялуун амттай хорз вэ? ” гэв. “Хаан бос, бос” гээд хөнжлийг татахд толгой нь б өнхөрч унав. Рогма хэлэв: “Эвүү!” гэв. “Эвүү!” гэхэд олзвой барааны завсраас Гэсэрийн дүрээр гарч ирэв. “Ээ! эрийнхээ махыг иддэг цусыг уудаг уу? ” гэв. Чингэтэл Гэсэр Рогмагийн гараа нь чирэн гарав. Гараад “Би ташуураа мартаж” гээд гэрт эргэж ортол Цагаан гэрт хааны (нялх) хүү төмөр өлгий дотроос төмөр нум, төмөр сум татаж гичирт нь хүргэж байв. Тэр хэлж б айна : “ одоо харвавал урьд нь болов уу? хойно харвавал хождоно болов уу? ” гэж байв. Гэсэр тэр үгийг сонсоод хоёр хөлөс нь барьж авав. “миний хүү болбол сүү гар! Цагаан гэрт хааны хүү болбол цус гар!” гээд хатавч дэлдэв. Дэлтэл цус гараад үхэв. Чингээд Гэсэр хаан рогмаг аван явав.

Хар гэрт хаан, Шар гэрт хаан хоёул үлдсэн арван гурван буман цэргээ авч нэхэв. Шамба Мэруз билгийн цагаан морио унаж дөрвөн хөлөөс нь дөрвөн төмөр дөш уяж, дээрээс нь

нэгэн төмөр дөшөөр цохиж гүйцэж ирэв. Арван зүгийн эзэн ачит Гэсэр богд мэргэн хаан өмнөөс нь угтаж зарлиг болов : “Чи намайг алья гэж ирэвүү? Алагдья гэж ирэвүү? Чи намайг дийлвэ гэж ирэв үү? Дийлдье гэж ирэвүү? ” гэв. Шамба Мэруу хэлэв: “ Алья % талья гэж ирсэн биш .Ахаа алуулж юу санаж суух вэ би ? харж амьд явсан нэрээс халдаж үхсэн нэр дээр биз гэж ирлээ би” гэв. Гэсэр хаан зарлиг болов : “За халдья гэж ирсэн хүн чи мэргэний шинжээр харва . Би баатрын шинжээр байж өгсүү” гэв. Гэсэр хаан одоо дөрөөгөө урт болго дүр үзүүлээд сааж охор болгов. Шамба Мэруз алгын чинээ (зэвтэй) сумаа дэлж байж тавив. Гэсэр хаан дөрөөн дэрээ дээш өндийсээн учир харваан сум нь түүний салтаан доогуур хангис хийж гарч одов. Чингэсэн хойно Гэсэр зарлиг болов : “ Цас Чихэр минь догшин билээ . махыг чинь иднэ биз гээд шамба Мэрузын давсгаар нь шувт харваж орхиод давхиж ирэн Шамба мэрцузын толгойгий нь тас цавчиж аваад билгийн хээр мориндоо молцог хийв.

Гэсэр хаан билгийн хээр морио унаад харин гэдрэг явна. Навса хүрээ эмэг эхдээ залбирар: “Навса Хүрээ эмэг эх ижий минь! хурмаст тэнгэр эцэг минь! Алтан дэлхий дээр явахад минь хоёр их байр (байлдаан) учрах гэсэн билээ. Түүнд чинь төмөр хутга, алтан хайрцаг буулгаж илгээе гэж билээ. одоо тэр хоёрыг буулгаж өг” гэж залбирар. Гэсэр хааныг залбирахад тэр хёуулыг буулгаж өгөв. Авч үзтэл төмөр бөмбөг, зөгий хоёр байв. төмөр бөмбөгийг тавихад Шар гэрт хааны чихийн угаар шувт харвав. Зөгийг тавихад Шар гэрт хааны нүдийг тас хатгаж гарав. Одоо шар гэрт хаан тэмтэрхийлж явна.

Гэсэр хаан: “Билгийн хаар морь минь! Энэ арван гурван буман цэргийг няц бяц гишгэхээ чи мэд. Есөн алд хар шор сэлмээр цавчихаа би мэдсүгэй” гэв. Тэгээд давхин оров. Билгйн хээрморь няц бяц гишгэлэв. Гэсэр хаан есөн алд хар шор сэлмээрээ тасар тарсар цавчлав. Шарайголын гурван хааны үр үндситг таслав. Эм хүүхдийг нь олз хийв. Чандмань эрдэнэ, цавгүй хар нүүрс, алтаар бичсэн ганжур данжур хоёр их хөлгөн ном, гурьён зуун хошуувч, гучин баатар, гурван отог улсын үр үндэс, эм хүүхэд, арван гурван очир сүм тэр бүгээ булт авав. Авсан хойно одоо арван зүгийн эзэн Гэсэр хан ахуй бүхий нутгийнхаа зүг залран өөд болов.

Өөд болохоосоо Цас Чихэрийн оршсон харцагатай уулзаж Хар гэрт Шамба мэрузын зүрхмйг Цасдаа идүүлэв. Гэсэр хаан зарлиг болов: “Цас Чихэр минь чи надтай ханилж явья гэнэүү? Тийм болбол хариад мөн би?д чинь хувилгая й би. үгүй болбол Хурмаст тэнгэр эцэгт минь очиж төрье гэнэ үү чи ? Би сүнсийг чинь залж төрүүлсүү” гэв. Чингэхэд Цас чихэр хэлэв: “Чамдаа өдий чинээхэн хүчээ өгөв би. Одоо хүний төрөл олбол хойд төрөл хүний төрөл олох минь бэрх биз. Би дээр хурмаст тэнгэр эцэгт чинь очиж төрсүү” гэв. Гэсэр Цас Чихэрийн тэр үгийг “Зөв” гээд Цасын сүнсийг Хурмаст тэнгэр эцэгтээ дээш залав.

Түүний хойно Рогма гуа нэг хөл, нэг гарыг хугалаад хонь алуулагч наян настай өвгөнд өгөв. Рогма гуа зовож явахдаа : “Намайг чөтгөр албин аваасай” гэж хэлсээр явж үхэв. Рогма хар буруу хараал хэлсний хүчээр чөтгөр албин бөгсий нь мөсөнд булав. Цээжий нь голд орхив. Гэдсий нь ганд (торхонд) хийв. Рогмагийн сүнсийг шар цөгций (цагцхай?) шувуу болгож хувилгав. Хэлтгий хар цачирт, гагч хар чмаатай орхив. Тэр ямааны сүү нэг аяга, тэр сүүний

тос нэг шанаг төдийг иддэг байв.

Дээрээс Цас хэлэв: “Ай Гэсэр хаан минь! Энэ Рогмаюд чамп хоёр тус хийв. Над нэг тус хийв. Түүнийг санавал Рогмаг гуаг эдгээж ав” гэв. Гэсэр хаан: “Цас Чихэр авгайн минь зөв ” гээд эдээгж авья гэв. Гэсэр мэргэнхаан хэлтгий хар цачирт нь өөр биеэр хувилж оров. Шанагны чинээ тосыг зуугаад тавив. Нэг аяга сүүнд сахлынхаа үзүүрийг хүргээд нуугдаж хэвтэв. Рогмагийн хувилгаан сүнас шар цөгцгий тооно дээр ирж суув. Суугаад хэлэв: “Энэ тосыг минь зуусан шүдний ором нь Гэсэрийн минь сахалтай адил. Авай богд минь мөн болбол яахав? Биш болбол миний адил болтугай ” гэв. Гэсэр тэр үгийг мэдээд есөн салаа төмөр урхиа орхиод цөгцгийг б арив. Бариад өөр өөр тавьсан биеийг нь цуглуулав. Цуглуулаад Цасын үгээр мөн биед нь тохруулав.

Чингэсэн хойно Гэсэр мэргэн хаан рогма гуаг аван очив. Аваачаад газартаа Нолом талд хүрэв. Чандмань эрдэнэ, цавгүй хар нүүрс, алтаар бичсэн ганжур Данжур хоёр их хөлгөн ном, арван гурван очирт сүм, тэд бүгдээ шинэтгэн засав. Гучин баатар, гурван зуун хошууч, гурван тоог улсынхаа үр үндсийг төгсгөөд тэнгэр нарын жаргалангаар жарган суув.

Цасын хүү Лайцавыг Рогмад өгөв.

Төдий Алтан дагина (Рогма гуа) ачит мэргэн Гэсэр хаанд ийн айлтгаруун: “Амраг Цас Чихэрийн хүү Лайцав, нанчүнгийн хүү Райцав энэ хоёрын нэгийг над хайрлах ажаамуу” гэвэл Гээр хаан зарлиг болруун: “”Алтан дагина! энэ чинь зөв Чи арлан гуагаас (Түмэнжаргалангаас) гуй. Чамд нэгийг нь өгнө биз. хэрэв эс өгвөл Ажу мэргэнд хэл. Ажу мэргэн мэдтүгэй . Би чамд нэгийг нь билээ. Чиний урьд Арлан гуад өгч билээ. Эдүгээ нэгийг чамд авч өгвөл чамд амраг байна. Арлан гуад таагүй байна гэж хамаг улс иргэн минь чингэж санах болно. тиймийн тулд Ажу мэргэн мэдтүгэй гэгч минь тэр бүлгээ” гэв. Төдий Алтан дагина хоёр алтан хөхүүрт арз архи хийгээд таван зууг дагуулаа дагуулаад очтол Арлан гуагийн гэрт Ажу мэргэн сууж байна ажээ. Алтан дагина Арлан гуа, Ажу мэргэн хоёрын мэндийг нь асуугаад Арлан гуад аяга бариад ийнхүү айлтгаруун: “”Чиний хоёр хүүхдийн нэгийг гуйхаар ирлээ” гэвэл. Арлан гуа асууруун: “ Гэсэрээс иштэй юу?” гэж асуувал.Алтан дагина өгүүлрүүн : “ Гэсэр мэдсэнгүй. Би өөрөө санасан минь энэ бүлгээ. Арлан гуа хилэгүнээд : “ Чи урьд болбол надад хар санаж Цотон та хоёужл мангаын газарт хөөж орхв. Эдүгээ хоёр хүүхдийн минь нэгийг өг гэнэ. Би өгөхгүй. ” гэв. Алтан дагина өгүүлрүүн : “Чамайг би урьд хар санаж мангасын газарт хөөж орхисон минь үнэн бана. Хорт Гурван Шарайголд чи хар санаж намайг хөөж орхисоныг яах вэ ? Эдүгээ үргэлж хүний худалч үгэнд орж над уурладагуу? ” гэвэл. Ажу мэргэн зарлиг болруун: “ Би та хоёрт үг хэлье. Бид гурвуул Гэсэрийн хатан биш билүү? Би Алтан дагинаыг өмөөрч хэлэх биш. ингэж гуйж ирсэнд чи өөрөө мэдээсэй ” гэсэнд. Арлан гуа : “Ажу мэргэний үгэнд ороод хоёр хүүхэнд минь над ялгалгүй билээ. Чи дураар мэдэж нэгийг ав гэж хэлбэл Алтан дагина баярылаж мөргөөд Цасын Хүү Лайцавыг аваад харьж ирэв. Гэсэр хаан эхлэн бүгдээр тэнгэр нарын жаргалаар жарган суув.

**АРВАН ЗҮГИЙН ЭЗЭН ГЭСЭР ХААН АРСЛАН МЭТ ГУЧИН БААТРАА
ЭДГЭЭЖ АВААД АХУЙ БҮГДЭЭ ТӨГСГӨЖ АМГАЛАН ЖАРГАН
СУУСАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

Түрүүчийн явдал

Арван зүгийн хамаг амьтныг эзлэн суусан арван хорын үндсийг таслан төрсөн арслан богд Гэсэр хаан, арван хоёр толгойто мангасын тивд өөд болоод Замбутивийн хөдлөх маьтны нэгэн өрөвхийхдээ таар залгигч хар шулмасыг арван зүгйн эзэн богд асар рид хувилгаанаар доройтуулан дараад Арлан гуа хатнаа аван арван хоёр толгойтой мангасын газарт алтан сувраганы дээр сууж байтал Арлан гуа хатан нь амьтныг өршөөгч дагина мөн бөгөд атархах сэтгэл нь ихийн тулд аливаа бүгдийг мартуулах баг нэрт хар идээг хорзонд нь нийлүүлээд арван зүгийн эзэн ГЭсэр хаанл айлтган барв. “” Аяа, арван зүгийн арван орхын үндсийн тасалсан аюух мэт богд минь, чи арван хоёр толгойтой мангасыг алаад ,Арлан гуа чинь маш баярлаж байна. Аяа богд минь зооглон соёрх” нээд богдод өргөвөл арван зүгийн эзэн Гэсэр хаан үл эндэх бөнгөөтөл эндэх хэмжээ нь хүрсний тулд авч зооглоод аливаа бүгдээ мартан суув.

Ачит богд Гэсэр хаан арван хоёр толгойт мангасын газарт аргагүй есөн жил суусан тэр чалаанд шарайголын гурван хаан ирж алтан өнгөт нолом тал дээр довтолж аливаа бүгдээ тэлэгдэдэх арван зүгийн эзэн богд эс мэдэв. Огторгуйгаас асар ялгуусан гурван дагина эг нь аливаа бүгдлийг үзэж асар маш ихэд гашуудан: “Эвүү! Аливаа юманд эс эрсдэсэн нцусгай минь Арлан гуа хатныхаа баг идээнд эрсдэв үү? ” гээд мангасын газарт өөд болж хүрээд хувилгаанаар Гэсэр хаанд мэдүүлбэл эс мэдэв.

Түүний хойно Алтан Дагина (Рогма гуа) эрдэнэт Цас Чихэр шидэт цагаан суманд бичиг бичиж Гэсэр хаанд элэч илгээв арван зүгийн эзэн богд сумны бичгийг үзээд : “Эвүү, Эвүү! Эрдэнэт Цасын минь сум бишүү энэ?” гээд аливаа бүгдээ санатал Арлан гуа хатан нь “Аюух мэт богд минь өлсөвүү? ” гээд баг идээгээ бариан зооглуулаад мартуулав. Түүнийхойно ялгуусан гурван эгч нь бас мангасын газарт өөд болоод бодолт биеэр байж Гэсэр хаанд зарлиг болж хайлав: “Аяа нусгай минь! Дээд биенд чинь арван зүгийн бурхан төгссөн авай. Дунд биенд чинь дөрвөн их тэнгэр нар солбицон давхарласан давхар хүчит нусгай минь! Арван гурван очирт сум, алтат цагаан суврага, амьд чандмань эрдэнэ энэ бүгд чин аль вэ? Эвүү яалаа чи? Доод биенд чинь найман Лусын хаад тулан сахисан тулгат Гэсэр минь! Тунамал эрдэнэсээр байгуулсан орд харш чинь аль вэ? Эвүү яалаа чи? Амь бие мэт учирсан амраг Цас Чихэр ах чинь аль вэ? Зүрх мэт учирсан Шуумар баатар чинь аль вэ? Сэитгэлээр чинь учирсан арван таван настай нанчүн ач чинь аль вэ? Гучин баатар гурван зуун хошууч чинь аль эв? Наян найман тангадын дарлага болсон наян настаы Царгин авга чинь аль вэ? Нуур далай мэт ч уулсан гурван тоог их уулс чинь аль вэ? Эвүү яалаа чи? Гэсэр минь! Шарайголы гурван хаанд аливаа бүгдээ агир болтол үл мэдэх чинв юу билээ? Арлан гуа хатныхаа баг идээнд дарагдавуу? Эвүү яалаа чи? Гэсэр минь үтэрхэн мордоосой чи! Гэж ялгуусан гурван эгч нь хайлан байж зарлиг болбол арван зүгийнэзэн Гэсэр богд хаан идсэн хар баг идээгээ тас бөөлжөөд ахуй бүгдээ санаад арслангийн ду гарган хайлбал наян найман үет алтан суврага хийгээд дөрвөн өнцөгт их хот болгос бүгд гурван үе эргэж тогтов.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан арван хоёр толгойтой мангасын аливаа бүгдийг тас түймэрдээд, Арлдан гуа хатнаа аваад өөрийн газарт ноломн талыг зорин явж хүрээд даруй дээр билгийн хээр морио унаж, элдэв чимгүүдээ өмсөөд хорт гурван шарайголын хааны мөрт орж хүрээд арван зүгийн эзэн богдд мянган эхт хувилгаанаар Шарайголын гурван ханы уг

язгуурыг таслаад Алтан дагина (Рогма гуа) хийгээд аливаа бүгдээ төгсгөж аваад арван зүгийн эзэн Гэсэр хаан ахуй их нутгийнхаа зүгт заларч өөд болоод зуун найман асарт хот, арван гурван очирт сүмээ байгуулаад суув.

Гэсэр, алагдсан баатруудаа гашуудав.

Тэгтэл начн наст Царгин өвгөн тэргүүлэн гучин баатар гурван зуун хошуучаас үлдсэн нэгэн хэдэн баатрууд, найман анст Лайцав хөвгүүн тэргүүлэн гучин хошууаас үлдсэн үр үндэс бүгдээр Гэсэр хаан золгохоор ирэх бараас арван зүгийн эзэн Гэсэр богд үзээд: “Энэ ирэгч аль баатрууд вэ?” гэж зарлиг болбол Алтан дагина өгүүллрүүн: “Ээ богд минь: Энэ Царгин өвгөн эхлэн хүүхэд шуухад байна” гэж алтгавал арван зүгийн эзэн Гэсэр хаан ариун богд Царгин өвгөнийг гагцаар тэргүүлэн ирэхийг үзээд гучин баатар гурюван үуун хошууч санаад арван зүгийн эзэн Гэсэр хаанын ариун сэтгэл нь будангүй болж арслан мэт дуугаа гарган хайлан зарлиг болруун: “Ай! хүний харцага болсон хүрэл эрдэнэ мэт зүрхт, хүний урьд ирэгч амраг Цас Чихэр минь Эвүү яалаа! Хүний бүргэд болсон бултралгүй санаат богд эрдэнэ мэт зүрхт, бурантгаггүй заан мэт хүчит эрдэнэ, эрийн эр эрхт Шуумар минь аль вэ? Эвүү яалаа. Хамгийн нагац болсон харгүй сэтгэлт, халтиралгүй чин зоригт, хас эрдэнэ мэт зүрхт, хар багаас хүчээ өгсөн хамгийн дарлага болсон Буйдан минь Эвүү яалаа? Арслан зааны хумс болсон амьтны дотор начин болсон ашдын дарлага үл сулдагч зүрхт наян найман Тангадын ач болсон начин шонхор мээ арван таван настай эрдэнэт эрх нанчүн минь аль вэ? Эвүү яалаа? Хар чулуу мэт зүрхт, хар эрээн барс мэт довтолдог хатан хар болд мэт биетэй хар хад мэт Барс баатар минь аль вэ? Эвүү яалаа?” гэж гашуудан хайлбал эрдэнээс бүтсэн хот балгас нь гурван үе эргэж тогтов. Эрхт хурмаст тэнгэрийн хөвгүүн эрдэнэ Гэсэр хаан дуугаа хураан сан тавьж тогтоов.

Алтан дэлхийнг тогтоогоод арван зүгийн эзэн Гэсэр хаан дөрүй дээр: “Билгийн хээр морийг минь үтэр барь. Бэлэн элдэв чимгүүдийг минь гарга. Би гучин баатар, гурван зуун хошуучийнхаа ясыг эргэж үзсүү” хэмээгээп “Аяа, Царгин авгай! Ямар явдал болсон бэ?” гэж асуувал Царгин өгүүллрүүн. “Ачит Гэсэр хаан минь ээ! Нолом талын дайсны цэрэг бүрхэж ирэхэд нуур далай мэт сэтгэл минь нэг мөсөн хав хар болж юу ч эс мэдэв би. Ээ! богд минь, урьд орд харш байгуулсан уудам зүлгээс цааш Хатны голын эх хүртэл байлдаан болсон билээ. Аяа хамгийн эзэн богд минь би хав харлаж хоцорч гагцхан Цас Чихэрээс өөр нэг ч баатрын барааг үзэсэнгүй” гэж Царгин өвгөн уйлж байж там тус айлтгавал арван зүгийн эзэнг Богд ч болов хайлж байж там тум сонсоод гуин баатар гурван зуун хошуучийн байлдсан газарт зорин өөд ыболов.

Гэсэр хааны хойноос наян намтай Царгин өвгөн заан шарган морио унаж солгой баруунгүзй савж зөв буруугүй зовсоор (гуядсаар) явав. Арван зүгийн эзэн богд арслангийн дуугаа гаргаж хайлсаар атаат гурван Шарайголын байлдсаа газарт хүрэв. Хүртэл хамгийн урьд Барс баатар, Буйдан баатар хоёр орж үхсэний тул Барс баатар, Буйдан хоёрын ясыг үзээд баатар Гэсэр хаан үхэитхийн унав. Тэр ясны дээр үхэтхйн хэвтгэл Царгин өвгөн хүрч ирэн Гэсэр хаанй унасныг үзээд: “Эвүү! Богд минь, юу болов?” гээд Боудыг ноцон зуурав. Царгин өвгөн хамгийн эзэн Богдын үхэтхийснийг үл мэдэн нэгэн үе үхэтхийж нэгэн үе сэхээ орж, барьж бархирч аргаа барсны хойнол дээш өндийн байж “Арван зүгийн эзэн Богд минь ингэж өөд боох ёсгүй билээ. Ёст баатрын ясуудыг үзээд үхэтхийвүү?” гэж Царгин өвгөн эрүүнийхээ сахлыг үгтээж Богдыг утав. Утасны хойно арван зүгийн эзэн богд арайхан тэнгэрч дээш өөд болоод ийн тийн хялам хийж харж үзвэл Барс баатар Буйдан хоёрын ясны хооронд унасан ажээ. Богд түүний цаана очтол нэгэн газар хоёр их ясыг үзээд арван зүгийн эзэн богд “Аяа! яалаа. нанчүн, Шуумар хоёрын минь яс бишүү?” гээд үл тэсэх бэрх их дуугаа гаргаад

тэсэшгүй хоёр баатараа дурдаж үхэтхийн унатал нанчүнгийн сүнс арслан болон түшив. Шуумарын сшнс Заан болон түшив. Ачит Богдыгоо унахад амьд мэт түшээд эс унагав. Арван зүгийн эзэн сэхээ рооод зүүнтээшээ харал арслан түшиж байна гэнэ. Баруунтаашаа хартал заан түшиж байна аж. Арван зүгийн эзэн Гэсэр хаан тэр хоёрын хүзүүг тэвэрч Нанчүн, Шуумар хоёроо дурдаж арван зүгийн бурхан төгссөн санаагаа арван зүгт санаж аливаа бүгдээ дуудан хайлав. “Ачит гуяин баатар минь Эвүү яалаа! Адилтгаж үл болох гурван зуун хошууч минь Эвүү яалаа! Арьснаас минь ялгалгүй Нанчүн, шуумар хоёр минь Эвүү яалаа! Аминаас минь ялгалгүй амраг Цас Чихэр авай минь. Эвүү яалаа! Асар их улсын урд хошууч болсон Барс батар минь. Эвүү яалаа! Хар багаа хүчээ өгсөн хамгийн урьд харуул болсон, харангуй шөнө зул болон хайран Буйдан минь. Эвүү яалаа! Хайрт гучин хошууч, гурван зуун баатрууд минь Эвүү яалаа! Хас хад мэт байгуулсан шашин төр хоёр минь. Ханаран хүрээлэн байгуулсан гурван отог их улс минь. Эвүү яалаа! Хамгийн эзэн би мөн бөгөөтөл хамаг бүгдээ тал болтол үл мэдэв. Арван хоёр толгойт хар мангасын хараалд дарагдав би. Аргт их Арлан гуа хатныхаа баг идээнд балагтав би. Эвүү яалаа! Гэж хөх огторгуйд дуугаа гарган хөх луу мэт хөвчин алтан дэлхийг доргитол хайлбаол гурван зуун баатар, гуин хошуучий нь сүнс арслан, заан барс, чоно болон хувилж ирээд арван зүгийн эзэн Богдыг гурван давхар хүрээлэн байж хайллаа.

Гэсэр үхсэн баатруудаа эдгээх арга эрэв.

Арван зүгийн эзэн Богдын асар ихэд хайхрлах дууг огторгуй дахв ялгуусан гурван дагина эгч нь сонсоод Хурмастын орд харшаас өөд болж ирээд, Арван зүгийн арван хорын үндсийг тасалсан ачит Богд Гэсэр хааныгш хамаг баатруудын сүнс нь хүрээлэн байхыг үзэн үзэн үлэмж ихэд гомдон гомдон гучин баатар, гурван зуун хошуучтайгаа санан санан дурдаж хайлахад гучин баатарын яс алтан дэлхийг доргитол Гэсэрийн дэргэд цуглаж хот мэт хүрээлэн байв. шарайголын гурван хааны цэргийн яс бүхий л Хатны голд урсав. Ялгуусан гурван дагина эгч нь : “ Ннгусгай минь ингэж тасралтгүй их дуун гаргах ёсгшүй билээ. Юу болов? ” гэж яаран хүрч ирэв. Гэсэр амраг гучин баатар, гурван зуун хошуучийнхаа ясан дээр хайлан байхыг гурван эгч нь үзээд. “Эвүү, аяа нусгай минь! Гучин баатрынхаа тулд гашуудаж бана. ” гэж яарч хүрч ирээд бодот биеэр байж зарлиг болов: “ Аяа нусгай минь! Чи юуны тулд үлэмж ихэд хайлав ? ” гэж зарлиг болбол арван зүгийн эзэн богд асрлан, заан хоёрын тэргүүнийг тавиад : “ Ээ, ялгуусан гурван эгч минь! Ийм зарлиг юунд болно та ? Энд урьд би Хурмастын орноос ирэхдээ эрхт шингэмуни бурхан багшийн бошиг зарлигаар эцэг Хурмаст тэнгэр ахайн зарлигаас үл давахын тулд би мах яс хоёроо гэж магад таван махбод, таван бэлэг билэг төгссөн биеэ тэвчиж мөн энэ Замбутивийн оронд ирэх цагтаа ингэж ганцаар ирлүү би? Тэндээс ирэх цагтаа ингэж хэдүүл ирлүү би? Эдүгээ би хэдүүлээ бана вэ? ” гэж зарлиг болоод бас хайлж байхад ялгуусан гурван дагина эгч нь эс тэсэж бас хайлалцав. Хайлаад гурван дагина зарлиг болов: “ Аяа нусгай минь! эдүгээ бүү гашууд. Үргэлж хайлах эм хүн билүү чи? Бид гурвуул одоо хурмаст тэнгэр ахайд ячинь айлтгая. Гучин баатар чинь чамаас урьд юутгэх заяатай болбол аргагүй б айна. Чамд минь үргэлж хүчээ өгөх заяатай болбол Хурмаст ахай чинь мэднэ биз” гээд огторгуйгаар өөд болсонд арван хүчин төгссөн арван зүгийн эзэн Гэсэр хаан гучин баатрыгаа эдгэсэн мэт маш их баясаад дээш өөд болж арван зүгийн бурханыг оройдоо сэтгээд адистидет идээгээ зооглон суув.

Тэндээс ялгуусан гурван дагина эгч нь Хурмаст тэнгэрт хүрээд ийн айлтгав:”Бид гурвуул доор Замбутивд нусгайнхаа дууг сонсоод очиж үзтэл нусгай минь арван хоёр толгойтой мангасыг нэхэж Арлан гуа хатнаа авахаар очсон тэр чөлөөнд нь атаат Шарайголын гцурван хаан гэгч ирж довглоод арван гурван эрдэнэс сүмийг эвдэж, алтан цагаан суврага, амьд чандмань эрдэнэ хийгээд Алтан дагиныг нь аван, гучин баатрыг нь алаад явсны хойно манай нусгай мангасын газраас ирээд гучин баатрынхаа үхсэн ясан дэр гашуудаж байына. Бид гурвуул сургаж эс болоод Хурмаст ахайд айлтгая гэж ирэв“ гэв.

Тэндээс хурмаст тэнгэр зарлиг болруун: “Эвүү! Үйл бүтээгч минь! Тэнд хоосон ясан дээрг гомдохоор энд ирж манд золгоод харивал яана? Бид аргыг мэдь” гэж зарлиг болоод ерөн есөн найман Донли нэрт заяаны бичигт нээж үзтэл “Гэсэр хаан тэнгэрээс дагуулж очсон заяат бааьрууд Гэсэрийн урьд юүтгэх ёсгүй бөгөөтөл эрт урьд тэрсүүдийн гурван тэнгэрийг үйл бүтээгч эхлэн есөн үе тахлан довтолсооны үр төлөөс нь эдүгээ нэгэн үе эндэхийн шалтгаан болж амтаг тэвчсэн нь тэр байна” гэж Хурмаст тэнгэр зарлиг болов.

Шингэмуни бурхан баатруудыг эдгээх рашаан хайрлав.

Шингэмуни бурханд Хурмаст тэнгэр тэггүүлэн хамаг тэнгэр нарыг дагуулан өөд бож шингэмуни буорхны гэгээнээ мөргөөд Хурмаст тэнгэр ийн айлтгав : “Аяа Бурхан багш! Замбутивд илгээсэн Үйл бүтээгчийн эндээс дагуулж очсон гучин баатрууд нь дайсанд эрсдэж үхсэнд нь үйл бүтээгч маш их гомдсоор байна гэж гурван хүүхэн минь үзээд над ирж хэлэв. Би сонсоод Бурханд айлтгаж байна. Түүнийг яаж аргалах вэ?” гэж айлтган сөгдөв. Тэгээд бурхан багш мишээж зарлиг болруун: “ үйл бүтээгч тэнд дэмий гомдохоор нааш ирэхгүй яасан юм бэ?” гэж зарлиг болоод : “Аяа Үйл бүтээгчийг урьд тэр баатрууд үхэх ёсгүй бөгөөтөл тэр шалтгаан нь урьд цагт тэрсүүдийн гурван тэнгэрийг үйл бүтээгч эхлэн явж есөн үүе доройтуулсаан тэр цагт тэр тэрсүүдийг гурван тэнгэр ийн өгүүлжээ. “Эдүгээ маньг нэхжэ ирээд есөн үе талж үйлдэв. Хойно бид таныг нэгэн үе ингэж эндүүлэх болтугай фгэж хутаг гуйснаар, тэр гурван тэнгэр эдүгээ хүч ихтэй гурван хаан болж төрөөд урьд ерөөлийн хүчээр эднүүсийг эндүүлсэн учир нь тэр бөлгөө. Эдүгээ боловч гайгүй”” гэж зарлиг болоод Бурхан багш өмнөө тавьсан мянган бурхны хутаг оршуулсан хар бадар аяга дотрох рашаанаас нэгэн хумханд хийж Хурмастын гарт соёрхоод зарлиг болруун: “Энэ рашааныг “Үйл бүтээгчид өгч илгээ” гэв. ”Энэ рашааныг тэр үхсэн баатаруудын ясан дээр нэгэнтээ дусаавал үе гишүүн нь төгсөөд мах арьс гүйцэх болно. Хоёронтоо дусаабал мөн бие биедээ тохорч босох болно. ” гэж зарлиг болоод бас нэгх өөр рашааныг авч соёрхоод : “Энэ рашааныг уулгавал өөр өөр салсан сахиус нь бие биенд нь нөхцөөд таван махбод нь төгссөн урьд биендээ тохорч болн” гэж зарлиг болоод Хурмастад соёрхов. Тэр рашааныг хурмаст тэнгэр авч ирээд гуран дагинаар өгч илгээхдээ ийн зарлиг болов: “үйл бүтээгч! Чи эдүгээ болтол гэнэ чинь юуны шалтгаан бэ? Дээд биенд чинь арван зүгийн бурхан төгссөн, Арьяабал Ишварийн хувилгаан Гэсэр хаан бишүү чи? Дунд биенд чинь дөрвөн их тэнгэр нар солбицсон давхарласан дөрвөн догшдын худилгаан Гэсэр хаан бишүү чи? Доод биенд чинь найман их Лусын хаан тулан сахисан наячна найман шидтэний нэгэн хуидгаан Гэсэр хаан бишүү яи? Бэлхүүсээр чинь зүүн найман эх дагинас ороон сахисан шагжлигуудын язгуурт Гэсэр хаан бишүү чи? Арван зүгийн амьтныг эзлэн сахисан, хотол хамаг амьтныг тойндоо (эрхэндээ) оруулсан Хурмастын язгуурт Гэсэр хаан бишүү чи? Хотол эндээс дагуулж очсон баатруудынхаа биенээсээ салгалгүй дагуулваас аливаа юманд эрсдэхгүй билээ” гэж Үйл бүтээгчид ингэж хэлээрэй гээд рашааныг өгөв.

Гэсэр рашааныг дусааж баатруудаа эдгээв.

Гурван дагина тэр рашааныг аваад огторгуйгаас буухдаа хорин луугийн дууг гарган хүржигнэсээр бууж ирэхийг арван зүгийн эзэн Гэсэр богд сонсоод зарлиг болруун: “ Ая, ялгуусан гурван эгч минь баяртайа айсуу . Гучин баатрыг минв эдгээх байна” гэж зарлиг болыбол Царгин өвгөн Гэсэр хааны зарлигийг сонсоод малгайгаа авч ы арван зүгийн эзэн Богдод есөнтээ наманчлаад : “Ая, арван зүгийн эзэн арван хорын үндсийг таслан төрсөн авай, аяит Богдын минь зарлигаар болтугай. Амраглан дагуулсан гучин баатар чинв эдгэх болтугай. Аливаа хүслээ хангаж жаргах болтугай. Өшөөтнөө өлмий дороо гишгэж, занаснаа зуузайдаа дарах болтугай” гэж ерөөж байтал гурван дагина хүрч ирэв.

Арван зүгийн эзэн Богд угтаж босоод: “Ая, ялгуусан гурван эгч минь! Яьдал зоригоо бүтээж ирэв үү?” гэж зарлиг болбол “Очсоны хойно үл бүтээх гэж байхуу ?” гэж гурван эгч зарлиг болов. Гэсэр хаан тэр зарлигийг сонсоод малгайгаа авч ялгуусан гурван эгчдээ мөргөвөл гурван дагина нь зарлиг болруун : “ Эвүү, эвүү Нусгай минь бидэнд юунд мөргөв чи? Мөргөх ёсгүй бишүү” гэж зарлиг болбол Гэсэр хаан зарлиг болруун “Хамаг амьтныг нигүүлсэгч наран ялгуусан гурван эгч минь! Хамаг бүгдийг минь зааж өгөгч Оточ бурхан мэт ялгуусан гурван эгч минь! Хаана одвол хагацалгүй нөхцөгч сүүдэр мэт дагагч ялгуусан гурван эгч минь! Хамаг хүслийг минь хангагч чандмань эрдэнэ мэт ялгуусан гурван эгч минь! Амраг ялгуусан гурван эгчдээ мөргөхөд юу билээ гээд гурвантаа наманчлаад алтан сандал дэр суув.

Ялгуусан гурванг эгч дагина бас алтан сандал дээр суугаад: “Ая, Нусгай минь! Шигэмуни бурхан багшийн зарлиг : “ Эдүгээ энэ баатрууд чинь Гэсэрээс урьд үхэх ёсгүй билээ. Эрт урьд цагт тэрсүүдийг гурван тэнгэрийг чи баатруудаа дагуулан явж есөн үе талж идэсний үрээр эдүгээ нэгэн үе эндэх учир нь энэ гэнэ. Бурхны соёрхсон энэ рашааныг баатруудын ясан дээр нэгтээ дусаавал үе гишүүн нь төгсөөд, арьс мах нь гүйцэх гэнэ. Хоёртаа дусаавал махбод нь гүйцээд амин сүнс нь тэгсэх гэнэ. Гурвантаа дусаавал мөн биедээ тохрох болно гэж зарлиг болов. Бас нэг рашааныг уулгавал өөр өөр салсан сахиус нь биедээ нөхцөөд таван махболд нь урьдах биедээ тохрох болно гэж рашааныг хайралв гэв.

Тэр зарлигийг сонсоод арван зүгийн эзэн Богдын ариун сэтгэд нь наран ургсан мэт маш ихэд баярлан байтал ялгуусан гурван эгч нь Хурмастын сургаал зарлигийг тоолж зарлиг болбол арван зүгийн эзэн богд ийн зарлиг болов: “Хурмаст ахайн минь зарлиг маш зөв. Би энэ Замбутивийн баг идээнд дарагдаад эндэж гэнэ болов. Надаас байтугай хурмаст тэнгэр ахай минь Шингэмуни бурхны зарлигийг мартаад долоон зуун жил болтол эс санаад Сударсан балгасны нэгэн талыг эвдэртэл эс мэдсэнээ санаж байна уу?” гээд. “тэгэвч Хурмаст ахайн минь зарлиг маш зөв гэж айлтгаарай, гурван эгч минь!” гэв. Гурван эгч нь : “Ая хурмаст ахайд чинь айлтгасуу” гээд огторгуйд өөд болов.

Эдүгээ арван зүгийн эзэн Гэсэр хаан босож Шигэмуни бурхан багшминь гэж ес ес наманчлав. Дэдэд нь болбол Хурмаст тэнгэр ахай минь нэгэнтээ дусаавал үе гишүүн нь төгсөөд арьс мах нь гүйцэв. Хоёртоо дусаавал мөн биедээ тохрох амин сүнс нь гүйцээд дэш болов. Гурвантаа дусаавал мөн биеэр болон дээш босоод очрын завиллаар завилан сув. Бас өөр өөр рашааныг уулгавал өөр өөр салсан сахиус нь бие биенд нөхцөв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан гучин баатрууд аян цагт яваад одоо гэртээ буусан мэт бүгд и дүрхэрч босоод Богдын тэвэрч зэргээр хайлбал арван зүгийн эзэн гучин баатруудаа үзэж арслан луугийн дуугаа гурван ертөнцөд сонсдол тачигнуулан хайлан зарлиг болруун: “ Хурмастын орноос дагуулж ирсэн гучин баатар минь! Хуьт биеэ алгасалгүй дагуулсан гучин баатар минь! энэ биенээсээ хагацалгүй дагуулсан гучин баатар минь! хайрт хар биенээсээ хагацалгүй дагуулсан гучин баатар минь! “ гэж хайлж байхад хүний бүргэд болсон Шуумар, арван таван настай эрх Нанчүн, зургаан зүйл амьтны хэл мэдэх хэлмэрч Буйдан _ Барьснаа үл алдагч Барс баатар эхлэн гучин баатар бүгдээр блгдын хормойноос барьснаа тавин цөм сөгдөн айлтгав:””Арван зүгийн арван хорын үндсийг таслан төрсөн аливаа бүгдийн зүрхийг атган төрсөн, арван зүгийн эзэн Богд минь! дөрвөн тивд Сүмбэр уул мэт биет, дөрвөн тивийн амьтныг тэгш эзлэгч аугаа хүчит, алтан дэлхий дээрх хамаг амьтныг тойндоо оруулагч тэнгэрлэг Богд Гэсэр хаан минь! Арван хоёр толгойт манасыг нэхэж Арлан гуа хатнаа авахаар явсны тэр чөлөөнд атаат гурван шарайголын цэрэг мордож ирэхэд Цас Чихэр авгай эхлэн гучин баатар бид өмнөөс нь нэг нэгээр угтаж очоод эрийн сайныг эндүүлж, агьны сайнбыг олу болгож вгал хорт Цотон ноён Шарайголд очоод баригдаж ирэд биднийг бүгдийг хуурч, тэдэнтэй зохицож мэхлэхэд Цас Чихэр авгай эхлэн бүгдээр хэлэлцэв. “Цотон ноён авгай харь дайсанд урвах гэж байхгүй. Энд бидэнд эрхэлж байна” гээд бид бүгд тархав. Атаат Цотонгийн хууралтанд орж байсаар аливаа бүгдээ тал болгов. Алиныг тоолж барах вэ? Арван зүгийн эзэн Богд минь гэрт үгүй байхад Цас Чихэр эхлэн гучин баатар бид амь биеэ хайрлалгүй орж цавчилдав. “Алж барах дайсан биш байна: Амиа гарая” гэмээр байлаа. Хойн гучин баатар дайснаас зугатаж гарав гэвэл хайран арван зүгийн эзэн Богдын минь мянган галавг хүртэл дуурсах нэрд муу байна гэж хар амиа хайрлалгүй явж үхсэн минь тэр билээ. Эдүгээ бид хувилгаан гурван эгчин ёинь ёин зоригоор, хурмаст тэнгэрийн зарилгаар, хутагт бурхан багшийн адистидээр, арван зүгийн эзэн Гэсэр хаан чинийхээ ачаар чамдаа золгов. Богд минь бүү хайлаасай! “ гэж сөгдөн мөргөвөл арван зүгийн эзэн Богд :” Ая би Хурмастын орноос дагуулж ирсэн хамаг баатруудаа бултыг үзэж баярлав би. Хүрэн эрээн барс мэт довтолгоот хөх тарлан харцага мэт шүүрээт, хөх луугийн цахилгаан мэт аугаа хүчит Цас Чихэр минь аль вэ? Эвүү яалаа!” _ гэж Цасыг дурдаж гурван үе хайлаад дуугаа хураан алтан дэлхийг сан тавьж тогтоов. Арван зүгийн эзэн Богд, гучин баатрууд, гурван зуун хошууч, гурван отог их улаа хурааж нуур далай мэт их хурим хийж найрлан суух цагт арван зүгийн эзэн Богдын санд дарсан мөрөнд хоёр лянхуй цэцэг бүтсэн, ар өвөрт нь нар сар хоёр бүтсэн, өдрийн цагт хүн харж, үл болох, шөнийн цагт зүл үл хэрэглэх тифйм ёандманьт дээлүүдийг гаргаж гучин баатартаа нэг нэг өмсгөвөл гучин баатар тэр дээлмйнг өмсөөд арван зүгийн эзэн богдод мөргөөд гурван сар болтол хуримлан жаргаад гэр гэртээ харив.

Ардан зүгийн эзэг Гэсэр хаан арслан мэт баатруудаа эдгээж ахуй бүгдээ төгсгөж амгалан жарган суув.

**АРВАН ЗҮГИЙН ЭЗЭН ГЭСЭР ХААН, АВАРГАСЫН ХААН
НАНДУЛАМЫГ ДОРОЙТУУЛСАН ДОЛДУГААР БҮЛЭГ**

Нандулам хаан, Гэсэрийн таван муж улсыг эзлэв.

Арван зүгийн эзэн Богд Гэсэр хаан аливаа бүгд юмаа төгсгөж амгалангаар жаргаж бурхныг шашныг наран мэт мандуулж, ертөнцийн төрийг хаш хад мэт байгуулж суун атал Дохиурын тивээс Нандулам нэрт хаан дээд биенд нь түмэн нүдэт түмэн гарт Рахын хүч төгссөн, дунд биенд нь найман аврагсын хүчин төгссөн, аливаа юманд үл эрсдэх Нандулам нэрт хаан нэгэн хувилахдаа далан нэгэн хувилгалт гурван мянган баатартай, гурван зуун жаран хошуучтай, гурван дөнчүр гурван сая олон цэрэгтэй, арван гурван луугийн хүч төгссөн уулын чийнээ шар цоохор морьтой гэнэ.

Тэр хаан Ганга мөрний тэртээх дан нэр газрын таван муж улсыг тойндоо оруулаад харьсны хойно тэр тадан муж улсын хаан, арван зүгийн эзэн богдод элч илгээв. Илгээхдээ ийн захив: “За та нар одоод арван зүгийн Гэсэр хаанд ийн айлтга: Дохиур гэгч тивээс Нандулам нэрт хаан “Энэ Замбутивд надаас дээр хаан буй буюу?” гэж ирээд бидний таван муж улсыг довлон оруулж авав. Дайлж үлү болохын тулд бид орж өгөв. Баатрууд нь гурван мянган гэнэ. Хошууч нь гурван зуун жар гэнэ. Цэрэг нь гурван дүнчүүр гурван сая олон цэрэгтэй гэнэ. Унасан морь нь арван гурван луугийн хүч төгссөн уулын я чинээ шар цоохор морь гэнэ. Нутаг нь Дохиурын тив гэнэ. Арван таван жил явж хүрэх хол гэээр гэнэ гэж ингэж айлтгаарай” гэж гурван ноён тэргүүнтэй зуун хүнийг зуу зуун агт өгөөд “Та өдөр шөнөгүй дүлэн явж хүр! Гурван жил яваад хүр! Тэндээс гурван жил болоод хүрч ир!” гэв.

“тэр газрын хооронд есөн жил явах хол буюу. тэр зуун хнү Гэсэр хааны газрыг зорин явж гурван жил болоод хүрч ирээд арван зүгийн эзэн Богд Алтан орд харшийн дпэргэд нэгэн бээрийн газарт буугаад Богдын зүг ес ес мөргөөд сууваас тэр улсын ирснийг хорооны хамаг улс үзээд: “Эвүү эвүү, Энэ аль газрын улс вэ? Адбиш өөр” гэж гайхалцав. Тэр улст Гэсэр хаан илч илгээв. “Та аль газрын улс вэ? Энд юунд ирэв?” гэж элч илгээв. “Тэр элч ирээд гэсэрийн зарлигийг бүрнээ хүргэвээс тэр улс “Бид ганга мөрний тэртээх дан нэрт газраас ирэв. Манай ноён арван зүгийн эзэн Богдод үгээ айлтга гэж илгээв. Дохиурын тивийн Нандулам гэгч хаан гэнэ. Гурван мянган баатартай, гурван зуун жаран хошуучтай, гурван дүнчүүр гурван сая олон цэрэгтэй ирээд “ Энэ Замбутивд надаас өөр сайн хаан буй буюу ” гэж ирээд манай таваг муж улсыг довлон оруулж аваад харив. Манай таван муж улс дийлж үл болох гэж эс дайралдав. Тэр хааныг хариулаад манай манай ноён арван зүгийн эзэн Богдод айлтга гэж илгээв” гэж тэр элч Богдын дэргэд ирээд бүрэн төгсөөр дэлгэрэнгүй айлтгаваас арван зүгийн эзэн Гэсэр хаан гучин баатрууд бүгд ир! гэж зарлиг болбоос гучин баатрууд бүгд цуглаж ирэв. Богд зарлиг болруун: “ за та бүгдээр мэдэвүү? Ганга мөрний тэртээх дан нэрт газрын таван муж улсыг минь Нандулам хаан Дохиурын тивээс ирээд тэр улсыг маань оруулж аваад явав гэнэ. Түүнийг яах буй? Гэж зарлиг болбоос гучин баатрууд бүгдээр: “Богд минь гэгээндээ айлд” гэв. Баатар Шуумар “Авай айв юутай сайхан үг билээ?” гээд тачигнатал инээвээс дарлага болсон Буйдан дарлаглан өгүүлрүүн: “ Шуумар минь юуны тулд гагцаар инээв. Чи байз. Богдынхоо зарилгыг хүлээгээд хойно хэлэцэе” хэмээвэл. Арван зүгийн эзэн Гэсэр хаан даруй дээр Нандулам хааныг шинжлээд зарлиг болруун: “Баатрууд минь та мэдэв үү? Дохиурын тивд арван таван толгойтой Нандулам нэрт аврагсан хаан байна. Дээд биендээ түмэн нүдэт, түмэн гарт Рахын хүчин төгссөн, Дунд биендээ тэрсүүдийн дөрвөн их тэнгэр нар төгссөн, доод биенд нь найман аврагчын хувилгаан мангас байна. Унах морь нь бол арван гурван луугийн хүч төгссөн уулын чинээ шар цоохор морь байна. Нэг хувилахдаа далан нэг хувилах

байна. Суух гэр нь гурван асарт хот балгас байна. Хатан нь бол алтан наран арны гэрлийг дарах үзэсгэлэнтэй Бадмараг нэртэй гуа хатан байна. Асар ер холын тул нарийн эс мэдэв би” гэж зарлиг болбоос гучин баатрууд нь ийн айлтгав: “ Арван зүгийн эзэн, арван хорын үндэсийг тасалсан ачит богд өөд болох буййзаа. тэр мангасыг их хүчтэй байна гэмээж нь айх буюу? Айвал б айх буюу бид?” гэж гучин баатар нь ийн айлтгаваас :Арван зүгийн эзэн Богдод Шуумар Нанчүн хоёр сөгдөн ийн айлтгав.. "Есөн хүслийг минь ханатал зарлиг болсон заяат богд минь! ер арван зүгийн хортныг эцэглэсэн хядагч Донров нэрт Богд минь! Билгийн хээр мориндоо өөд болоосой. Бэхэлсэн эрдэнэт чимгүүдээ өмсөөсэй! Бэлэн байсан гучин баатрууд биднийг дагуулж үтэрхэн өөд болоосой. Бидний дотор тэсэж ядав” гээд Гэсэр хаанд мөргөвөөс арван зүгийн эзэн Богд мишээгээд зарлиг болруун: “ Хүний бүргэд болсон Шуумар минь байз, Хүрэгдэй бүргэдийн хумс болсон Нанчүн минь байз ” гэж зарлиг болоод “Эдүгээ бид хэдий чинээ олон цэрэг мордох буй?” гэж зарлиг болбоос баруун зэргийн эрхэн болсон, зургаан зүйл амьтны хэлийг мэдэгч хэлмэрч Буйдан сөгдөн айлтгав: “ Богд минь! Арван зүгийн хаанд арван элч илгээ” гэв. “Арваад арваад сая цэргээ авч бие биеэрээ цэргээ аван өдөр шөнөгүй дүлж явж ирээд Цэцэгт тал дээр цугла гэж зарлаасай. тэр цэргийг цуглуулаад Богд цэргээ ө аван өөд болоосой” гэж айлтгаваас арван зүгийн эзэн Гэсэр : “Энэ үг маш зөв” гээд арван зүгийн эзэн хаанд элөч илгээв.

Чингэтэл Шуумар заан ахйан хар морио унаж зуун найман давхар ш шөрмөсөн хөвчит мянга таван зуун хүйрт (хөвчний гогцоот) догшин хар нум юугаа дүрж, арьсан хар саадаг юугаа бүсэлж наян найман хангай хар сум юугаа яихэ, гилбэлгээн өнгөт хуягаа өмсөж, есөн алд молор хар шор юугаа зүүж Богдын дэргэд хүрч ирээд: “ Арван зүгийн эзэн аюух мэт Богд минь ээ! Таван хорын хүчин төгссөн арван толгойт мангасын хувилгаан ирж таван их муж улсыг минь идэв. Гэтэл ингэж удаж болох уу бид. Би урьдаар очоод туршсуу. ” гэж айлтгаваас арван зүгийн ээн богд зарлиг болруун: “ Эрийн эр эрдэнэт бүргэд шуумар минь! Энэ чинь маш зөв. Эдүгээ цэрэг хурж байна. Бид мордъё” гэж зарлиг болов. Гучин баатар, гурван зуун хошууч бүгдээр Шуумарын очих й болсныг мэдээд яаран мордож үелсэн биеэ ханилж, зүйлсэн чимгүүдээ өмсөж, жигүүрэлсэн морио унаж туг түмэн цэргийн чимээ гаргаж ирэхэд арван зүгийн эзэн Гэсэр богд цочиж зарлиг болруун: “Эвүү Нандулам хааны цэрэг хүрч ирэв үү! Энэ юу би билээ? ” гээд зарлиг болбоос баатар Шуумар эс мэдэж “За энэ бишүү” гээд заан хайсан хас морь юугаа тас гуядаж есөн алд хар шор юугаа суга татаад ухасхийвээс Гэсэр хаан цочин өндийж үзээд өөрийн баатруудаа танив. Шуумар харил халтиралгүй хүрч ирэхэд Буйдан үзээд : “Эвүү, эвүү! Энэ Шуумар бишүү?” гээд Буйдан өмнөөс угтаж өгүүлрүүн : “ Баатар шуумар минь! ” барс хийвэл довтолдог буюу? Барс мэт үсэрдэг буюу? ” гэж хэлбээс Шуумар Буйданг таниад тас хийтэл инээгээд морио татав. Нанчүн өгүүлрүүн : “ Шуумар минь нандулам хааны цэрэгт хүрсэн хойно инээх баяр тэнд буй за. Тал дээр дэмий инээдэг буюу?” гээд гучин баатар бүгдээрээ Богдын дэргэд хүрч ирээд нанчүн Шуумар хоёр бас сөгдө айлдав. “Арван зүгийн эзэн Богд минь айлдан соёрх. Далан нэгэн хувилгаант арван таван толгойт мангасын хааныг мянган хувилгаант мянган бурхны нэгэн биеийн чанарт хутагт Богд Гэсэр минь үл дийлэх буюу? Энэ олон цэргээ зовоож юу хийх буй ? Арван зүгийн эзэн Богд, бидний гучин баатар, гурван зуун хошууч юугаа дагуулаад шулуухан өөд болоосой. ” гэж айлтгаваас Арван зүгийн эзэн Гэсэр хаан Нанчүн Шуумар хоёрын үгийг зөвшөөрөн, Буйдангаас “Энэ хоёрын үг зөвүү? Буруу юу?” гэж асууваас Буйдан айлтгав. “Арван зүгийн эзэн богд минь гэгээндээ айлтга ” гэхэд төдий Гэсэр хаан олон цэрэг авч мордохыг байлгав.

Гэсэр хаан Нандулам хаантай байлдахаар мордов.

Эдүгээ арван зүгийнг арван хорын үндсийн тасалсан аюух мэт Гэсэр хаан гуин баатар, гурван зуун хошууч юугаа дагуулаад арван таван толгойт мангасын газарт аялан өөд болов. Арван таван жил явж хүрэх хол газрыг арван зүгий эзэн Гэсэр богд арван хоёр сарын газар болгон товчилж явахдаа наян наст Царгин өвгөнийг “Гэртээ улс малаа захирч суу. Харь!” гэж зарлимг болбоос Царгин өвгөн өгүүлрүүн: “Авай богд минь. Би эдүгээ дахиж наян наслаад ч ийм их хуримыг үезэх үү би? Эрт эцэг минь хурмаст тэнгэр чамайг Замбутивд очсоны хойно хоёр их байр (байлдаан) болох буй гэж зарлиг болов гэлээ. нэг нт хорт шарайыголын гурван хаан байна. нэг нь эдүгээ энэ Нандулам хаанб айна. Авай Богд минь! намайг бүү хорь. Би очилцлө” гэж Царгин өвгөн уйлж б айхад өарван зүгийн эзэн Богд наян настай Царгин өвгөнийг уйлахад эс эсэж хайлав. Нанчүн ирээд: “Ахай чи богдын зарлигаас давдаг билүү? харивал яана ? ” гэж хэлбээс Царгин өвгөн өгүүлрүүн : “Арван таван наст хэнз төрсөн Нанчүн минь мэдэвүү чи ? Наян настай хөгшин ахай чинь өтлөв би. Заан шаргал морь минь өвс даах чинээгүй болов. Загал толгой хөгшин ах чинь би тараг уух чинээгүй болов би. Арван зүгийн эзэн авай Богд юугаа дэргэд энэ их хуримд ороод харьсуу” гээд хайож байсаад хамаг баатргууд бүгд уярч уйлалцваас арван зүгийн эзэн богд дотроо өмссөн суьд цамцаа тайлж Царгин авганд өмсгөөд зарлиг болруун: “За Царгин авгай минть! Энэ үг чинь маш зөв. Миний үүгнээс чи гардаг билүү? Гэртээ харьж хамаг улсыг минь захираад, хаш их төрийг минь түшиж суу” гэж зарлиг болбоос Царгн өвгөн : “Авай Богд минь энэ чинь зөв. Өсөхдөө чиний зарлигаас эс давсан Царгин өвгөн, өтлөх цагтаа чиний зарлигаас дахав уу би? Хатуу яс минь нимгэрч, хар цус минь шингэрч, хайран бие минь өтөлсний тулд харь дайсны дотор таныхаа өмнө орж үхье гэж билээ. авай Богд минь хорьсны хойно над аргагүй. Би харьсуу” гээд Царгин өвгөн уйлсаар харв.

Буйдан, Улааннүдэн хоёр туршуулд явав

Арван з зүгийн эзэн богд мангасын газарт зорин яваад Буйдан Удааннүдэн хоёрыг туршуулд илгээхдээ : “ За та хоёр яваад Нандулам хааны захалд нь хүрч хэлээд ир. Энэ замбутивийн эзэн Гэсэр хаан арван таван толгойт мангасын хааны арван таван толгойгий нь нэг нэгээр огтольё гэж цэрэг мордож айсуй гэж хэл оруул” хэмээн туршуул илгээв. Буйдан Улааннүдэн хоёр “За” гэж баярлан гарё мордоод явав. Нандулам хааны түмэн цагаан сүрэг адуунаас Буйдан, Улааннүдэн хоёр алтан дэлхийг доргимол хашгиран түмэн цагаан агтыг хөөн гаран явав. Нангийн эзэн (Нандулам хаан) : “Энэ газар хадалтал дуу гарах хэн болов ? Энэн газар дээр над халдаж ирэх нэгн ч амьта үгүй билээ. Хурмаст хаан ирэвүү? ” гэж байтал адууч тайш нар нь ирээд хаанд айлтгав. “” Нэг хэсэг дээрэмчин ирж бидний түмэн цагаан адууг булаан аваачив гэж хэлэв.

Нандулам хаан : “Хэдийчинээ олон цэрэг байна?” гэж асууваас “довтлох чинээ нь түг түмэн цэрэг мэт. И Бие байдлыг үзэхэд хоёрхон хүн байна” гэв. Нангийн хаан зарлиг болруун: “Эжнэй. Хорт Гэсэрийн туршуулчин байна.” гээд Аргай Шаргай хоёр баатарт нэгэн мянган цэрэг өгөөд : “Та үтэр гүйуээд бүү ал! Амьд бариад адуугаа аваад ир. ” хэмээгээд нэхүүлбээс хоёр баатар нэг мянган цэргийг аваад нэхэв. Буйдан, улааннүдэн хоёр адуугаа хөөн явж Арслан уулын хөтөл дээр гарч адуунаас нэг морь сонгон алж тэнгэрт өргөж мөргөөд, арван зүгийн эзэн Богд юугаа сахиусын залбирч сууьал Буйдан нэхүүлэн цэргийн агтын

төвөргөөнийг сонсоод, бэх цагаан морио унаад Арслан уулын оргил дээр гарч бараагий нь харья гэтэл Аргай Шаргай хоёр тэргүүлэн нэгэн мянган цэрэг хүрч ирэхийг Буйдан үзээд өгүүлрүү: “эвүү эвүү! Улааннүдэн минь! морд Дайсан хүчр ирэв.” гэв. Улааннүдэн тачигнатал инээгээд мориндоо үсэрч мордоод “Аль ? Аль” гэж харахад дарлага болсон Буйдан дарлаган өгүүлрүүн : “ За Улааннүдэн минь Харьтан дайсан гэндээд хайран нэрээ гутааж явав? Чи хичээ” гэхэд Улааннүдэн өгүүлрүүн : “За Буйдан авгай мөн, энэхэн цэрэгт эндэх буюу би? Билд цааш одъё” гээд Улааннүдэн харцагай бор морио тас гуядаж хар шор юугаа суга татаад, царын чинээ амаа ангайу, аягын чинээ нүждээ улаанаар эргүүлж хашгиран дайрав Буйдан цагаан мориой тас гуядаж бэх болд илдээ суга татаад хашгиран дайрваа Аргай Үаргай хоёр баатар цочин зүрөх алдав. Буйдан, Улааннүдэн хочр “”Арван зүгийн эзэн Богдын минь сахиус мэдтүгэй!” гээд Буйдан баатар Аргай баатрын дуулгат толгойг тас дэлдээд ммориндоо молцог хийв. _ Улааннүдэн Шарагай баатрын хөндлөн(нударгат) хоёр гарыг нь тас цавчаад ыиеийг нь мориндоо хөндлөн дүүрч авахад Буйдан өгүүлрүүн : “ Авай Улааннүдэн минь! Түүнийг бүү ал” гээд мянган цэргийг нь Буйдан Улааннүдэн хоёрхон ширвээд бүгдийг та цавчаад алав. Шаргай баатрыг эс алад амьд бариад үг асууваас Нандулам хааны захисныг тоолж хэлээд “Ээ! хоёр хайрхан Богд минь, амийг минь авран соёрх ” гээд мөргөвөөс Буйдан өгүүлрүүн : “ Авай бидэнд тийм их үг зохихгүй бишүү. Арван зүгийн эзэн Бондод зохих үг байна. Чамайг авар гэж гуйсан ч аварана Авар гэж гуйгаагүй ч авар гэнэ. Чи дуугүй харьж очоод хаандаа ингэж хэл. ЭнэЗамбутивийн эзэн гэсэр хаан аюух мэт баатруудаа авч, арван таван толгойт нандулам хаанб арван таван толгойи нь нэг нэгээр огтлоод аливаа бүгдийг ол болгоё гэж цэрэг мордож айсуй гэ. Бид Гэсэрийн хоёр хөтөч билээ. гэсэр хаан минь биднийг туршуулаар танд явуулсан билээ ” гээд хоср гарыг бүсэнд нь хавчуулаад өгөөд илгээв. Шаргай баатрыг морин дээр нь хүлж орхисны тулд шаргай баатар хүрч хаандаа айлтгав. “Эвүү эвүү! Бид очвол үнэхээр хоёрхон хүн байв. Дайлахдаа туг түмэн цэргийн хүчэнээс илүү байна. энэ ЗАмбутивийн эзэн Гэсэр хаан, арван таван арван таван толгойт Нандулам хааныг алаад аливаа бүгдийг нь олз болгоёё гэж аюух мэт баатруудаа авч мордож айсуй гэнэ. Тэр хоёр баатар гэсэрийн хөтөч гэнэ. Манд хэл оруулаад турших гэж ирсэн байна” гэж хэлбээс Нандулам хаан алгаа ташин өгүүлрүүн: “Эвүү! Та хоёр их баатар тэргүүлэн мянган цэрэгтэй очоод хоёрхон хүнд ингэж дийлдээд гар хөлгүй ирдэг билүү?” гэж тэр баатрыг алав.

Нандулам хаан, Гэсэрийг угтаж мордов.

Нандулам хаан хэнгэргээ дэлдэхэд их түмэн отог нь хурав. Бага хэнгэрэг дэлдэхэд бага түмэн отог нь хурав гурюан мянган баатар, гурван зуун жаран хошууч хийгээд хамаг цэргүүдээ Нандулам хаан өгүүлрүүн : “За та мэдэв үү? Хорт Гэсэр хаан манд мордож айсуй гэнэ. Урьд хоёрхон хүн ирээд түмэн цагаан агтыгш минь аваад явлаа. Би хойноос нь Аргай Шаргай хоёр тэргүүлэн мянган цэргээр нэхүүлтэл харин миний хоёр баатар тэргүүлэн мянган цэргийг минь алаад, түмэн цагаан агтыг минь аваад явсан байна. Яах вэ би?” гэж асууваас хамаг баатрууд дуу эс гарав. нангийн хаан бас өгүүлрүүн : “За та юунд дуу үл гарах улс вэ?” хэмээвээс баруун зэргийн эрхэн болсон хатан хар бааар ийн өгүүлрүүн : “Урьд бид хорт Дан нэрт улсыг эс идвэл манд тийм дайсан хаанаас учрах билээ? Гэсэр, дээд биенд нь арван зүгийн бурхан төгссөн гэлээ. дунд биенд нь дөрвөн их тэнгэр нар төгссөн билээ. Бэлхүүсэнд нь зуун найман дагинасын хүч төгссөн гэнэлээ. Доод биенд нь найман их лусын хаадын хүч төгссөн гэлээ. Хорт Гэсэр хаан үэнхээр цэрэглэж ирсэн нь үнэн болбоос манд амрах ёсгүй байна.” гэв. Зүүн зэргийн эрхэн болсон гурван зуун аран хошуучийн нь тэргүүн болсон заан тшмэл гэгч өгүүлрүүн : “Гэсэр хаан тийм хувилгаантай байхад манай хаан тийм хувилгаангүй вү? Бид яарч цэрэг мордоод а өмнөөс нь угтъя” гэхэд нанпулам хаан тэр үгийг зөвшөөрөөд арван гурван луугийн хүч төгссөн уулын чинээ шар цоохор морио унаж, есөн давхар чулуун хуягаа өмсөж хамаг цэрэгүүдээ авч гурван зуун асарт хотын наана угтаж гарав. Тэндээс Буйдан Улааннүдэн хоёр, нэг түмэн агт нүцгэн (хуяггүй), нэг мянган агт, хуяг татсаар(цэргийн унаж явсан хуягтай морьдийг) авч ирээд арван зүгийн эзэн Гэсэр хаанд барин айлтгав. “Бид Богдынхоо зарилгаар очиж Нандудам хааны Аргай Шаргай гэгч хоёр баатар тэргүүтэй нэг мянган цэрэг нэхэж ирсэнд бид угтаж ороод нэг баатар, и нэг мянган цэргийг нь алаад нэг баатрын хочр гарыг нь тус тус цавчиж бүсэнд нь хавчуулаад моринд хүлээ Бондын зарлигийг бүрэн төгс тоолж хэлээд цааш хаанд нь илгээв. Бид нааш ирэв” гэж айлтгаваас арван зүгийн эзэн Богд “Аливаа явдал зориг минь бүтэх байна. Буйдан Улааннүдэн хоёр минь явдлаа бүтээж ирлээ” гээд нэг түмэн, нэг мянган агтыг б элэгтэй сайн гэж бүгдээр сайхан хувааж аваад цааш явав.

Гэсэр хаан Нандулам хаантай байлдаж эхлэв.

Тэгтэл Нандулам хаан гурван зуун асарт хотыг нь гурван сарын газраас үзээд арван зүгийн эзэн Богд зарлиг болруун: “Эвүү! Та үзэвүү? Нангийн хааны хот тэр биүшүү?” гээд арван зүгийн эзэн Гэсэр хаан билгйн хээр морины алтан жолоог залж лугшин хатирваас хамаг баатар их баяр төрөөд “Аль аль” гэж мориныхоо жолоог сул тавин Гэсэр хаан хойнооё дүүлэн явбаас аран зүгийн эзэн Богд хүрэх цагтаа арван дүнчүүр арван сая арван бман олон цэргийн б араа гараад хөвчин алтан дэлхийг бүрхэн ирэхийг Нандулам хаан үзээд “”Эвүү! Энэ юу вэ ? Газар хөдөлсөн мэт яаж багтаж ирсэн олон цэрэг вэ? гэж зүрх алдаж байв.

“Арван зүгийн эзэн Гэсэр хаан хамаг баатруудаа ийн зарлиг болов: “За, хатан хар болд мэт биед, хар чулуу мэт зүрхт харцагахй мэт шүүрлэгт, хамаг нөхөд минь мэдэв үү? Харь дайсны хүч нь их байна. Хамаг дайсныг хамран цавч, хүчээ мөхстөх цагт намайг удрдан залбир. Арван хүчин төгссөн Гэсэр хаан бишүү би. Хүчийг танв төгсгөн өгөх бишүү би. Асар их хүчит дайсанп намайг духрдан орвоос хав харласан зүрхийг тань хатаан өгөх баатар Гэсэр хаан бишүү би. Хатан зэр зэвийн ирд дайрагдаад шархдахын цагт намайг дурдан залбир. Эмч Гэсэр хаан бишүү би. Яр шарх хоёр тань өөрөө эдгэх болно. харь дайсанд ороод хатан зүрхээ бүлүүлж хар цусаа урсгаж харангадан ундаасах цагт намайг дурдан залбир. Ундыг чинь хангаж, рашааны усыг уулгагч ухаанд Гэсэр бишүү би. гэж зарлиг болоос хамаг баатрууд цөм сөгдөн мөргөөд “Ээ, арван зүгийн арван хорын үндпсийг тасалсан аюух мэт Богд минь! Чамаас өөр манд ивээлгүй” гээд мөргөвөөс арюан зүгийн эзэн гэсэр богд зөвшөөгөөд билгийн хээр морио унаж, нар сар хоёрыбг ургуулан хийсэн манла цагаан дуулгаа эрдэнэт тэргүүндээ өмсөж, оюу оныг гуин цагаан сумаа чихэж соронзон гүрээр бүтээж хийсэн есөн алд хар шрооо зүүж, бидгийн догшин хар нум нв юугаа дүрж арван таван толгойт нандулам нэрт аврагаын хааныг дайрах цагт, арван зүгийн эзэн гэсэр хаан мянган луугийн дуугаар хүрчигнэн тачигнаж, оройноосоо есөн өнгийн солного татуулан, хоёр самсаанаасаа блэг билгийн галыг огторгуйд тултал дүрэлзүүлж ,магнайнаасас Махагалын дүр гаргаж, оройн шар үснээс таван гарди цэрвүүлэг нисгэж соронзон гүрээр бүтээж хийсэг хар шро илдээ бэлэг билгийн галаар үймтэл суга татаад орох цагт хөлөглөсөн билгийн хээр морины үс бүрээс гал шатаж хоёр хамраа утаа бургиулж, дөрвөн тавагнаас нь гал цахиж явав. Арван зүгийн эзэн Богдын гучин баатрууд соалхин жигүүрт морьдоо унаж элдэв чимгүүдээ өмсөж, энгүй олон чандмань эрдэнэсийг олсон мэт их баяр төрөөд “Яв яв” гэж ирвээс хамгийн урьд хүний бүргэд болсон Шуумар, оддын гилбэлгээн өнгөт хуягаа мөрөндөө хэдрэн г зуун найман ширээсээр мушгиж хийсэн мянга таван зуун шөрмөсөн хүйрт (хөвчний гогцоо) догшин хар нумаа дүрж арван үхрийн арьсаар хийсэн архад хар саадгаа бзсэлж, арван хоёр зэсээр хавчин өдөлсөн хар шор юугаа зүүж каан хайсан хар морио унаж, хорин луугийн дуугаар тачигнатал орвоос Шуумрын оройноос таван бнгийн солоного татан, и оройноос нь Очирваанийн дүр гарав. Заан хайсан хар морины дөрвөн тавгаас гал цахиж орох цагт, нанчүн : “Өөе, Шуумар байз, өөе! Шуумар байз!” гэж гурван үе хашгиран дуудваас үл сонссон заан хайёан хар мориныхоо жолоог сул тавьсар арван зүгийн эзэн Богдын өмнө гарч нандцулам хааны тугйг чиглдэн ороход тэнгэр газар хоёр нэг болсон мэт болов. шуумар хамгийн урьд хошууран ирэхийг үзээд нандпулдам хааны Хатан хар баатар уулын чинээ хар морио унаж ,хар хөө хуягаа өмсөж гурван алд шор юугаа барин Шуумарын өмнөөс угъав. Хоёул зөрөлдвөөс шуумарыбн орой дахь Очирваанийг дүрийг үзээд зүрх алдаад цавчин эс чадав. Баатар Шумар есөн алд молор хар шор юугаа барин хатан хар баатрын дуулгад толгойг тас дэлдэж аван заан

хайсан хар мориндоо молцог хийгээд есөн алд хар шор юугаа ерөн есөн алд болгон сунгаж Нандулам хааны гурюан дүнчүүр гурван сая олон цэрэгт нь орон цавчиж ширвэн гарахдаа нэг түмэн цэргийг цавчаад тэртээ нь гаран хойшоо хялдам хийн харваас арван зүгийн эзэн Богд гучин баатар, гурван зуун хошуучаа дагуулж аюух мэт мянган луугийн дуу гаргаж алтан дэхийг нэг мөсөн доргиулж ороход хүний бүргэд болсон Шуумар гагцаар гурван түмэн цэргийг цавчаад өөрийн баатруудаа нийлэв. Арван зүгийн эзэн Гэсэр богд соронзон гүрээр хийсэн илдээ мянган таван зуун алд урт болгон сунгаж дохих бүр түмэн цц эргийг цавчив. Арван таван настай эрдэнэт нанчүн арван буман таван түмэн цэргийг цавчив. Амбарын хөвгүүн Банжур зургаан түмэн цэргийг цавчиж алаад гарав. Түүнээс бусад баатрууд дөрвөн түм, таван түм, гурван түм, хоёр түм, нэг түмэн цэргийг тус тусдаа цавчаад Богдын дэргэд цуглав.

Хамаг баатрууд Богдын дэргэд бүгд цуглаж ирэхэд тоолбоос гагц шуумар үгүй ажээ. Хамаг бүгд “Эвүү, эвүү! Шуумарыг минь Нандулам хаан алсан байна.” гэж хамгаар гомдон Гэсэр хаанд айлтган байтал Нандулам хааны цэргээс Шуумарын унасан заан айхсан хар морь нь цусан зээрд морь болж, өмссөн гилбэлгээн өнгөт хуяг нь гал улаан хуяг болж дуртай дургүй морио ганц хоёр гишгүүлж галигуулж ирээд өгүүлрүүн : “За та өлбсөв үү? Ундаасав уу? юуны тулд яарч цуглав?” гээд тачигнатал инээсээр хүрч иртэл Богдын дэргэд суугаад: “ Би ирэхгүй билээ. Арван зүгийн эзэн Богд юугаа үзээд арайхан гарч ирэв би” гэж суув. Гэсэр хаан зарлиг болруун: “ За хүний бүргэд болсон Шуумар минь! Гүр хар чулуун зүрхт Шуумар минь хэдийг цавчаад ирэв?” гэвээс Шуумар : “Богд минь! би яарч нэг сая нэг буман цэргийг цавчаад гарч ирэв” гэж айлтгаваас Гэсэр хаан зарлиг болруун: “За эдүгээ хэчнээн цэрэг үлдэв?” гэж зарлиг болбоос : Шуумар: “Зохиж (нарийн) эс тоолов би. Эдүгээ арван сая арван буман цэрэг үлдсэн бололтой. ” гэж айлтгаваас арван зүгийн эзэг Гэсэр хаан зарлиг болруун: “Эдүгээ бид рашааны идээгээ зооглов. Уналага, бие маань амрав. Одоо мордоё” гээд арван зүгийн Богд, Нандулам хааныг тусгайлан оров (чиглэж чвавБусад баатрууд хоёр тээгүүр жигүүр мэт болон орвоос арван зүгийн эзэн Гэсэр хаан нандулам хаантай зөрөлдвөөс Гсээр хаан есөн алд сорнозон гүр иолдээ нандулам хааны таван толгой нь тас дэлдвээс мөн биедээ тохров. Чингэтэл нандулам хааны заан түшмэл гэгч нум сумаа хаяж орхиод таван хүний тэвэрт үл багтах их модыг үндэстэй нь сугалж аваад зөв буруугүй цохилж яьтал Шуумар нанчиүн хоёр гэзэг даран ирж арайхан цавчиж алав. Арван зүгийн эзэн гэсэр хаан Нандулам хааны бас таван толгойг нь тас дэлдвээс мөн бас эргэн биедээ тохорч байхад гэсэр хаан илдээ гэдрэг хариулан зогсов. Нандулам хаан алд гүр хар шороор Гэсэр хааны зүүн мөрийг үл хүртэл цавчваас арван зүгийн эзэн Богдын өөр салсан бие нь нэгэн агшин зуур эдгэв.

Цас Чихэр тэнгэрээс бууж Гэсэрт туслав

Гэсэр хаан зарлиг болруун: “Ер энэ хааныг биалж болохгүй шиг байна” гэж “дээд ялгуусан гурван эгч минь! Эвүү, яалаа. Анд гурван тэнгэр минь, эвүү яалаа Хаан хурмаст эцгийн зарилгаар энэ Замбутивийн амьтныгш туслахын тул ирээд арван хорын үндэсийг таслан арван зүгийн хортныг доройтуулан явтал ийм хэцүү дайсаньай эс дайралдлаа би. гэж хайлах дууг ялгуусан гурван эгч б нь сонсоод ачит Хурмаст тэнгэро очиж айлтгаваас хурмаст тэнгэр зарлиг болруун:

Эжнэй, үйл бүтээгч минь Замбутивд очсоны хойно хоёр их байр (байлдаан) учрах гэж билээ. нэг нь энэ байна. одоо хэн очих вэ? гэсэнд Гэсэрийн анд гурван Богд тэнгэр : “ Бид очьё” гэж айлтгаваас Цас Чихэр сонсоод Хурмастын дэргэд ирээд айлтгав: “ Ээ! Арван зүгийн эзэн Богд Гэсэр хаан минь арван таван толгойтой аврагсын хаанд хүч эс хүрэв гэнэ. Би очьё Ачит Богдын минь хүч эс хүсрнийг анд гурван тэнгэр та очивч хүч үл хүрнэ. Би очоод аргалж үзсүү. Урьд Замбутивд Богдынхоо дэргэд явснаараа би танаас хэрсүүхэн буйза” гэж Хурмаст тэнгэрот айлтгаваас Хурмаст тэнгэр: “Цасын очих зөв” гээд анд гурван тэнгэрийг байлгав. Цас Чихэрээсээ хагацав би. Хаана явж усанд унаж үхэх вэ би? Хорт сэтгэт Цотон ноён урьд хутгасан учир би есан нуруут байшингийн алтан баганаас боож үхээд, тэнгэр нарт төрөөд Цас Яихэртэйгээ нийлсэн билээ. Цас Чихэртай хэмт очно гэв.

Цас Чихэр одоо арван найман лагшин бие төгссөн жигүүрт бор морио унаж дуурьсахуй нэрл дуулгаа эрдэнэт тэргүүндээ тавьж билгийн догшин хар нумаа доурж, есөн алд цод (хүнд) болд илдээ зүүж, Хумсан гуа хатнаа аваад: “За, хурмаст ахай минь тэргүүлэн, хамгаар мэнд амаглан суугтун. Би арван зүгийн эзэн Богддоо очно. ” гээд тэнгэр нарны орноос Замбутивд буугаад Цас Чихэр дөрвөн зүгт тав и таван нарын орноос Замбутивд буугаад Цас Чихэр дөрвөн зүгт тав таван хоногийн газрыг эргэн эргэн харж байсаар Гэсэр хаан Нандулам хоёрын золголдож байхыг Цас Чихэр үзээд Хумсхан гуа хатандаа зарлиг болруун: “ тэр хорт харвагсан хааны бүзхий л биеийг нь харваж цавчиж ер алж болох байна. Амь нь хоёр нүдэнд нь байна. Хүрч харая гэтэл удаарч байснаа арван зүгийн эзэн Богдын минь бие чилэх байна” гээд таван хоногийн газраас нандулам хааны хоёр нүдийг чиглүүлэн харваваас аминд нь туссаны тулд аврагсан хаан арван гурвани луугийн хүч төгссөн шар цоохор мориндоосоо ууд унасан мэл алдагдаж ойчиход арван зүгийн эзэн Гэсэр хаан: “Ээ! Ялгуусан гурван эгч минь өмгөөлөв үү? Анд гурван Богд тэнгэр минь өмгөөлөв үү? ” гээд уулын чинээ шар цоохор морийг (морины цулбуурыг) билгийн ташуураар өлгөж аваад хартал Нандулам хааны хоёр нүдэнд сум хадаж байхыг Гэсэр хаан үзээд, Цасын сумыг таниад: “Эвүү, эвүү Цасын минь сум биш үү энэ ” гээд суга татан аваад тэвэр хайлав: “Хаш эрдэнэ оныт хатан болд төмөр, молор эрдэнэ мэт өнгөт цагаан сум чинь энэ байна. Эрийг эр эрдэнэт Цас Чихэр жигүүрт бор морийнхоо жолоог сул и тавьж, цодз болд илдээ б арьж Нандулам хааны үлдсэн цэргийг хашгиран олон хонинд чоно орсон мэт бутруулж, үнс мэт хийсгэж ширвэсээр гарч ирэв. Арван зүгийн эзэн Богд амраг Цас Чихэр ахаа үзээд билгийн хээр мориноос буулгүй үсэрч ноцон хайлав: “Харь дайсныг хамхалж өгөш хаш хад минь! Хаанаас явж ирэв үү чи? ” гэж хайлж байхад Цас Чихэр “Аран зүгифн эзэн, арван хоёр толгойтой мангаст Арлан гуа хатнаа нэхэж очсоны хойно атаат Шарайголын гурван хааны цэрэг ирж аливаа бүгдийг минь талж довглох цагт амөраг Цас Чихэр ах чинь би амь биеэ хайрлалгүй, авай Богд минь гэрт үгүй болов ах дүү баатрууд нь байна гэж амиа хайрлалгүй явж хар цус минь хатаж, хайран биеийн

минь сүлд алдран, хатан далайн цуси усыг уугаад харин согтуурч унаанд ухраангүй болоод харь дайсанд дийлдсэн минь тэр. Түүний хойно чинийхээ зарлигаар Хурмаст ахайн чинь дэргэд төрөөд суутал ялгуусан гурван эгч нь ирээд, нусгай минь доор Замбутивд арван таван толгойт аврагсын хаанд баатруудаа авч мордоод алан ядаж байна гэхийн сонсоод анд гурван тэнгэрийг юу ирлээ би” гэж айлтгаваас арван зүгийн эзэн Богд, ЦасЧихэр эзэн Богд Гэсэр хаан амраг Цас Чихэр ахыгаа тавмад алтан дэлхийг сан тавьж номхотгов. Нанчүн, шуумар хоёр эхлэн ирж бүгдээр ирж амраг Цас Чихэртэйгээ тэврэлдэв.

Нандулам хааны хатныг булаалдав

Эдүгээ арван таван толгойт аврагсын хаанчгш дороотуулав. Аливаах бүгдий нь олз болгов. Нандулам хааны нарны гэрлийг дарах мэт үзэсгэлэнт Бадмаараг нэрт гуа хатан бөлгөө. тэр хатныг Шуумар “Би авсуу” гэж батал арван таван наст Нанчүн хүрч ирээд “Шуумар авгай! Дүүдээ, над хайрла!” гэж хүсэв. Шуумар өгүүлрүүн : “ Ахаасаа биш юм өг гэж авч болно. олзонд ганцхан эмийг авбал ахтайгаа атаатай болно” гээд эс өгөв. Ер бзгдийн сэтгэлийг булаах мэт үзэсгэлэнтэй тул Цас Чихэр ирээд өгүүлрүүн :” Нэгд болбол Нандулам хааны би алав. Хоёрт болбол би ах чинь бишүү. Энэ эмийг би авна гэж зарлиг болбоос Шуумар өгүүлрүүн: ” “ Эвүү Цас Чихэр минь ирсэндээ баярлах буй за. Муу дүү нартайгаа энэ эмийг булаалдаж авдаг юмуу? ” гэж байтал арван зүгийн эзэн богд өөд болоод “Энэ эмийг юуны тулд булаалдана та ? Авбал Цас Чихэр бид хоёрын нэг авна Авахгүй болбол бид мэдэж танд өгнө” гэж байтал Гэсэр хааны соронзон гүр илд нь дундаа хүртэл сугарав. Арван зүгийн эзэн Богд зарлиг болруун: “Энэ шор минь юуны тулд сугарав? Урьд нэг сугарав. Арван хоёр толгойт аврагасын хааны Нандулам хааны толгойг авав. Эдүгээ хэний толгойг авья гэж сугарав чи? Мөн энэ эмийн толгойг авья гэж сугарав за” гээд илдээ суга татаад тэр хатны толгойг тас дэлдэж орхивоос Цас Чихэр арлиг болруун: “Богд минь! Энэ эмийг юуны тулд цавчив? ” гэж айлтгаваас Гэсэр хаан зарлиг болруун: “Авай Цас минь чи эс мэдэв үү? Миний энэ соронзон гүр илд сугарах ёсгүй бишүү. Сугарвал нэг хортнй толгойг авах тэмдэг билээ. Цас минь өөрөө шинжлэн үз” гэж зарлиг болбоос Цас Чихэр шинжлээд цод болд илдээрээ тэр хатны гэдэсийг цөм дэлдвээс дотор нь мөн аран таван толгойтой есөн сар болон шулмасйын хөвгүүн байхыг үзээд Цас Чихэр зарлиг болруун: “ Арван зүгийн эзэн авай богд минв багаагүй бол бид юу болох бол?” гээд тэр хөвгүүнийг түймэрдэж алаад нандулам хааны гурван зуун асарт хортыг түймэрдээд, аливаа бүгдийг нь олз болгоод арван зүгийн эзэн гэсэр хаан амраг Цас Чихэр ахаа авч ахуй бүхий нутгийн зүг залран өөд болов.

Бүгдээр Цас Чихэртэй баярлан золгов

Арван зүгийн эзэн гэсэр хаан Нандулам хаанд аялан өөд болохдоо арваэн таваэн жилийн хол газрыг арван хоёр сарын газар болгон товчилсон ажээ. эдүгээ Нандулам хааныг дороотуулаад нааш өөд болох цагтаа арван таван хоногийн газар болгон товчлоод өөл болж ирэхэд таван хоногийн урьдаас Цасыг тэнгэрээс буж ирсэн Гэсэр богдтой нийлснийг сонсон, арван зүгийн эзэн Богд арван таван толгойтой аваргасыг хааныг доройтуулав гэж давхар баярлан Алтан дагина, Ажу мэргэн, Арлан гуа хатан тэргүүлэн наян наст Царгн авган, Сэнлон өвгөн, гурван отог их улс хамгаар угтаж ирэв Түүнийг сонсоод Цас чихэр, гэсэр богд хаанд айлтгав: “ Арван зүгийнэзэн минь! Алтан дагина тэргүүлэн хамгаар угтаж айсуу гэнэ. Би урьд очиж Алтан дагина ,Царгин авгай тэргүүлэн бүгдэд золгосуу би” гэж айлтгаваас арван зүгийн эзэн Богд : “Цасын минь энэ үг зөв. Чи урьд очиж золго. ” гэж зарлиг болов. Цас Яихэр Начүн аваад урагшилж ирэхэд угтсан хамаг улс Цасын барааг үзээд: “Эвүү, эвүү! Арван зүгийн эзэн богд минь урьд өөд болж айсуу бишүү” гэж хэлэлцвээс Царгин өвгөн: “Эвүү, та юу хэлнэ? Арван зүгийн эзэн эзэн авай богд минь юунд өөд болж ирэх билээ? Ирвэл Цас минь манд золгоё гэж урьд ирэх буйза та юу хэлнэм ? гэж хэлбэл Алтан дагина зарлиг болрун: “ Ер Царгин авгайн зг эгээ үнэн” гэж байтал Цас Чихэр жигүүрт бор морио ташуурёаар савж Цасын өмнөөс угтаж хүрэн: “Эвүү, эвүү! Эжий минь. цас Чихэр минь. Гэнэт хаанаас ирэв ? Чи минь! мэнд үү?” гэж бархирсаар үсрэн ойчтол Цас Чихэр яарч морин дээрээс өргөж аваад тэврэлдэв. Царгин өвгөн хайлж байж өгүүлрүүн : “ хар уулын оргил дээрэх хадыг хангинуулан явагч, хар эрэн б аргс мэт довлон явагч, хамагт зохист Цас Чихэр минь. Хатан далайн ёроолд туйлан явагч аврага загас мэт араг Цас Чихэр минь ль газарт явж, хаанаас ирэв чи? Эжий минь! Атаат гурван Шарайголын хаанд арьс мах хоёроо хайрлалгүй явж амь биеэ тэвчсжэн авай, ачит Цас Чихэр минь! Заяат Богддоо золгоё гэж ирэв үү? Эжий минь ” гэж хайлаад тавив.

Цотон ноёныг алах ёсгүй

Цас Чихэр, хамаг бүгдтэйгээ золгож байтал хамгийн сүүлд Цотон ноён гагцаар ирж золговоос Цас зарлиг болруун: “Ер хамаг бүгдээр намайг санасан нь тун худал байна. Ганцхан Цотон авгай минь намайг үнэхээр мөрөөдсөн ажээ” гэж хуурч зарлиг болбоос хамаг улс: “Цас авган тэр зарлиг үнэн” гэж хэлэлцвээс Цотон ноён дуу эс гарав.

Түүний хойно арван зүгийн эзэн Гэсэр хаан арван таван толгойт аврагасын хааныгш амраг цас Чихэр ахыгаа тэнгэрээс буулгаж аваад ахуй суух гэртээ өөд болж ирээд алтан өнгөт Нолом тал дпээо арван гурван эрдэнэ сүм хийгээд, зуун найман асарт шил хот юугаа засаад тэр дээр мянга таван зуун хүн багатаж суух алтан орд харшаа байгуулаад арван зүгийн их улсаа хурааж ахуй их тунхаг зарлигаа өгч албат улсаа хурааж гурван ар болтол нур далай мэт их хурим хийж жарган суух цагт эрдэнэт Цас Чихэр хорин хасаг архи зооглоод хөвчүүрхэн улаан зээрд болж суухдаа Цотон ноёны үзээд цас Чихэр зарлиг болруун: “Хайран арван зүгийн эзэн Богдын минь хаш хад мэт багуулсан шашин төр хоёрыг эндүүрсэн, эрдэнэт Цэс Чихэр намайг тэвчүүлсэн, элгэндээ хар доторт Цото. Хөдлөшгүй шашин төр хоёрыг минь хөдөлгөсөн, хөдлөхийн эзэн Богдын миньсэтгэлийг зовоосон, хөдлөх бүгдийн минв талаар болгосон хөө мэт доторт Цотон, хорт Шарайголын гурван хаанд арван зүгийн эзэн Богдыг минь мартаад амь битеэс нь хагцуулсан, аливаа бүгдийг минь агир болгуулсан хор мэт сэтгэлт хөө мэт доторт Цотон, Махыш чинь одоо идсүү би” гээд Цас Чихэр цод болд илдээ суга татаап дэв хийвээс Цотон : “Авай Богд минь би яая” гээд Цотоэ ночн ширээний доор шургаж орвоос арван зүгийн эзэн Гэсэр зарлиг болрун: “ Авай Цас минь! Энэ мууг алж у хийх буй. үүнийг алах болбоос би хэдийн үгүй болох бишүү. Энэ үгүй болбол арван зүгийн хортныг би ингэж дарахгүй” гэж зарлиг болбоос Цас Чихэр бас айлтгав. “аяа арван зүгийн эзэн аюух мэт Богд минь! Арван зүгийн хортныг доройтуулахдаа онц Цотонгоор хошуу удирдуулан явж дарсныг эс үзэв би. Алтан орд харшийг чинь эвүддлсэн, Алтан дагиныг(Рогма) чинь авахуулсан, арван зүгийн эзэн Богдоос минв хагацуулсан, амь биеийг минь тэвчүүлсэн, тэсэшгүй муу доторт Цотон . Амлашгүй гучин баатруудыг минь гэндүүлсэн, арван зүгийн эзэн Богдынг минь шашин төр хоёрыг хөдөлгөсөн атаат гурван Шарайголыг тавыг хангасан, аливаа бүгдийг минь талаар болгосон агир хувхай дотор Цотон ноён! Алийг чинь мартах вэ би? ” гээд Цас чихэр босон гүйвээс Цотон ноён ширээний доор сэхээтэй, сэхээгүй хоёрын хооронд хэвтэв. Арван зүгийн эзэн Богд зарлиг ыолруун: “ Авай Цас Чихэр минь байз” гэж зарлиг болов. Цас минь! үүнийг амийг алах ёсгүй билээ. үлгэрлэвээс Цотонгийн явдал үндэсныг сэрүүлэх мэт . Мартсаныг санццлах мэт бишүү. үүнээс биш бид жаргалдаа ташуурч аливаа үйлэ бүтээж үл чадах буй. тиймийн тулд миний мянган хувилгааныг нэг нь энэ муу Цотон буй. Миний адистидгүй болбол энэ муу Цотон ноён хар санаандаа хэдийн зхэх байсан. Тиймийн тул үүнийг эдүгээ болтол авч явагч учир минь тэр бишүү. Авай Цас минь Цотонг алах ёсгүй . Би чамд үзүүлсүү гээд хамаг улсыг гаргаад арван зүгийн эзэн Богд зарлиг болруун: “Өөө! Цотон авгай нааш ир золгоё” гжу дуудваас Цотон ночн унаж боссоор очоод Богдын гэгээнд золговоос аран зүгийн эзэн Богд Гэсэ р Цотон хёрын нэг бие мэт бахыг Цас үзээд : “Эжнээ Хишигт (азтай) хүн чи Богдын минь дэргэд над учираад амьд гарлаа. ” гэж Цас зарлиг болоод цод болд илдээ хуйлаад алахаа байв.

Түүний хойно аан зүгийн эзэн эгсэр хаан амраг Цас Чихэр ахдаа арван таван толгойт

аврагасын хааны арван гурван луугийн хүч төгссөн шар цоохор морь тэргүүдэнг олзыг өгөв. Есөн зүйл болдоор найруулсан хийсэн чулуун нэрт хуягийг Шуумартаа өгөв. нандулам хааны Заан хар түшмэлийн уулын чинээ улаан морийг Царгин өвгөнд өгөв. Таван давхар гал улаан хуягийг энх нанчүнд өгөв. Түүнээс биш баатруудад тус бүрт өглөг соёрхоод арван зүгийн эзэн аюух мэт Гэсэр хаан аливаа бүгд юугаа төгсгөж алтан өнгөт Нолом тал дээр алтан орд харшийн дотор, ариун дээд тэнгэр нарын ёсоор амаглангаар жарган суув. Арван зүгийн эзэн арван хорын үндсийг таслан төрсөн, аюух мэх богд Гэсэр хаан арюан толгойт аваргаёын хааныгш алж амраг Цас чихэр ахаа тэнгэро нараас буулгаж аваад аливаа амьтныгш тэгш жаргуулсан эрхт цадиг төгсөв.

арван зүгийн арван хорыны нздсийг таслан төрөөн ачит богд Гэсэр хаан, арван таван толгойт Нандпулам хааныг алж бараад гучин баатар, гурван зуун хошууч, гурван отог улс таван хатнаа аван эрдэнэт цэцэгт талд очиж суув. Тэр талд арван зүгийн эзэн Гэсэр хаан, зуун найман хүнээр бариулах орд цагаан гэрээ байриулж тооноо алтан баганаар тулж гэрийн хүрээ дээс оосроо ив мяндсаар хйж, дөрвөн өнцөгт нь гал мандал үүсгэж тэр дотор Ганжур Данжур, хоёр их хөлгөн ном, аливаа эрдэнэ, хар нүүрс, хүслийг хангагч, чандамань эрждэнэ хийгээд ,ц эцэгт тал дээр алтан суврага байгуулж, өвөл зунгүй цас бороо орж мод өвсгүй газарт модөвс ургав. Арван зүгийн эзэн Гэсэр хаан гурван үе сан тавьж Ногоон Дарь эх, Цагаан Дарь эх, Яда эд бүгдийгш уншиж байхад адиваа гөрөөс бэлчиж, шуву яруу дуугаар донгодож, өвсгүй газарт бадамлянхуа цэцэг ургаж, модгүй газар бодь мод ургаж, усгүй газраас рашаан булаг дэвлэн оргилж, хүйтэн газар дулаан болж, шуургать газар цас бороо шуурахаа больж, гурван луу хүрхрэн тэнгэрт тачигнаж дорд алтан дэлхий гурван үе хөдөлж ыб айв. Эд бүгдийг арван зүгийн эзэн Гэсэр хаан төгсгөн номхотгож Цэцэгт талын төв дунд алтан суврагны дэргэд энх амгалангаар жарган суув.

Арван зүгийн эзэн гэсэр хаан, Жало баяны охин, тэнгэт нарын дагинын хувилгаан Рогма гуа хатнаа биеийн шадар авч суув. Лусын хаадын охин Ажу мэргэн хатнаа бодь модны дэргэдп мөнхүү орд цагаан гэрийг байгуулж тэнд суув. Бас мя баяны охин хөрст алтан дэлхийн хувилгаан төгссөн Түмэнжаргалан (Арлан гуа) хатнаа бадам лянхуа цэцэгийн дэргэд орд цагаан гэрийн байгуулж тэгд суулгав. Бас Чойрон урны охин хөхөө гувууны хувилгаан төгссөн Чоймсон гуа хатнаа рашаант булгийн дэргэд алтан суврагыг байгуулж орд цагаан гэрийн бариулж тэнд суулгав. Бас хятадын Гонма хааны охин, амьтны хувилгаан төгссөн Гүнэ гуа хатнаа эрдэнэт улаан хадын дэргэд орд цагаан гэрийг байгуулж алтан суврагыг байгуулаад тэнд суулгав. Ролгма гуа хатны гадна нь аливаа шувуу, хан гарди, тоть, хөхөө, ангир, шингүй, хөтүү, нангиа, гцургуул, хатан харга, хараацай, хун, галуу, алтан гургалдай, хал мэргэн, ходой бүргэд, тогоруу, нугас, иргүүл, алтгай, шод шувуу донгодож, с сарлаг, хандгай хар гөрөөс, бух шөрөөс, ирж байна. Арван зүгийн эзэн гэсэр хаан эд бүгдээ төгсгөж энх амгалангаар амирлан алтан сувраганы дэргэд жарган суув.

АРВАН ЗҮГИЙН ЭЗЭН ГЭСЭР ХААН, МАНГАСЫН ХУВИЛГААН ЛАМЫГ ДАРСАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Нэгэн мангас лам болон хувилж Гэсэрт ирэв.

Аван зүгийн арван хорын үндсийг тасалсан Гэсэр хаан, нэгэн өдөр шил хотын өмнөх асар дээр гараад арван зүгт билгийн нүдээр ийн тийн харан үзвээс урьд ерөөлийн хүчээр болсон хавьгүй амьтан зарим нь нүдгүй балай ажээ. зарим нь чихгүй дүлий хийгээд доголлон ба үгүү ядуу тийм олон амьтныгш үзээд Гэсэ хаанд өргшөөх сэтгэл төрж, дотроо ийн сэтэгрүүн : “эжнээ, урьд миний эцэг Хурмаст тэнгэр хамаг амьтныг тусын тулд намайг энэ Замбутивд илгээсэн. Одоо би харалгүй жаргалдаа ташуурч суух минь юутай буруу билээ” гэж сэтгээд “Би энэ ертөнцөд төрснөөс нааш хортон пайсан мангас хийгээд хоргүй боловч миний мөрт дарагдаж үхсэн амьтан олон болов. одоо хийсэн үйл минь их. тиймийн тул зуун найман хоног даяаныг бясалгасугай” гэж дотроо сэтгээд гэртээ харьж ирээд Алтан Дагинад Гэсэр хаан зарлиг болруун: “Одоо би зуун найман хоног сэм суусугай. үүдийг минь бүү нээ. миний сангаас үгүү ядуу ирсэн амьтанд өглөг өг. тойн хуврагуудыг үзвээс ихэд хичээн хүндэл” гэж зарлиг болоодп даяанд бясалган суув.

Тэр цагт арван хүчин төгссөн манасын хувилгаан Ловсгаа гэгч Гэсэрийн газраас арван хоёр жилийн газар хол орших билээ. тэр Ловсгаа нь төрөхдөө уулын чинээ цагаан морьтой, хоёр үлэмж хувилгаан эгчтэй билээ. Түүний ханилах нөхөр сэлт нь Тэмдэгт, Бэлигт хоёр хувилгаан цэцэн түшмэл байна. Тэр хоёрын унах морь нь уулын чинээ хоёр хар морь байна. Түүнд бас хоёр хувилгаан бөө (бөх?) байна. нэг нь хар бөө, нэг нь шар бөө билээ. тэдний морь нь уулын чинээ хоёр хүрэн морт билээ. Дөчин дөрөн их сайд, дөрвөн зууг баатартай билээ .

Мангасын хувилгаан Ловсгаа тэд бүгдээ хурааж хуримлан суухад Ловсгаа ихэд бардан өгүүлрүүн: “Эдүгээ Гэсэрээс өшөөгөө авья . Гэсэрийн газарт цэрэг мордьё” гэвэл баруун зэргийн эрхэн болсон хувилаанг түшмэл Тэмдэгт сэцэн өгүүлрүүн. “Бид Гэсэрийн газарт цэрэглэж очвоос Гэсэр гэгч тэнгэрийн хүү гэнэ. Гучин баатар, гурван зуун хошууч нь цөм тэнгэрийн хөвгүүд гэнэ. Бид тэднийг дийлж яаж чадах вэ? ” гэв. Ловсгаа өгүүлрүүн : “ тийм бол бид арга хийж лам болж очъё гэв. Зүүн зэргийн эрхэн болсон хувилгаан түшмэл Бэлэгт сэцэн өгүүлрүүн : “ Бид арга хийж лам болж очвол Гэсэр хаан билднийг ухаанаа мэдээд “Эвүү мангас хувилж ирсэн ажээ. Эднийг алсугай” гээд алахн болно. ” гэв. Төдий Ловсгаа эгчдээ өгүүлрүүн :“ Цэргээр очвол дийлж үл чадна. Арга хийж хувилж очвол мэдэх ажээ. Эдүгээ өшөөгөө яаж авах вэ?” гэвэл эгч нь ийн өгүүлрүүн : “ Ай Ловсгаа минь бүү зою. Чамд би арга заасугай. Эрт урьд миний сонссон нэгэн цагт Шигэмуни бурхан гэгч амьтныгш тусдан өөд болох цагтаа хоёр гартаа цангилзах дулдуй, харб адар аягыг барьж өөд болов гэлээ. Бид тэр аргаар очвол Гэсэрийг илжиг болгох увиидас бүгдийг цөм би бүүээж өгсүү. Ловсгаа чи их лам болон хувил. Хоёр хувилгаан түшмэл банди болон хувил. Холёр хувилгаан бөө эгэд хар шавь болон хувил” тэгж зарлиг болбоос Ловсгаа баясаж эгчдээ ийн айлтагруун: “ Өхийн минь энэ зарлиг зөв. Эдүгээ дарийы дээр өшөөгөө аюах тэр удидасаа өгөн соёрх ” гэж айлтгавал тэндээс эгч нь ийн зарлиг болруун: “ Миний хотод миний хойнооёс түргэн ир. Би далан гурван үет алтан сувраганы дээр гарч “Өгий минь . Эдүгээ бид Гэсэрийн газкарт очно. Бидэнд дайсныш дарах аливаа хэрэгт увидсыг өгөн соёрх” гэвэл төдий эгч нь “тавуул нааш тэргүүнээ бөхийж ир” гээд тавуулын тэргүүнд увидсыг тавьж өгөхөд Ловсгаа алтан өнгөт дам болон хувилав. Хоёр хувилгаан түшмэл нь хоёр банди болон хувилав. Хоёр хувилгаан бөө нь эгэд хар шавь болон хувирав. Ловсгаагийн баруун гарт илжигний хөргийн увидсыг бясалгаж өгөв. Зүүн гарт нь хамаг амьтныг туслах увидсыг бясалгаж өгөв. Цангилзах

дулдуй, хар бадар аягыг бүтээ ж өгөв. Очсон явдла бүтээж Гэсэрийг илжиг болгосны хойно над үтэр түргэн хүргэж ир. та хадгалж үл чадах ” тэгж захираад “Та нар харь” гэв. Ловсгаа эхлэн тавуул гэртээ нэгэн үдийн цагт хүрч ирээд Гэсэрийн газарт зорчив. Гэсэрийн ялгшуусан гурван өхий нь түүнийг мэдээд огторгуйд тулмаар хар үүл болон хөшиж байв. Төдий Ловсгаа давж гарах аргаа завхаж зүдэж мэгдэж байв. Гэсэрийн Овоо Дүнжон эгч нь зарлиг болрун: “ Бид гурвуулыг Гэсэрт очих дайсанд саад хий гэсэн билүү? Эдүгээ төөрөг (аз) урьдаар ламд болох байна. Ламынг зориг үйл бүтэх байна. Түүний хоной гэсэрийн зориг үйл бүтэх байна. Гайгүй” гэж гурван дагина өвөр зуураа хэлэлцээд хар уулаа хурааж аваад өөд болов.

Лам түүнээс цааш газрын пунд очтол Гэсэрийн анд босон гурван тэнгэр мэдээд дээрээс нь тор орхиж лам эхлэн тавуулыг барив. Төдий Гэсэрийн анд болсон гурван богд тэнгэро өвөр зуураа өгүүлдэрүү: “Эрт урьд Хурмаст тэнгэрийн зарлиг . Энэ замбутивийн эзлэгч Гэсэро хаан билээ. хэрэв гэсэрийн хүч мөхөсдвөл бид гурван тэнгэрийг өмөглөлц гэсэн нь үнэн билээ. Гэсэрт ирэх дайсан бүү саад хий гэсэн байтал бид гурюан тэнгэо эдүгээ энэ таваг дайсан хүнийг Гэсэрт хүргэхгүй байна. Гэсэрийг дйилсэнгүй байтал бид санаагаар (дураар) замд нь тосож урьдаар баривал хаан хурмаст тэнгэро бидэнд хилэгнэх болно. хойно үйл бүтээгч сонсоод, бас буруушаах болно” гэж хэлэлцээд тавив. Үлгэрлэвэл лам эхлэн тавуул урхинд торсон шувуу урхинаас мултруулсан мэт гараап яаран яаран явж Гэсэрэийн улсын захад хүрээд бүс гэр (майхан) барьж суутал ламын дэргэд Гэсэрийн үгүү ядуу улс мөргөөр ирсэн хүмүүст өглөн ихэд өгөд сохор доголон өвчин цэртэн амьтан ирвэл увидас өгөөд мөн биенд нь тохируулж эцэг эх мэт асрах нигүүлсэн сэтгэл төрүүлж байв. Тэдгээр мунхаг амьтан эс мэдээд тэр ламыг ихэд хүндлэх сэтгэлтэн болов.

Лам мэхэлж Гэсэрийг илжиг болгов.

Төдий тэр лам цааш очоод Гэсэрийн хотын баруун өмнө бууж суутал эн тэргүүн лам мөргөсөн нэгэн сохор хүн ирээд Алтан дагинад айлтгаруун: “Миний нүдийг эдгээв. Энд нэгэн алтан өнгөт их хутагт лам ирээд манай үгүү ядууд өглөг өгөөд нүдгүй амьтанд нүд оруулав. Дүлий амьтны чихийг сонор болгов. тийм их гайхамшигт лам байна” гэв. Тэндээ Алтан дагина ийн сэтэгрүүн : “Эжнээ! Би яагаад эс мэдэв? гэсэрийн зарлигаас давдаг билүү?” гээд төдий Алтан дагина таван зуун дагуулаа дагуулж өглөг барамидаа авч ламын дэргэд хүрээд дагна мөргөлгүй, ламын суусан ширээний гадуур ламын биеийг гурван үе эргэж үзээд шинжилбэл Сайваар одогсдын (бурхны) биеэс ялгалгүй алтан өнгөт лам байхыг үзээд дагина үзэлжм сүсэлж мөргөөд өглөг ббаримдаа бариад (өргөөд) харив.

Тэр цагт Гэсэрийн бясалгал найман хоног дутуу байжээ. Найм хоносны дараа сэлмээ өргөөд Алтан дагинад зарлиг болруун: “ Үүдийг минь нээ. Эдүгээ амьтныг туслах цаг минь боллоо” гэв. Алтан дагина Гэсэрийн зарлигийг сонсоод гадна сан тавьж зул хүж шатааж цан хэнгэрэг дэлдээд бүрээ бишгүүр татаж номын харшийн алтан үүдийг нээвэл Гэсэр хаан Алтан дагинад зарлиг болруун: “Үгүү дутуу амьтныг цуглуул. Өглөг өгсүү. Өвчтөн цэртэн амьтныг цуглуул. Өвчин цэрийг эдгээе. гэхэд. Алтан дагна ийн айлтгарун: “ Арван зүгийн эзэн гэсэр хаан минь . Чамайг бясалгалд суусны хойно нэгэн алтан өнгөнт гайхамшигт лам ирээд манай үгүү дутуу амьтанд өглөг өгөөд балай амьтанд нүд оруулаад дүлий үгүү дутуу амьтанд сонор өолгов гэхийг сонсооп чиний зарлилгаар өглөг баримадыг аваад таван зун дагуулаа дагуулж очоод мөргөлгүй ширээний гадур гурван үе эргэж шинжлэн үзвэл адлтан өнгөт сайваар одогсдын биетэй адил лам байна. Энэ лам мөнч биз, биш ч биз. Би үүнийг яаж таних вэ? Юу ч болов, мөртөө гжэ мөргөөд ирэв би. Гэсэр чи юу ч болов, түүнийг очиж таниасай” гэж айлтгавал Гээр хаан зарлиг болруун: “ Энэ Замбутивд надаас дээр лам байхгүй билээ. Би очихгүй . Над хэрэгтэй ирсэн лам болбол тэр энд ирж над иөргөх биз. Дэмий замын лам очиж мөргөх ёсгүй билээ. ” гэвэл Алтан дагина бас айлтгаруун: “ Чамайг тэр ламд очиж мөргө гэсэн биш. Чамайг жаргалдаа ташуурав гэж эцэг чинь хурмаст тэнгэр тэнсүү (туршуул) илгээсэн ч биз. Бус, шулмасын хувилгаан лам ч байж болно . Би дагинын хувилгаан боловч эс танив. Би чамайг таньтугай гэж айлтгалаа. Чи өөрөө номын харшдаа суугаадп надаас дээр ламгүй гэх чинь юу вэ? Эцгийн чинь илгээсэн тэнёүүлч биз Тэнсүүл мөн болбол чи гэртээ залж мөргөхгүй юу? Биш шулмасын хувилгаан лам болбол чи түүнийг таниад доройтуулахгүй юу? гэж айлтгасан учир минь энэ билээ” гэсэнд Гэсэр хаан тэр үгийг зөвшөөгөөп Гэсэрийн өөд болоход Гэсэрийн өмнө цан хэнгэрэг дэлдээд туг хиур барьж бүрээ бишгүүрийг татаж өөд болоход Билгийн хээр морь нь огторгужйгаас угтан бууж ирээд гэсэрийн өөд болох зам дээр хөндлөн зогсоод ийн айлтгаруун: “Арван зүгийн эзэн Гэсэр хаан чи, юунд өөд болов?” гэж асуувал Гэсэр хаан зарлиг болруун: “манай энд нэгэн их лам ирж гэнэ. Би түүнд мөргөхөө очьё ” гэв. Хээр морь бас айлтгаруун: “ Эрт урьд эцэг чинь Хурмаст тэнгэр чамайг сургахдаа зарлиг болдог билээ. Дээд биенд чинь арван зүгийн бурхан төгссөн, дунд биенд чинь дбрвөн их тэнгэр нар төгссөн, бэлхүүсээр чинь зуун найман эх дагина төгссөн, энэ Замбутиваас чамаас дээр бурхангүй гэж зарлиг эс болуу? Одоо энэ замын ламын аль явдлыг мэдэж мөргөө гэнэ вий? ” гэж айлтгавал арван зүгийн эзэн гэсэр хаан хэр моринд зарлиг болруун: “ Би эцгийн зарлигийг мартах билүү? Намайг мартсан мэт санаад ирж хэлэр яинь энэ байна. Энэ чинь маш зөв. Чиний хэлсэн үг үнэн байтал, би лам бүрд юунд мөргөх вэ? Энэ ямар учиртай ирсэн лам болов ? гжэ тэнсэн танихын тул очих минь энэ билээ. Хээр морь чиний мэдэхийг

би мэдэхгүй гэж үү?” гэсэнд хээр морь өгүүлрүүн : “Гэсэр ийм зарлиг болсны хойно адгуусан амьтан над ямар үг б айх вэ! үүний хойно над зэмгүй” шээд огторгуйд гарч очив.

Гэсэр одоо ламын дэргэд хүрч ламын биеийгш шинжлэн үээд ламйын ширээний гадуур гурван үе эргэж үзвэл ламын үе гишүүн нь чичирч үс ячс нь ширвээтэж бор зүрх нь булгилж богино хаврига нь шархирч байв. лам их айсан боловч биеэ эрхгүй даран даран суув. Төдий Гэсэр хаан ирээд баруунтаа нь алтан сандал дээр арсалны арьсан дэвсгэр дээр суув. Арван зүгийн эзэн Гэсэр хаан арсланы дуугаар ихэд тасхийн дамд зарлиг болруун: “ Ай лам чи хаанаас ирэв? Ахуй сүх газар ус чинь хаана вэ? Ачит үндсэн б агш лам чинь хэн бэ? Аль өглөгийн эзэд тахидаг вэ? энэ ямар учиртахй ирсэн лам бэ? надтай рид хувилгааны тэмцэлдье. Эсбүгээс надаас өглөг барамид гуйхын тул ирэв үү? Би өглөг барамидаа өгье. Энэ Замбутивд надаас дээр бурхан үгүй батал чиний ирсэн учир шалтгаан юу вэ? Чи надаас дээр рид хувилгаантай лам болбол над рид хувилгаанаа үзүүл. Би чамд мөргөө. Чи надаас дор лам болбол би чамд рип хувилгаанаа үзүүлсүү. Чи над мөргө гэж Гэсэр хаан зарлиг болсонд тэр лам ихэд айж цочин байтад үл айхын ёсоор лам биеэ эрхгшүй даран даран сууж ийн өгүүлрүүн ::“ намайг хэлэхийн урьд Гэсэр хаан чи ухаандаа мэдсэн ажээ. одоо чамтай рид хувилгаан тэмцэлдэх гэсэн биш. Би Очирт орон дахь Шигэмуни бурхнаас бурхан чамайг ямар учиртай энэ Замбутивд илгээв? Ай лам? Энэ үг чинь тун худал үг мэт юу вэ? ” гэв.

Тэндээс лам Гэсэртэй суусаар дааж ийн айлтгаруун: “Шигэмуни бурхан очирт оронд суух цагт би шинэхэн дагасан (ширээ даасан) нэгэн аяга тахималиг (гэлон) байлаа. Бурхандп над зарлиг болруун: “Чи дорд Замбутивд түргэн одоод миний энэ зарилгийг үйл бүтээгчид номлож өг. Энэ урьд эцэг чинь хурмаст тэнгэр таван зуун жил болоод гурван хүүдийнхээ нэгийг илгээ гэвэл жаргалдаа ташуурч миний зарлигийг мартаад хоёр зуун жил илүү болсны хойно илгээв. Түүний хойно болбол үйл бүтээгч, мангаын газарт очоод манаыг дараад ирэхгүй жаргаж Арлан гуа хатныг баг идээнд ташуурч суув. Түүний хойно Шарайголын гурван хаан ирж өаливаа бүгдийг чинь эцэс болгож . одоо болбол чи хамаг амьтныг хичээж өршөөхгүй байна. тиймийн тул Бурханы зарлиг : “Үйл бүтээгч надтай атаархах болбол чи очирт оронлд гарч ир. Би дорд Замбутивд очоод чиний чинээ амьтныг туслахгүй юу ? гэж зарлиг болсонд тэр цагт Бурханд намайг үл итгэх биз“ гэж айлтгаваас, тэндээс бурхан миний оронд аьшиг тавиад сац би алтъан өнгөт болов. Чамайгүл итгэх гэж энэ бадар аяга, цангилзах дулдуйг тэмдэг болгож өгсөн учир нь тэр билээ. ” тэгж лам өгүүлбээс “гэсэо хаан зарлиг болруун: “За бид эцэг хөвгүүн хоёр буруу явсан нь үнэн байна. Бурханы зарилгаар миний эцэг хурматтэнгэр чамд юм хэлэвүү? Чамаас өөр илч илгээв үү? Тэндээс чамайг ирэхэд гучин гурван тэнгэр нар мэдэв үү? Ялгуусаан гурван өхий минь золгов уу? Анд гурван бонгд тэнгэр минь мэдэв үү? Миний эцгийн гэрт чи оров уу? ” гэж асуувал лам өгүүлрүүн. “Бурхан намайг чиний эцгийн гэрт ор гэсэнгүй. Чиний гурван эгчийг би мэдэхгүй : Чиний анд гурван тэнгэотийг би танихгүй . Бурхан намайг тэнд хамаг тэнгэро нарт золго гэсэнгүй” тэгж хэлээд лам хилэгнэхийн дүрээр ийн өгүүлрүүн : “Урьд болбол чи рид хувилгаанар тэнсэлдье гэлээ, чи. Түүнийг хойно болбол Бурхны цангилзах удлдуй, хар бадар аяга хоёрыг итгэхгүй байна. чи. Храин намайг худалч гэж бана Эдүгээ Шигэмуний зарлигийг тоохгүй байна . Энэ үгийг чинь Бурханд айлтгасуу. та хоёр уулзаж хэлэлц. Би харьсугай” гээд дулдуйн хар бадар аягаа аваад босоход Гэсэр хаан зарлиг болов:” Аай лам чи Шигэмунийн дэргэдээс ирсэн аяга тахимлаг боловч би чамд мөргөх ёсгүй билээ. Бурхны дулдуй бадар аяга хоёрт мөргөм үү. Миний тэргүүнд Бурхны дулдуйд тавьж өг. ” гэж зарлиг болоод төдий Гэсэр хаан мөргөвөөс

лам дулдуйг авагч болоод илжигний хөргийг авч Гэсэрийн тэргүүн дээр тавиваас гэсэр хан хар илжиг болон байв. лам мэргэн яарч илжигний дээр гутал, өмд оймс, аливаа муу хувцасыг ачиж гэсэрийн биеийг бузарласны тул дээд биендэх арван зүгийн бурхан дээш гарав. Доод биен дэх найман лусын хаан доош лусын хаадад оров. Дундах биендэх соливцон давхарлах дөрвөн их тэнгэр нар дээд тэнгэр нарт гарав. Бэлхүүсээр нь ороон сахисан зуун найман дагина, дагинасын оронд харив. Эдүгээ шавар бие махбод нь үлдэв. Лам яаран илжгийг гурван давхар төмөр ногтоор ногтлоод гурван давхар төмөр чөдрөөр чөдөрлөөд хоёр хувидаан бөөгөөр бариулаад, төдий лам Алтан дагина, хамаг эрдэнсийн сан, илжиг тэд бүгдийг аваад лам эхлэн тавуул огторгуйд нисэн өөрийн газартаа зорчив.

Цас, Шуумар Нанчүн гурвуул Гэсэрийг нэхэж явав.

Алтан дагина явахдаа уйлан айж Лайцав хөвгүүнд өгүүлрүүн : “Чи очиж амраг Цас чихэр ахад нь гучин баатар, гурван зуун хошуучид нь хэл ” гэв. Лайцав хөвгүүн уйлсаар Цасад хүрээд хэлэв: “нэгэн хорт лам ирээд гэсэр авгай минь илжиг болгоод Алтан дагина эхийг минь аваад огторгуйгаар нисэн явав” гэж уйлан өгүүлбээс Цас сонсоод “Эвүү, энэ хөвгүүн над юу хэлнэм ” гэж уйлаад нисэх бор морио барьж эмээлээ тохоод морин дээр байж дүү Ронсад зарлиг болруун: “ түмэнжаргалан(Арлан гуа), ажу мэргэн, гучин баатар, гурван зуун хошуучид нь хэл. Миний хшойноос Гэсэрийн хотод зүг зүгээс яарч хүрч ирэ” гээд Цас Чихэр жигүүрт бор морио унаж уйлсаар гэсэрийн хотод хүрч ирэв. Цасын хойноос Арлан гуа, ажу мэргэн эхлэн, гучин баатар, гурван зуун хошуучид зүг зүгээсм дэд дэдээр хүрч ирээд Цас эхлэн хамаг бүгдээр уйлахад алтан дэлхий бүгд догдлон хөдлөв. дээр нисэх шувуу, лдохр гүйх гөрөөс бүгд цөм уйлалцав. Цас ухаан төгссөн бүхүйн тул сан тавиад тогтоов.

Цас зарлимг болруун: “ та бүгдээр юу санаж байна? Би нэхсүгэй” гэвэл гучин баатар, гурван зуун хошууч : “Цас авайг л мэд. Бид бүгд гэртээ суусаар Гэсэрийг илжиг болохыг эс мэдэв. Эдүгээ бас аливаа зүгээс дайсан ирэх мэдээгүй (магадгүй). та буль очъё гэх тань буруу. Би нэгэн хоёр баатарыг аваад очъё” гэв. Цасын зарлигаас үл давахын тул хамаг баатрууд дуу эс гарав. Тэндээс Арлан гуа, Ажу мэргэн хоёр бэр нь Цасад айлтгаруун: “ Бид хоёр эм хүн юу мэдэх вэ? авгай чи мэдээсэй” гэсэнд Цас зарлиг болруун: “ надтай Шуумар, нанчүн хоёр яв” гээд гурвуул мордоод нэгэн сарын газарт явж очтол гурван дпавхар их хар уулыг үзээд түүнийг Цас түдэлгүй харваж зам гаргаад явав. Түүний цаана очвоос хоёр давхар улаан хад байв. Цас зарлиг болруун: “Нанчүн минь, чи энэ хадыг харва” гэсэнд Нанчүн харваад зам гаргав. Түүний цаана очтол огторгуйд тулам зузаан хар модыг үзээ Цас зарлиг болруун. “Шуумар минь, чи үүнийг цавчиж зам гарга” гэсэнд төдөлгүй Шуумар есөн алд молор хар шороо сугаа татаад нэгэн агшин зуур модыг тас фцавчиж зам гаргав. Түүний цаана очтол их далайг үзээд Цас зарлиг болруун: “Шуумар Нанчүн хоёр минь . саяын огтолсон мод түргэн зөөж ир. Би сал хүлээж энэ далайг туулж гарья” гэсэнд шуумар нанчүн хоёр, Гэсэрийн тулд уйлж явж модыг зөөв. Цас чихэр Гэсэрийн тулд гашуудаж сал хүлээж байтал огторгуйгаа ялгуусан гурван өхий нь уйлсаар буж ирэв. Цас, Шуумар, Нанчүн гурвыг гашуунд дарагдсаныг мэдээд уйлахаа байгаа хатуужих сэтгэлээр буужж ирээд Цасад зарлиг болруун: “Ай та гурвуул минв гашуунд дарагдаж байна. гэсэр минь үхэх ёсгүй бишүү. Бид гурван өхий нь эцэгт нь Хурмаст тэнгэрт мэдүүлье. Та гурвуул санаагаа бүү зою. Харь” гэж хэлээд төдий гурван дагина огторгуйд өөд болов. Ялгуусан гурван өхий зарлигаас үл давахын тул Цас эхлэн гурваал харьж ирэв.

Ажу мэргэн хатан Гэсэрт туслах заяатай

Тэр гурван дагина очоод Хурмаст тэнгэрт айлтгав: “мангаын нэгэн хувилдгаан, лам болж ирээд Гэсэрийг илжиг болгоод Алтан дагиныг аваад очив” гэж мэдүүлбэс Хурмаст тэнгэр хоёр хүүгээ аваад гуин гурван тэнгэр нарыг хураагаад зарлиг болруун: “Эдүгээ миний хөвгүүн Үйл бүтээгчиг мангас илжиг болгож гэнэ. Түүнд туслах арга юу байна?” гэж асууваас төдий гучин гурван тэнгэр нар: “Бид юу мэдэх вэ! Чи мэдэх бэ” гэсэнд тэндээс хурмаст тэнгэр, ААмин сахигч, Төгс цогт хоёр хөвгүүндээ зарлиг болруун: “та хоёрын хэн танв эрдмээр илүү вэ? тэр нь очиж тусал гэсэнд төдий Амин сахигч сөгдөн айлтгаруун: “Чи намайг эцэгээ зарлиг болсныг сонсож, дүүгээ илжиг болсныг мэдээд очихгүй гэхүү? Би хүч үл хүрэхээ мэдүүлнэ.” гэв. ЫБас дүү нь Төгс Цогт сөгдөн айлтгаруу: “Би ахаа илжиг болов гэхэд очихгүй яах вэ дийлж үл чадахаа айлтгая Эцэг минь, гэгээндээ айлд!” гэсэнд хурмаст тэнгэр зарлиг болруун “Энэ хоёр хөвгүүдийн минь цөм үнэн. Эдүгээ бид бүгдээр Шигэмуни бурханд айлтгая.” гээд Бурханд хүрээд Хурмаст эхлэн гучин гурван тэнгэр нар Бурханд мөргөөд хурмаст тэнгэрт айдтгав: “мангасын нэгэн хутдгаан, лам болж ирээд Үйл бүтээгчийг минв илжиг болгоод Алтан дагина, аливаа бүгдийг аван очив гэнэ. Түүнд туслах хүнийг эс олоодп Бурхандп айтлгаж б айна” гэвэл бурхан зарлиг болруун: “та нар хариад үйл бүтээгчийн дээр тэнгэр нарт эцэг эхээс аль сар, аль өдөр, аль цагт өтөрв? Дор Замбутивд очоод эцэг эхээс аль жил, альсар, аль өдөр, аль цагт, төрөв? тэр хоёр эхийн төрсөн өдрийн үүдний мэнгийг нийлүүлж гэсэрийн заяаны бичигт үз. гэсэр хэдэн үе эндэх нь вэ? Ямар ёст хүн туслах вэ? Түүнийг зохиж (Нягталж) шүүз үз. Эдүгээ би илэрхий зааж өгөх билээ. Бясалгалд минь саад болно. Миний зарлиг, болсонд хурмаст тэнгэр тэргүүлэн гуин гурван тэнгэр нар бүгдээр харьж ирээд дээрх эх, дорх эх тэр хоёр эхээс нь төрсөн сар өдрийг асуугаад үүдний мөнгийг нийлүүлж заяаны биичгт үзвээс Гэсэрийн илжиг болох хэмжээ нь мөн байжээ. гэсэр есөн үе эндэх болно. “Эдүгээ хэн туслах вэ?” гэж заяаны бичигт дахиж шүүж үзвэл гэсэрийн нэгэн хатан Ажу мэргэн хатан туслах юм байна. төдий хамаг бүгдийг заяаны бичгээс тодорхой мэдэв.

Ажу мэргэн Гэсэрт туслахаар мордов.

Тэндээс Хурмаст тэнгээ, гурван дагинад зарлиг болруун: “Энэ алтан хумхандах рашааны архийг аваад Ажу мэргэн бэрд минь очоод миний зарлигийг, үйл бүтээгчийн учрыг тодорхой бүрэн төгс хэлж өг” гэв. Гурван дагина тэр рашааныг архийг авад огторгуйгаас нисэн буух цагтаа мянган луугийн дуугаар зэрэгцэн тасхиын дуу гарваас алтан дэлхий догдлон хөвдөл. Ажу мэргэний гэрийн тоонос есөн өнгийн солонго татав. Цас эхлэн гучин өаатар, гурван зуун хошууёч цочин босож гүйн гараад ийм тийм харж үзвээс Ажу мэргэний тооноос есөн өнгийн солонго татсаныг үзээд: Цас зарлиг болруун: “Эвүү, гэсэр минь ирсэн болов уу? Энэд ийм их дуу гарах хүнгүй билээ” гаад морьтой морьгүй, эмээлтэй эмээлгүй зайдан унасаар, зарим нь бүсгүй үарим нь малгаагүй, зарим нь хөл нүцгэн холоос ойроос хамаг улс дэд дэдээр Ажу мэргэний гадаа хүрч ирвээс өАжу мэргэн алтан ширээн дээр арван гурван давхар торгон олбог дэвсэн сууж байв. Огторгуйгаас гурван дагина алтан хумханд рашааны архийг гартаа барьсаар Ажу мэргэний өмнө сөгдөж байхыг Цас эхлэн бүгдээр үзээд басхүү сөгдөлцөн байв.

Тэндээс Ажу мэргэн карлиг болруун: “Эвүү, ялгуусан гурван өхий минь юуны тулд сөгдөв? Би айж үхэх шахаж б байна. Над сөгдөх ёсгүй бишүү.”: төдий гурван дагина зарлиг болруун: “Ажцу мэргэн чи бүү хөдөл. Хөдлөх чиньхойно болтугай. Бид гурвуул өчүүхэн хэрэгтэй билээ.” гээд зарлиг болруун: Хадам эцэг чинь, Хурмаст тэнгэрийн зарлиг үйл бүтээгч илжиг болсон тул хурмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр бид бүгдээр хэлэлцэж хэн туслах вэ? гэж аралцвээс бас эс олдов. Төдий хурмаст тэргүүлэн бид бүгдээр очиж Шигэмуни бурханд айлтгаваас Бурхны зарлиг: “Би илэрхий зааж өгөх билээ? сэмд (бясалгалд) сууж байна. та бүгдээр очиж гэсэрийн заяаны бичигт үз.” гэж зарлиг болсонд бид бүгдээр ирж заяаны бичигт нь үзвээс гэсэрийн илжиг болох хувь нь мөн ажээ. Заяаны бичигт нь үзвээс эгэср есөн үе энждэх ажээ. Энэ илиж болон эндмэн Ажу мэргэн хатан нь туслах байна. хадам эцэг чинь хурмаст тэнгэр энэ алтан хумханд рашааны архи хийгээд чамд бэрдээ өгч илгээсэн учир тэр билээ гэсэнд Ажу мэргэн яарч рашааны архийг гартаа авад гурван дагинад Ажу мэргэн ийн айлтгаруун: гэсэр над ирж хоёр гурван сар сууваас над амбраг байна. гэж би үл баячрладаг билээ. надаас өөр очоод хоёр гурван жил болтол эс ирвээс би юм үл санадаг билээ. Гэсэр бид хоёр ханилсаар Гэсэр “Би илжиг болох. Чи намайг ирж тусалж ав” гэж ыгэсэр минь зарлиг болсонгүй билээ. гэвч дээр Хурмаст тэнгэр ахайн минь зарлиг, дэргэд минь ирсэн гурван өхийн минь зарлиг: “намайг очтугай!” гэсэн хойно, би эс чадавч аргагүй. очьё би” гээд Ажу мэргэн гурван дагинад ийн айлтгаруун: “надтай ялгуусан гурван өхийн минь сахиулсаа нөхцүүл. гэсэрийн минь анд гурван тэнгэрийн сахиулс та нөхц. тийм болбол би очих байна” гэсэнд гурван өхий зарлиг болруун: “тэгж нөхцөх болтугай” гэж бошиг өгсөнд гурван өхийд Ажу мэргэн мөргөөд рашааныг архийг зоогловоос гурван өхий эхлэн гучин баатар, гурван зуун хошууч бүгдээр баясаад цөм мөргөв. дарий дээр Ажу мэргэн босон гүйж хуягаа авч өмсөөд саадгаа бүсэлж жад илдээ хоёр гартаа барин, биеэ хөх и тарлан харцага өолгон хувилгаад тооноор түргэн нисэн гарваас тоононоос таван өнгийн солонго татав. Төдий Ажу мэргэн мангасын газарт зорчитв. Ялгуусан гурван өхий нь дээш огторгуйд өөд болов. Цас эхлэн гучин баатар, гурван зуун хошууч бүгдээр баясалцан гэр гэртээ тархав.

Ловсгаа Гэсэрийг илжиг болгоод элдвээр зовоов.

Ловсгаа тэр илжгийг аваачсаар гурвани сар болтол өвс ус өгөхгүй байв. Нэгэн өдөр мянган таар буудай дарж (талхалж) байв. тэр буудайг дарахад хоёр хувилгаан бөө хоёртаа нь байгаад шийдмээр цохиж байдаг байв. Тэр хоёр бөжөгийн эм нь гурил элгэгдэж (шигшиж) суудаг байв. Төдий нэгэн өдөр тэр илжиг үхэх лйртсонд уярха мэт дуугаар гаслан уйлав: “Дээрх Хурмаст тэнгэр эцэг минь эвүү яалаа, дэдэд нь болбол Эсруагийн аймгийн эрвэн долоон тэнгэр минь эвүү яалаа. Ялгуусан гурван өхий минь, эвүү яалаа. Анд болсон гурван тэнгэро минь эвүү яалаа. Мангасын сахиулс ингэж байхад миний сахиулс эвүү яалаа,” гэж гаслан уйдбаас дэргэд нь байсаан хочр бөө, хоёр эм дөрвүүл фцөм уярч уйлалцаад нэгэн өдөр дарах буудайн таван зуун таарыг дарав. Таван зуун таарыг эс дарав. Дарий дээд хоёр бөө, Ловсгаад очоод ийн айлтгаруун: “Энэ илжгэнд гурван сар болтол юм идүүлсанэгүй . Эдүгээ илжигэнд явах чинээгүй (чадалгүй) болов. Энэ өдөр таван зуун таар буудай дарав. Эдүгээ илжиг явж чадахгүй байна. Яах вэ? гэж асууваас тэндээс Ловсгаа зарлиг болруун: “тийм болбол нэгэн өдөр нэгэн шил (арваад атга) буурцаг, нэгэн боолт өвс өг. түүнээс илүү бүү өг. Алдах болуузай. Тэр та нарт арга хийж лав хуурах бий. Тэр илжиг үхэх ёсгүй бишүү. Маргааш бас мянган таар буудай дар” гэв.

Төдий хоёр бөө харьж ирээд илжгэнд нэгэн шин буурцаг, нэгэн боолт өвс өгч хонов. Маргааш нь мөн илжгээр бас мянган таар буудай дарж явахад Ажу мэргэн огторгуйгаас нисэн яваад зуун найман асарт хотын дээгүүр эргэж явбаас илжиг басхүү уярах мэт дуугаар гаслан уйлав.””””

Дээр Хурмаст тэнгэр эцэг минь эвүү яалаа. Дэдэ нь болбол Эсруагийн аймагт арван долоон тэнгэр минь, эвүү яалаа. Ялгуусан гурван өхий минь, эвүү яалаа. Анд болсон гурван тэнгэр минь, эвүү яалаа. Мангасын сахиулс иэнгэж байхад миний сахиулс эвүү яалаа. Миний эм Алтан дагина яи энэ илжигэнд баахан өвс ханатал өг. Усал гэж хэлээсэй. Урвах чинь энэ биүү? Эвүү яалаа гэж гашуудан уйлбаас Ажу мэргэн хатан огторгуйгаар нисэн эргэж явсаар сонасоод үлгэрлгүй ихэд уярч “Эжнээ, Гэсэр минь ингэж үлгэргүй зовож байна” гэж дотроо сэтгээд Ажу мэргэн уйлан явж ялгуусан гурван өхийд залбираад “Над адистидийн идээг мөндөр болгон, рашааны усыг хур болгон өгөх ажаамуу” гэж залбирсанд дарий дээр гурван өхий Ажу мэргэний залбирсанаар мөндөр хурыг илжигний биен дээр оруулж өгөв. төдий илжиг муу тээрсмээ татан явж зөв буруугүй үмхлэн явав. Ажу мэргэн огторгуйгаар нисэн эргэж үзвээс жаран гурван үет алтан сувраганы дпээр, мангас Алтан дагина хоёр, алтан ширээн дээр сууж өмнөө элдэв зүйлсийн жимс тавиад шатарцаж байхыг Ажэу мэргэн үзээд :Эжнээ, Алтан дагина үлгэрлгүй сайн эрийг олжээ. Мангас чи ч болов юутай сайн эмийг олоов вэ? Би та хоёрын тавихгүй (зүгээр орхихгүй): гээд Ажу мэргэн хилэн төрж огторгуйгаас гурван үе довлон дүүлж шүүрэхийш зайвдаад харин дээш гаран Ажу мэргэн дотроо сэтгэрүүн : “Эжнээ, Би энэ мангасыг довтлоод Гэсэрээ авч чадвал маш сайн билээ. Хэрэв хүч эс хүрвэл гэсэрийн минь биеийг ихэд зовоох болов уу? Дээр Хурцмаст тэнгэр ахай минь, ялгууса гураван өхий минь, намаг зэмлэх болов уу?. Эдүгээ чамайгаа яаж аргалая? Гэж ийш тийфш хяламлзан харж үзвэл гурван сарын газарт гурван зуун аартай нэгэн их хотйг үзээд “Энэ ямар учиртай хот болов ? Түүнийг үзэж тэнссүгэй” гээд тэр хотыг зүг сүрхрэн нисэн явав. Эдүгээ илжиг, тэр хурын усыг уугаад мөндрийг идээд хээл гараад (цадаад) дотроо ифн сэтгэрүүн : “Эжнээ. Би өөрийн газраас ирсээр энэ мэт цадаж ханасан минь үгүй билээ.

Үүнийг Хурмаст тэнгэр эцэг минь хайрлавуу? Ялгуусан гурван эгч минь хайрлав уу? Эдшгээ би язгуурын Гэсэрийын биенээс ялгалгүй болов. Би энэ дээр нэг аргалж үзсүгэй” гээд мөн тэр шөнө гурван давхар ширмэн байшингийн дотроос илжиг далан луугийн дуугаар тасхийж хашгиран туйлбаас гурван давхар ширмэн байшин дэлбэ үсрэв. Гурван давхар ширмэн хүрээ дэлбэ очив. Гурван давхар төмөр ногт, гурван даюхар төмөр чөдрийг тас татаад илжиг огторгуйд гарч очтол хоёр хувилгаан түшмээл сурваганы дээрээс үзээп нисэн гүйцэж илжигний хоёр чихэн дээрээс нь аваад Ловсгаад авчирч өгөв. төдий Ловсгаа хоёр бөөг днгодоод “Эдүээ илжиг үхэх гэгч тнв алдъ вэ? Би атнд юу захилаа?” гэж хоёр хувилгаан бөөг зуугаад модоор занчив. “Эдүгээ алдвал та хоёрыг ална” гэв. Төдий илжигийг есөн давхар төмөр ногт, есөн давхар төмөр чөдрөөр чөдөрлөөд есөн давхар ширмэн хүрээнд, емөн давхар ширсэн байшингийн дотор оруулаап есөн алд ширмэн гадсаар уяж орхив. Ловсгаа хоёр бөөд зарлиг болруун: Шөнө хичээж мана. Бдбр нь нэгэн мянган таван зуун таар буудай толхи(тээрэмд)“ гэж захираад харив. Маргааш нь илжгийг тээрэмд хөллөөд хоёр бөө хоёртэгээс нь ширсэн сараалжаар кодож нэгэн өдөр мянган таван зуун буудай парж явав.

Ажу мэргэн, Гэсэрийг мангасаас салгаж авав.

Төдий Ажу мэргэн тэр хотод хүрээд дээгүүр нь эргэж нисэн явбал далан гурван үет алтан суюраганы дээр мангаын нэгэн хувилгаан эгч сахиус үзээд шинжлэн үзвэл нүдн нь нэгэн алд ширгэсэн хөмсөг нь өвчүүндээ хүрсэн, дээд соёо нь доош хандсан, доод соёо нь дээш хандсан ярзайсан шүдтэй, хоёр хөх нь өвдөгтөө хүрсэн, хоёр чиг нь дээвэо мэт түрүүлгээ дэлийсэн, хамрын хоёр нүх нь ойнгойсон, хоёр гарын хумс нь бүргэдийн хүмс мэт, үс нь гурван үе алаг: улаан, цагаан, шар гурван өнгөтэй, дуу нь батгана мэт гингэнэх ажээ. Тийм жигших мэт муу зүст эмгэнийг Ажу мэргэн үзээд “Би энэ мэт хувилгаан Гэсэрээ аргаж үзсүгэй” гэж дотроо сэтгээд “Энэ хортын аль тэмдэгийг нь алдах болов?” гэж эрэн нисэж явгал эмжгэн “Би идшилсүгэй” гээд есөн алд хар таяг модоо тулж төмөр хэдрэгээ бариад сувраганы дээрээс буувал нэгэн хөл нь доглон байв. Түүнийг үзээд Ажу мэргэн мангаын агчид адил хувилгаад Ловсгаагийн хотын зүг ирвэл Тэмдэнгт хувилгаан сэцүүн, сувраганы дээрээс үзээд Ловсгоод айлтгаруун”Манай өхий айсуу байна” гэвэл Ловсгаа зарлиг болруун: “Өхий ирэх нь зав бий Та хоёр түшмэл миний хойнооос алтан сандал аваад үтэр ир. Би урьдаар золгоё” гээд аравны газарт (1 газар нь 300 алд) очиж золгоод “Өхий минь мэнд үү?” гэж тэврэлдээд Эгч нь “Мэнд ” гэв. Ловсгаа ийн асууруун: “Өхий минь, намайгаа гурван үе тэвэрч гцурван үе үнсэх чинь аль вэ? Хоёр алтан бяруу чинь аль вэ? ” гэв. “Эжнээ. Чамайгаа ирэв гэхийг сонсоод яарч хоёр бяруугаа мартав. Одоо биеийг чиэнь үзээд баяр төрж тэврэх үнэсэхээ мартав”. Ловсгаа өгүүлрүүн : “ Өхийн минь үг зөв” гээд алтан ширээн дээр суулгаж дамнаж гэртээ авч ирэв. Эмгэн өгүүлрүүн : “ Ловсгаа чамайгаа Гэсэрийг илжиг болгож Алтан дагчиныг авч ирэв гэхийг сонсоод би баярлаж ирсэн минь энэ билээ. Эдүгээ над Алтан дагчиныг юунд золгуулахгүй байна вэ? ” гэв. “Өхийн минь зарлиг зөв. Хоёр түшмэл та очиж Алтан дагчиныг авч ирээд гаднаа мөргүүл” гэв. Алтан дагина ирээд гадна мөргөвөл эмгэн ерөөл тавив. “Эрдээ арвантээ гээгд. Зуур жарга гэв. Алтан дагина хоёр түшмэлд өгүүлрүүн: “ Эжнээ, Газар газрын зан болов уу? манай гэсэрийн газарт болбол бэр мөргвөл “Зуун насал, Зохиж жарга” гэж ерөөдөг билээ. Энэ тань хараал юмуу, ерөөл юмуу? Би эс мэдэв Газар газарын зан болов уу? ” гэж Алтан дагина хилэгцунэн өгүүлэхэд эмгэн сонсоод “Бнр минь над уурлаж байна Ловсгаагийн минь амь болтугай. Чи намайш яах вэ? ” гээд эмгэн “Тэр бэрийг үзье. үүд нээ” гэв. үүдээр шагайж нүдээ сарвачилж үзээд “Эвүү, эвүү яасан сайханы билээ . Юутай өнгөтэй билэ. Эвий минь ” гэв. Алтан дагина ганцхан хялам хийж үзээд хоёр түшмэлд өгүүлрүүн: “Ловсгаагийн эгчитйг би урьд үзээгүй билээ. Эдүгээ Ловсгаа та хоёр түшмэлгүй болбол би энэ эмгэнийг жигшиж золгохгүй билээ. Ажиглаж гшинжилбэл чихний гурван ойл нь Ажу мэргэни й чихний гурван ойлтой (эргүүлэгтэй) адил байна” гэвэл хоёр түшмэл өгүүлрүүн : “ Алтан дагина дуугүй бай. Өхий мэдэх болууай. Хойно бид Ловсгаатай нууж хэлэлцэе ” гэв. Тэр үгийг эм сонсоод “Тэр бэрийг үтэр цааш аваач” гээд “Намайг таниузай” гэж Ажу мэргэн ихэд айгаал ялгуусан гурван өхийдөө залбирвал (Алтан дагчиныб тэр үгийг) дарий мартуулав. Эмүгэн : “Одоо би харъя” гэв. Ловсгаа өгүүлрүүн : “ Өхий минь. Гэсэрийн газраас авчирсан аливаа эрдэнийн зүйлийг авч харь” гэв. Эмгэн : “Эмгэн хүн би тэр эрдэнээр юу хийх вэ! Над Гэсэрийн илжиг биеийг өг” гэв. “Өхий минь чи хадгалж чадах . Би чамд хайрлах биш.” гэсэнд эмгэн өгүүлрүүн : “Харин өгшөөт дайсныг над өгювөл зохих биз. Чи надаа илүү хадгалах уу?” гээд эмгэн хилэгнээд “Харьсуу” гээд хэдрэгээ авч босон гүйвэл Ловсгаа өгүүлрүүн : “ Өхий минь. Юу гэж уурлав? Байз. Илжгийг өгье” гэв. Алтан дагина өгүүлрүүн : “ Гэсэрийн аль хувилгааныг мэдэж өгье гэв та?” гэвэл Ловсгаа илжгийг өгөхөө байв. Эмгэн хилэгнэн хэлэв: “Хэний хүчээр авчирсан илжгийг хэнд хайрлаж байна? Миний

увдисын хүчээр Гэсэрийг илжиг болгосон гэж би саналаа . Одоо үзэхэд Ловсгаа чи өөрөө увидсаар Гэсэрийг илжиг болгосон гэж санаж байна” гэж уурлан донгодоод явав. Төдий Ловсгаа : “ Өхий минь. түр түдэн соёрх. Би чамдаа эрхэлж тэглээ шүү. илжгийг үтжэр авчир” гэв. Илжгийг авчирч өгөв. илжиг эмгэнийг үзээд үүрсэн янцгаав. Хоёр түшмэл хувилгаан өгүүлрүүн : “ Энэ илжиг өхийг үзээд юунд янцгаан уйлав. ” гэвэл эмгэн өгүүлрүүн : “та нар юу ч мэдэхгүй хүүхэд байна. нэгэн өдөр та нар мянган таар буудай дарж б айна. Би аваачаад нэгэн өдөр түмэн таарб уудай дарахгүй юу? Энэ хувилгаан илижг түүнийг мэдээд аргаа заюхаж янцгааж уялсан нь тэр билээ” гэвэл Ловсгаа : “ӨХийн минь тэр зарлиг үнгэн” гэв. Эмгэн илжгээ унаад явав.

Ловсгаа хоёр хувилгаан түшмэлд зарлиг болруун: “Энэ миний эгч мөн үү? Биш үү? Та хоёр харцага болон огторгуйгаар биеэ нууж даган яв” гэв. Хоёр хувилгаан түшмэд харцага болон хувилгаад огторгуйгаар биеэ нууж нисэн дагаж явав. Илжиг Ажу мэргэнд ийн өгүүлрүүн : “ намайг үтэрхэн дээш авч гараасай” гэв. Ажу мэргэн дээрээс нь илжигний чихний язгуурыг чичээд “Урьд болбол намайг үзээд бархиран уйлав чи. Одоо дээр чимнь хоёр хувилгаан элч явахыг юу гэж чи мэдэхгүй байна уу?” гэвэл илжиг : “Эжнээ, Би тэнэг болж мэдэгдэн алдаж б айна.” Гэж Гэсэр дотроо гэмшиж санав. Ажу мэргэн, ялгуусан гурван өхийг зууртаа залбиран явж мангасын эгчийн хотод хүрвэл үүдийг хадгалан улс төмөр бялуу бариад сууж б айв. Ажу мэргэн хувилгаанаао нүдийг халхалж хотод орж очоод алтан сувраганы дэргэд хүрч буувал “манай өхий мөн байна” гээп хоёр харцага гэртээ харив.

Төдий Ажу мэргэн мянган луугийн дуу гаргаад илжигээ сугадан дээш тасхийн гарвал мангасын эгч тэргүүлэн хамаг бүгдээр “Энэ юу болов?” хамаан үймцэж гайхцаж б айв. Хот нь гурван үе буруу эргэж тогтов. Ажу мэргэн илжгээ огторгуйд аван гарвал ялгуусан гурван өхий нь угтаж ирээд “Нусгай минь, мэнд үү? Манд үү?” гэж булиалдав Ажу мэргэн зарлиг болруун: “ Нусгай тань та нарт золгох чинээгүй (чадалгүй) байна. Би Гэсэрийг пээр тэнгэрт хүргэж өгөх билээ. Би дээд тэнгэр т гарах ёсгүй . Энэ илжгийг Хурмаст тэнгэр ахайд минь хүргэж өг” гээд Ажу мэргэн гэртээ харив.

Гэсэр өөрийн биендээ тохиров.

Төдий гурван өхий илжгийг Хурмаст тэнгэр хүргэж өгөв. хурмаст тэнгэро тэргүүлэн гучин гурван тэнгэр нар бүгдээр илжгийг аваад Шигэмунид очвол тэндээс Бурхан зарлиг болрун: “Эдүгээ би энэ илжгийг хувилгаж Гэсэр 8 болгох билээ. дөрвөн догшдын тарнийг бясалгаж байна. Энэ дээр гэсэрийг хувилгавал үл болох. Хувилгавал гэсэрийн хүч нь язгуурын хүчнээс илүү болоод хэрэв хилэгнэвэл хилэнгээ дарж үл чадах. Өвөр бусад хоёрыг үл таних болно. тиймийн тул үл хувилгах учир минь тэр билээ. Эдүгээ Хурмаст тэнгэр чи илжгийг авч хариад адистидийн идээгээр гурван үе бордоод олон бурсан хуваргуудыг залж ж ном уншуулаад рашааны усаар биеийг нь угаагаад арц гүглээр ариулбал өөрөө Гээр болж байх бий. Тэр цагт чи над Гэсэрийг дагуулж авчир. Би ван (эрх), авшиг өгье” хэмээн зарлиг болсонд төдий Хурмаст тэнгэр илжгийг гэртээ авч ирээд гурван үе бордвол арьс шөрмөс гүйцэж үлэмж сайхан болсны хойно, олон бурсан хувагудыг хурааж ном уншуулаад рашааны усаар, биеийг угаагаад арц, гүглээр ариулбал өөрөө Гэсэр болон байв. Тэд Хурмаст тэнгэр, Үйл бүтээгчийг Шигэмуни бурханлд авч очвол тэндээс Бурхан зарлиг болруун: “ За Үйл бүтээгч минь есөнтээ наманчлаад ийн айлтгаруун: “Тэр хорт мангаст нэгэн хар бадар аяга цуангилзах дулдуй хоёр байхыг үзээд эндсэн минь тэр билээ” Тийн хэмээн айтлгаваас Бурхан мишээн зарлиг болруун: “ үйл бүтээгч минь, нааш ир.” хамаавал Гэсэр бөхийж ирвэл тэргүүнд нь авшиг тавьж алтан өнгөт болгов. Бурхан зарлиг болруун: “ Үйл бүтээгч минв, эдүгээ харьж биеэр амар ” гэв. Төдий Хурцмаст тэнгэр тэргүүлэн гучин гурван тэнгэр, ялгуусан гурван өхий, анд болсон гурван тэнгэро тэд бүгдтэыгээ гурван сар болтол жаргал хийж суугаад Гэсэр “Эдүгээ би харьсугай” хэмээн хурмаст тэнгэрт айлтгавал Хурмаст тэнгэр зарлиг болруун: “Энэ алтан хумхан дахь рашааны архийг аваачаад Ажу мэргэн хатандаа аяганд хийж өгөөд мөргө” гэв. Гэсэр рашааныг архийг аваад харьж ирээд Амин сахигч, төгсцогт хоёул үдэж ирээд харив.

Эдүгээ Гэсэр мянган луугийн дуу гаргаж хүрчигнэсээр есөн өнгийн солонго татуулж бууж ирэхэд алтан дэлхий догдлон хөдлөв.Цас эхлэн гучин баатар, гурван зуун хошууч урьд ёсоор хүрч ирэв. Гэсэр бууж ирээд рашааны архийг Ажу мэргэн хатанд бариад сөгдөж мөргөвөл Ажу мэргэн рашааныг архийг яарч аваад “Гэсэр минь, зүгээр суу. Эр хүн эмдээ мөргөдөг билүү?” гэвэл Гэсэр мишээн босоод Цастай тэврэлдээд алтан ширээн дээр завилан суувал нанчүн, Шуумар хоёр эхлэн гучин баатар, гурван зуун хошууч цөм босож гучин хасаг архийг зооглоод улаан зээрд болон суув. Цас, Ажу мэргэн хоёул гучин хааг архийг зооглоод улаан зээрд болон суув. Шуумар, нанчүн эхлэн гучин баатар, гурван зуун хошууч дэд дэдээр арваад таваад хасаг архийг зооглоод тархав.

Гэсэр мангасын дунд эгчийг хатан болгов.

Төдий арван зүгийн эзэн Гэсэр хаан зарлиг болруун: “Эдүгээ би Ловсгааг алаад Алтан дагина авахын тул явъя” гэвэл Ажу мэргэн айлтгаруун: “ Би чамайг нэхэж очих замөдаа үзэв: Манай газраас цаана, Ловсаагийн газрааас наана, тэг дунд нь нэгэн их хүчтэй манасын эгч хоёулын хүчнээс наадах эгч нь үлэмж хүчтэй бололтой. Түүнийг урьдаар доройтуулбал цаадах хоёр нь гайгүй билээ” гэвэл Гэсэр (Тэр үг зөв) гээд төдий Гэсэр, Ажу мэргэн хоёул явав. Замд нь нэгэн хуа даваа б айв. тэр давааны наад дамд (хонхорт?) нь хоёр морио нууж уяд хярд нь гүйж гараад мярааж үзвэл хуа марал өвс идэж байв. Ажу мэргэн түүнийг үзээд Гэсэрт зааж өгөв. “Магнайн цагааныг бүү алд” гэв. Гэсэр татаж байж тавивал (харвавал) марал сэрд хийхэд нь алдаж орхив. Ажу мэргэн татаж б айж харвавал магнийн ц агаанаао хадтал харвав. Харвсан сумны төмөр, бөгсөөр нв цухуйж ирэхэд марал хялалзаж унаж боссоор тутаав. Ажу мэргэн зарлиг болруун: “Би чамайг эр хүн байна гэж урьдаао харва гэсэн. Чи харин алдав. Би эм хүн боловч ямар байна?” гэж хошигнон хэлэхэд Гэсэр, Ажу мэргэн хоёр инээлцээд эргэж ирж морио унаад марлын хойноос хөөсөөр очиж эмгэний хотод хүрвэл хаалга нь хаалттай байв. Гэсэр бууж гүйж очоод ирэн гурван жингээр хийсэн их болд сүхээ ширмэн хаалгыг болба дэлдээд Гэсэр Ажу мэргэн хоёр биеэ хувилгаж хоёр хүүхэд болон гүйж оров. Мангаын эгч нь нохойчилж оцойн сууж байв. “Ай хоёр хүүхэд энэ сумыг сугалж аваасай” гэв. Хөвгүүн өгүүлрүүн “ сумыг сугалж авбал чи миний гэргий болох уу? ” гэв. “За чиний гэргий болья” гэв. Гэсэр сумны төмрөөс бариад сугалж авна. Эмгэн гүйж босоод Гэсэр, Ажу мэргэн хоёрыг залгиж орхив. Гэсэр Ажу мэргэн хоёул гэдсэн дотроос нь зарлиг болруун : “ Чи бид хоёр эрдэнийг залгивч шингээж чадахгүй Үтэр гарга. Эс гаргавал бид хоёр зүрхийг чинь сугалаад гарна” гээд зүрхмийг нь тэмтэрвэл тэр эм ихэд айгаад бөөлжиж гаргавал Гэсэр босон гүйж эмийн оройн үснээс нь аваад есөн алд хар шороо суга татаад толгойг нь огтлон завдахад Ажу мэргэн Гэсэрийн гараас нь бариад Гэсэрт айлтгаруун: “ Ай богд минь. Үүнийг алах ёсгүй билээ. Эдүгээ үүнийг чи биедээ ав” хэмээн зарлимг болсонд Гэсэр тэр эмийг алахаа байгаад “Чи ам алд” гэв. Тэр эм Гэсэрийн илдийг долоож ам алдав. Гэсэр тавьж орхид Ажу мэргэний үгнээс нь үл давахын тул Гэсэр түүнийг гэргий болгоод Гэсэр Ажу мэргэн хоёр хариад тэнгэро нарын жаргалаар жарган суув.

Гэсэрийн Баатрууд, Ловсгаа мангасын зарим баатруудыг алав.

Төдий Ловсгаагийн их эгч нь “Гэсэрийг илжиг болгож Алтан дагиныг авчрав гэнэ. Би очиж үзье” гээд явбал сувраганы дээрээс хоёр түшмэл үзээд өгүүллрүүн : “ Өхий минь ирэхгүй билээ. илжгээ алдав уу? ” гээд уулын чинээ цагаан морио унаад яаран угтаж очив. “Өхий чи тэр өдөр ирж илджиг аваачаад эдүгээ юунд ирэв?” гэв. Эгч өгүүллрүүн : “ Эвүү. Илжиг гэгч чинь юу билээ? Ловсгаа минь нааш ир.” гээд гургван үе тэвэрч гурван үе үнсээд тавив. Ловсгаа өгүүллрүүн: “Өхий чи илжгээ алдаж орхиод мэлзэж байна уу? Гэрт орж хэлэлцэе ” гээд алтан ширээн дээр дамнаж аваачаад суулгаж ловсгаа асуув: “Чи яаж б айгаад илжгээ алдав ?” гэв. Эгч нь өгүүллрүүн : “Би илжиг аваагүй шүү . Та хүнд хуурагдаж өгсөн байна” гээд эмгэн түмэн эхт ам алдаагаар уураж сув. Алтан дагина зарлиг болруун: “ Чихний гурван ойл нь Ажу мэргэний чихний гурван ойлтой адил байнга гэж та хоёр түшмэлд эс хэллүү би? Ловсгаа чамайг илжиг өгөхөд Гэсэрийн аль хувилгааныг мэдэж өгье гэнэ вэ? гэж би эс хэллүү? ” гэв. Хоёр түшмэл өгүүллрүүн : “Бид хоёр огторгуйгаар нууж очоод өхийн сувраганы дэргэд буухлаар би ирсэн. Яасан жиг билээ?” гэв. Ловсгаа өгүүллрүүн : “эжнээ, Шившиг бол! Эдүгээ арга юу байна?” гэж асууваас агч нь өгүүллрүүн : “Урьд би танд юу гэж захилаа ? над одоо аргагүй” гэсэнд Ловсгаа өгүүлхрүүн : “Эдүгээ хотын гадуур гурван давхар төмөр тор хийе. Яаж орох вэ! ” гэв. Эгч нь ийн өгүүллрүүн : “Гэсэр гэгч тэнгэрийн хүү бишүү. Огторгуйгаар нисэж ирээд чиний хотын дээгүүр ирээд есөн давхар төмөр тор орхиод чамайг барьж алаад энэ Алтан дагинаа аваачих биз” гэв. Хоёр түшмэл өгүүллрүүн : “Алтан дагина өөрөө босож ирсэн үү? Гэсэр өшөөндөө хүргэж очсон элчийг алаад Гэсэр ирж өшөөндөө та нарыг алахгүй гэж үү? ” гэв.

Ловсгаа, Алтан дагина хоёр эхлэн, дөчин дөрвөн их сайд, дөрвөөн зуун баатар бүгдээрх “Өхийн тэр үг үнэн” гээд алгаа ташилдан “Ёо, халаг хоохой!” гэж халаглан уйлалдав. Ловсгаа эхлэн бүгдийг алаад, Алтан дагинаа аваад хотыг маан түймэрдээд хамаг улс малыг олз болгоод буцах байн гэж бүгдээр цурхиран уйлалдав. Ловсгаа үэхтхийн унаж байв. Эгч нь түүнд ус үсэргэн сэргээж байв. Ловсгаа өгүүллрүүн : “За өхий минь. Яах билээ? ” гэж асуувал эгч нь зарлиг болруун: “Энгд ч суувал алагпар мөн. и Тэнд ч очвол үхэх мөн. Заяа мэдтүгэй. Дөрвөн зүгээс нь цэрэг морпье” гэв эгч нь хойд зүгээс нь мордою. Лдовсгаа өмнө зүгээс нь мордов. Холёр хувилгаан түшмэл нь баруун зүгээс нь мордов. Хоёр хувилгаан бөө нь зүүн зүгээс нь цэрэг мордов. Ловсгаа дундад эгчдээ элөч илгээв. : “Би Гэсэрт дөрвөн зүгээс нв цэрэг мордов. Чи бас морд” гэв. Төдий дунд эгч нь зарлиг болруун. “Гэсэр бид хоёр өшөөгүй тул би цэрэг мордохгүй” гэв. Ловсгаагийн элч нь уурлаад арван түмэн адууг нь хөөж аваад явав. Гэсэрт мангаст мангасын хувилгаан хатан нь жороо хөх халзан луусаа унаж Гэсэрт хүрээд ийн айлигаруун: “ Лровсгаа чамд дөрвөн зүгээс чинь цэрэг мордож айсуй. намайг морд гэв. Би эс мордов гэж элч нь уурлаад арван түмэн цагаан адууг минь аваад очив” гэв. Тэндээс Гэсэр зарлиг болруун: “Адууг чинь би авч өгье. Чи харь” гэв. Төдий тэр хатан харив.

Цас эхлэн гучин ыбаатар, гурван зуун хошууч нь тэр хатны үгийг сонсоод цуглав. Арван зүгийн эзэн Гэсэр хаан зарлиг болруун: “Тэр муу Ловсгаа дөрвөн зүгээс минь цэрэг мордож айсуй гэнэ. Эдүгээ бид өмнөөс нь цэрэг мордьё. Цас, Нанчүн та хоёр минь эхлээд арван баатар, зуун хошуучийг абаад хоёр хувилгаан түшмэлийг тосож морд. Шуумар, Буйдан хорё минь эхлээд арван баатар, зуун хошуучийг аваад мангасын элчийг тосож морд. Банжур, Улааннүдэн та хоёр минь эхлээд арван баатар, зуун хошуучийг аваад хоёр хувилгаан бөөг

тосож морд. Би өөрөө Лайцав, Райцав хоёрыг аваад тэр муу ловсгааг тосъё” гэв. Ажу мэргэн Гэсэрт айлтгаруун: “Чи алтан дагиныг над хүргэж ирэхийг урьд зэмлэвэл би ихэд уурлах болно. Лайцав, Райцав хоёр хүүхдийг минь авч яваарай. Хүүхэд минь явж суртугай” гэв. Гэсэр “тэр үг чинь зөв” гэв.

Цас, Шуумар, Банжур гурвуул эхлэн зүг зүгт мордов. Шуумар Буйдандаа өгүүллүүн. “Бид яарч явж дайсснаа дараад Гэсэр Ловсгаа хоёрын дайлдахыг үзэлтэй билээ” гэв. Буйдан “тэр үг чинь зөв” гээд арван баатар, үуун хошуучаа аяаад өдөр шөнөгүй дүлж яваад ийн тийн харж үзвжл хэрээ туруу мэт олон хав хар дайсныг Шуумар үзээд Буйданд өгүүллүүн : “Эвүү. Энэ ямар ёст дайсан болов ? Туг хиургүй, саадаг, сэлэм, нумгүй. үүнийг би туршсугай” гэв. Буйдан өгүүллүүн: “ Чамаас илүү миний нүдэнд муухай үзэгдэнэ. Гарт нь төмөр хэдрэгнээс өөр юм үзэгдэхгүй байна. Чи урьдаар болгоогоод үтэрхэн ир” гэв. Шуумар хайсан хар морио тас гуядаж орж очюол олон эм адйсан угтаж байжээ. шуумарыг мориноос нь татаж орхиод мангасын эгч нь тэргүүлэн бүгдээр түүнийг саадаг нум, жад иолднээс нь хагацуулаад төмөр хэдрэгээр зодож байв. Буйдан өгүллүүн: “Энэ Шуумар ингэж удахгүй билээ. Ямар жигтэй дайсан болов?” гээхд Буйдан бэх цагаан морио унаад тасар гуядаж арван баатар, зуун хошуучаа аван орвол Шуумарыг морь, зэв зэхээс нь хагацуулж олшн эм дайсан биеийг нь төмөр хэдрэгээр зодож байхыг үзээд Буйдан өгүүллүүн: “”Эвүү Шуумар минь Чамд нэгэн арга байдаг бишүү. Чи марьав уу?” гэсэнд Шуумар эмгэний дөрвөн соёог хавсран атгаад огторгуйд нисэн гарч гал улаан булуу болон хувилаад огторгуйгаас доош өнхөрвөл түймэр болон шатаж хамаг цэргийг түлж орхив. Буйдан Шуумарын морь, зэр зэв бүгдийг төгсгөж ирэв. Шуумар эмгэнийг дөрвөн соёоноос нь аван чирж булуу мэт өнхрүүлж явсаарб айв. Буйдан эмгэний толгойг тас дэлдэж орхивол сүнс нь ялааб атгана болон хувирав. Буйдан хувилгааны галаар дээгүүр нь түймэрдэж Шуумар доогуур нь түймэрдэж тас алаад орхив. Шуумар Буйдан хоёр, эмгэний дөрвөн соёог тэмдэг болгож аваад Гэсэрийн дэргэд ирэв.

Цас, Нанчүн хоёул ийн тийн харан яьтал түг түмэн дайсны барааг үзээд хувь магнай баясав. Цас зарлиг болруун: “ Арван баатар, зун хрошууч минь та, дөрвөн зүгээс нь ороод түймэр шатсан мэт аашлаад ир” гэв. “тэр дайсанд хоёр хувилгаан хүн бий гэнэ. Тэр муу ямар дүрээр хувилбал нанчүн бид хоёр тэр дүрээр хувилаад алья” гэв. Төдий Цас нанчүн хоёр эхлэн арван баатар, гучин хошууч дэд дэдээр морио тасар гуядаж түмйрэ мэт дайсныг түргэн зуур алаад Цас Нанчүн хоёул хоёр хувилгаан хүний толгойг тас дэлдвэл хоёр хувилгаан түшмэлийн сүнс нь хоёр үнэг болон тутаавал Цас Нанчүн хоёр бүргэд болон хөөв. Гүйцэж ирэхэд хоёр чоно болон дутаав. Цас Нанчүн хоёр, тэнгэрийн аврага нохой боон хувилаад хөөв. Бас гүйцэж ирэхэд хоёр барс болон хувилаад хүрхэрч хярж байвал Цас Нанчүн хоёр арслан бролон хувилаад үсрэн барьж алав. Төдий Цас нанчүн хоёр тэргүүлэн арван баатар ,зуун хошуучаа дагуулан цогтой хатиран ирээд Гэсэрийн дэргэд суув. Гэсэр Цасад Шуумарын аливаа явдлыг тоолж зарлиг болбоос: “Цас эхлэн бүгдээр ихэд инээлцэв.

Түүний хойно, Банжур, Улааннүдэн хоёул од мэт олон дайысныг үзээд Банжур өгүүллүүн: “Энэ дайсныг алаад үүнд хоёр хувилгаан бөө бий гэнэ. Тэр муу ямар дүрээр хувилбал Улааннүдэн бид хоёул тийм дүрээр хувилаад алья” гэв. Банжур, Улааннүдэн хоёул эхлэн арван баатар, зуун хоушч, дэд дэдээр морио тасар гуядаж ороод түг түмэн дайсны сүнсийг гаргаад хоёр хувилгаан ыбөөгийн толгойг тасар дэлдвээс тэр хоёрын сүнс нь хоёр бялжуухай болж хувилан тутаав. Банжур, Улааннүдан хоёр, арван баатар зуун хошуучид “Бидний морийг

ав” гэж хэлээд хоёр хүйхнэг болон хувилаад хоёр бялжуухайгш хөөв. Гүйцэж ирэхэд тэр бялжуухай дээш гурвал нэг нь шүүрэн, доош буувал нөгөө нь шүүрэн, бут бургасан шургуулж хөөсөөр хоёр хүйхнэг, хоёр бялжуухайг Гэсэрийн өмнө гүйцэж бариад алав. Гэсэр, Цас эхлэн бүгдээр үзээд инээлцэн байв.

Гэсэр хаан Ловсгаагийн сүнсийг устгаж түүнийг доройтуулав.

Төдий арван зүгийн эзэн Гэсэр хаан зарлиг болруун: “ та бүгдээр аливаа атаатнаа алав. Дайснаа цөм дарав. Эдүгэ хишиг (ээлж) над болов. ловсгаа бид хоёрын наадахыг та нар сайн үзэж бай” гээд Гэсэр билгийн хээр морио унаад лугшин хатирч очвоос Ловсгаа гэнэт Гэсэрийг үзээд яаран уулын чинээ цагаан морио унаад морио тасар гуядаж тутааваас Гэсэр хойноос нь хөөж очоод эрхгүй гүйцэж морио татаж орхиод есөн алд хар шороо суга татаад хоёр гурвантээ цавчваас даахгүй байв ерэн гурван жингээр хийсэн их болд сүхээр толгойг нь цоор цоор дэлдвээс үхсэнгүй. гэсэр түүний үл үхэхийг мэдээд нэгэн их уулыг өргөөд босов. Гэсэр мориноосоо бууж гүйж очоод хоёр уулаар дарваас хоёр уулыг өргөөд босоов. гурван уулаар дарваас бас өргөөд босов. Гэсэр таван уулыг хавсаран тавиад дээр нв зургаан үсгийг бичвээс мангас эс хөдлөж чадав. Гэсэр ловсгаа хоёрын байлдах тоосонд хүн мал цангаж үхэхэд ойртов. Гэсэрийн биений хөлс баруун этгээдэд урсав. Ловсгаагийн биений хөлс зүүн этгээдэд урсав. Гэсэрийн хөлсийг уусан амьтан эдгэж байв. Ловсаагийн хөлсийг уусан амьтан үхэж байв.

Төдий Гэсэр эргэж ирээд алтан сандал дээс сууж хөлсөө арчиж байваас цас эхлэн бүгдээр айлтгаруун: “ Чи түр амарзана. Энэ цэрэгт нь бид бүгдээр орж цавчлаадъя” гэвэл Гэсэр зарлиг болруун: “ та нар байг. Миний хоёх хөвгүүн Лайцав, Райцав хоёр орж цавчтугай. Бид бүгдээр үзье” гэв. Төдий хоёр хөвгүүн Гэсэрт сөгдөн мөргөөд ийн айлтгаруун: “Бие минь бага боловч уур минь их. Бие морины уурыг дарах увидсыг хайрлан соёрх” хэмээвээс Гэсэр тэр хоёр хөвгүүний бие мориний уурыг дарах увидас өгөю. Хоёр хөвгүүн мөргөөд мордон очиж дайсанд хүрээд дөчин дөрвөн их сайд, дөрвөн зуун баатрын толдгойг тасар дэлдэж орхиволлс сүнс нь олон борчин соно болон огторгуйд нисэж гарав. Хоёр хөвгүүн өгүүлрүүн : “хэнд хувилгаан бий? Хэнд хувилгаан байхгүй ?” гээд нэг нь шонхор болон хөөв. нөгөө нь начин болон хөөв. хоёул огторгуйд нисэн гүйцэж тас нударч орхиод эргэж ирээд морио унаад Гэсэрийн дэргэд ирж Гэсэрт мөргөөд сууваас Цас зарлиг болруун: “Хоёр хөвгүүн минь. Хав бах тань ханав уу?” хэмээн асууваас “Баахан уур дарав” гэж айлтгав. Гэсэр тэргүүлэн бүгдээр инээлцэв.

Гэсэр зарлиг болруун: “Цас эхлэн бүгдээр харь. Би лайцав, Райцав хоёрыг аваад мангасын хотод нь очье. Мангасын аливаа сүнс нь хотдоо бий. Би хотод нь хүрээд аливаа рид хувилгаанаар аргалж сүнсийг нь албаас энэ муу ловсаагийн бие, үе гишүүн нь өөрөө цуцрах болно. хотын найман өнцөгт нь найман алтан гадас бий. Найман гал эрдэнэ, найман шил эрдэнэ бий. нэгэн алтан суврага бий. итэр сувраганы дотор нэгэн алтан гадас нэгэн алтан тарвага бий. тэр бүгд цөм мангасын сүнс болно. Суврагыг буулгаж орхиод хотыг нь түймэрдээд Алтан дагиныг авч ирье” хэмээн зарлиг болоод төдий Гээр, Лайцав, райцав хоёрыг аваад мангасын газарт өөд болов. Цас эхлэн гучин баатар, гурван зуун хошууч _, тэр энгүй олзоо төгсгөж аваад харив.

Төдий Гэсэр, Лайцав, райцав хоёрыг аваад явбаас нэгэн их уулын дээр мангасын сүнс хоёр өвгөн сүжж б айв. гэсэр хувилгаанаар хүрээд сүхээр цохиж алаад Гэсэр зарлиг болруун: “ Лайцав, Райцав хоёр минь. Мангасын аливаа дөрвөн хошуу малыг та хоёр төгсгөж аваад намайг хүлээж суу. та хоёр очиж болохгүй. Би мангасын хотод хүрээд мангасын алиюаа сүнсийг рид хцувилгаанаар арга хийж барьж алаад Алтан дагина эхийг чинь тан дээр авч

ирье” гэв. Төдий Гэсэр нэгэн агшинд хүрээд хотын найман өцөгөр нь найман гадас, найман шилд эрдэнэ, найман гал эрдэнийг аваад суваргыг түлхэж орхиод, лотрох нэгэн алтан гадасыг сугалж у аваад, алтан тарвага, есөн алтан гадас гал эрдэнэ шил эрдэнэ, хотыг түймэрдээд аливаа бүгдийг цөм хамарч Алтан дагиныг хүлж авган тужж билгийн ташуураар жанчсаар авч ирвээс хоёр хөвгүүн угтаж ирээд Алтан дагинын хүлсэн гарыг тайлж тавив. Арван зүгийн эзэн Гэсэр хаан мангасын дөрвөн хошуу хүн мал, аливаа зүйл эрдэнэ бүгдийг хувилгаж хоёр имдий (?) болгон хоёр хөвгүүнднн өгөв. Хоёул аваад хэтэвчиндээ дүрээд мангасын оюу өнгөт хөх морийг Алтан дагинад унуулж арван зүгийн эзэн Гэсэр хаан гэрийн зүг залран явахдаа Алтан дагинын унасан мангасын хөх морь эс явж хойно хоцров. Хоёр хөвгүүд эргэж ирэд Лайцав мориноос бууж эхдээ унуулав. Ах дүү хоёул сундалж хөх морийг хөтөлж явтал гэнэт Гэсэр үзээд хөх моринд удисийг өгвөөс амар мэт морь болов. Ловсгааг дайрч ирвээс түүний үе гишүүн нь өөрөө цуцарсан байв.

Арван зүгийн эзэн Гэсэр хаан гэртээ ирээд Алтанв дагинаыг бууруулж таван зуун дагуул улс малаас нь хагацуулж ганц гэрээр буулгав. Гэсэрт Ажу мэргэн алтан аяганад рашааны архийг хийж сөгдөн бариад ийн айлтгаруун: “Алтан дагинын яьдал буруу боловч Ажу мэргэн хатан чинь гуйна”гээд мөргөсөнд Гэсэр хаан зарлиг болруун: “Муу хүнийг түр зовооё гэж билээ би” гэв. Гэсэр, Ажу мэргэний үгээс үл давахын тул Алтан дагинын аливаа бүгдийг Ажу мэргэн төгсгөж өгөв. Арван зүгийн эзэн гээр хаан, арван хүч төгссөн мангасыг алж шумнасын үндсийг тасалж тэнгэр нарын жаргалаар жарган суусан цадиг төгсөв.

**АРВАН ЗҮГИЙН АРВАН ХОРЫН ҮНДСИЙГ ТАСАЛСАН АЧИТ БОГД
ГЭСЭР МЭРГЭН ХААНЫ ХАМАГ ДАЙСНЫГ ДОРОЙТУУЛЖ, ХАМАГ
АМЬТНЫГ ЖАРГУУЛСАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

Арван зүгийн эзэн Гэсэр мэргэн хаан: “Эжий минь хаана байна?” гэв. Цасын хөвгүүн Лайцав хэлэв: “Эжий чинь хэдийн бурхны хутгийг олсон бишүү. Чамайг илжиг болж явах цагт муу санаж бэтэг өвчин дүүрч үгүй болсон” гэв. Гэсэрийг хайлж байхад эрдэнэсээр бүтсэн хот нь зөвөөр дээш гурван үе эргэж тогтов. Гэсэр хаан билгийн хээр морио унав. Билгийн ташуураа барив. Есөн алд хар шор илдээ зүүв. Нар сар хоёрыг хамтаар зэрэгцүүлсэн хийсэн манлай цагаан дуулгаа эрдэнэт тэргүүндээ өмсөв. Шүүдрийн гилбэлгээн өнгөт хөө хар хуягаа өмсөв. Цахилгаан өнгөт далавчаа дүүрэв. Оюу эрдэнэт гучин цагаан сум, догшин хар нумаа дүрэв. Ерөн гурван болд сүхээ авав. Нарыг барих алтан цалам, сарыг барих мөнгөн цалам, есөн салаат төмөр урхиа, ерөн есөн салаат төмөр бялуугаа булт авав.

Ажу мэргэн хатандаа зарлиг болов: “Би удваас гурван сарын тэртээ, эс удваас гучин хоногийн тэртээ золгоно. Явдал минь дуусав. Эжийн сүнсийг олж үзсүү “ гээд огторгуйд гарч Хурмаст тэнгэр ахайдаа хүрэв. Хүрээд айлтгав: “Хурмаст тэнгэр ахай минь айлдан соёрх .Миний ертөнц дэх эхийн минь сүнсийг үзэв үү?” гэж асуув. “Үзсэнгүй ” гэв. Гучин гурван тэнгэр нарт очиж сураглав. Бас “Үгүй” гэв. Навса Хүрзэ эмэг эхдээ бас сураглав. “Үгүй” гэв. Ялгуусан гурван эгчдээ очиж сураглав. “Энд хаанаас ирэх вэ? Үгүй” гэв. Бас Уулсын хаан Овоо Гүнжид ахайдаа очиж бас асуув. “Үгүй ” гэв. Огторгуйгаас буухдаа хан гарди болж буув.

Буусны хойно эрлэг хаанд очив. Очтол арван найман тамын хаалтыг хаасан байв. “Хаалгыг тайл!” гэв. Эс тайлж өгөв. Тамын хаалгыг хамх дэлдээд оров. Арван найман тамын хаалгачнаас явж асуув. Булт эс мэдэв. Чингэсэн хойно Гэсэр хаан арван найман тамын хаалганд хэвтэж байж эрлэг хааныг хар даруулав. Эрлэг хааны сүнс нь хулгана байсан ажээ. Гэсэр хаан түүнийг мэдээд сүнсийг хүрнэ болгож алтан цалмаар гэрийн өрхний нүхийг (бөглөж) хүрнэд бариулав. Сар барих мөнгөн цалмаар (үүдийг) бүрхэв. (Хулгана) доош орох гэхэд алтан цалманд унаж үл гарч болов. Чингэж байгаад Эрлэг хааныг барив. Хоёр гарыг нь хүлж ерэн есөн салаа төмөр бялуугаар занчиж: “ Үтэр хэлж өг! Эжийн минь сүнс хаана байна? зааж өг” гэв. Эрлэг хаан хэлэв: “Чиний эхийн сүнс нь миний чихэнд сонсдсонгүй. Нүдэнд минь үзэгдсэнгүй” гэв. Эрлэг хаан бас хэлэв: “Үгүй болбоос арван найман иамын хаалгачаас асуу” гэв. Очиж бас асуув: “ Булт “үгүй” гэв. Арван зүгийн эзкэн Гэсэр хааны эх Амаржил ирвэл бид Эрлэг хаанд үл айлтгах буюу?” гэв. Тэр дотор нэг цал буурал өвгөн хэлэв: “ Гэсэр хааны эхийг нь эс мэдлээ. нэгэн эмгэн : “Нусгай Шилү Дасва минь!” гэж үүнээс түүнээс ус өг гэж гуйж ус олохгүй явна билээ. тэгээд агь шаваг түүж идэж явна билээ” гэхэд гэсэр хаан зарлиг болов : “Эвүү! Энэ юу хэлнэ? Үтэр очиж эрж ир” гэв. Өвгөн хэлэв: “Одоо тэр шавгийг дотор бий болов уу?” гэж өвгөн явав. Очиж үзтэл байсан ажээ. гэсэрийн эхийн сүнсийг олж авав. Тэр өвгөнөөс (бусад) арван найман тамын хаалгачныг тас алав. Чингэсний хойнол Гэсэр хаан (Эрлэг хаантай уулзаж) зарлиг болов: “Үнэхээр чиний эх ” Миний нүдэнд үзэгдсэнгүй. Чихэнд сонсогдсонгүй. Би мэдвэл чиний эхийг юу гэж тамд унагаах буй гэв. (Тэндпээс Гэсэр) “Билгийн хээр морь минь! нэгэн дүр үзүүл” гэв. (Морь нь) ридийн хүчийг хөдөлгөн ирт мэсийг өвчүүндээ зүүгээд арслан тэргүүнийг тэргүүлэн аюух мэт дүр үзүүлэн рашааны булгаас амаа гурван үе зайлаад, гурван үе залгив. Чингэсний хойно Гэсэр хэлэв: “Миний эжийн минь сүнсийг амандаа зууж хурмаст тэнгэо ахайд минь аваачиж өг” гэв. “намайг Замбутивд төрөхөд эх босон бөлгөө. Тэд минь мэднэ ээ” гэв. Морь нт тэр бүгд сургуулыг аваад огторгуйн замаар дотлон) явж очтол ялгуусан гурван өхий нь угтаж ирэв. Морь нь хүрэхдээ зана уурлан өвчүүндээ ирт мэс уяж түг түмэн дайсныг тасар дэлдэх мэт аашлан хүрэв. Ялгуусан гурван өхий нь үзээд гайхалдаад угтаж ирэв: “Нусгай Жур минь

дор замбутив ертөнцөд төрж билээ. ингжэ догшин дзүрээр явах байна” гээд билгийн хээр морины аман дахь сүнсийг авав. Ялгуусан гурван эгч нь : “ Бид мэднэ ээ. Чи Гэсэрт харь” гэв. Чингэсний хойнол ялгуусаан угрван эгч нь эхийн нь сүнсийг аван очиж Хурмаст тэнгээ ахайд нь хүргэж өгөв. “Нусгай Жур минь дор Замбутивд ертөнцөд төрөхдөө үүнийхэвэлд нь орж төрсөн ажээ. үүний сүнсийг дээр тэнгэр нарт төрүүл гэж илгээж байна” гэв. “Нусгай минь зөв” гээд Хурмаст тэнгэр ахай нь арван зүгээс лам нарыг урьж сүнсий нь залж ном унуулж, цан хэнгэрэг дэлдэж, хүж зул, шатааж байтал эхийн нь сүнс тоо тоомшгүй олон бурхан болов. Бас ном уншуулж, арван зүгийн бурхануудыг урьж байтал биндэрья эрдэнэ болов. Бас ном уншуулж арван зүгийн бурхануудыг урьж байтал дагина нарын (дотор эрхэн) хатан болов. Чингэсэн хойнол (билгийн хээр морь буцаж ирсэнд) Гэсэр хаан зарлиг болов: “”Ай билгийн хээр морь минь! вдалаа бүтээж ирэв үү чи?” гэв. “Очсоны хойно үл бүтээж ирэх буюу?” гэв. “Билгийн хээр морт минь ээ! сайн” гэв. Чингэсний хойно Гэсэр хаан Эрлэн хааныг (урхинаас) тавив. Тавихдаа хэлэв: “ Эрлэг хаан! Үүний хойно аливаа юмны өв бурууг ялгаж тамд унагаасай чи” гэв. Чингэсний хойно Эрлэг хаан зарлиг болов. “Гэсэр хаан мөргөөд байв. Тэгээд Эрлэг хаан зарлиг болов. “Энэ юун жиг билээ? Би л биеэр чиний эхийг тамд унагаах ёс үгүй билээ л” гээд заяаны толиндоо үзтэл Гэсэр хааныг төрөх цагт Гагса Амаржил эх нь “Энэ нь чөтгөр үү?, бурхан уу?” гэж эс мэдэж арван найман алд гуу ухаж тэр гуунд орхигэсний хүчээр раван найман тамд унасан нь энэ ажээ. Эрлэг хаан түүнийг Гэсэр хаанд хэлэв: “ Гэсэр хаан чингэсний хойно (Гэсэр хаан буруугаа хүлээж эрлэг хааныг орд балгасанд нь урин залруулаад өөрөө) гэрийн зүг заларч өөд болов. гэртээ хүрээд Ажу мэргэн, Арлан гуа хатнаа аваад Нолом талдаа буув. Арван гурва очирт сүмээ сайхан байгуулав. Чандмань эрдэнэ, цавгүй хар нүүрс, хамаг эрднэсээр бүрдсэн дөрвөн өнцөгт хотын дотор мянган галав болтол суун жаргав.

МОНГОЛ ГЭСЭРИЙН ТУУЖИД ГАРДАГ ЗАРИМ НЭРСИЙН ТАЙЛБАР

Монгол Гэсэрийн туужид гарч байгаа нэрсийг тайлбарлах гэвэл Монгол Гэсэрийн туужийн нэрсийг төвд Гэсэрийн туужийн нэрстэй нийлүүлэн шалгаж үзэх хэрэгтэй болох юм. Гэвч энэ нь тийм ч амархан ажил биш байлаа. Яагаад вэ? гэхэд монгол Лин Гэсэрийн туужтай адил буюу 1716 онд барлагдсан Гэсэрийн туужийн эх болов уу? гэж санамаар төвд Гэсэрийн тууж олохгүй байгаа бөгөөд бид тийм төвд туужийг олж үзээгүй учраас харьцуулж судлах боломж бага байна.

Гэвч Монгол гэсэрийн туужид гарч байгаа нэлээд нэрс төвд Гэсэрийн туужид гарч байна. Нарийвчилан хэлбэл Заяын Гэсэр, 1716 онд хэвлэгдсэн Гэсэрийн туужтай адил төвд Гэсэрийн тууж олоогүй боловч Гэсэрийн төрсөн байдал гэргий авсан байдал Гэсэр Цотон нарын дайсан бололцсон байвал, Шарайголын байлдаан зэргийн ерөнхий явдал нь төвд монгол Гэсэрийн туужуудад хоорондоо төстэй байна. Ийм учраас Төвд Монгол Гэсэрийн туужуудад адил буюу адилавтар нэрсийг харьцуулан судалж болох байна. Эдгээр адил буюу адилавтар үйл явдал, адил буюу адилавтар нэрс нь төвд монгол Гэсэрийн туужууд угаасаа нэг гаралтай боловч олон зуун жилийн дотор өвөрмөц нөхцөлд өвөрмөц замаар тус тус хөгжсөнийг бас үгүйсгэж болохгүй. Дээр хэлсэн ёсоор Монгол Гэсэрийн тууж доторх хүмүүс нь голдуу төвд нэртэй байна. Ганц энэ баримт дээр үндэслэж Монгол Гэсэрийн туужид төвд оронд болсон үйл явдал гарч байна гэж шууд нотолж арай болохгүй. Монгол, Уйгар буюу Төвд биш өөр угсааны хүмүүс төвд нэртэй байх нь аль олон байдаг билээ. Одоо ч монголчуудын дотор Лувсан, Давга, Цэрэн, Дондов, Дамдин гэх мэтийн төвд нэртэй хүмүүс олон байна. Үүнээс гадна, Монгол Гэсэрийн туужид ба ялангуяа Заяын Гэсэрийн тууж дотор жинхэнэ монгол нэртэй хүмүүс олон байна. Жишээ нь : Заяын Гэсэрийн тууж дотор Аригун, Үзэсгэлэнт мэргэн хиа, Алтан сэцэн, Есүтэй сэцэн, Исман ноён, Холочи баатар, Амбагадай, Тормогдой гэх зэргийн жинхэнэ монгол нэртэй хүмүүс олон тохиолдож байна. Монгол, Төвд, Уйгар зэрэг олон угсааны хүмүүс оршдог Амдо орны уран зохиол монгол, төвд, Уйгар нэртэй хүмүүс гарах нь хачирхалтай хэрэг биш болоо.

Энд хэвлэж байгаа монгол Гэсэрийн тууж дотор гардаг зарим хүмүүс, бурхан тэнгэр, газар орны нэрсийг товчийн төдий тайлбарлаж бичье. Монгол Гэсэрийн туужид төвд нэрийг ихээхэн хазайлгаж монгол хэлбэр дуудлагатай болгож монголжуулсан явдал үлэмжхэн байна. Жишээ нь, Жац Шалгарыг Цас Чихэр, Бругмог Рогма буюу Орогма, Бумжидийг Түмэнжаргалан болсон байна. Энэ нь монгол туульч нар Гэсэрийн туужийг монголжуулж монгол нөхцөлд тохируулж байгаа явдлын нэг сэжүүр мөн тул ийнхүү монголжуулсан нэрийг хэвээр бичив.

Бид энэ номд ka, kha, ga, ca, cha, ja, nya, ta, tha, da, na, pa, pha, ba, ma, tza, tsa, dza, va, zha, za, ya, ra, la, sha, sa, ha, a, гэсэн ийм галиг үсгийг хэрэглэж төвд үгийг галиглав

АЖУ МЭРГЭН ХАТАН

Ажу мэргэн хатан бол төвд Гэсэрийн туужид байдаггүй юм. Үүнийг лусын хааны охин гэдэг. Ажу мэргэнийг их дайчин баатар эмэгтэй гэж монгол Гэсэрийн туужид гардаг. Гэсэрийг мангасын оронд илжиг болоод зовж байхад Ажу мэргэн очиж авардаг юм. Ажу мэргэнээс нэг хүү төрсөн боловч урт насалж чадсангүй. Тэгээд Гэсэрт өөр хүү төрсөнгүй тул Гэсэрийн хаан

төрийг Цас Чихэрийн хүү Лайцав залгамжлав гэдэг.

АЛТАН ДАГИНА

Рогма гуа Гэсэрийн туужийн сүүлийн бүлгүүдэд Алтан дагина гэж нэрлэсэн нь цөөнгүй тохиолдоно. Алтан дагина гэдэг нь хааны төрийн гол хатан гэсэн утгатай мэт байна.

АРЛАН ГУА ХАТАН

Арлан гуа бол Гэсэрийн анхны хатан бололтой юм. Энэ хатан бол Арлан гуа Бумжид, Түмэнжаргалан гэдэг гурван өөр нэртэй байна. Төвдөөр Бумжид Bum skyid гэж бичдэг. Энэ нэрийг монголоор орчуулаад Түмэнжаргалан гэдэг нэр үүсчээ. Бумжид Түмэнжаргалан гэдэг бол нэг хатны төвд монгол хоёр нэр болох нь тодорхой байна. Харин Арлан гуа гэдэг нэрийн учир юу вэ? Энэ тухай зөвлөлтийн эрдэмтэн С. Ю. Неклюдов шинэ сонин саналыг “Монгол туулийн судлал” гэдэг номдоо дэвшүүлж байна. Түүний хэлж байгаар бол Арлан гуа бол угтаа Бумжид буюу Түмэнжаргаланаас өөр хатан бөгөөд өөр бүлгийн баатар байжээ. Хожим Монгол Гэсэрийн тууж дотор Арлан гуа, Түмэнжаргалан хоёр хатан нь нэг хатан болж хувирсан боловч нэр нь засагдалгүй, өөр хэвээр үлджээ гэж таамагласан байна. Цотон ноён, Рогма хатан хоёул хуйвалдаж Арлан гуа буюу Түмэнжаргалан хатныг Гэсэрийн өвчний гайд гаргаж хойд зүг хөөж цөлсөн энэ бүлгийн үлгэрч нар хожим нэмсэн байх гэдэг миний таамаглалтай Неклюдовын санал яг тохирч байна. Арлан гуа хатны нэрийг Монгол Гэсэрийн туужууд дотор Арлан, Арлага, Арла, гэх зэрэг олон янзаар бичдэг боловч бид энэ хэвлэлд Арлан гуа гэж бичив.

АРЪЯ АВАЛОКИ ОДКАРИ

Аръя Авалоки Одкари гэдэг үгийг баралган тайлбарлавал Аръя Авалоки гэж санскрит хэлээр Хутагт ертөнцийн эх гэсэн үг бололтой. Одкари гэдэг нь төвдөөр Цагаан гэрэлт эх гэсэн үг бололтой. Энэ бол Гэсэрийн сахиулсан тэнгэр болно.

АРЪЯ АЛАНКАРИ

Аръя Аланкари гэдэг бол санскрит хэлээр Хутагт чимэг эх гэсэн үг бололтой .

АСУР

Асур бол эртний санскрит хэлний үг юм. Санскритаар Asura гэж бичнэ. Асура гэдэг эрт

балар цагт амьдралын хүчний эзэн гэсэн утгатай үг байжээ. Хожим нь энэ үгний эхний а үсгийг үгүйсгэж угтвар гэж, сура-г тэнгэр буюу дасрс гэсэн үг гэж хавируулан тайлбарлах явдал дэлгэрчээ. Тэгээд тэнгэр нарыг эсэргүүцэж үргэлж байлддаг асур нар гэж ном сударт дүрслэгдэх болжээ. Энэ үгийг төвдөөр Лхамин (Lha min) гэж орчуулжээ. Тонголоор орчуулахдаа санскрит үгийг сэргээж асури гэж бичжээ. Асури гэдгийг эцсийн и эгшиг санскирт хэлэнд байхгүй боловч монгол хэлэнд бий болжээ. Санскирт хэлний олон нэр томъёо согд, уйгар хэлээр дамжиж Монгол оронд нэвтрэхдээ эцэстээ и эгшигтэй болсон байна. Жишээ нь, асури, бодгали, эрдэни, убаси гэх мэт. Эдгээр үгийн эцсийн и эгшигийг одоо шинэ бичигт заавал бичих явдалгүй мэт. Харин эцсийн гийгүүлэгч нь зөөлөрсөн байвал и буюу зөөлний тэмдгийг бичиж болох юм. Ингэж бодоод бид энэ номд Асур гэж бичлээ.

ОВОО ГҮНЖИД

Овоо Гүнжид гэж нэг уулын эзэн сахиулсын нэг, мэргэн төлөгчийн нэр болно. Гүнжид гэж төвдөөр хамгийг жаргуулагч гэсэн үг бололтой .

ГЭСЭР

Гэсэр гэдэг нэр төвдөөр Гэсэр (Ge sar) гэсэн үгний монгол дуудлага болно. Гэсар гэж төвдөөр цэцгийн туурцгийн нэр болно. Түүхэнд үзвэл Гэсэр хүүхэд байхдаа Госрой буюу монголоор орчуулбал Ухаант агь нэртэй байгаад Гэсэр нэртэй болжээ. Тэгээд түүхэнд Госыло нэрээр тэмдэглэгдсэн байна. Гэсэр хааныг Гэсар нэртэй болоход Ромын Цезарийн тухай домог ч нөлөөлсөн байж болно. Төвдийн түүхэн зохиол домогт хааяа Хром Кесар (Khrom Kesar) гэдэг нэр үзэгддэг юм. Хорм гэдэг нь эртний Италийн Ром хотын араб дуудлага юм гэдэг.

ГЭСЭР СЭРВО ДОНДҮВ

Гэсэр Сэрво Дондүв гэдгийг төвд билэгийг сэргээвэл Ge sar Ser bo Don grub болно. Үүнийг орчуулбал Шар үйл бүтээгч Гэсэр гэсэн үг болно. Гэсэр тэнгэрийн оронд байхдаа дондүб буюу үйл бүтээгч нэртэй байсан. Шар гэдэг үгийн учир мэдэгдэхгүй байна.

ДАЙВУН ХААН

Дайвун хаан хяиад улсын эзэн хааны нэр болно. Энэ нэр монголд Хятадын Тан улсын үеэс дэлгэрсэн бололтой. Монгол галын тахилгалын сударт Далай Дайвун хааны нутгаас эд мөнгөний хишгийг гуйна гэж байдаг.

ДОНСАР

Донсар гэдэг бол Амдо орны төвдийн нэг аймгийн нэр болно.

ДОС

Дос гэж Амдо орны нэг аймгийн нэр болно. Дос, Тос Тус Дус гэж алинаар дуудах нь тодорхойгүй. Учир нь энэ аймгийн нэр төвд Гэсэрийн туужид олдохгүй байна.

ЖАЛО

Төвд монгол Гэсэрийн туужуудад Жало гэдэг нэр олон тохиолдож байна. Энэ үг бол IX - XI зууны үед төв Азид оршиж байсан монголд угсааны хятан улсын нэр мөн бололтой. Хятан гэдэг олны тэмдгийн “Д” дагаврыг нэмээд хятад болжээ. Уг нь хятад гэдэг бол өмнө зүгийн нэгэн монгол аймгийн нэр байсан боловч сүүлдээ нанхиад хүмүүсийн нэр болон хувирчээ. Нанхиад хүмүүс өөрсдийгөө Хань буюу дундад улсын хүн гэж нэрлэдэг. Олон жижиг аймаг нанхиад нарыг манай он тооллын өмнөх III зууны үед Цинь Ши Хуанди нэгтгэж нэг гүрэн болгожээ. Энэ үеэс нанхиад нарын нэр гадаад оронд Цинь буюу Чина гэж алдаршсан байна. Нанхиад нарын улсыг Энэтхэгийн санскрит хэлээр Махачина гэдэг болжээ. Маха гэдэг нь их гэсэн үг, Чина гэдэг нанхиад улсын нэр болно. Энэхүү Чина гэдэг үгийг латин үсгээр China гэж бичдэг үүнийг англичууд Чайн гэж, францчууд Шинэ гэж, германчууд хина гэж дууддаг бөгөөд энэ нь Нанхиад нарын нар болно. Монголчуудын хэрэглэдэг нанхиад гэсэн үг бол өмнө зүгийнхэн гэсэн үг бололтой. Монголын хуучин ном сударт нанхиад улсын нэрийг махачина буюу махазина гэж нэрлэсэн удаа цөөнгүй тохиолдоно.

Монгол угсааны хятан буюу хятад улс X зууны орчимд өөрийгөө Даляо улс гэж нэрлэх болсон байна. Даляо гэдгийн утга бол их Ляо улс буюу Их Төмөр улс гэсэн утгатай ажээ. Энэ Даляо гэдэг нэр, Гэсэрийн тууж дотор Жало болж орсон бололтой гэж дээр хэлсэн билээ. Одоо энэ санаагаа өчүүхэн тайлбарлая.

Монгол Гэсэрийн туужид Рогма гуагийн нутаг орныг уйгаржин монгол үсгээр Жало, Скило гэх мэт бичсэн үзэгдэж байна. Энэ бол төвд Гэсэрийн туужид байгаа skya lo гэсэн үгний монгол галиг болно. skya lo гэдэг төвд үгийг монголчууд Жало гэж уншдаг билээ. Энэ үгийн утга нь Цайвар Ло гэсэн үг болно. Цайвар Ло гэж юу вэ?

Заяын Гэсэрийн туужид үзвэл тэр улсын нэрийг заримдаа Жало гээд заримдаа Саран улс гэсэн байна. Сарани гэдэг монгол үгийг төвд хэлэнд орчуулбал zla гэж бичээд Да гэж уншдаг үг болно. Тэгэхлээр Жало гэдэг нь дало гэсэн дуудлагатай байсан болов уу? гэдэг саналыг төрүүлж байна. Төвд хэлэнд зөөлөрсөн л авиа байхгүй тул ляо –г ло гэж бичсэн байж болно. Гэсэрийн (Госылогийн) хаад ноёд нь Хятан эхнэр авах заншилтай гэж түүхэнд байдаг. Энэ бүгдийг нийлүүлэн таамаглаж бодвол Гэсэрийн туужид байгаа Жало улс нь монгол угсааны даляо улс буюу хятан улс мөн гэж санамаар байна.

ЖАМЦО ДАРИ ОДДАМ

Жамцо дари Оддам гэж Гэсэрийн сахиулс гурван охин тэнгэрийн нэгний нэр болно. Төвд санскрит холилдсон энэ нэрийн төвд билэгийг таамаглан сэргээвэл rGya mtso Dari Odtam болно. Үүнийг бараглан орчуулбал Далай Гэтэлгэгч (ногоон) Дам үсгийн гэрэлт эх гэсэн үг бололтой. Дари гэдэг санскрит үг бол гэтэлгэгч гэсэн утгатай . Эцсийн и үсэг нь санскрит хэлний эмийн хүйсийг заасан дагавар мөн тул эх гэсэн үгийг урьдын төвд монгол заншлаар нэмж бичив.

ЛИН ОРОН

Лин орныг төвд Гэсэрийн туужид gling гэж бичээд Лин гэж дуудна. Энэ бол хойд төвдийн Амдо нутагт хөх нуур, Хатны голын эх хавийн газрын нэр болно. Лин орны хаан нь Цойтон байгаад дараа нь Гэсэр болсон гэж Гэсэрийн туужид гардаг. Лин оронд монгол төвд, уйгар зэрэг олон үндэстэн урьд нутаглаж байсан, одоо ч нутаглаж байна. Амдогийн Лин оронд XI зууны үед Гэсэрийн тууж зохиогдсон гэж бид таамаглаж байна.

ЛУС

Газар дэлхий, уул усны эздийг лус гэдэг. Лусыг могой буюу морьтой хүний дүрээр зурж тахиж явдал урьд үзэмжхэн байсан. Уул тайх ёслол бол чухамдаа уулын эзэн лусыг тахиж ёслол болно.

МАЧИН БОМРА

Мачин Бомра бол Хатны голын эхний хувьд байдаг алдартай өндөр уул болно. Энэ уулын нэрийг төвдөөр rMa chen ‘Bom га гэж бичдэг. Энэ уулын хавь нутгаар Лин, Шарай гол хоёр улсын байлдаан болсон мэтээр Гэсэрийн туужид гардаг.

МО ГҮҮШ, ДАНБО

Мо буюу mo гэдэг үг бол төвдөөр төлөг бэлэг үзэх, мэргэлэхийн нэр болно. Гүүш буюу Рүоши гэдэг бол XIII – XIV зууны үед улсын багш гэсэн утгатай байгаад

НАВСА ХҮРЗЭ ЭМЭГ ЭХ

Навса Хүрзэ эмэг эх бол тэнгэрийн оронд байдаг. Гэсэрийн авралт эмэг эх болно. Навса Хүрзэ төвд Гэсэрийн туужид байхгүй, үүний нэр нь өөр байна. Төвд Гэсэрийн туужид тэнгэрийн оронд байгаа Гэсэрийн эмэг эхийг Гүнман жалмо гэж нэрлэдэг. Үүнийг төвдөөр Gung sman rgyal mo гэж бичдэг. Үүнийг зарим номд дүл ялгуугч оточ эх гэж орчуулсан байдаг. Дүл гэдэг монгол үг бол өдөр дунд буюу шөнө дундын нэр болно. Заримдаа Гүнжалма гэж товчилж бичсэнийг Заяагч эх гэж шидэт хүүрийн туужид орчуулсан байдаг. Монгол Навса Хүрзэ эмэг эх гэдэг нь ямар нэг гажсан төвд үгний галиг гэж санагдах юм. Төвдөөр sNa bza' bKur bza' тэргүүлэгч хүндэт эх гэж үг байж магадгүй .

ОВОО ДҮНЖИНГАРВО

Овоо Дүнжингарво гэдэг үгийн овоо нь төвд хэлний Пүво (Phu bo) ах гэсэн үг болно. Дүнжингарво бол тэнгэрээс газарт бууж төрсөн Гэсэрийн ах болох учраас Пүво (ах) гэж нэрлэсэн бололтой. Гэвч энэ пүво гэдэг үгийг зарим Гэсэрт овоо гэж хувирган монголчилон бичсэн удаа байна. Иймийн тул бид овоо гэж бичив. Дүнжингарво бол санскрит хэлээр Sit Sankha pala, төвдөөр Dung skoung dkar bo гэсэн үг юм. Үүнийг монголоор Дүнжингарво гэж уншина. Монголоор орчуулбал Цагаан лавай тэтгэгч (лус) гэсэн үг болно. Энэ лус буюу лусын хаан бол төвд, Монгол оронд их алдаршсан газрын эзэн сахиус болно. Улаанбаатарын дэргэдэх Богд уулын сахиусыг Дүнжингарво гэдэг. Энэ лусын хааны тухай монгол Шидэт хүүрийн үлгэрийн 26-р бүлэгт өгүүлсэн байна. Дүнжин гэдэг үгний жон (skoung) гэдгийг чүн (kkyung) гэж буруу дуудаж унших явдал байсан учир Богд уулын эзнийг гарди шувуу дүрстэй зурах болсон юм. Төвдөөр чүн (khyung) гэж гарди шувууны нэр болно. Бидний хэвлэж байгаа Гэсэрийн туужийн III бүлэгт (х.11) Гэсэрийн сахиулсан эгчийн нэрийг Дүнжингарво гэсэн байна. Эрэгтэй лусын хааны нэрийг тэнгэрийн дагина яагаад зүүх болсон нь тодорхойгүй бөгөөд эргэлзэлтэй байна.

РОГМА ГУА

Гэсэр хааны үзэсгэлэнт сайхан Рогма хатныг булаах гэж Шарайголын байлдаан эхэлсэн юм. Төвдөөр 'Brug mo гэж бичнэ. Эм луу гэсэн үг. Монголоор Рогма гэж бичээд Орогма гэж дуудна. Буриад Гэсэрт Урмай гоохон гэж нэрлэжээ.

РОЦА

Ронца гэдэг нэрийг төвдөөр Rong tsa гэж бичнэ. Рон гэдэг бол Амдо нутгийн нэг төвд аймгийн нэр болно. Ронца гэхлээр рон аймгийн зээ гэсэн утгатай болно. Рон аймгаас авсан эхнэрээс төрсөн хүний нэрийн өмнө Ронца гэж нэмж бичнэ. Жишээ нь: Ронца Царгин, Ронца Марлэв гэх мэт. Заримдаа ронца Марлэвийн нэрээс Марлэвийг хасаад зөвхөн Ронца (Ронса) гэж бичсэн удаа Гэсэрийн туужид олон байна.

СЭНЛОН НОЁН

Сэнлон ноён –Гэсэрийн эцэг бөгөөд Цотон ноёны ах болно. Үүний нэрийг төвдөөр Seng blon гэж бичнэ. Утга нь Арслан ноён гэсэн үг .

ТАГЗИГИЙН ЭРДЭНИЙН ХААН

Тагзиг гэж ирэн улсыг нэрлэж байна. Тагзигийг төвд Гэсэрийн туужид Stag gzig буюу ta zig гэж хоёр янзаар бичдэг. Stag gzig гэдэг үгийг орчуулбал барс ирвэс гэсэн үг болно. Монгол Гэсэрийн туужид Тагзиг гэж байхгүй, Барс ирвэсийн хаан гэж дурдагдсан байна. Тагзиг улсыг элдэв идээ хүнсээр баялаг гэж төвд домогт олон гардаг. Төвд Гэсэрийн туужид Гэсэр хаан Тагзиг оронд очиж аливаа ядууст эд юм буюу идээ хүнсийг түгээж өгсөн гэж бүлэг байхгүй, харин Гэсэр хаан уулын чинээ эрээн барсыг алсан гэж тусгай бүлэг байна. Монгол үлгэрч нар төвд Гэсэрт байгаа Тагзиг улсыг барс гэж ойлгоод барсыг алсан бүлгийг зохиосон гэж санагдмаар байна.

ХОНСИМ БОДЬСАД

Санскрит хэлээр Авалокитэшвара (Avalokiteshvara), төвдөөр Жанрайсэг (sPyan ras hzigs), монголоор Нигүүлсэхүй нүдээр үзэгч буюу хонсим бодьсад гэдэг бол Буддийн шашны их алдаршсан нэг бодьсадын нэр болно. Авалокитэшвара гэдэг санскрит нэрийг Хятад хэлээр Гуань ши инь гэж орчуулсан. Үүнд дүрс бичгийн дотор эмийн тэмдэг байсан учир тэр бодьсад сүүлдээ Дари эх болон хувирчээ. Тэр хятад орчуулгаас монгол хонсим хэмээх үг гарчээ. Улаанбаатарын дэргэдэх Амагланбаатар хотод Дари эхийн сүм байсан нь чухамдаа Хонсим бодьсадын сүм байсан билээ. Халхын Бари лам Дамцигдорж “Ертөнцийн сав шим” гэдэг төвд Дари эх суудаг гэж бичжээ. Хонсим бодьсад, Дари эх хоёрыг арга билгийн хос гэж номолсон ном ч байдаг. Төвдийн Сронзан гамбо хаан ба Далай лам Хонсим бодьсадын хувилгаан гэж алдаршжээ.

ХУРМАСТ

Урьд монгол бөө мөргөл ноёрхож байхад ерөн есөн тэнгэр байдаг гэдэг байв. Барууны 55 тэнгэр, зүүний 44 тэнгэр гэж хоёр хэсэг хуваадаг байлаа. Монголд бурхны шашин ноёрхож ирэхэд Энэтхэгийн домгийн нөлөөгөөр 33 тэнгэр байна гэдэг болов. Тэр 33 тэнгэрийн хаан нь Хурмаст тэнгэр болно. Хурмаст тэнгэрийн суудаг орд харшийг Сударсун гэдэг байв. Хурмаст тэнгэрийн зарлигаар түүний хүү Дондүв буюу үйл бүтээгч ертөнцөд төрж Гэсэр хаан болсон гэж монгол гэсэрийн туужид гардаг билээ. Хурмастыг санскритаар Андра (Inda), төвдөөр Жажин (rGya byin) гэдэг.

Төвд Гэсэрийн туужид бол үүнээс арай өөрөөр гарсан байна. Лин Гэсэрийн туужид Гэсэрийн эцэг нь хурмаст биш Цамба болно. Төвдөөр Цамбыг Tsangs pa гэдэг, санскритаар Брахма (Brahma) гэдэг, монголоор Эсруа гэдэг. Давид-Нэлийн орчуулсан Кам орны Гэсэрийн туужид бол хурмаст ч байхгүй, Цамба ч байхгүй, харин VIII зууны үед Энэтхэгээс төвдөд ирж шашин дэлгэрүүлж байсан Бадмасамбава багш, тэнгэр язгуурт Тувпа-Гава-г дэлхий дээр Гэсэр хаан болж төр гэж илгээсэн байна.

ЦАРГИН

Царгин өвгөний нэрийг төвд Гэсэрт ингэж бичдэг боловч голдуу Rong tsa Khra rgan гэж бичнэ. Ронца Царгин гэж уншина. Утга нь Рон аймгийн зээ өвгөн Шонхор гэсэн үг. Үүнээс Царгины эх нь Рон аймгаас авсан эхнэр байжээ гэж мэдэж болно.

Төвд Гэсэрийн туужид гардаг олон хүний нэрийг бүрэлдэхүүнд эх нь ямар аймгийн хүүхэн байсныг заасан үг ордог байна. Зээгийн нэр дотор нагац аймгийн нэр ордог нь эхийн эрхт ёсны үлдэгдэл бололтой. Нагац нарыг их хүндэтгэх ёс нь эхийн эрхт ёсны үлдэгдэл болно. Монгол оронд мөн ийм эхийн эрхт ёсны үлдэгдэл заншил байдаг. Жишээ нь: зээ хүнд нагацын шар нохой ахална гэх буюу нагацын дэргэд дал идэж болохгүй гэх, улсын эх нагац усны эх булаг гэх мэт.

ЦАС ЧИХЭР

Цас Чихэр Гэсэрийн хайрт ахын нэр болно. Төвдөөр rGya tsa Zhal dkar гэж голдуу бичнэ. Утга нь: Хятаны зээ, цагаан гэсэн үг бололтой. Жаца гэдэг нь хятаны зээ гэсэн үг. Учир нь Сэнлон ноёны их эхнэр нь хятан хүүхэн байсан юм. Шалгар гэдэг нь Цагаан царайт гэсэн үг. Жаца Шалгар гэдэг төвд нэрийг монголчууд гуйвуулж Зас Шихэр буюу Цас Чихэр гэж дууддаг болсон юм. Буриад Гэсэрийн туужид Дашан Шөөхөр болсон байна.

ЦОТОН НОЁН

Энэ нэрийг төвдөөр Khro tung гэж голдуу бичдэг. Утга нь хилэнт оготор буюу түргэн хилэнт гэсэн үг. Дуудлага нь Тотүн гэх боловч монголчууд Цотон, Чотон гэж дууддаг. Буриадууд Зутан гэдэг. Цотон, Гэсэрийн авга ах бөгөөд Гэсэртэй үргэлж тэмцдэг, урвамтгай, зальхай муу дүрээр дүрслэгдсэн юм. Гэвч зарим Гэсэрийн туужид Цотонгийн урвамтгай муу чанар нь Гэсэрийн шудрага баатар болох дүрийг гаргахад тус болдог учир Цотонг Гэсэрийн нэг хувилгаан Дамдин бурхан гэж хэлсэн удаа бий.